

411(Mon)
415
54384



BIBLIOTHECA MONGOLICA: Monograph 1
CENTRE FOR MONGOL STUDIES
National University of Mongolia

Цэвэлийн
ШАГДАРСҮРЭН

МОНГОЛЧУУДЫН
ҮСЭГ БИЧИГИЙН
ТОВЧООН

ᠮᠣᠩᠭᠣᠯᠴᠢᠳᠤᠨ
ᠤᠰᠡᠭ ᠪᠢᠴᠢᠭᠢᠨ
ᠲᠣᠪᠴᠣᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯᠴᠢᠳᠤᠨ
ᠤᠰᠡᠭ ᠪᠢᠴᠢᠭᠢᠨ
ᠲᠣᠪᠴᠣᠨ



УЛААНБААТАР
2001 он



BIBLIOTHECA MONGOLICA: Monograph 1
CENTRE FOR MONGOL STUDIES
National University of Mongolia

Ли(Мон)
43 15

Цэвэлийн
ШАГДАРСҮРЭН

МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧИГИЙН ТОВЧООН

(ҮСЭГЗҮЙН СУДЛАГАА)

Нэмж зассан хоёдугаар хэвлэл

Эрхилэн нийтлүүлсэн Шаравын ЧОЙМАА



1
2
3
4
5
6
7
8
9
10
11
12
13
14
15
16
17
18
19
20
21
22
23
24
25
26
27
28
29
30
31
32
33
34
35
36
37
38
39
40
41
42
43
44
45
46
47
48
49
50
51
52
53
54
55
56
57
58
59
60
61
62
63
64
65
66
67
68
69
70
71
72
73
74
75
76
77
78
79
80
81
82
83
84
85
86
87
88
89
90
91
92
93
94
95
96
97
98
99
100

УЛААНБААТАР

2001 он

Библиотека



BIBLIOTHECA MONGOLICA: Monograph 1
CENTRE FOR MONGOL STUDIES
National University of Mongolia

Tseveliin
SHAGDARSÜRÜNG

STUDY OF MONGOLIAN
SCRIPTS

(GRAPHIC STUDY or GRAMMATOLOGY)

Enlarged second edition

Edited by Sharaviin CHOIMAA



Copyright © Tseveliin SHAGDARSÜRÜNG / Centre for Mongolian Studies, NUM
All rights reserved

ISBN 99929-5-347-0

VLAANBAATAR
2001

ОРШИЛ

Дэлхий нийтээр бичиг үсгийн мөн чанарыг хэрхэн үздэг тухай хөндөж ярилгүйгээр түүхэн үеийн туршид Монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсэгийг судлахын учир холбогдлыг тайлбарлахын арга үгүй бөлгөө. Дэлхий дахинаа алдар цууд гарсан гүн ухаантан, түүхч, угсаатны зүйч нарын дүгнэлтэд үндэслэн үсэг бичиг судлагч, америк эрдэмтэн И. Е. Гельб (I. J. Gelb) авгай соёл боловсролтой хүмүүсийн уншилгүй өнгөрч болохгүй хэмээн үздэг *"Бичиг үсэгийн судлагаа"* гэдэг номдоо:

"...Хэл гэдэг зүйл хүнийг бусад амьтанаас ялгаж өгдөг бол, бичиг гэдэг зүйл соёл иргэншилт хүнийг зэрлэгүүдээс ялгаж өгдөг болой... Өөрөөр хэлбэл, зөвхөн соёл иргэншилийн орчинд л бичиг үсэг баймуй; бичиг үсэггүйгээр соёл иргэншил гэдэг зүйл байж үл чадмуй..."¹

хэмээн ер энгийн үгээр тун ойлгомжтой тодорхойлсон нь буй. Үүгээр бодохул Ази, Европын олон орны түүхч, судлагчидын ганц нэг бус бүтээлд өвөг дээдэсүүдийнхээ үеэс "зэрлэгүүд" гэж нэрлүүлж ирсэн монголчуудын энэ "нэр"-ийн мөн чанарт эрхгүй эргэлзэхэд хүрмүй. Дээрхи хэмжүүрээр үзэхүл, хүннү шүннүгийн үеэс ямар ч атугай бичиг үсэг хэрэглэж хөрш зэргэлдээ орныхоо эзэн хаанд албан захидал илгээж, газар нутгийнхаа зургийг үйлддэг байсан тухай нуттай баримтыг эс тооцлоо ч гэсэн түүхэн хөгжлийнхөө туршид арав гаруй бичигийн тогтолцоог эх хэлэндээ тохируулан боловсруулж хэрэглэсээр өнөөг хүрсэн улс үндэстэн "зэрлэгүүд" байсан байж яав ч таарахгүйн дээр өөрийн гэсэн өвөрмиц соёл иргэншилээ буй болгосон гэж үзэх бүрэн үндэстэйг энэхүү эшлэл харуулж өгнө.

Толилуулан буй номд юуны өмнө монголчуудын өвөг дээдэсийнхээ үеэс өнөөдрийг хүртэл хэрэглэсээр ирсэн олон зүйл бичиг үсгийн тогтолцоо, тэдгээрийн дотоод гадаад харилцаа холбооны асуудлыг хэлшинжлэлийн нэгэн чухал салбар ухаан болох үсэгзүйн үүднээс судлан гаргахыг эрмэлзсэн бөгөөд үүний дүнд дээр өгүүлсэн эргэлзээг аль нэгэн хэмжээгээр лавшруулж чадсан ахул эл номын бас нэгэн дам зорилго давхар биелэж байгаа нь тэр.

Дэлхий дахинаа монголын судлал гүнзгийрч, эх бичигийн судлагаа (Textology) нарийсан хөгжихийн хэрээр монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсэгийн тогтолцоог үсэгзүйн үүднээс судлах шаардалга эрхгүй гарч ирлээ.

Үсэгзүй (Graphics) нь бичиг үсэгийн тогтолцоог хэлбэр болон агүүлгын талаас нь үлэмжхэн өргөн хүрээнд авч судладаг, хэлшинжлэлийн салбар ухаан бөлгөө. Үүнд: бичиг үсэгийг хэлбэрийн талаас судлана гэдэгт тухайн үсэгийн үүсэл гарал, үсэг болон үсэгийн махбод, нэмэлт тэмдэгийн зүйл, бичих дараалал, цагаан толгойн бүтэц, үсэгийн галигийн тогтолцоо, бичигийн хэлбэр, бичих байдал зэрэг гадаад хэлбэрийн тал судлагдахуун болж өгнө. Агүүлгын талаас судлана гэдэгт нь товчоор хэлбэл үсэг дуудалга хоёрын харьцаа буюу ямар нөхцөлд, ямар үсгээр, ямар авиаг хэрхэн тэмдэглэдэг болон ямар авиаг, ямар нөхцөлд, ямар үсгээр яаж тэмдэглэдэг, мөн түүнчилэн дуудалгын галигийн тогтолцоо зэргийг судлана гэсэн үг. Үүнээс гадна үсэгзүйд бичвэрийн доторхи алдаа мадагийн зүйл, уншиж үл болох буюу гаргагдахгүй үг үсгийн судлагаа; мөр тэтгэх, мөр дарах, бичиг ацлах,

¹ I. J. Gelb, *A Study of Writing*, Chicago, 1952 / Revised (second) edition, Chicago-London, 1963; И. Е. Гельб, *Опыт изучения письма* (основы грамматиологии), Москва, 1982, стр. 211.

үг таслан бичих, тамга дарах ёсон хийгээд тухайн дурсгалын он цаг, газар нутаг, бичээчийг тогтоох зэрэг эх бичигийн судлагдахуун аль нэгэн хэмжээгээр дам хамаардаг бөлгөө.

Монгол туургатны хэрэглэж ирсэн олон зүйл бичигийн тогтолцоог үсэгзүйн үүднээс судлах эхлэлийг анх академич Йеншөөбү Ринчен профессор тавьсан бөгөөд уг судлагааг улам нарийсган гүнзгийрүүлэхийг зохиол бүтээлдээ нэг бус удаа дурдсан нь буй. Багштаныхаа захиасыг ёсоор болгохсон гэж 1970 хэдэн оноос төлөвлөгөөт ажлын хажуугаар чармайн, холбогдох хэрэглэгдэхүүн цуглуул цуглуулсаар ганц сэдэвт зохиол болгох хэмжээнд хүргэж 1977 онд Польшийн ШУА-ийн Эдийн боловсролын түүхийн хүрээлэнд хүмүүнлигийн шинжлэх ухааны докторын зэрэг горилож бичсэн *"Монголчуудын утга соёлын товчоон"* (*Culture Spirituelle des Mongols*) хэмээх бүтээлийн хоёрдугаар дэвтэр болгон дуусгаж билээ. Эрдэмийн зэрэг Хамгаалуулах зөвлөлөөс уг бүтээлийн эхний дэвтэр хангалттай гэж үзсэний учир мөнөөхи хоёрдугаар хэсгийг тусад нь монголчлож 1981 онд *"Монгол үсэг зүй"*² гэдэг нэрээр нийтлүүлсэн бөлгөө.

Тухайн цагийн улс төрийн учир шалтгаан, Москва Бээжингийн харьцаа зэргээс үүдэж ШУА-ийн Хэлзохиолын хүрээлэнгийн тэр үеийн удирдалгын зүгээс уг номын *"Өвөг монголчуудын бичиг үсэгийн асуудал", "Хятан бичиг", "Шинэ үсэг", "Латин үсэг", "Төв Азийн ард түмний соёлын түүхнээ монгол бичиг үсэгийн эзлэх байр"* зэрэг хэд хэдэн бөлөгийг бүхлээр нь, мөн *"Монгол бичиг", "Дөрвөлжин бичиг"* бөлөгөөс нэлээд хэсгийг хасуулсан билээ. Гэвч уг ажлыг бүрэнээ гүйцэлдүүлэх талаар Хэл зохиолын хүрээлэнгийн захиргаанд албан бичиг ирүүлэх зэргээр удаа дараа дэмжилгэ өгч байсан профессор Эдхям Рахимович Тенишевт гүнээ баярлаж явдаг билээ. Мөн энэ номыг хэвлүүлэхэд санхүүгийн туслалцаа үзүүлсэн *"МУИС" хөгжлийн сан-д* талархалаа илэрхийлээ.

Энэхүү толилуулан буй *"Монголчуудын үсэг бичигийн товчоон"* (Үсэгзүйн судлагаа) хэмээх номд түрүүчийн хэвлэлээс хасагдсан бөлөг хэсгийг нэмэн оруулж бас энэ завсар монгол хэл, монгол бичиг үсгийн талаар дотоод гадаадад гарсан шинэ сэрэг судлагаа болон түрүүн үзэж амжаагүй байсан ном бүтээлийг бололцооны дотор уг эхээр нь олж үзэхийг чармайж, холбогдох санал дүгнэлт, баримт сэлтийн зүйлийг аль болохуйц эш баримтаар тодорхой тусгахыг хичээсэн болно.

Таргуд Цэвэлийн ШАГДАРСҮРЭН

Аргын 2000 оны 2-р сар,
Бэлгийн тооллын XVII жарны
Тийн дарагч буюу Баатар хэмээх
төмөр (цагаан) луу жилийн
цагаан сарын өлзийт сайн өдөр

Улаанбаатар хот.

² Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Тэргүүн дэвтэр, (Эрт үеэс 1921 он хүртэл), редактор Х. Лувсанбалдан, Улаанбаатар, 1981, 168 тал.

УДИРТХАЛ

(Бичиг үсгийн хөгжлийн түүхэн тойм)

Хүн төрөлхитөн эх байгалиасаа ялгарч хүмүүнийхээ нийгэмлигийг байгуулж аж төрөхөд нь **хэл** онцгой үүрэг гүйцэтгэсэн нь ямар ч эргэлзээгүй бөлгөө. Хэдийгээр сүүлийн үеэс амьтаны хэлний тухай үзэл бодол их бага аль нэгэн хэмжээгээр гарч байгаа боловч хэл гэдэг гайхамшигт зүйл хөгжлийнхөө дээд хэлбэрийг зөвхөн хүмүүний нийгэмлигт л олж ерөнхий үүргээрээ хүмүүсийн "харилцахын хэрэглүүр" болж ирсэний хажуугаар тухайн хэлэлцэгч үндэстнийхээ оршин байх нэгэн гол батлагаа болж өгдөг ажээ.

Гэвч хэл гэдэг зүйл "харилцахын хэрэглүүр" болохдоо харьцангуй хязгаарлагдмал нөхцөлд уг үүргээ биедүүлдэг бөлгөө. Тухайлбал: цаг хугацаа болон орон зайн шалтгаацал давхацсан үед буюу өгүүлэгч соносогч хоёр этгээд тодорхой нэг орон зайд, тодорхой нэг цаг хугацаанд хамт байх нөхцөлд л хэл "харилцахын хэрэглүүр" болж өгдөг. Гэтэл нэг талаас хүн төрөлхитөний аж төрөл хөгжихийн хирээр, нөгөө талаас хүмүүний хэзээ ч дуусч ханадаггүй хэрэгцээний эрхээр цаг хугацаа, орон зайн шалтгаацалыг давах шаардалга арга буюу гарч өгүүлэгч, соносогч хоёр этгээд өөр өөр газар оронд, өөр өөр цаг хугацаанд байх нөхцөлд хэрхэн харилцаж болох боломжийг хайсаар, үүний дүнд хүн төрөлхитөн **бичиг** гэдэг бас нэгэн гайхамшигт зүйлийг буй болгожээ.

Харилцахын хүрээнд цаг хугацаа, орон зайн давхар хязгаарыг давах өргөн боломжийг олгож өгсөн бичиг хэмээх энэхүү их бүтээл туурвил бол хүн төрөлхитөний буй болгосон утга соёлын хамгийн үнэт зүйл гарцаагүй мөн буй заа. Гэхдээ нэгэн зүйлийг үгүйсгэх аргагүй. Үүнд: тухайн хэлний тогтолцоо нь тухайн үсэг бичгийнхээ онцлогийг тодорхойлж өгдөг тул харилцахын эхний шатанд буй болсон хэлгүйгээр бичиг үсгийг авч үзэхийн аргагүй юм. Иймээс уг хэлнийхээ хэвшинжийн онцлогт тохирсон бичиг үсэг нь эргээд тухайн хэлээ хөгжүүлэх үндэс болж өгдөг, тохироогүй бичиг үсэг нь эхний шатанд тухайн хэлээ, дараа нь тухайн үндэстэнээ аажмаар мөхөөдөг ерөнхий зүй тогтолтой бөгөөд хүн төрөлхитөний түүхээс үүний жишээ батлагааг толгой зовоолгүй олж болно.

Үсэг бичиг нь хүн төрөлхитөний оюун ухаан болон түүний тусгал болсон хэлний хөгжлийн урт удаан замналын үр дүн байдаг тул бичиг үсгийн түүх мөн л тийм урт замыг туулжээ.

Үсэг бичиг буй болохын өмнө ямар ч атугай уридал болсон тодорхой шатыг туулсан нь мэдээж. Энэ үеэс л бичиг үсгийн хөгжлийн түүхийг авч үзвэл зохино. Францын эрдэмтэн Марсел Коэн (Marcel Cohen, 1884-1974) нарын уламжлалт хуваариар хүн төрөлхитөний үсэг бичгийн хөгжлийн түүхийг

Зураг бичиг (Pictogrammes),
Санаа бичиг (Idéogrammes),
Авиа(ны) бичиг (Phonogrammes)

хэмээн ерөнхийд нь гурав ангиласан байх ба уг хуваарийг улам нарийсгасан судлагаа ч гарч байна. Үүнд: Францын нэрт угсаатны зүйч А. Леруа-Гуран¹ (André Leroi-Gourhan):

¹ Marcel Cohen, *La grande invention de l'écriture*, 2e vol., Paris, 1958
André Leroi-Gourhan, *Le geste et la parole*, Paris, 1964/1965.
La Linguistique, Encyclopoche Larousse, Paris, 1977, pp. 173-186.

Домог буюу үүсгэл бичиг (Mythogrammes),
Өгүүлбэр бичиг (Phrasogrammes),
Үг бичиг (Logogrammes),
Бүтээвэр бичиг (Morphéogrammes),
Үе бичиг (Syllagrammes),
Авиа(ны) бичиг (Phonogrammes)

хэмээн үзжээ. Марсел Козний зураг бичиг гэдэг нь А. Леруа-Гураны хуваариар домог буюу үүсгэл бичигтэй үндсэндээ дүйдэг.

Үсэг бичиг гэдэг зүйл сонгомол утгаараа бие даан буй болохынхоо өмнө тодорхой нэгэн үе шатыг дамжсан нь мэдээж бөгөөд чухам энэ үеэс л *юм бичиг* гэдэг зүйл бичгийн үүргийг гүйцэтгэж байсан гэж судлагчид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ нь А. Леруа-Гураныхаар домог буюу үүсгэл бичигийн шатанд багтдаг юм.

Тэгвэл *юм бичиг* гэж юуг хэлдэг вэ? гэдэг асуулт гарна. Юм бичиг гэдэг нь хүмүүн төрөлхитөний нийгмийн хөгжлийн нэн эрт цагт буй болж харилцах хэрэглүүрийн үүрэг гүйцэтгэж ирсэн эд юмс болой. Европ зүгийн ном зохиолд *юм бичигийн* баримт болох мэдээ түүхийн эцэг хэмээн алдаршсан Херодот (Hérodotos, Христусын тооллын өмнөхи ~484 - ~425 он)-ийн бүтээлд үлдсэн гэж үздэг. Үүнд: Перс Скитийн дайны үеэр Дарий хаанд Скит нараас шувуу, хулгана, мэлхий хийгээд таван ширхэг сум бүхий учир битүүлгэ захиа ирсэн гэдэг мэдээ бөлгөө. Үүний учрыг Дарий хааны *тайлагч* түшмэл Гобрий гэгч "Хэрэвзээ та шувуу болж тэнгэрт халин ниссэн ч, хулгана болж газарт шурган орсон ч, мэлхий шиг уснаа шунгасан ч миний сумнаас зайлж үл чадмуй" хэмээсэн далд санаа ажгуу хэмээн тайлсан гэдэг².

Энэ домогийг соносмогц, монгол түмний дунд ч яг үүн шиг өгүүлэмж бүхий үлгэр олон байдаг бөгөөд түүний нэгд өгүүлсэнээр: нэгэн их хаанд хил нийлж нутаг савласан улсаас нь тасын ед, тарваганы хумс, сум (буюу мөс), сур бүхий учир битүүлгэ бэлэг-захидал ирсэн тухай; түүнийг нь нэгэн их ухаант хүн мөн л дээрхи маягаар тайлсан тухай өгүүлдэг нь монгол хүний санаанд тов хийтэл орж ирнэ. Харин нэгэн зүйлийг нэмж хэлэхэд, монгол үлгэрийн доторхи өгүүлэмжийг Херодотынхитой харьцуулахад илүү хийсвэрлэсэн байдал, тухайлбал: тас шувууг өдөөр нь, тарвагыг хумсаар нь төлөөлүүлсэн байдал бэлхэнээ харагддаг бөлгөө. Харин бид энэхүү өгүүлэмжийг бичиг гэж үзэхээсээ илүү оюун ухааныг сорьсон бодолго гэж ойлгож ирсэн явдал буй боловч хүмүүн төрөлхитөний өнө эртний *юм бичиг*-ийн ул мөр биш гэж үгүйсгэхийн арга бас байхгүй.

Хүмүүний нийгэмлэг хөгжихийн хэрээр *юм бичиг* нарийсан хөгжиж улам хийсвэржсээр иржээ. Үүний жишээнд Суматрын Батак нарын дунд өдгөө хүртэл хэрэглэсээр буй, өстөнийхээ үүдэнд өлгөдөг, баруун дахины ном зохиолд "*галт бичиг*" гэж нэрлэдэг зүйл, мөн Йоруб нарын *хэлхээст бичиг*, Австралынхины элч зардсандаа өгч явуулдаг гэрэгэ маягийн пайз, эртний нангиадад хэрэглэж байсан бөгөөд Перу нарын дунд дэлгэр дайралддаг, тооцооны зорилго бүхий *зангилаа бичиг*, түүнчилэн цэцэгийн эрхи мэт хэлбэртэй кипу хэмээх *хэлхээст бичиг* зэргийг дурдаж болно.

Энэ бүхнээс яргуулан бодохул хүн төрөлхитөний үсэг бичгийн хөгжлийн үүсгэл хэлбэрүүдийг монголчуудын өвөг дээдэс мөн л хэрэглэж байсаны баримтыг монгол ардын билигзүй, зан заншилын уламжлалаас бэлхэнээ мэдэж болох нь ээ.

Үсэг бичиг жинхэнэ утгагаараа буй болсоны эхний шат нь зураг бичигтэй шууд холбоотой бөгөөд хөгжлийнхээ эхин үед хийсвэрлэц гэх юмгүй, уг юмаа хэвээр нь дүрслэсэн буюу зураг бичиг хоёрын зааг бараг байхгүй, өөрөөр хэлбэл нийлэг хэлбэртэй байжээ. Дэлхий дахинаа ийм зураг бичгийн сонгодог баримт гэвэл эртний хүмүүсийн сууц оромжоос олдсон тухайлбал: Франц, Испанийн нутагт оршдог Дордони (Dordogne)-ийн Ляско (Lascaux), Алитамир (Altamira) болон Фон дө Гом (Font-de-Gaume) зэрэг агуйн

² Johannes Friedrich, *Geschicht der Schrift*, Heidelberg, 1966; Иоганнес Фридрих, *История письма*, Москва, 1979, стр. 12.

туурганы зураг гэж үздэг. Бидний өнөөдөрийн мэдэлгийн хэрээр долоон зуун мянган гаруй жилийн өмнө гэхэд хүн аж төрж байсан Монгол газарын хувьд ур чадал хийгээд цаг хугацааны хувьд дээр дурдсан туурвилуудаас дутахааргүй дурасгал гэвэл Ховд аймагийн Хойд Цэнхэрийн агуйн туурганы зураг гэж мэргэжлийн судлагчид хэдийнээ хүлээн зөвшөөрчээ³. Энэчилэн монгол нутгаас хаа сайгүй олддог хад чулууны сүг зурагийг эрт цагийн хүн төрөлхитөний бичиг үсгийн эхи гэж үзэх үндэстэй юм.

Тэдгээр зураг хөрөгийг үзэхэд, амьтаны сүрэг олныг заасан, мод юмсыг бэлгэдсэн болзмол тэмдэг, дөрөвдөгч галбын үед сөнөж үгүй болсоноос арслан заан, бизон хэмээх үхэр, одоо байгаагаас хоёр бөхтэй тэмээ, тэмээн хяруул зэрэг амьтныг дүрслэсэн нь монгол нутаг дээр эртний чулуун зэвсэгийн үеэс ямар ч атугай тэр цагтаа харьцангуй боловсорсон хүмүүний аймаг аж төрж, соёл боловсролынхоо баримт дурасгалыг хойд үедээ үлдээсний гэрч бөлгөө.

Үүнээс гадна тус улсын нутаг дэвсгэр дээрхи хад чулууны зурагийн дотор аливаа нэгэн зүйлийг эзэгнэснийг заасан гарын зураг, гол мөрнийг гатлан хамигаа одсоныг дүрслэсэн хөлийн зураг гэх зэрэг илүү хийсвэрлэнгүй хөрөг дүрс олонтаа тохиолддог нь үсэг бичигийн үүдэл болсон сүг зургийн зүйл улам боловсорч ирсэний нутлагаа буюу Монгол нутаг дээрхи хад чулууны зурагийг XIX зууны сүүлээс Н. М. Ядренцев (1889), В. В. Радлов (1891) зэрэг оросын эрдэмтэд эхлэж судласан байх бөгөөд харьцангуй сүүл үеэс эл сэдэвт тусгайлан зориулж бичсэн, бие даасан ном бүтээл олон гарчээ⁴.

Үсэг бичигийн хөгжлийн дараагийн шатанд дүрс зургийн хийсвэрлэц улам бүр хөгжсөөр уг дүрслэгдэхүүнээсээ аажим аажмаар холдон тодорхой утга илэрхийлэх санаа бичиг-ийн шатанд хүрдэг ажээ. Чухам энэ үеэс л бичиг гэдэг сонгодог утгаа олдог гэж үзэж болно. Санаа бичигийг дотор нь хэд ангилдаг. Үүнд, нэг тэмдэг нь бүхэл бүтэн санааг илэрхийлж байвал өгүүлбэр бичиг болно. Харин нэг тэмдэг нь ямар нэгэн санааг нэмэн гаргаж байвал бүтээвэр бичиг болно.

Зураг бичиг нь хөгжлийнхөө дараагийнхаа шатанд уугуул тэмдэглэгдэхүүнээсээ бүрмөсөн салж, хийсвэрлэн бие дааж тухайн хэлнийхээ нэг буюу хэдэн авиаг тэмдэглэх болсноор авианы бичиг үүссэн хэмээмүй. Авианы бичгийг дотор нь хэд хуваан үздэг. Үүнд: нэгэн тэмдэг нь нэг бүхэл бүтэн үеийг тэмдэглэж болно. Ийм бичигийн тогтолцоог үеийн бичиг гэнэ. Үеийн бичгийг бүтэцээр нь цааш нь задлаж, энэ нь эгшиг, энэ нь гийгүүлэгч байна гэж салгаж болдоггүй. Хятан бага бичиг, япон бичиг үүний жишээ бөлгөө. Авианы бичигийн нөгөө нэгэн хэсэг нь үүнээс огт өөр, нэгэн тэмдэгт нь тодорхой нэг (буюу түүний хувилбар) авиаг тэмдэглэж байж болно. Ийм бичигийн тогтолцоог цагаан толгойт бичиг гэнэ. Цагаан толгойт бичигтэй жишихэд үеийн бичиг нь харьцангуй олон тэмдэгттэй; гэхдээ хэдэн зуугаас үл хэтрэнэ. Цагаан толгойт бичиг нь хамгийн олондоо 50-60-аас нэг их хэтрэхгүй. Харин үеийн тогтолцоо бүхий дүрс бичигийн тэмдэгт бол хэдэн арван мянгад ч хүрдэг.

Харин нэгэн зүйлийг дурдахад, цагаан толгойт бичгээр үгийг үе үеэр нь таслан бичдэг ёсон буй боловч түүнийг үеийн бичиг гэж самууран үзэх ёсгүй. Монголын дөрвөлжин, соёмбо болон самгард, төвөд, солонгос зэрэг бичиг нь цөм цагаан толгойтой; үгийг үе үеэр нь таслан бичдэг боловч үеийн бичиг бус цагаан толгойт бичиг болой.

³ А. П. Окладников, *Центрально-Азиатский очаг первобытного искусства*, Новосибирск, 1972.

⁴ А. П. Окладников, *Центрально-Азиатский очаг первобытного искусства*, Новосибирск, 1972; Д. Дорж, Э. А. Новгородова, *Петроглифы Монголии*, Улан-Батор, 1975; Х. Пэрлээ, *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*, Улаанбаатар, 1976; А. П. Окладников, *Петроглифы Монголии*, Новосибирск, 1981; А. П. Окладников, *Петроглифы Чулутын-Гола*, Новосибирск, 1981; А. П. Окладников, *Древнейшие петроглифы Аршан-Хада* (Монголия, Хэнтэй), Пластика и рисунки древних культур, Новосибирск, 1983; Э. А. Новгородова, *Мир петроглифов Монголии*, Москва, 1984; Н. Сэр-оджав, *Баян-лигийн хадны зураг*, Улаанбаатар, 1987; Э. А. Новгородова, *Древняя Монголия*, Москва, 1989; Т. Санжмятав, *Монголын хадны зураг*, Улаанбаатар, 1997.

Хүн төрөлхитөний үсэг бичигийн хөгжлийн хандалгыг ерөнхийд нь авч үзвэл хийсвэрлэх, хялбарчлах гэсэн хоёр гол шаардалгад чиглэгдэж иржээ.

Өнгөрсөн түүхийнхээ хугацаанд арваад бичиг үсгийн тогтолцоог янз бүрийн учир шалтгаанаар боловсруулж, янз бүрийн хугацаагаар хэрэглэж ирсэн монголчуудын бичиг үсэг нь дэлхий нийтийн бичиг үсгийн түүхийн салгажгүй нэгэн бүрэлдэхүүн хэсэг мөнөөс мөний учир толилуулан буй энэ номын удиртгал болгож дэлхийн үсэг бичгийн үүсэл хөгжлийн ерөнхий тоймыг ийнхүү товч өгүүлж байгаа бөлгөө.

Монголчуудын өвөг дээдэс олон үеийн туршид ам дамжиж ирсэн овог аймгийнхаа түүх, аман уламжлалыг чухам хэдий үеэс бичиглэн тэмдэглэж ирэх болсон тухай олон эрдэмтний санал зөрүү байсаар ирсэн бөгөөд одоо энэ хир ац хагалан нэгэн тийш болгон шийдэж чадаагүй байна.

Нангиад түүх шаштарт тэмдэглэгдэн үлдсэн, энэ хэр хамгийн эртний гэгдэж буй баримтаас үзэхэд христусын тооллын өмнөхи (х. т. ө.) 192 онд Хүн(нү) улсын эзэн хаан Маодунгаас Хятадын хатан хаан Гао-хэү 'д бичсэн захидлын үг хятад орчуулгаар бидний үед хүрэлцэн иржээ⁵. Бас "Хожуу Хан улсын судар"-т тэмдэглэснээр христусын тоолол (х. т.)-ын 46 он гэхэд Хүн(нү) нар нутаг орныхоо газарын зурагтай байсан ажээ⁶. Харамсалтай нь энэ бүхэн уг эхээрээ хадгалагдаж чадсангүй. Гэвч олон эрдэмтний хүчин зүтгэлээр Хүн(нү) нарын бичиг үсэгт холбогдох хэсэг бусаг мэдээ хэрэглэгдэхүүн цугларсаар наад зах нь тодорхой таамаглал дэвшүүлэх хэмжээнд хүрсэн бөгөөд энэ тухай холбогдох бөлөгт дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Академич Л. Лигети "Сүй шү" хэмээх түүхийн 32-р дэвтэрээс Сянби хэлээр гарсан 13 номын жагсаалтыг олохын сац Сянби хэлний нэг аялгуу болох Табгач хэлийг судлаж Сянби нар монгол хэлтэн болохыг батлаж өгсөн билээ⁷.

"Вэй шү", "Сүй шү" зэрэг нангиад түүхэн сурвалжид Тоба нар шинэ бичиг боловсруулсан тухай мэдээ буй. Бас Сянби нараас өмнө Ухуани нар модон дээр хэрчлээс үйлдэн бичдэг тусгай үсэг бичигтэй байсан гэж тэмдэглэсэн баримт буй⁸. Эдгээр бичигийн дурасгал одоогоор олдоогүй боловч бичигийн байдал төлөв нь хүн(нү) нарынх гэж үздэг бичигийн уламжлалд дам холбогдох ач холбогдолтой бөлгөө.

Энэ бүхний дараагаар, түүхийн янз бүрийн нөхцөлд, янз бүрийн шалтгаан шаардалгаар монгол туургатны боловсруулан хэрэглэсээр ирсэн монгол, хятан, дөрвөлжин зэрэг арваад бичиг үсэгийн тогтолцоо бидний үе хүртэл дурсгал хоцролоо үлдээж өгсөнөөс гадна тэдгээрт шууд холбогдох мэдээ баримтын зүйл Х зуунаас тов тодорхой тэмдэглэгдэн үлджээ. Энэ бүхэн нь монгол хэл, монгол бичиг, монгол соёл төдийгүй монголчуудын гадаад харилцаа, Төв Ази дахины бусад улс үндэстний соёл боловсролын хэлхээ холбоог судлахад бодат хэрэглэдэхүүн болж өгсөөр байна.

Бичиг үсэг гэдэг зүйл хэдийгээр тодорхой нэг хэлэн дээр суурилан буй болдог боловч эргээд тухайн хэлнийхээ өөрчлөлт хувиралтыг зохицуулан зөв голдиролоор нь хөгжүүлэх хүчин зүйл болж өгдөг бөлгөө. Дэлхийн бичиг үсгийн хөгжилийг нарийвчилан судласан эрдэмтний тэмдэглэснээс үзэхэд тухайн хэлэндээ тохирсон бичиг үсэг бүхий ард

⁵ Н. Я. Бичурин (Иакинф), *Собрание сведений о народах, обитавших в средней Азии в древние времена*, I, Москва-Ленинград, 1950, стр. 53.

Б. Сумъяабаатар, *Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975, 9-10-р тал.

Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 1991, 164-р тал.

⁶ Н. Я. Бичурин (Иакинф), *Собрание сведений о народах, обитавших в средней Азии в древние времена*, I, Москва-Ленинград, 1950, стр. 117.

Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 1991, 64-р тал.

⁷ L. Ligeti, *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*, - Mongolian Studies, Edited by L. Ligeti, Budapest, 1970, pp. 265-308.

⁸ *Материалы по истории древних кочевых народов группы Дунху*, Москва, 1984, стр. 63.

түмний хэл нь харьцангуй аажим бөгөөд авиазүй, хэлбэрсудлалын хувьд зөв тогтолцоотой өөрчлөгдөж байхад бичиг үсэггүй ард түмнийхи маш түргэн хувирч шинэ хэл буюу аялгуунд амархан шилждэг ажээ⁹. Тухайлбал: Америкийн индей, Африкийн банту нар бичиг үсэггүй, бүдүүн бараг аж төрдөг учраас хэдэн зуун хэл аялгуутай байдаг нь үүнтэй холбоотой гэнэ. Тэр ч бүү хэл, индей нарын аль нэгэн аймагийн залуучууд нь өөрөөс дээшхи хоёр буюу гурван үеийнхээ¹⁰ ахмадуудтай хэл авалцахад бэрхтэй буюу заримдаа чадахгүйд хүрдэг байна.

Иймд хүн төрөлхитөний буй болгосон бичиг гэдэг зүйл бол тухайн хэлнийхээ бүтэц, онцлогт бүрэн тохирсон нөхцөлд л тэр ард түмнээ хэлнийхи нь хувьд нэгтгэж өгдөг онцгой үүрэгтэй зүйл ажээ. Тийм ч учраас эрдэмтэд "... Аливаа үндэстний оршин байх гадаад бэлгэ тэмдэг нь тэдний хэл бичиг хоёр нь бөлгөө. Тэгээд ч аливаа байлдан дагуулагчидын хувьд, аль нэг ард түмнийг устгах зорилгодоо бичигийн үнэт өв сангий нь үгүй хийх явдал эн тэргүүний зорилго нь болдог билээ. Чухамхүү энэ учир шалтгаанаар 1520 онд Испанийн колончлогч Кортес Мексикийг дайлахдаа уугуул нутгийнхины өнө эртний баатарлаг идэрхэг явдалыг нь өгүүлсэн бүх номыг шатаа! хэмээн тушааж байсан хэрэг. Мөн л ийм шалтгаанаар Нацистууд өөрийнхөө сурталд харшилсан үзэл бодолыг нүхчин дарах гэсэндээ эсрэг талынхиныхаа ном бичигийг шатааж байсан юм..."¹¹ гэж онцлон тэмдэглэсэн нь санамсаргүй хэрэг огт биш ээ. Харин тухайн бичиг үсэг нь хэлэндээ үл тохирох ахул серег нөлөө үзүүлж эхний шатанд уг хэлний өвөрмиц мөн чанарыг, аажимдаа тухайн үндэстнийхээ онцлогийг алдаруулах хүчин зүйл болж хувирдаг бөлгөө. Ази дахины олон улс үндэстэн тусгаар төр улсаа байгуулмагц хэлнийхээ онцлогт тохирсон шинэ бичиг зохион хэрэглэж ирсэн нь үүнтэй холбоотой.

Уг хэлнийхээ зүй тогтолд тохирсон эртний уламжлал бүхий бичиг үсэг нь тэр ард түмнийхээ хэлний хөгжлийг зөв чиглүүлэхийн хамт, тухайн хэлний өнгөрсөн, өдгөө, ирээдүйг холбосон гүүр нь болж өгдөг бөлгөө. Өөрөөр хэлбэл, тухайн бичгээр тэмдэглэсэн үг бүр анх ямар язгуур үндэсээс хэрхин үүссэн, угтаа ямар утга учиртай байсан, өдгөө тэр утга нь хэвээрээ буюу өөрчлөгдсөн эсэх зэрэг уламжлал, хувирал, шинэчлэл зэргийг харуулж өгдөг толийн үүрэгтэй ажгуу. Утга учир нь олсон хэлний мэдэлгэ тухайн үндэстний сэтгэхүйг улам хөгжүүлж өгдөг. Харин уг хэлэндээ тохируулж шинэ тутам авсан бичиг үсэг нь тухайн цаг үеэсээ хойш л дээрхи үүргийг гүйцэтгэж эхлэх бөгөөд уг хэлний түрүү өнгөрсөн үеийн толь болж чаддаггүй байна.

Чухам ийм учраас эртний уламжлалт, хөгжил өндөр гээд бидний үлгэр загвар болгоод байгаа англи, америка, франц, герман, хятад зэрэг улсуудын бичиг үсэг болон тэдгээр бичигийн зөв бичихзүй нь өдгөөгийнхөө ярианы хэлнээс асар их ялгаатай, эртний уламжлалаа баримтласаар байгаагийн учир нь тэр болой. Жишээлбэл: англи хэлний аль нэгэн толь гэхэд толгой үг бүрийн ард тэр үгийг хэрхэн уншихийг галиглан хадсан дуудалга байдагийг бид мэдэх болсон билээ. Гэвч тэдгээр улс орны дотоодод эрт эдүгээ аль ч үед хэлшинжлэл, бичиг үсгийн судлал гэдэг ухаанд мэргэжжээгүй (ер нь бүх хүн мэргэжих боломжгүй буй заа) зарим хүмүүс, манай зарим нэгэн шиг, зөв бичихзүйг одоогийнхоо ярианы хэлэнд ойртуулан хялбарчлах нь зүйтэй бөгөөд энэ нь хэл үзэж сурахад дөхөм болно гэж үздэг явдал байсаар ирсэн боловч жинхэнэ шинжлэх ухааны үүднээс тухайн бичигээр барахгүй тухайн хэл, цаашилбал тухайн ард түмний алс ирээдүйн хувь заяаны асуудлыг ухаалаг удирдагчидтай байх нөхцөлд өрийн нэг багаж техник шиг хялбарчлах боломжгүй тул тэр бүр санаснаар нь болж өгөлгүй лавтайяа өнөөдөрийг хүрсэн бөлгөө. Үүнийлэн хэдэн түмэн тэмдэгт бүхий хятад бичигийг сурах гэдэг тийм хялбаргүй гэнэм. Тэглээ гээд англи, франц, герман, хятад хэлт улс түмэн аль ч талаараа хоцрогдсонгүй.

⁹ I. J. Gelb, *A Study of Writing*, Chicago, 1952 / Revised (second) edition, Chicago-London, 1963; И. Е. Гельб, *Опыт изучения письма* (основы грамматологии), Москва, 1982, стр. 213.

¹⁰ Угсаатны зүйн ухаанд хүний хөгжлийн нэг үеийг дундажаар 25 жил гэж үздэг бөгөөд энэ нь тухайн хүн төрж, өсч, гэрлэж, үр хүүхэдтэй болох хугацааг бодолцсон хэрэг бөлгөө.

¹¹ I. Gelb, *A Study of Writing*, Chicago, 1952 / Revised (second) edition, Chicago-London, 1963 | Гельб И. Е., *Опыт изучения письма*, Москва, 1982, стр. 223.

Энэ жишлэнгээр олон улсын хэмжээнд бичиг үсгийг хэрхэн судладаг аргазүйн дагуу, толилуулан буй эл номд монголчуудын хэрэглэж ирсэн арав гаруй бичигийн тогтолцоог гарал үүсэл, үсэгзүйн судлагаа, дотоод гадаад холбоо харилцаа хийгээд монгол хэл аялгууны онцлог болон нийгмийн хэрэгцээ шаардалгад хэрхэн нийцсэн хийгээд нийцээгүй зэрэг үсэгзүйн ухаанд шууд холбогдох олон асуудлыг бичиг нэг бүрээр авч үзэхийг чармайлаа.

ӨВӨГ МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧГИЙН АСУУДАЛД

Монгол туургатны өвөг дээдэс нарын хэрэглэж байсан боловч он цагийн саалт, судлагдахууны олдоц, мөн судлагч хүний бэлтгэл боловсрол, эс бөгөөс монголчуудын хувьд улс төр үзэл суртлын шалтгаан зэргээс болж судлагаанд бараг өртөөгүй буюу харьцангуй бага анхаарсан үсэг бичгийн талаар авч үзэлгүй өнгөрвөөс монгол бичиг үсгийн судлагаа ямар ч атугай дутуу дулимаг болох нь мэдээж бөлгөө.

Үүнд, юуны өмнө хүн(нү), ухуан, сянби, тоба, жүжан зэрэг монгол аймаг угсаатны бичиг үсгийн асуудал холбогдоно. Түүхийн баримт сэлтэд дулдуйдан, нарийвчлаж яргуулан үзвэл дээр дурдсан аймаг улс нь Хятан нарын "Их" болоод "Бага" бичгээ зохион хэрэглэх болтол цөмөөрөө нэгэн ойролцоо бичигтэй байсан бололтой гэдэг нэгэн улбаагаар холбогддог билээ.

Хүн(нү) нар бичигтэй байсан эсэх талаар их төлөв үгүйсгэсэн санал ноёрхсоор ирсэн боловч сүүлийн тавиад жилээс түүхэн тэмдэглэл хийгээд эртний судлалын олдвор зэрэгт тулгуурлаж Хүн(нү) нар өөрийн гэсэн бичигтэй байсан гэж үзэх явдал улам бүр үнэмшилтэй болж, энэ нь ч бодтой баримт сэлтээр нутлагдсаар байна. Энэ талаар арай дэлгэрүүлэн ярьсу.

Сы Ма-цианы "Түүхэн тэмдэглэл"-д "...Хүн(нү) нар бичиггүй. Цааз хуулийн зүйлийг амаар тархаамуй..." гэж тэмдэглэсэн нь буй¹. Үүнд үндэслэж Хүн(нү) нар бичиг үсэггүй байсан гэдэг үзлийг батлах гэхдээ "...Хан улсаас очсон Жүнг Шинг Йүвэй гэдэг хятад бичгийн багш тэдэнд бичиг зааж байв..."² гэдэг мэдээнээс үүдэж Хүн(нү) нар хятад бичиг хэрэглэж байсан гэдэг үзэл ч буй болжээ. Гэтэл хятад бичиг хэрэглэж байсан бөгөөс хятадын он дарааллын бичгүүдэд үүнийг яагаад тэмдэглэсэнгүй вэ? гэдэг нь бас л эргэлзээ төрүүлнэ. Ер нь хөрш зэргэлдээ улс орныхоо хэл, бичгийг сурах судлах, үүндээ тэр улсынхи нь багшийг урьж заалгах ёсон аль ч үед боломжийн доторхи хэрэг бөлгөө.

"Түүхэн тэмдэглэл"-д Христусын тооллын өмнөхи 192 онд Хүн(нү)-гийн их хаан Моодун шан-юй Нангиадын Хан улсын хатан хаан Гао-хэү-д бичсэн захидлын хятад орчуулгыг хавсаргасан нь буй³. Бас Христусын тоололын 46-47 оны үеийн мэдээнд Хүн(нү) улс нутаг дэсгэрийнхээ газрын зурагтай байсан тухай баримт гардаг бөгөөд үүнд: эзэн хааны ширээнд санаа орхиод их ор сууж чадаагүйдээ хорссон Би гэгч түшмэл хэдэн жил дараалан их ган гачиг болж царцаа ихдэж улс даяар зовлон зүдгүүр хэтийдсэнийг ашиглаж Хүн(нү) улсын газрын зургийг хулууж нууцаар Хан улсад өгч Хүн(нү) улсын хүчийг сарниулсан тухай тодорхой баримт гардаг билээ⁴. Мөн Хүн(нү) улс өмнөд хөрштэйгээ нэг бус удаа гэрээ хэлэлцээр хийж байсан тухай мэдээг бид мэднэ. Энэ бүхэнд ямар нэгэн бичиг шаардагдах нь тодорхой боловч чухам ямар бичиг хэрэглэж байсан бэ? гэдэг асуулт аяндаа гарч ирэх нь мэдээж.

¹ Н.Я. Бичурин (Иакинф), *Собрание сведений о народах, обитавших в средней Азии в древние времена*, Том. 1, Москва-Ленинград, стр. 40.

² Rinchenyava, *Mong'ol bičig-ün soyul-un teüke-yin tursily-a-yin tegüke*, Köke qota, 1990, 3-4.

³ Н.Я. Бичурин (Иакинф), *Собрание сведений о народах, обитавших в средней Азии в древние времена*, Том. 1, Москва-Ленинград, стр. 55.

⁴ Мөн тэнд, стр. 117.

Үүний хариултыг мөн л түүхийн бусад баримтаас хайхын зэргэцээ Хүн(нү) нар бичиг үсэггүй байсан гэдэг мэдээг сайтар эргэцүүлэн үзэх нь зохилтой гэж бодож байна. Энэ талаар ч монголын болоод гадаадын судлагчид онцлон тэмдэглэсэн зүйл буй. Үүнд: тэр цагийн Хан үндэстний бодолгын улмаас хятадын "ханз"-аас бусад үсэг бичгийг бичиг хэмээн тоон үздэггүй байсан тул үгүйсгэдэг байлаа гэж олон судлагчид тэмдэглэсэн нь буй⁵. Тийм учраас хятадын түүхэн дэхи бичиг үсгийн холбогдолтой мэдээг орчуулгаар бус жинхэнэ эхээр нь нягтлаж чухам ямар ханзаар тэмдэглэснийг харгалзан үзэх шаардалга аргагүй гарна.

Учир нь, хятадын түүхэн тэмдэглэлийн зүйлд бусад улс үндэстэнд бичиг үсэг байхгүй гэж үгүйсгэсэн тохиолдолд "үсэг бичиг" гэдэг үгийг гол төлөв *wen zi* (文字) буюу "нангиад бичиг" гэсэн утга бүхий ханзаар тэмдэглэсэн байдаг ажээ. Ийм жишээ Хүн(нү) нараас гадна ухуан, сянби, тэр ч битгий хэл, нийт даяар бичиг үсэгтэйгий нь хүлээн зөвшөөрдөгөөр барахгүй, бичгийн дурсгал хоцрол нь бидний үед өдий төдийгөөрөө уларин ирсэн эртий түрэг зэрэг улс үндэстний тухайд ч "бичиг үсэггүй" гэхдээ уг ханзыг хэрэглэсэн байдаг ажгуу. Ийм ч учраас судлагчид дээр дурдсан "бичиггүй" гэсэн үгийн ард "хятадын ойлголтоор"⁶ гэх буюу "хятадаар вынь цзы гэдэг нь зөвхөн хятад бичгийг хэлдэг..."⁷ гэж тусхай тэмдэглэл үйлдсэн байдагийг анхааралгүй орхих аргагүй юм.

Монголчуудын эртний өвөг - Ухуан нарын үсэг бичгийн талаар "Хожуу Хан улсын түүх"-энд тэмдэглэгдсэн нэгэн мэдээг Н.Я. Бичурины орчуулгаар эшлэвэл: "... Ахлагч нь хүн дуудах болвол мод сийлж тэмдэглэдэг бөгөөд хэдийгээр түүн дээр үсэг бичиг байхгүй боловч түүнийг зүрхлэж зөрчих хүмүн нэгээхэн-бээр үгүй..."⁸ гэсэн байдаг. Эл мэдээг В.С. Таскин орчуулахдаа: "...Ахлагч нар нь хэн нэгнийг дуудах болохул модон дээр хэрчлээ гаргана. Тэр хэрчлээ нь үсэг бичгийн үүрэг гүйцэтгэхгүй. Хэдийгээр бичгийн тэмдэгт үгүй боловч тэдний дотор тэрхүү зар тушаалыг зөрчиж зүрхлэх хүн байхгүй..."⁹ гэжээ.

"Сүй шү" хэмээх түүхнээ Сянби хэлээр гарсан 13 номын нэрийг жагсаасан баримт бидний үед хүрч иржээ¹⁰. Үүнд: тэрхүү 13 ном ямар үсгээр байсан бэ? гэдэг асуулт гарах нь мэдээж!

Энэ мэтчилэнгээр хятадын түүхийн хэд хэдэн ном бичигт "...тэд нар бичиг байхгүй. Мод сийлж (刻木 Ke-mu) тэмдэглэл үйлэдмүй..." гэсэн зүйлийг хүн(нү) нараас эхлээд эртний түрэг, мөн хятан нарт нэгэн адил хамааруулсан байдаг тухай доктор Г. Сүхбаатар тэмдэглээд¹¹ "Жоу ши"-гийн 99-р бөлөгт эртний түрэг нарын тухайд "...мод сийлдэг... Бичиг байхгүй" гэсэн атлаа нэлээд хэдэн хуудасны дараа "...тэдний бичиг (書字 shu-zi) нь Ху нарынхитай төстэй..." гэснийг гярхай ажиглажээ¹².

Энэ бүхнээс үзвэл *Shu zi* гэдэг ханзыг *Wen zi* гэдгээс эрс ялган хэрэглэж байсан баримт бүр тодорхой харагдана. Дээр өгүүлсэн зүйлээс ямар дүгнэлт гарч байна вэ? гэвэл нэгд, *ke-mu* буюу мод сийлэх бичгийг хэдийгээр тэр цагийн хятадын ойлголтоор бичиг гэж үздэггүй байсан боловч тодорхой мэдээлэл дамжуулах чадал бүхий өвөрмиц тогтолцоотой

⁵ Г. Сүхбаатар, *Сянби, Улаанбаатар, 1971, 106; А. Дамдинсүрэн, Археологийн шинжилгээгээр олдсон хуннугийн бичгийн дурсгал*, - Монголын эртний түүх-соёлын зарим асуудал, Улаанбаатар, 1972, 100.

⁶ G.Schreiber, *Das volk der Hsien-pi zur Han zeit*, - Monumenta Serica, Journal of Oriental Studies of Catholic University of Peking, Tom. XII, Peking, 1947, p. 106.

⁷ Н.Я. Бичурин (Иакинф), *Собрание сведений о народах, обитавших в средней Азии в древние времена*, Том. 1, Москва-Ленинград, стр. 229.

⁸ Мөн тэнд, 142-143.

⁹ В.С. Таскин, *Материалы по истории древних кочевых народов группы Дунху*, Москва, 1984, стр. 63.

¹⁰ L. Ligeti, *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*, -Mongolian Studies, Budapest, 1970, pp. 279-280

¹¹ Г. Сүхбаатар, *Сянби, Улаанбаатар, 1971, 105-118.*

¹² Мөн тэнд, 107.

бичиг мөн байжээ; хоёрт. эртний түрэг бичиг нь Ху нарынхитай төстэй байсан гэдэг баримтаас үүдүүлэн тэрхүү мод сийлэн бичдэг *Ke-tu* хэмээх бичигийн хэлбэр нь рүн маягийн тамга бичиг байжээ гэдэг дүгнэлтийг хийж болно.

Ke-tu гэдэг нь мод сийлж хэрчлээ гарган тэмдэглэдэг бичиг мөн байх гэж А.Лувсандэндэв доктор үзсэн¹³ байхад доктор Н.Сэр-оджав уг бичгийн тогтолцоо улам нарийсан боловсорсоор түрэг бичгийн эх болсон бололтой¹⁴ гэж гэдэг таамаглалаа дэвшүүлжээ.

Ер нь яргуулан бодохул хүн төрөлхитөний хөгжлийн эхний шатанд гарын дор давын өмнө элбэг олдох бичгийн зүйл нь мод, чулуу, яс, арьс тэргүүтэн бөгөөд тэдгээр дээр хамгийн хялбархан тэмдэглэж болох бичгийн хэлбэр нь эртний нангиад түүхнээ *Ke-tu* гэж нэрлэсээр ирсэн шулуун маягийн хэрчлээс болох нь маргаангүй буй заа. Тэгээд ч эрт цагаас Ази, Европ дахины олон газар нийтлэг тархан хөгжсөн нэгэн зүйл үсэг "рүн" хэмээх бичиг байжээ гэж хэлэх бүрэн үндэс буй. Ийм "рүн" маягийн нэлээд хэдэн дүрс Саран дээрээс олдсон тухай хэвлэлд дурдсан зүйл байдагийг энэ далимд нэмэн өгүүлсү¹⁵.

Судлагааны ном зохиолоос үзвэл Европын олон бүс нутагт хэрэглэж байсан "рүн" хэмээх тамга бичгийг гол хоёр төрөлд хуваан үздэг ажээ. Үүнд: Скандинав - германы (швед, норвег, дани, германы), Англи - саксоний гэж хуваан үздэг бөгөөд дотроо бас л олон салбарладаг ажгуу. Тэдгээрийн хоцрол дурсгал нь гэхэд мөн л мод чулуун дээр хэрчлээс гаргаж их төлөв онгон шүтэлгэ хийгээд дурсгалын зүйлийг бичсэн байдаг гэнэ. Ийм бичиг анх хэрхин үүссэн талаар хэдэн зүйл маргаантай санал байдаг боловч он цагийн хувьд христусын тооллын эхин үед хамаарна гэж нийтээр хүлээн зөвшөөрдөг байна¹⁶.

Европын "рүн" хэмээх бичиг нь авианы үсэгтэй боловч анх бэлгэдэл, үзэлгийн чанартай үүсч улмаар бичгийн үүрэгтэй болсон үе буй гэж судлагчид үзэж байна. "Рүн" гэдэг нэр нь германаар "*нууц бичиг, далд бичиг*" гэдэг утгаас үүссэн, мөн энэ үг нь иймэрхүү утгаараа скандинавынхений хэлэнд байгаа гэж ном зохиолд тэмдэглэжээ.

Ази дахины, ялангуяа Төв Азийн нүүдэлчдийн дунд өргөн тархаж байсан "рүн" маягийн тамга бичгийн үүслийг нэгэн хэсэгтээ Энэдхэгийн Кхарошти, мөн өмнөд арабын бичиг, зарим хүн германы "рүн"-тэй холбон үздэг байсныг ташаарал гэж хүлээн зөвшөөрцгөөж сүүлийн үеэс түүнийг Арамей гаралтай Согд бичигтэй холбох болсон бөгөөд Европын эрдэмтдийн судлагааны ном зохиолд "Түрэгийн рүн бичиг" гэх буюу бас заримд нь "Сибирийн бичиг" хэмээн нэрлэж ирсэн гэдгийг дурдахад илүүц зүйл болохгүй буй заа¹⁷.

Эртний нангиадын түүхэн тэмдэглэлээс үзэхүл ХТӨ үеэс эхлэн Хүн(нү) нар нангиад түүхнээ их төлөв Кангюй (康居 Kang-ju) гэдэг нэрээр гардаг Согдуудын өвөг дээдэстэй нутаг ус савлаж, ойр харилцаатай байсан тухай баримт цөөн бус буй¹⁸. Ийм болохоор Төв Азийн "рүн" хэмээх бичгийн үүслийг Согд нарын эртний бичигтэй холбон үзэх учир шалтгааны холбоо буй бөлгөө. Төв Азийн "рүн" бичиг нь гадаад хэлбэрийн хувьд Мажарын "рүн"-тэй холбоотой гэж харьцуулсан судлагаа бий¹⁹. Үүнийг Хүн(нү) болон Аваруудын их нүүдэлээр тайлбарлаж болох юм. Тэр ч бүү хэл сүүлийн үеийн судлагаанаас үзэхэд Польшийн нэрт түрэгч профессор Э. Трыарски Төв Азийн "рүн" бичиг нь Европ дахины

¹³ А.Лувсандэндэв, *Монгол бичгийн түүхээс*, - Монгол хэл зохиол түүх, N. 5, Хөх хот, 1959, 41-р тал.

¹⁴ *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх*, Тэргүүн боть, Улаанбаатар, 1966, 130.

¹⁵ *Совершенно секретно* (сонин), Москва, 1993, N. 5.

¹⁶ В. Истрин, *Возникновение и развитие письма*, Москва, 1965, стр. 379-382; Hans Jensen, *Die Schrift*, Berlin, 1969, ss. 540-568; И. Фридрих, *История письма*, Москва, 1979, стр. 141-143.

¹⁷ Hans Jensen, *Die Schrift*, Berlin, 1969, s. 411; И. Фридрих, *История письма*, Москва, 1979, стр. 167-168

¹⁸ Н.Я. Бичурин (Иакинф), *Собрание сведений о народах, обитавших в средней Азии в древние времена*, Том. 1, Москва-Ленинград, стр. 85, 92, 93.

¹⁹ Hans Jensen, *Die Schrift*, Berlin, 1969, ss. 416-420.

"рүн"-тэй гадаад дүрс төдийгүй, цөөн бус тохиолдолд дуудалгын хувьд ч ойр төстэй болохыг ажигласан байдаг²⁰.

Хятадын түүхийн сурвалжид Өвөг монголчуудын бичиг үсгийн талаар үгүйсгэсэн тэмдэглэл байхын сац бас өвөрмөц бичигтэй байсан гэдэг мэдээ арай хожуухан үеэс дайралддаг. Ийм мэдээг үндэслэсэн ном зохиол Манжийн үед гарах болжээ. Тухайлбал Цин улсын түүхч Ван Сян-цян зэрэг түүхчидийн бүтээлд Хүн(нү) нарын бичиг нь хятадынхитай адилгүй гэж тэмдэглэсэнийг энд дурдаж болно²¹.

Мөн "Ганжур", "Данжур"-ыг бүрэнээ монголчлохын бэлтгэл болгож Жанжаа хутагт Ролбийдоржийн удирдалгаар зохиосон "Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даг-йиг"-ийн Дуун ухааны аймагт олон зүйл үсэг бичгийг тоочин жагсаасны дотор төвөдөөр *h'u-na'i yi-ge* гэсэн нэр гардаг нь даруй Хүн(нү) үсэг болой гэж үздэг²². Иймд эртний төвөд сурвалжид буй мэдээг бид анхааралгүй орхих аргагүй бөлгөө.

Тэгвэл Хүн(нү) нар чухам ямар бичиг үсэгтэй байв? Бидний үед хүрч ирсэн дурсгал байна уу? гэдэг асуулт гарч ирнэ.

Энэ асуултын хариутай холбогдол бүхий санал, таамаглал, судлагааны зүйл академич Ринчен профессор, эрдэмтэн Ц. Доржсүрэн, Г. Сүхбаатар, Б. Сумъяабаатар, А. Дамдинсүрэн, францын Е. Блоше (E. Blochet), германы Ф. Алтхайм (B. Franz Altheim), польшийн Э. Трыярски (E. Tryjarski), мажарын Я. Харматта (J. Harmatta), хятадын Ринченгаваа зэрэг олон эрдэмтний бүтээлд аль нэгэн хэмжээгээр тусгалаа олсон гэж хэлж болно.

"БНМАУ-ын түүх"-ийн тэргүүн ботид Хүн(нү) нарын үед холбогдох дурсгалын зүйлээс давхардуулалгүй тоолоход 14 янзын тамга үсэг олдсоныг дурдаад үүний нэлээд нь харьцангуй хожуу үед хамааруулан үздэг Орхоны түрэг бичигтэй тохирдог хэмээн тэмдэглэжээ²³. Энэ 14 үсгийн үүх түүхийг хөөн үзвэл 1961 онд манай ахмад түүхч Ц.Доржсүрэнгийн "Умард хүннү" хэмээх зохиолдоо түрүү үеийн эрдэмтэн С.В.Киселев, П.К. Козлов, Х. Пэрлээ нарын удирдсан шинжээний ангийн олж илрүүлсэн Хүн(нү)гийн үед шууд холбогдох эд өлөгийн зүйл дээрээс олдсон тамга үсгийг нэгтгэн авч үзсэн хэрэглэгдэхүүн бөлгөө²⁴.

1966 онд академич Ринчен Фин-Угорын нийгэмлигийн сэтгүүлд хэвлүүлсэн "Цагаан голын хадны зураг" гэдэг өгүүлэлдээ Говь-алтайн Цагаан голын хадан дээрхи Хүн(нү)-гийн үед холбогдох тамгын зүйл хийгээд 8 янзын үсгийн зургийг хавсаргаж үе үеэр бичдэг энэхүү авианы үсэг нь Орхон-Енисей (буюу Горлог)-н түрэгчүүдийн "рүн" бичигтэй төстэйг тэмдэглэсэн байдаг²⁵.

Төв Азийн нүүдэлчин Дүнхү, Хүн(нү) нарын оршин нутаглаж байсан Чэндэ хавиас олдсон бөгөөд түүхийн зохиолд "Хүннү хутга" гэж нэрлэж заншсан олдворын зүйл дээрээс бас 40-өөд тамга үсгийн дурсгал гарсныг эрдэмтэн А. Дамдинсүрэн судлаж үзээд мөн л эртний түрэг бичигтэй хэлбэр дүрсийн хувьд үндсэндээ тохирч байгааг дурджээ²⁶.

²⁰ Edward Tryjarski, *Altes und Neues zur Entstehung der turkischen Runenschrift*, - Rocznik Orientalistyczny, Tom. XLX, z. 1, Warszawa, 1985, ss. 59-80.

²¹ А. Дамдинсүрэн, *Археологийн шинжилгээгээр олдсон хүннүгийн бичгийн дурсгал*, - Монголын эртний түүх соёлын зарим асуудал, Улаанбаатар, 1972, 100.

²² Rinchenyava, *Mongᡥol bičig-ün soyul-un teüke-yin tursily-a-yin tegüke*, Köke qota, 1990, 4.

²³ БНМАУ-ын түүх, тэргүүн боть, Улаанбаатар, 1966, 95-р тал.

²⁴ Ц. Доржсүрэн, *Умард хүннү*, Улаанбаатар, 1961, 104-105.

²⁵ Rinchen, *The petroglyphs of Tsagan gol*, - Journal de la Societe Finno-Ougrienne, 68, Helsinki, 1966, pp. 66-67.

²⁶ А. Дамдинсүрэн, *Археологийн шинжилгээгээр олдсон хүннүгийн бичгийн дурсгал*, - Монголын эртний түүх-соёлын зарим асуудал, Улаанбаатар, 1972, 99-111.

Бас нэгэн зүйл, он цагийн хувьд Хүн(нү)-гийн үед хамаарах бөгөөд судлагааны зохиол бүтээлд "Алтан хүн" хэмээн нэрлэгдэх болсон, 1983 онд Булган аймгийн Бүрэгхангай сумын Өвгөнт гэдэг газраас олдсон дүгриг хэлбэртэй цул алтан олдвор дээрхи тамга үсгийн бичээсийг судласан дүнгээс үзвэл доктор Б. Сумъяабаатар уг дурсгалын хэлийг хүн(нү) нарын хэл мөн, бичгийн тухайд финикээс гаралтай авианы бичиг бөгөөд хүн(нү) нарын хэрэглэж байсан үсэг бичиг гэж олон баримтаар дэлгэрэнгүй нутлажээ²⁷ (Уг дурсгалыг хэрхэн тэнхрүүлэн уншсаныг нь энэ бөлөгийн эцэст авч үзнэ).

Мөн Жүжан буюу Нирун нарын холбоонд багтаж байсан Аваруудын Европод үлдээсэн үсэг бичгийн дурсгал бидний судлагдахуунд зохих шинэ баримт болж өгнө гэж найдаж байна. Аваруудын гарлын талаар зөрөөтэй саналууд байдаг бөгөөд нэгэн хэсэгтээ түрэг гаралтай гэж үздэг явдал зонхилож байсан нь нэг талаас 1940-өөд оноос Зөвлөлтийн түрэг судлал монголын судлалтай харьцуулахад түлхүү хөгжиж байсантай, нөгөө талаас улс төржсөн бодолготой холбоотой гэж хэлж болно. Үүнээс үүдэж монголын судлалын олон асуудлыг түрэг судлалын цонхоор харах явдал илэрхий давамгайлж байсныг ч бид мэдэх билээ. Тэгээд ч сүүлийн үеийн судлагааны үр дүн Аварууд бүхэлдээ түрэг хэлтэн байсан гэдэг үзлийг дэлхийн хэмжээгээр эргэлзүүлэхэд хүрсэн бөлгөө.

Христусын тоололын III-IV зууны үест Европ рүү нүүдэллэн очсон Аваруудын хэлний эртний дурсгал хийгээд эдийн боловсролын талаар хийсэн судлагаа шинжилгээний бүтээлийг үзэхэд тэд нар монгол язгуур гаралтай гэж хэлэх бүрэн боломж байдаг. Францын нэрт монголч, нангиадач эрдэмтэн П. Пеллио Аваруудын хэлийг монгол хэлэнд хамааруулан үздэг байлаа²⁸. Олон улс нийтээр сүүлийн үед гарсан судлагааны үр дүнг нэгтгэсэн европ зүгийн олон нэвтэрхий тольд Аваруудыг "...Жүжаны холбоонд багтаж байсан эртний монгол аймгийн нэг..."²⁹ гэж тодорхойлсон байдаг.

Аваруудын хэлний дурсгал сэлтийг үзэхэд монголжуу болох нь тодорхой харагддаг. Үүнд: Авар хэлний дурсгалд *qaγan*, *qatun*, *tarqan*, *tudun* гэх мэтийн зэрэг дэвийн нэр, *Bayan*, *Kok*, *Solaq* гэх зэрэг хүний нэр байдагийг академич Г. Немет нарын судлагаанаас үзэж болно³⁰. Үүнээс уламлаж *tudun* гэдэг үгийн талаар нэгэн санааг нэмж хэлсү. Энэ үг "Монголын нууц товчоон"-ы 45-р зүйлд гардаг *Menen tudun* гэдэгтэй холбоотой болов уу гэж санагддаг. Бас Рашид Ад-дины "Сударын чуулган" болон Монголын түүхтэй холбогдол бүхий Дундад Азийн араб, перс сурвалжуудад³¹ *Tudun menen* гэдэг хэлбэрээр тэмдэглэгдсэн нь буй. Иймд *tudun* гэдэг зэрэг дэвийн нэрийн учир холбогдлыг мөшгин хайна гэвэл түүхч Г. Сүхбаатарын нэрлэсэн Нирун монгол хэл хийгээд Аваруудын хэлний хэрэглэгдэхүүнийг зайлашгүй харгалзах шаардалгатай болно гэж сананам.

Мөн Мажарын Яношидын Аваруудын бичгийн дурсгалд монгол хэлний *bol-* гэдгийг *bol-*, *egeči* гэдгийг *ice*, *ki-* гэдгийг *qil-*, тэнгэр гэдгийг *(t)anri*, оёж шидэх гэсэн утга бүхий *side-* гэдгийг *yed-* гэдэг байсан тухай Унгарын ШУА-ийн жинхэнэ гишүүн Янош Харматта авгай "Аваруудын хэлний асуудалд" гэдэг өгүүлэлдээ тэмдэглэсэн нь буй³².

Я. Харматта академич энэ бүтээлдээ Мажар нутаг дахи Аваруудын үеийн Яношидын булшнаас гарсан, гурван талдаа рүн бичиг бүхий, модоор үйлдсэн зүүний сав дээрхи бичээс болон авар хэл, бичгийн талаар бичсэн И. Вазари (I. Vászary), Г. Ласло (Gy. László), Д. Шалани (D. Csallány) нарын бүтээлийг харьцуулан судлаад тэрхүү зүүний сав

²⁷ Д. Наваан, Б. Сумъяабаатар, Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал, Улаанбаатар, 1987.

²⁸ J. Harmatta, *De la question concernant la langue des Avars*, Ankara, 1988, p. 4.

²⁹ *Petit Robert 2*, Dictionnaire universel des noms propres, Paris, 1982, p. 142.

³⁰ J. Harmatta, *De la question concernant la langue des Avars*, Ankara, 1988, p. 18-19.

³¹ Emel Esin, *Hanlar Ulaki (The Succssion of Kings)*, - Gedanke und Wirkung, Festschrift zum 90. Geburtstag von Nicolas Poppe von W. Heissig und K. Sagaster, AF, band 108, Wiesbaden, 1989, p. 119; Ц. Шагдарсүрэн, Монголчуудын удамын судар буюу гэрийн үеийн бичмэл,- Ил товчоон, 1997. 2-р сар, N. 5 (228), 6-7-р нүүр.

³² J. Harmatta, *De la question concernant la langue des Avars*, Ankara, 1988, p. 18-19.

дээр сийлсэн 18 рүн үсгийн хэлбэр нь Орхон, Енисейн түрэг бичиг хийгээд бусад дурсгалд байгааг олж тогтоожээ (*1-р хавсралтыг үзмүү*).

Үүнээс гадна профессор И. Вазари(I.Vásáry)-ийн судлагаанд Мажарын нутаг дэвсгэр дэх Аваруудын булш бунханаас олдсон зүүний хайрцаг, домбо, аяганы суурь, ээрүүлийн дугуй зэрэг арван эд зүйл дээрхи рүн бичээс хамрагдсан байдаг³³.

Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд, хүн(нү) нарын бичиг үсгийн асуудал нь (түрүүчийн нийгмийн тогтолцооны үед) зарим нэгэн хүний үздэг байсанчлан зөвхөн монголчууд л үндэс угсаагаа бодсоны улмаас буюу сэтгэлийн хоосон хөөрлөөр гарган тавьж байгаа зүйл огт биш. Тэр мэтийн хүмүүсийн олж үзэх, ойлгож чадахгүй судлагааны бүтээлүүдэд XIX зууны сүүл үеэс өдгөө хүртэл өдий төдий санал дүгнэлт гарсаныг үгүйсгэх аргагүй. Үүнд: нэрт түрэгч Е. Блоше, Ф. Алтхайм, Э.Трыарски нарын олон эрдэмтэн эртний түрэгийн "рүн" бичгийн гарлыг хүн(нү) нарын үсэг бичигтэй холбож үзсээр ирсэн нь ер нэгэн тохиолдлын буюу "монгол хүний сэтгэл хөдлөл" хэмээн үзэх аргагүй. Заримаас нь эшлэл татсу. 1898 онд Е. Блоше Парист гардаг "Эртний судлалын сэтгүүл"-д нийтлүүлсэн "Орхоны түрэг бичээс" гэдэг өгүүлэлдээ:

"...Орхоны түрэгүүдийн бичгийг хүннү буюу хүн нарын бичгээс дам салбарласан гэж үзвэл хүннү нарын анхдагч бичиг буюу өөрөөр хэлбэл түүн дээр түрэгүүдийн нэмж оруулсан тэмдэгтүүдийг хасчихлаа гэхэд тэр бичиг нь арамей гаралтай болохын батлагаа хангалттай буй..."

хэмээн онцлон тэмдэглэжээ³⁴.

Түүний энэ саналыг дэмжин тэжээж лавшруулсан судлагаа европ дахинд цөөнгүй гарчээ. Жишээлбэл: Хүн(нү)-гийн түүхийн судлалд нэр гарсан Ф. Алтхайм IX зуун хүртэл Болгарт хэрэглэж байсан бичгийг хүн(нү) нар Азиас аваачсан байна гэж тэмдэглээд бас Хүн(нү) нар бичиг үсгээс гадна өөрчлөлт шинэчлэлтийн олон зүйлийг Европ дахинд хүргэсэн гэж дүгнэсэн нь буй³⁵.

Харамсалтай нь бид нийгэм улс төрийн хязгаарлагдмал нөхцөлд дээр эш татсан судлагааны зохиол бүтээлийн үр дүнг эх түүх, сургалт, амьдрал ахуйдаа авч хэрэглэсэн нь үгүй бөлгөө.

Энэ бүхэнтэй холбон хэлэхэд "БНМАУ-ын түүх"-ийн нэмж зассан гуравдахи хэвлэлд: "...Жүжан нар өвөг орхон бичгийн загвар бүхий бичиг үсэг хэрэглэж байжээ гэж үзэх бүрэн үндэс байна..." гэсэн атлаа хэдхэн хуудасны дараа "Түрэгчүүд бусад нүүдэлчдээс эн тэргүүнд соёлын салбарт олсон амжилт нь авиа тэмдэглэх бичигтэй болсон явдал юм..."³⁶ гэсэн зөрөөтэй дүгнэлтийг ч эргэж нягтлууштай санагддаг бөлгөө.

"Рүн" хэмээх тамга бичиг анх хэрхин буй болсон талаар нийт судлагчид санал нэгдээгүй боловч энэ хир ерөнхийд нь гурав ангилаж болно. Үүнд:

1. тухайн нутаг усныхины бичиг үсэг буюу уугуул бичиг;
2. бусад улс аймгаас авсан буюу авмал бичиг;
3. уугуул болон авмал бичгийн дундаас буй болсон бичиг

³³ I. Vásáry, *Runiform signs on objects of the Avar Period* (6th-8th CC. A.D.) - AOH, Tomus XXV, Fasc. 1-3, Budapest, 1972, pp. 335-347.

³⁴ E. Blochet, *Les inscriptions turques de l'Orkhon*, - Revue Archeologique, Troisieme serie, XXXII, mai-juin 1898, Paris, p. 381.

³⁵ B. Franz Altheim, *Hunnische Runen*, Halle, 1948, s. 22; Cf. Edward Tryjarski, *Altes und Neues zur Entstehung der turkischen Runenschrift*, - Rocznik Orientalistyczny, Tom. XLX, z. 1, Warszawa, 1985, s. 69.

³⁶ *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх*, Улаанбаатар, 1984, 123, 128-р тал.

гэж санал хуваагддаг ажээ³⁷. Бидний бодоход дээрхи гурван саналын аль нэг нь зөв, бусад нь ташаарал гэж үзэх аргагүй бөгөөд эрт язур цагаас Төв Ази даяар нүүдэлчдийн хэрэглэж байсан тамга маягийн "рүн" бичиг болоод Европ дахинд хэрэглэж байсан бүх "рүн" бичгийн зүйлийг хэрхэн үүссэн талаар нэг янзын тайлбар байж болохгүй нь мэдээж билээ.

Академич Янош Харматта Аварын үеэс эхлэн Дорнод Европод байсан рүн бичээсийн дурсгалыг судлаж Орхон, Енисей (буюу Горлог мөрөн)-н болоод Тонъюкүкийн хөшөөний хэл, бичигтэй харьцуулан судласан "*Дорнод Европ дахи түрээгийн рүн бичээс*" гэдэг томоохон өгүүлэлдээ зүүн европын 11 газраас олдсон түрэг бичээсийн 33 янзын тэмдэгтэд үсэгзүйн харьцуулсан судлагаа хийж цөмд нь дүйх хэлбэрийг Төв Азийн дурдсан дурсгалуудаас олж чадсан байна³⁸.

Рүн бичгийн гарлын талаар харьцангуй сүүл үеийн судлагаануудаас үзвэл уул бичгийг эртний Согд нарын бичигтэй холбоотой болохын батлагаа улам бүр лавширсаар байна. Энэ талаар В.А.Лившиц³⁹, Э. Трыарски (E. Tryjarski)⁴⁰, Г. Клоузон (Gerhard Clauson)⁴¹, А. Рона-Таш (A. Rona-Tas)⁴², Е. Хоудхауген (Even Haudhaugen)⁴³ нарын судлагаа ямар нэгэн хэмжээгээр онцгой сонирхол татсаар бөлгөө.

Дээр дурдсан бүх зүйлээс ямар таамаглал, дүгнэлт гарч болох вэ? гэвэл доорхи хэдэн зүйлийг хэлж болно. Үүнд:

1. Хүн(нү) нар төр улсаа байгуулсан цагт ямар ч атугай бичигтэй байсан бөгөөд тэр нь тухайн үедээ Төв Азийн нүүдэлчдийн дунд нийтлэг хэрэглэгдэж байсан тамга маягийн бичиг байсан бололтой.

2. Түүхэн нөхцөл байдлаас үүдэн ХТӨ I зуунд Хүн(нү) нар, ХТ-ын VI зууны үед Аварууд алс баруун зүг рүү их нүүдэл хийхдээ аль аль нь бичиг үсэгтэй байжээ.

3. Төв Азийн нүүдэлчдийн хэрэглэж байсан бичиг нь Согдуудын эртний өвөг дээдсийн бичгийн нөлөө тусхалыг авсан байж бүрэн болох бөгөөд цаг хугацааны хувьд ХТӨ II - I зуунаас яавч наашгүй гэж үзэх үндэс буй.

4. Хүн(нү) нарын хэрэглэж байсан тамга бичгийг эртний Түрэгүүд уламжлан авч өөрийнхөө хэлд нийцүүлэн нарийсган боловсруулсан буй заа.

5. Тамга маягийн бичиг нь хүн төрөлхитөний хөгжлийн үлэмжхэн түрүү шатанд, мод, чулуу тэргүүтэн дээр бичиж тэмдэглэхэд тохирсон шулуундуу зураас маягийн хялбархан дүрстэй үүсч Ази, Европод нийтлэг хэрэглэгдсээр ХТ-ын IX зууныг хүргэжээ.

Дээрхи дүгнэлтийг хэрхэн батлаж байна вэ? гэдэг асуулт аяндаа гарах нь мэдээж тул дээр өгүүлсэн зүйлүүдээс гадна ХТ-ын II зуунаас аваад Төв Азийн нүүдэлч иргэд, ялангуяа монголчуудын дээд өвөг болох Хүн(нү), Сянби хийгээд тэдний дотроос дайжиж

³⁷ Edward Tryjarski, *Altes und Neues zur Entstehung der turkischen Runenschrift*, - Rocznik Orientalistyczny, Tom. XLX, z. 1, Warszawa, 1985, s. 59.

³⁸ Janos Harmatta, *Inscriptions runiques turques en Europe orientale*, Ankara, 1988, pp. 47-48.

³⁹ В.А. Лившиц, *О происхождении древнетюркской рунической письменности*, - Советская тюркология, 1978, 4, Москва, стр. 84-98.

⁴⁰ Edward Tryjarski, *Altes und Neues zur Entstehung der turkischen Runenschrift*, - Rocznik Orientalistyczny, Tom. XLX, z. 1, Warszawa, 1985, ss. 59-80; Edward Tryjarski, *Anonymity, Adaptation and Diffusion of the Asian and European Runic Scripts*, - Turk Dili Arastirmalari Yilligi (Yearbook of Turkic Studies), Belletin 1993, Ankara, 1995, pp. 35-42.

⁴¹ Gerhard Clauson, *The Origin of the Turkish "Runic" Alphabet*, - Acta Orientalia, T. XXXII, Munksgaard, Copenhagen, 1970, pp. 51-76.

⁴² A. Rona-Tas, *On the Development and Origin of the East Turkic "Runic" Script*, - Acta Orientalia Hung., T. XLI, Budapest, 1987, pp. 7-14.

⁴³ Even Haudhaugen (Oslo), *The Structure and Origin of the Turkish Runic Alphabet*, - I. Milletlerarasi Turkoloji Kongresi ... pp. 470-478.

өрнө зүг рүү нүүдэллэн одсон Хүн(нү) хийгээд Аварчууд чухам ямар үсэг бичигтэй байв? Хүн(нү) нарын тамга үсэгийг эртний түрэг аймгууд уламжлан авсан гэхүл тэрхүү тамга үсэг хийгээд эртний түрэгийн "рүн" гээд байгаа бичгийн хэлбэр, дуудалгын хувьд адил төсөө буй эсэхийг харьцуулалгүй орхих аргагүй юм.

Иймд олон эрдэмтний бүтээлд дулдуйдаж Хүн(нү) нарт холбогдох дурсгал, эд өлөг тэргүүтэн дээрээс олж цуглуулсан тамга үсэг, мөн мажарын Яношидын Авар нарын булш бунханаас олдсон зүүны хайрцаг дээрхи бичээс зэргийг түрэгийн үеийн орхон, енисейн бичгийн хэлбэр, дуудалгатай харьцуулсан хүснэгтээ ард хавсаргав. Ийнхүү харьцуулахдаа юуны өмнө хэлбэр дүрсэд шүтсэн гэдгээ хэлэх хэрэгтэй. Эл хүснэгтэд багтсан 60 гаруй үсгийн тэмдэгт нь өнөөдрийн олдоцын хир хэмжээ болохоос биш уг бичгийн бүхий л үсгийг гүйцэд хамарсан хэмээсэн үг огт бус. Бас энэхүү харьцуулсан хүснэгт нь "рүн" бичгийн судлагааг үсгийн гадаад хэлбэр хийгээд дуудалгын хувьд ац хагалаж шийдсэн эцсийн хувилбар биш гэдгийг нуршин тайлбарлах хэрэггүй буй заа.

"Орхон", "Енисей" (буюу Горлог мөрөн), болон "Талас" (гол)-ын дурсгалын хувьд, түрүү түрүү үеийн судлагааг нэгтгэн авч үзсэн *"Древнетюркский словарь"* (Ленинград, 1969) болон эртний түрэг бичгийн үсэг тус бүрийг бараг бүх хувилбараар нь жагсаасан Г. Айдаровын *"Язык орхонских памятников древнетюркской письменности VIII века"* (Алма-Ата, 1971) гэдэг хоёр номд орсон цагаан толгойг үндэс болгосон бөлгөө. (2-р хавсралтыг үзмүү!)

Жич: Доктор Б.Сумъяабаатар 2-р хавсралтын V баганад буй долоон тэмдэгтийг холбогдох бусад хэрэглэгдэхүүнтэй харьцуулж доорхи байдлаар тэнхрүүлэн уншсан нь VI баганад хадсан дуудалгатай зөрдөг болохыг анхаармуу.

Д. Наваан, Б. Сумъяабаатар, *Өвөг монгол хэл бичгийн чухаг дурсгал*, Улаанбаатар, 1987 номдоо тэмдэглэсэн нь:

1. V. * - u (ui, yui) / ü (üi, yüi)
2. V. * - n
3. V. * - k (g, γ)
4. V. * - q/k, s/š
5. V. * - m (b)
6. V. * - (ä)
7. V. * - t (d)



Булганаас олдсон "Алтан хүн"-ий зураг

Аваруудын булшнаас олдсон "рүн" үсгийн харьцуулсан хүснэгт
(Янош Харматта академичийнхиар)

I. Дуудалгын галиг;

III. Зүүний савын 3-р талд буй үсэг;

II. Зүүний савын 2-р талд буй үсэг;

IV. Зүүний савын 4-р талд буй үсэг;

V. Түрэгийн "рүн" бичиг дэхи дүйх үсэг:

Ye. - Енисейн бичиг,

O. - Орхоны бичиг,

K. - Бусад дурсгал.

Nº	I	II	III	IV	Y
I	a			Σ	Ye: Z J
2	e		ᠡ		Ye: ᠡ
3	2y	ᠢ			Ye: ᠢ
4	I _b		ᠣ		Ye: ᠣ
5	2b			ᠨ	Ye: ᠨ
6	ic		ᠥ		Ye: ᠥ
7	I _d			33	Ye: 33
8	2d	x			Ye: x
9	I _γ		ᠦ		Ye: ᠦ
10	2g	ᠬ		ᠬ	Ye: ᠬ
II	kū	ᠮ			O: ᠮ
12	I _l		ᠯ	ᠯ	Ye: ᠯ
13	°ᠣ	ᠣ		ᠣ	Ye: ᠣ
14	°ᠣc			ᠣ	Ye: ᠣ
15	i _q	ᠠ	ᠠ	ᠠ	Ye: ᠠ
16	2r			ᠷ	K: ᠷ
17	2t			ᠬ	Ye: ᠬ
18	°z	ᠵ			Ye: ᠵ

Хүн(нү)-гийн тамга үсэгтэй харьцуулсан жагсаалт

I. 1960 хэдэн оны дундуур гэхэд олдсон хүн(нү)-гийн тамга үсэг;

II. Чэндэ хавиас олдсон "хүн(нү) хутга" дээрхи үсэг;

III. Цагаан голын бичээс дэхи үсэг:

а. Ц. Доржсүрэнгийн тэмдэглэсэн нь,

b. Академич Ринчений тэмдэглэсэн нь;

IV. Б. Сумъяабаатарын сэргээсэн "Алтан хүн" дээрхи үсэг;

V. Аварын үеийн булшны олдвор дээрхи үсэг;

VI. Орхон, Енисейн бичиг дэхи дүйх хэлбэр:

DTS - Древнетюркский словарь (Ленинград, 1969).

Ai - Г. Айдаров, "Язык Орхонских ..." (Алма-Ата, 1971).

N°	I	II	III		IV	V		VI	
			a	b		a	b	a	b
1	У			У	*У	У	l	У	l (DTS 25)
2	М	М М						М	lt (Ai 16)
3	Д							Д	j (DTS 22)
4	✓				*Z	Σ	a	✓	a/ä (DTS I,3)
5	С	У						С	s (DTS 36)
6	Р		Р	Р					
7	Х					Х	b	Х	b (DTS 5)
8	А								
9	Л		Л	Л					
10	Г		Г	Г		Г	γ	Г	r (DTS 35)
11	Д							Д	r' (Ai 28)
12	ω				*ω			З	ǰ (DTS 23)/ ni (Ai 2I)
13	Т	Т						Т	š/š' (DTS 37,38)
14	С							С	n (DTS 27)
15		Х				Х	d	Х	d (DTS 7)
16		Х						Х	baš (Ai 35)
17		У							
18		Д						Д	q (DTS 34)
19		Х						Х	a,e (Ai I)
20		С							
21		А			*А			А	š/š' (DTS 38)
22		Т	Т	Т					
23		Д				Д	b	Д	b (DTS 5/ Ai 2)
24		З						З	a/ä,e (DTS I,3,II)
25		Т							
26		З				З	z	З	z (DTS 50)
27		Т							
28		С	С						
29		П	П					П	p (DTS 33)
30		Т						Т	t (DTS 40, Ai 3I)

№	I	II	III		IV	V		VI	
			a	b		a	b	a	b
31		ᳵᳶ							
32		ᳵᳶ ᳵᳶ						ᳵ ᳶ	ŋ (DTS 28)
33		ᳵ							
34		ᳶ							
35		ᳶ				ᳶᳶ	i q	ᳶᳶᳶᳶᳶᳶ	k (A1 I2)/ q (DTS 34)
36		ᳶ						ᳶ ᳶᳶ ᳶ	y (DTS 15)
37		ᳶ ᳶ		ᳶ					
38		ᳶ				ᳶ	ic	ᳶ ᳶ	č (DTS 6)
39		ᳶ ᳶ							
40		ᳶ							
41		ᳶ ᳶ							
42		ᳶ							
43		ᳶ						ᳶ ᳶ ᳶ	š (A1 34)
44		ᳶ							
45		ᳶ							
46		ᳶ						ᳶᳶᳶᳶᳶᳶ	nt (A1 22)
47		ᳶ ᳶ			ᳶ			ᳶ ᳶ ᳶ ᳶ ... ᳶ	š (A1 34)
48		ᳶ							
49		ᳶ				ᳶ	nč	ᳶ ᳶ ᳶ ᳶ	nč (A1 23)
50			ᳶ	ᳶ					
51			ᳶ ᳶ ᳶ	ᳶ					
52				ᳶ				ᳶ ᳶ / ᳶ	s, š (DTS 36, 39), s' (A1 30)
53					*				
54						ᳶ	y	ᳶ	y' (A1 II)
55						ᳶ	g	ᳶ ᳶ	g (A1 4)
56						ᳶ	kü	ᳶ ᳶ ᳶ ᳶ ᳶ	k (DTS 24; A1 I3)
57						ᳶ	n	ᳶ ᳶ	ŋ (DTS 28)
58						ᳶ	r	ᳶ ᳶ ᳶ ᳶ ... ᳶ	š (A1 34)
59						ᳶ	e	ᳶ ᳶ ᳶ	e (DTS II)
60						ᳶ	d	ᳶ ᳶ ᳶ ᳶ	d (DTS 7)
61					ᳶ	ᳶ	t	ᳶ ᳶ ᳶ ᳶ ᳶ ᳶ	t (DTS 40)

МОНГОЛ БИЧИГ

Олон нийтийн дунд "хуучин монгол бичиг", "уйгуржин монгол бичиг", баруун монголчуудын дунд "худма монгол" гэдэг монгол бичиг нь монгол туургатнуудын бичиг соёлын түүхнээ онцгой байр эзлэдэг. Үүний гол учир нь монгол бичиг он удаан жил, өргөн хүрээнд тогтвортой хэрэглэгдэж ирсэнтэй шууд холбоотой бөлгөө.

Монгол бичгийн гаралын тухайд, Арамей гаралтай Согд шинэ үсгээс үүсэлтэй гэж судлагчид нэгэн дуугаар зөвшөөрөн хүлээдэг боловч цаг хугацаа, зам чийрийн хувьд санал хуваагдсаар иржээ. Үүнд: нэгэн хэсэг нь христусын тооллын эхний мянган жилийн сүүлээр Согдоос Уйгурууд авч, улмаар XIII зуунд Уйгураас Монголчууд дам авсан гэж үздэг бөгөөд энэ үзэл нэгэн хэсэгтээ хүчтэй байсаар иржээ¹. Зарим судлагчид түүхэн нөхцөл байдал хийгээд XIII зууны үеийн монгол бичгийн хэлний тогтсон ёс байдал зэргийг бодолцоод Монголчууд монгол бичгийг Уйгур улсын мөхсөний дараа буюу XIII зуунд авсан бус, харин Уйгур улсыг өв тэгш мандаж байх үед авсан байх ёстой хэмээн үздэг². Учир нь хүчирхэгжиж буй улс үндэстэн мөхөж байгаа улсын бичиг үсгийг авч байсан баримт байдаггүй. Энэхүү хоёрдугаар санал нь түүхэн байдалд нийцэхийн зэргэцээ X-XI зуунд Уйгурууд Согдоос бичиг үсэг авсан гэдэг үзлийг ч давхар эргэлзүүлэхэд хүрч байгаа юм. Үүнд: Христусын тооллын YШ зуун гэхэд Согдууд Арабад эзлэгдэж улмаар согд бичгийн оронд араб бичиг хэрэглэх болсон билээ³. Иймд эзэн нь хэрэглэхгүй болж мартагдаад 300 шахам жилийн нүүрийг үзсэн согд бичгийг Уйгурууд X-XI зуунд авч, түүхийн тавцанаас хэдийнээ буучихсан Уйгуруудаас Монголчууд XIII зуунд дам авсан гэж үзэхэд түүх, хэлшинжлэлийн талаас олон эргэлзээ эрхгүй төрнө.

Уйгур бичгийн гарлын талаар А. Махмутов 1969 онд бичсэн судлагааны нэг өгүүлэлдээ "...Бишбалыкын баянбүрдээр нутаглаж байсан Уйгурууд барагцаалахад Y зууны үед согд цагаан толгойноос эртний уйгур үсгээ авчээ..."⁴ хэмээн бичсэн нь түүхэн он цаг хийгээд учир шалтгааны үүднээс зөрчилдөх зүйлгүй юм.

Харьцангуй сүүл үед Төв Азийн олон улс үндэстний бичиг үсэг болон монгол хэл, монгол бичгийн түүхэнд холбогдох шинэ тулгар олдсон баримт гэрч, тэдгээрийг судласан

¹ В.В. Бартольд, *История Туркестана*, Ташкент, 1922; Ф.А. Розенберг, *О согдийцах*, ЗКВ, т. 1, Ленинград, 1925, стр. 81-95; *Согдийский сборник*, Ленинград, 1934; С.П. Толстов, *Древняя культура Узбекистана*, Ташкент, 1943; С.П. Толстов, *Древний Хорезм*, Москва, 1948; С. Малов, *Памятники древнетюркской письменности*, Москва-Ленинград, 1951; Б.Г. Гафуров, *История Таджикского народа в кратком изложении*, том. 1, 2 издание, Москва, 1952; В.И. Истрин, *Возникновение и развитие письма*, Москва, 1965.

² G.J. Ramstedt, *Das Schriftmongolische und die Urgamundart phonetisch Verglichen*, JSFOu, XXI, s. 2, Helsingfors, 1902; Б.Я. Владимирцов, *Монгольские литературные языки*, Ленинград, 1934, стр. 4-5; В. Rinčen, *Mongγol üsüg-ün γarul kögijil*, МТКВ, 1958, N. 5, Kokeqota, 5-26; Y. Rincen, *Les inscriptions inconnues sur pierre et les plaques d'or ornamentees du harnais de Tonyoucouc*, CAJ, vol. IV, 1959, pp.289-299; БНМАУ-ын түүх, 1-р боть, Улаанбаатар, 1966.

³ В.И. Истрин, *Возникновение и развитие письма*, Москва, 1965, стр. 399; О.И. Смирнова, *Очерки из истории Согда*, Москва, 1970.

⁴ А. Махмутов, *Как возник древнетюркский алфавит*, - Исследование тюркологии, Алма-Ата, 1969, стр. 142.

эрдэм шинжилгээний ажлын шинэ дүгнэлт, таамаглал монголын судлал хөгжсөн олон оронд багагүй гарсан нь монгол бичгийн гарал үүслийн талаархи хуучин судлагааг эрхгүй эргэж нягтлахад хүргэсэн гэж үзэх үндэс буй.

1970 хэдэн оноос монголын эрдэмтэд монгол туургатан болон монгол хэлний түүхэнд холбогдох шинэ хэрэглэгдэхүүний судлагаанд түшиглэж монгол бичгийн гарлын тухайд, Уйгураас дам аваагүй, харин Монгол Уйгур хоёр согдоос зэрэг авсан байх магадлалыг дэвшүүлжээ⁵. Энэхүү таамаглал нь монгол бичгийн гарлын талаархи дээр дурдсан саналуудтай харьцуулахад бодот байдалд илүү нийцтэй гэж үзэх үндэстэй тул тодруулан тайлбарлах нь зүйтэй буй заа.

Монгол бичгийн хэл нь чухам хэдий үеийн монгол хэл буюу аялгууны онцлогийг тусгасан бэ? гэдэг асуултын хариу давын өмнө монгол бичгийн түүх, анх авсан он цагтай зайлашгүй холбогдоно. Монгол бичгийн хэлийг монгол хэлний түүхэн баримт сэлт, тухайлбал: эртний монгол хэл, дундад үеийн монгол хэл аялгуу, нутгийн аялгууны хэрэглэгдэхүүнтэй харьцуулан үзвэл авиазүй, хэлбэрсудлал, хэлзүйн онцлог шинжээрээ ямар ч атугай дундад үеийн монгол хэлнийхээс түрүү, эртний монгол хэлний онцлогийг тусгасан бөгөөд өдгөө болтол идэвхитэй хэрэглэгдэж буй өвөрмиц бичгийн хэл болох нь тодорхой харагддаг.

Хэрэвзээ XIII зууны эхээр монгол бичгийг авсан байх бөгөөс тэр үеийнхээ буюу Дундад үеийн монгол хэлний дорнод, өрнөд, өмнөд гурван аялгууны аль нэгийн онцлогийг тусгасан байх ёстой боловч тийм гэх баримт огт байхгүй бөлгөө. "*Чингисийн чулууны бичиг*"-ийн хэлийг дундад үеийн монгол хэлний дорнод аялгууны дурсгал болсон "*Монголын нууц товчоон*" хийгээд дөрвөлжин бичгийн хэл, өрнөд аялгууны дурсгал болсон "*Мукадимад Ал-Адаб*", "*Стамбулын толь*"-той харьцуулахад дөч тавиадхан жилийн хугацаанд хэлний хөгжлийн бүхэл бүтэн хоёр үеийн ялгаа гарна гэх ямар ч боломж байхгүй нь мэдээж билээ. Дундад үеийн монгол хэлний энэ хоёр аялгуу бол тухайн цагийнхаа нийгмийн ноёрхох ангийн хэлийг бүрнээ төлөөлөх чадвартай байсан тул тэр үед бичиг авсан байх бөгөөс тухайн үеийн онцлог нь ямар нэгэн хэмжээгээр туссан байх ёстой гэдэгт эргэлзэх явдалгүй юм.

Тэгвэл монгол бичгийн хэл нь чухам ямар үеийн монгол хэлний онцлогийг хадгалж байна вэ? гэдэг асуулт аяндаа гарч ирнэ.

Хятан хэлний байдлыг өнөөдрийн бидний мэдэлгийн хирээр авч үзэхэд гол онцлогоороо дундад үеийн монгол хэлэнд илүү ойрхон болох нь илэрхий байдаг⁶. Тийм болохоор түүнээс харьцангуй түрүү үеийн буюу эртний монгол хэлний хэрэглэгдэхүүнийг авч үзэх хэрэгтэй болно. Үүнд: Хүн(нү) болон түүний дараахи үеийн монгол хэлний баримт хэрэглэгдэхүүнүүдийн дотроос, харьцангуй нарийн судлагдсан Сянби нарын хэлний Табгач аялгууны хэрэглэгдэхүүнийг⁷ авч үзэж болно.

Академич Л. Лигети зэрэг олон судлагчидын санал нэгтэйгээр эртний монгол хэлэнд хамааруулдаг Табгач хэлний *qabaqān* гэдэг дуудалга бүхий (可薄眞) - *k'o-po-tchen*, мөн

⁵ Y. Rintchen, *Sanscrit in Mongolia*, - SIAAC, vol. 3, New-Delhi, 1973, pp. 91-103; Г. Сүхбаатар, *Сянби*, Улаанбаатар, 1971, 114-р тал; Х. Лувсанбалдан, *Тод үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975, 19-р тал; Ц. Шагдарсүрэн, *К вопросу о происхождении монгольского письма*, - Олон улсын монголч эрдэмтний III их хурал, III боть, Улаанбаатар, 1978, 286-290-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 9-12-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол утга соёлын товчоон*, Улаанбаатар, 1991, 119-141-р тал.

⁶ G. Kara, *On the Khitan writing systems*, - Mongolian Studies, Tom. X, 1986-1987, Bloomington, pp. 19-24; Ц. Шагдарсүрэн, *Эртний монгол хэлний хэрэглэгдэхүүнд хийсэн зарим ажиглалт*, - Олон Улсын Монголч Эрдэмтний YП Их хурал, Улаанбаатар, 1997. YШ. 11-15.

⁷ Peter A. Boodberg, *The Language of the T'o-pa Wei*, -HJAS, V. I, July, 1936, N. 2, pp.167-185. L. Ligeti, *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*, -Mongolian Studies, Budapest, 1970, pp. 265-308.

түүнчлэн *üglen* гэдэг дуудалгатай (有連) - *yeou-lien* гэх зэрэг үгийг монгол бичгийн хэлний *qaɣalʲaɕ*, *egülen* гэдэг хэлбэртэй харьцуулахад авиазүйн хувьд хоёр эгшигийн хоорондхи *ɣ*, *b* гийгүүлэгч сугараагүй байгаа зэрэг шинжээрээ их л ойролцоо болох нь харагддаг⁸. Энэ байдал нь монгол хэлний хөгжлийн дундад үед буюу XIII зуунд монгол бичгийг авсан гэж үзэх хэлшинжлэлийн үндэслэл эргэлзээтэй болохыг харуулж байна.

Үүнээс гадна монгол бичгийн түрүү үеийн дурсгалуудад, гол төлөв гаднаас орж ирсэн нэр томъёоны зүйл дээр эгшигийн шүд ('), шилбэ (*y/i*)-ийг *jrɣ*, *tngri*, *slüg*, *tngsuɣ*⁹ гэх мэтээр орхиж бичдэг ёсон цөөн бус тохиолддог бөгөөд үүнийг нэлээд судлагч уйгур бичгийн уламжлал нөлөө гэж үзсээр ирсэн бөлгөө.

Гэтэл нарийвчлан үзвэл ийм онцлог нь зөвхөн уйгурт төдийгүй мөн согд, араб, перс болон согдоос үүсэлтэй гэж үздэг (Орхоны) түрэг бичгийн дурсгалд ч нийтлэг тохиолддог ажээ¹⁰. Нэгэнт Уйгурууд Согдоос бичгээ авсан нь илэрхий болохоор ийм уламжлалыг зөвхөн уйгурын уламжлал гэж үзэхэд учир дутагдалтай болно заа. Зарим нэгэн жишээ татсу.

Sans. <i>bodhisattva</i>	Sog. <i>pwtystβ</i>	Uig., Mong. <i>bodistv</i>
Sans. <i>vajra</i>	Sog. <i>βār</i>	Uig., Mong. <i>vār</i>

гэх зэрэг харьцангуй цөөвтөр үгэнд монгол, уйгур бичиглэг тохирч байгаа боловч бусад үгнээ, тухайлбал:

Mong. <i>jrɣ</i>	Uig. <i>jrliɣ</i>
Mong. <i>bir(g)man</i>	Uig. <i>bram(a)n</i>
Mong. <i>birit</i>	Uig. <i>prīt</i>
Mong. <i>maqaraɕa</i>	Uig. <i>mɣarac</i> < Sog. <i>mɣ'r'c</i>
Mong. <i>šastir</i>	Uig. <i>šastr</i>

гэх мэтийн олонхи үгэнд яг таардаггүй тул дээр өгүүлсэнчлэн зөвхөн уйгурын нөлөө хэмээн үзэхэд арга буюу эргэлзэл төрүүлж байгаа юм.

Монгол хэлэнд орсон иран нэр томъёоны талаар 1919 онд Б. Лауфер (B. Laufer)-ийн судлагаа¹¹ гарсны дараа акад. Б.Я. Владимирцов нарийвчлан үзээд монгол хэлэнд буй гол төлөв шашны холбогдол бүхий самгард нэр томъёо согдоос шууд орж ирсэн байна гэдэг дүгнэлт хийснийг бид сайн мэдэх билээ¹². Үүнийг давхар батлах нэгэн сонин мэдээг Г.И. Рамстедт (G.J. Ramstedt) "*Glan-ru'i mdo*" буюу "Үхэр уулын судар" зэрэг төвөд хэлт сурвалжаас авч "*Уйгур улсын хураангуй түүх*" хэмээх номдоо оруулсныг монголын түүхч Заваа Дамдин "*Hor-čhos-byun*"-даа давхар дурдсан байдаг¹³.

⁸ Ц. Шагдарсүрэн, *К вопросу о происхождении монгольского письма*, - Олон улсын монголч эрдэмтний III их хурал, III боть, Улаанбаатар, 1978, 286-290-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 9-12-р тал.

⁹ L.Ligeti, *Preklasszikus Emlekeki*, Budapest, 1963; Б.Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия*, Ленинград, 1929.

¹⁰ Ф. Розенберг, *О Согдийцах*, ЗКВ, N. 1, Ленинград, 1925, стр. 89; R. Gauthiot, *Essai de grammaire sogdienne*, Paris, 1914-1923.

¹¹ B. Laufer, *Sino-Iranica*, Chicago, 1912.

¹² Б.Я. Владимирцов, *Mongolica*, *Об отношении монгольского языка к Индо-Европейским языкам Средней Азии*, ЗКВ, N. 1, Ленинград, 1925, стр. 305-341.

¹³ *Byun-phyogs-hor-gyi-yul-du-dam-pa'i-čhoi-rin-pu-che-byur-tshul-gyi-gtam-rgyud-bkra-sis-chos-dun-bzad-pa'i-sgra-dbyuns-zes-bya-ba-bzugs-so - Umar-a jüg-ün mongɣol oron-a degedü nom erdeni ɣaruɣsan yosun-u domuɣ öljei-tü labai müsiyegsen daɣun egesig orosibai*, 10b-12b.

Үүнд: бидний доор эш татах мэдээ бол цаг үеийн хувьд Чингис хаанаас зургаа долоон зуун жилийн өмнө буюу Y1-YII зуунд хамаарна гэж зохиогч онцлон тэмдэглэсэн нь буй.

"...pksi-mkhas-pa-rnam-kyis-yu-gur-dan //
mon-kol-rnam-la-yi-ge-'bri-klog-dan //
ston-pa'i-idam-chos-bka'-bstan-gsun-rab-rnam //
ran-ran-skad-du-bsgyur-tshul-ston-cin-bslabs // ..."

буюу монголчлосон нь:

"...(Согдын Ц.Ш.) mergen baysi-nar-bar uyiyur kiged mongyol-nuyud-tur üsüg bičikü ungsiqu ba : burqan-u degedü nom jarliy sastar-a sayin jarliy-ud-i öber öber-ün kele-ber orčiyulqu yosun-i üjegüljü suryabai..."

гэсэн их л сонирхолтой баримт буй. Энэ баримтаас үүдүүлэн цааш нь дараахи зүйлийг дурдсан байна. Үүнд:

"...Тэр цагт тэд (Уйгур болон Монголчууд Ц. Ш.) сайн зарлигийг уншихуйд согдаг бичгийн дээрээс энэдхэг хийгээд өөр өөрийн хэлнүүд холимогоор орчуулсанаас, номлон соносох амны уншилгыг үйлдсээр буй ажгуу. Тэр шалтгаанаар одоо манагаар ч номын хэл нь энэдхэг, уйгур, монгол холимогоор оршисон болой. Тиймийн тул монгол үсэг үүнийг Сажа Бандида-баар урлав хэмээх итгэмээргүй үг буй. Бус бас Монгол орны дунд Согдаг-нугууд Энэдхэгийн ороноос Бүддын ном ёсон (хийгээд наран шингэхүй зүгээс Маанийн ном ёсон хоёрыг) залж ирсэн..."

хэмээн тодорхой тайлбарласан зүйл байдаг нь монгол бичгийн үүсэл, монгол номын хэл, нэр томъёоны гарлын талаар олон зүйлийг эргэцүүлэн үзэхийг сануулж байгаа юм.

Судлагчдын онож тодорхойлсноор тухайн цагтаа Төв Азийн *Lingua Franca*¹⁴ болж байсан Согд хэл бичгээр дамжуулан Энэдхэгийн соёлын нөлөөг Монгол, Уйгур хоёр зэрэг хүлээн авсан гэдгийг дээрхи баримт өгүүлж байна. Ташрамд дурдахад аливаа улс үндэстний бичиг үсгийн үүсэл ямагт шашин ном (орчин үед бол үзэл суртал)-той холбоотой байдаг бөгөөд энэ талаар мэргэжлийн судлагчид ч хүлээн зөвшөөрдөг бөлгөө¹⁵.

Дээрхи түүхэн баримт болон учир шалтгааны холбоонд тулгуурлаж монгол бичгийн гарал үүслийн талаар доорхи саналыг дэвшүүлж болно. Үүнд:

- Монголчуудын өвөг дээдэс XIII зуунд согд бичгийг Уйгуруудаас дам авч хэрэглэсэнгүй, харин YI-YII зууны үед, Монгол, Уйгур хоёр Согд нараас нэгэн зэрэг авсан байж болох магадлал гарч байна. Хэрэвзээ Уйгурууд Согдоос Y зуунд бичиг үсэг авсан гэж нутлаж байгаа А. Махмутовын судлагааг бодолцох аваас монгол бичгийн үүссэн он цаг даруй нэгэн зуунаар урагшлах болно.

-Монгол, Уйгур бичгийн үсэгзүй дэхи адил төстэй тал, монгол, уйгур бичгийн хэлэн дэхи нэр томъёоны ойролцоо байдал нь уйгураас монголд нөлөөлсөн нөлөө гэхээс илүү Согдын багш нар монгол, уйгур хоёрт нэгэн зэрэг бичиг үсэг бичих, ном зохиол орчуулах уламжлалыг заасан учир шалтгаанаар тайлбарлахад төдий л эргэлзээ гарахгүй.


Энэ бүхэнтэй холбогдуулан өөр нэгэн зүйлийг дурдах хэрэгтэй буй заа. Монгол бичгийг Баруун монгол, Халимагт "худма үзүг" гэж нэрлэдэгийг дээр цухас дурдсан. Монгол бичигт "тэргэ", "зэргэ" гэдэг үгийг оросжин үсгээр "тэрэг", "зэрэг" гэж бичдэг болсонтой адил "худма" гэдэг үгийг одоо "худам" гэж бичдэг бөлгөө. Энэ үгийн гарал үүсэл, утгын талаар

¹⁴ P. Pelliot, *La Haute Asie*, Paris, p. 9; P. Pelliot, *Les influences iraniennes en Asie Central et en Extrême Orient*, Paris, 1911.

¹⁵ В. Истрин, *Возникновение и развитие письма*, Москва, 1965, стр. 536.

эрдэмтэд янз бүрээр тайлбарлаж иржээ. Нэг зарим нь Ойродын Зая Бандида Огторгуйн Далай - Намхайжамцын зохиосон бичгийг "Тод" гэж нэрлэсэн нь түүний үсэг нь "тодорхой" гэсэн үг бөгөөд монгол бичгийг "худам" гэсэн нь үүний эсрэг утгатай буюу "тодорхой бус" хэмээсэн санаа гэж тайлбарлаад монгол хэлний "хуудуу", "хуудам" (< Mo. *qayu- ~quu-*) гэдэг үгтэй холбосон нь ч бий. Гэтэл "худма" гэдэг үгийн бичилгэ, дуудалгыг үзэхэд урт эгшиггүй байгаа нь дээрхи тайлбарыг хэлшинжлэлийн үүднээс эргэлзүүлэхэд хүргэдэг.

Г.И. Рамстедт "*Халимаг толь бичиг*"-тээ *Xudm mongǎl* гэдэг нэр томъёог толгой үг болгон оруулж "*Xudm mongǎl* - Ö die alte mongolische schrift im gegens... qudu'ma, BB xudma 'ursprünglich' zu xuD..." буюу "... *Xudm mongǎl* - Өөлдөд монгол бичгийг ийнхүү нэрлэнэ... qudu'ma, BB xudma нь "анхны", 'уугуул' гэсэн үг; xuD гэдгийг үзмүү!" хэмээн тайлбарлажээ. Уг толиос тэрхүү xuD гэдэг үгийг үзвэл германаар "*wurzel, kern, ursprung (Zwicky 203)*" буюу монголчловол "үндэс, яс, цөм, үр тариа; эхин, эх булаг (Zwicky 203)" гэдэг үг хадсан байх ба уйгур, Цагаадайн түрэг, Алтай хэлэнд байдаг холбогдох үгийг хаалтнаа хавсаргажээ¹⁶.

1880 онд Санктпетербург хотноо К.Ө. Голстунскийн хэвлүүлсэн "*Монголо-ойратские законы 1640 года*" номын тайлбарт мөнөөхи үг тод үсгээр  *xudma* гэдэг хэлбэртэй тохиолддог¹⁷.

Бас Дундад үеийн монгол хэлний өрнөд аялгууны дурсгал болох "*Мукаддимат ал-Адаб*" толь бичгийн монгол хэлний дурсгалд *kesuk xutba* - "прерванная молитва", *xutba ungsiba xatib irgendu* - *xutba oqudi xatib elge* - "проповедник читал людям молитву" гэх зэргээр "уншилга, ном, эш, зарлиг" хэмээсэн утгаар *xutba* гэдэг үг хэдэнтээ дайралддаг¹⁸. Энэ нэр томъёог мөшгин үзвэл Христусын тооллын эхний 800 гаруй жилийн турш тогтнож байсан Согд нарыг түүхийн тавцанаас буулгасан Араб нарын хэл хийгээд Перс хэлэнд "ном, уншилга, дэвтэр" гэсэн утгатай *кутуб, хутба, хотба, кетаб, котоб* гэдэг үгийн хэлбэр өдгөө ч байсаар байна¹⁹. Мөн уйгур хэлний зарим аялгуунд энэ үг мөнөөхи л утгаар *xutbэ* гэдэг хэлбэрээр одоо ч хэрэглэгдэж байна²⁰.

Дээрхи баримт сэлтэд дулдуйдан үзвэл *худма* гэдэг нэр томъёо нь лавтайяа XIV зууны үед монгол хэлний өрнөд аялгуунд идэвхитэй хэрэглэгдэж байсан бөгөөд утгаа согд гаралтай байж бүрэн болмоор санагдана. Үүний зам чийрийг (Sog. *ɣwt'w*) > *xutba* > *xutma* > *xudma* гэж тоймлон бүдүүвчлэж болно. Учир нь, Дүн-хуанаас олдсон Бүддийн шашны согд бичвэрийн дотор "эзэн, хан дээдэс, дээд" гэсэн утга бүхий *ɣwt'w* (*xvataw*) гэдэг үг *mz'yy* *ɣwt'w*, *ɣwt'wt* буюу *'wt''kcykt* *ɣwt'wt* гэх зэрэг хэлэлгэд тохиолддогийг аль эрт Ф. Розенберг профессор тогтоосон билээ²¹. Бас Мүг уулнаас олдсон согд дурсгалын дотор ч ийм хэлбэрээр олонтаа тохиолдож байна²².

Энэ үгийг согдоч эрдэмтэн О.И.Смирнова нэг бүтээлдээ Бурханы *k'wδm'* буюу *k'wt'm'* гэдэг нэртэй холбоотой байж болзошгүй гэж бичсэн нь буй²³. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд доктор Б. Сумъяабаатар *xudma* гэдэг нэр томъёог хуучин герег бичгийг

¹⁶ G.J. Ramstedt, *Kalmückisches Wörterbuch*, Helsinki, 1935, s. 194. d.

¹⁷ К.Ө. Голстунский, *Монголо-ойратские законы 1640 года*, Санктпетербург, 1880, стр. 25, 62, 135.

¹⁸ Н. Поппе, *Монгольский словарь Мукаддимат ал-Адаб*, часть 2, Москва-Ленинград, 1938, стр. 268, 385.

¹⁹ *Таджикско-русский словарь*, Москва, 1954, стр. 197; *Узбекско-русский словарь*, Москва, 1959, стр. 508; *Русско-узбекский словарь*, Москва, 1954, стр. 667; *Персидско-русский словарь*, Москва, 1950, стр. 314, 659; *Русско-персидский словарь*, Москва, 1986, стр. 223.

²⁰ *Уйгурско-русский словарь*, Москва, 1939, стр. 168.

²¹ F.A. Rosenberg, *Deux fragments sogdien-boudhique du Ts'ien-fo-Tong de Touen-huan* (Mission S. d'Oldenburg 1914-1915) - ИРАН, т. XIV, Петербург, 1920, стр. 418.

²² *Согдийские документы с горы Муг*, вып. II, Москва, 1962, стр. 123-124.

²³ О.И. Смирнова, *Очерки из истории Согда*, Москва, 1970, стр. 123-124.

зохиосон тухай домогт өгүүлдэг *Кадма* гэдэг нэртэй холбон үзжээ²⁴. Энэ домогт Финикийн эзэн хээн Агенорын хүү Кадма гэгчийг дагаж ирсэн финик нар герегүүдийн мэддэггүй байсан бичгийг авчирсан хэмээн өгүүлдэг бөлгөө. Ийм учраас Атин (Афин), Итака, Эгина хавиас олдсон бичээсийг эртний Кадмагийн үсэг гэж нэрлэх болсон байна²⁵.

Монгол бичигт үндэслэсэн манж бичгийг ойрод, халимагт "хар худма" гэж нэрлэдэг тухай эрдэмтэн Х. Лувсанбалдан, Д. Цэрэнсодном нар мэдээлэн тэмдэглэжээ²⁶.

Монгол хэлний үгсийн санд Бурханы шашны самгард нэр томъёоны зүйл Согд болон Тохараар дамжин орж ирдэг байсныг Г.И. Рамстедт, Н. Поппе, академич Б.Я. Владимирцов, Б. Ринчен, Ш. Бира нар санал нэгтэй зөвшөөрдөг билээ²⁷.

Тэгвэл эрт цагт Монголчууд дээд өвөгийнхээ үеэс Согдтой ямар хэлхээ холбоотой байсан бэ? гэдэг асуулт эрхгүй гарна.

Тус улсын нутаг дэвсгэр дээр Согд нарын үлдээсэн тодорхой ул мөр цөөнгүй байдаг. Тухайлбал: монгол нутгаас олдсон согд бичээс хэд хэд буй бөгөөд үүнээс Зөвлөлтийн эрдэмтэн С.Г. Кляшторный, В.А. Лившиц нар Сэврэй, Бугатын согд бичээсийг судлан нийтлүүлсэн билээ²⁸.

Мөн Моюнчүрийн хөшөөний түрэг бичээсийн дотор "...Согдак Табгачка Селенеде Байбалык йапыты бртм..." буюу монголчловол: "...ингээд би Согд, Табгач (энд хятад гэсэн утгаар буй) нарт Сэлэнгийн (эрэг) дээр Байбалык (хот) цогцлохыг тушаав..."²⁹ гэсэн үг буй. Ийнхүү цогцлосон хотын туурь нь одоо Булган аймгийн Хутаг сумын нутагт Бийбулаг гэдэг нэртэй байгааг бид мэдэх билээ. Иймд Байбалык хотыг цогцлоход Согд нар оролцсоноос гадна тэнд хүйгээрээ аж төрөн сууж арилжаа наймааны хэрэг эрхлэж байсан тухай тодорхой түүхэн баримт буй бөлгөө.

Энэ ташрамд хэлэхэд, эрдэмтэн О.И. Смирнова согд нарын дэлдсэн олон зүйл зоосыг судлах явцдаа хоёр бөхтэй "монгол" тэмээний дүрс бүхий, арынхаа бичгээр ялгаатай хоёр янзын зоос олж 1981 онд хэвлүүлсэн согд зоосны жагсаалт товъёгтоо оруулжээ³⁰. Энэ хоёр зоос нь одоогоор эзгүй шахуу болсон Бухаарын Баянбүрд орчмын Варахши хэмээх ор гагц буйд балгасын хавиас олдсон бөгөөд судлагч уг хоёр зоосны учир

²⁴ Д. Наваан, Б. Сумъяабаатар, *Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал*, Улаанбаатар, 1987, 50-р тал.

²⁵ В. Истрин, *Возникновение и развитие письма*, Москва, 1965, стр. 333-334.

²⁶ Д. Цэрэнсодном, *Монгол Данжуурын төгсгөлийн шүлэг*, Хэл зохиол судлал, ҮШ боть, 4-р дэвтэр, Улаанбаатар, 1970, 73-163-р тал.

²⁷ Б.Я. Владимирцов, *Mongolica, Об отношении монгольского языка к Индо-Европейским языкам Средней Азии*, ЗКВ, N. 1, Ленинград, 1925, стр. 305-341; G.J. Ramstedt, *Uyjur ulus-un quriyangui teüke*, Ulaanbayatur, 1922, 16-17; N.N. Poppe, *Introduction to Altaic Linguistics*, Wiesbaden, 1965, p. 168; Y. Rinchen, *Sanskrit in Mongolia*, SIAAC, vol. 3, New-Delhi, pp. 91-103; Й. Ринчен, *К истории древних культурных связей монголов с другими народами по данным монгольского фольклора*, - Роль кочевых народов в цивилизации Центральной Азии, Улан-Батор, 1974, 259-293; Ш. Бира, *Монголия и страны Центральной Азии*, -Олон улсын Монголч эрдэмтний III их хурал, III боть, Улаанбаатар, 1979, 105-112-р тал.

²⁸ В.В. Радлов, *Атлас древности Монголии*, С-Петербург, 1902; B. Rintchen, *Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stele en Mongolie*, Oulan-Bator, 1968; S.G. Kjaštornyj, V.A. Livšic, *La stele de Sevrey (Gobi meridional)*, JA, Paris, 1971, pp.11-20; С.Г. Кляшторный, В.А. Лившиц, *Согдийская надпись из Бугута*, СНВ, Москва, 1971, т. X, стр. 121-146; S.G. Kjaštornyj, V.A. Livšic, *The Sogdian inscription of Bugut Revised*, АОН, Tom. XXVI (1), Budapest, 1972, pp. 69-102.

²⁹ Г. Айдаров, *Язык орхонских памятников древнетюрской письменности VШ века*, Алма-Ата, 1971, стр. 30.

³⁰ О.И. Смирнова, *Сводный каталог Согдийских монет*, Бронза, Москва, 1981, стр. 28-78.

холбогдол одоогоор битүүлгэ байгааг тэмдэглээд "...Бухаар газрын зоосон дээр (хоёр бөхтэй) тэмээ байдаг эсэх талаар сонирхолтой асуулт гарч байна..."³¹ гэж дурдаад тэрхүү асуултын хариуг цаашдын нухацтай судлагаанд найдан үлдээжээ. Бидний бодоход монгол, согдын харилцааны түүхээс холбогдох хариу гарч ч магадгүй юм.

Эдгээрээс гадна Сы Ма-цианы "Түүхэн тэмдэглэл" болон "Түрүү Хан Улсын түүх" зэрэг эртний нангиад судар дэвтэрийн дотор 康居 (k'ang-ju заримдаа k'ang, оросоор Кан-гуй³²) гэж тэмдэглэгддэг Согд нар лавтайяа Монголчуудын өвөг дээдэс - Хүн(нү) нартай нутаг савлан хил залгаж, тал талын холбоо харилцаатай байсан мэдээ үлэмжхэн буй.

Энэ бүхнээс үүдүүлэн үзэхэд монгол бичгийн гарлын асуудлыг XIII зуунаас өмнөхи үед эрхгүй хамааруулж, согд бичигтэй дам бус, шууд холбон үзэх олон боломж гарч ирдэг. Мөн сүүлийн үес Халимагийн эрдэмтэн П.Ц. Биткеев³³, БНХАУ-ын эрдэмтэн Боошиан, Данзан нарын зэрэг олон судлагч монгол бичгийн гарлын талаар шинэ санал онолоо гаргаж байгаа бөгөөд ерөнхийдөө цөмөөрөө XIII зуунаас өмнөхи үетэй холбон үзэж байгаагаараа нэгдмэл байна. Гэвч тодорхой он цагийн хувьд санал адилгүй. Тухайлбал: Боошиан профессор Х зуунд хамааруулсан байхад Данзан түүхэн үйл явдлыг нарийвчлан бодолцсоны үндсэн дээр нэг бол 805-840 оны хооронд, эсбөгөөс 971-1125 оны хооронд авсан байх магадлалтай хэмээн үзжээ³⁴.

"Юан Улсын судар"-ын 124-р бөлөгт гардаг, Найманы Тататунгаг барин авахад өврөөс нь гарсан уйгур бичиг бүхий тамга, түүнээс уламлан тэр бичгийн хүнээр Чингис хаантан үр ач, дүү нар хийгээд угсаат ноёдод бичиг заалгуулсан мэдээг үндэслэж гадаад дотоодын нэлээд судлаач Монголчууд 1205 оны орчим Уйгураас бичиг үсэг авсан гэж үзэх болсон боловч харьцангуй сүүлийн үеэс тэрхүү үзэл баримтлал эргэлзээтэй болохыг нутласан олон баримт сэлт хойно хойноосоо гарч ирсээр байна³⁵.

Одоогийн бидний мэдэлгийн хирээр монгол бичгийн хамгийн эртний дурсгал нь Чингисийн чулууны бичиг хэмээн алдаршсан, их наадамд *Yisüngge* мэргэний 335 алдад харваж оносоныг алдаршуулан босгосон чулуун дээрхи таван мөр бичээс бөлгөө (5-р хавсралтыг үзмүү). Эргэцүүлэн бодохул энэхүү бичээс нь энэ хир бидэнд олдоод буйн хувьд хамгийн эртнийхи болохоос биш монгол бичгийн дурсгалын хувьд хамгийн эртнийхи биш гэдэг тодорхой юм. Уг дурсгалыг олон эрдэмтэн 1224-1225 онд хамааруулсаар ирсэн боловч профессор И. де Рахевильз (Igor de Rachewiltz) *a terminus ex quo of 1225 and a terminus ad quem of c. 1270* гэж үзсэн явдал буй³⁶. Профессор Ф. В. Кливиз (F. W. Cleaves) "Монголын нууц товчоон"-ы анхны эхийг монгол бичгээр байсан гэж нухацтай тайлбарласаныг бас мартаха аргагүй³⁷.

³¹ О.И. Смирнова, *Двугорбый верблюд на согдийских монетах*, - Страны и народы Востока, Вып. XXV, Москва, 1987, стр. 142-148.

³² Н.Я. Бичурин (Иакинф), *Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена*, Том. 1, Москва-Ленинград, 1950.

³³ П.Ц. Биткеев, *Языки и письменные системы Монгольских народов*, Москва-Элиста, 1995, стр. 121-128.

³⁴ Boosiyang, *Mongγol üsüg biāg-ün uqayan*, Kōke kota, 1984; Danjan, *Mongγol biāg-ün egüsel-ün cāγ-un asaγudal*, Mongγol kele sinjilelgen-ü ögülel-üd, Kōke kota, 1987, 895-942.

³⁵ Danjan, *Tatatungγa-yin namtar-daki mongγol üsüg biāg-ün tuqai medege-yi naribālaqu-anu*, Mongγol kele bičig, N. 104, Kōke kota, 1986, 24-31.

³⁶ Igor de Rachewiltz, *Some remarks on the Stele of Yisüngge*, - *Tractata Altaica* by Denis Sinor, Wiesbaden, 1976, pp. 487-508, esp. 495.

³⁷ F. W. Cleaves, *The Secret History of the Mongols*, Vol. I, Cambridge-London, 1982, pp. Lx-lxv; Ts. Shagdarsuren, *On the question of the First original of SHM*, - *Mongolian Studies*, (The Korean Association for Mongol Studies) N. 2 (1994), Seoul, 1995, pp. 120-123; Ц. Шагдарсүрэн, "Монголын нууц товчоон"-ы анхны эхийн талаар эргэцүүлэх нь, - *Эрдэм шинжилгээний бичиг* (МУИС, Монголын судлалын сургууль) XIV боть, Улаанбаатар, 1999, 10-19-р тал.

Монгол бичгийн дурсгалуудаас үсгийн бичилгэ, махбод буюу зурам³⁸-ын хэлбэр дүрсийг авч үзвэл бичих байдлын хувьд доорхи хоёр үндсэн үед хуваан үзэх үндэс буй.

Н э г д: дундад эртний үеийн бичилгэ. Энэ үеийг ерөнхийд нь XVI зуун хүртэл үргэлжлэнэ гэж үзэж болох бөгөөд бичилгэ зурамын хувьд уугуул согд бичгийн хэлбэр дүрстэй нэлээд ойр. Тийм ч учраас уйгур бичгийн хэлбэртэй төстэй. Монгол бичгийн энэ үеийн бичилгийн хэлбэрийг зарим эрдэмтэн уйгуржин монгол бичиг гэж нэрлэдэг нь үүнтэй холбоотой буй заа (5-6-р хавсралтыг үзмүү).

Х о ё р т: шинэ үеийн бичилгэ. Энэ үеийн бичилгэ нь өдгөөгийн бидний үе хүртэл хэрэглэсээр буй ерөнхий хэлбэр байдлыг буй болгосон бөгөөд дотроо Төв Халхын, Буриадын, Өвөрлөгч нутгийн гэх зэргээр газар газрын онцлогтой боловч үндсэн зарчим нь нэгдмэл байсан гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Энэхүү хоёр үечлэлийн хувьд үсгийн зурам болон бичилгийн хэлбэр нь ялгаатай болохоос зөв бичихзүйн тухайд зарчмын онцгой зөрөөгүй, өөрөөр хэлбэл аль аль үед нь үлэмжхэн тогтворжсон төдийгүй монгол хэлний үгийн бүтэц, тогтолцоог бүрэн тусгасан нийтлэг дүрэм үйлчлэж байсан гэдгийг онцлон дурдвал зохино. Энэ нь монгол бичгийн зөв бичих дүрэм монгол хэлний хөгжлийн дундад үе гэхэд хэзээний төлөвшин тогтсон байжээ гэж үзэхэд хүргэдэг бөгөөд түүний үүсэл нь бидний дээр өгүүлсэнчлэн монгол бичгийг анх авч хэрэглэсэн гэж таамаглаж буй цаг хугацаатай холбогдох бүрэн боломжтой юм.

Монгол үсгийн бүтэх махбодыг энэ удаа хамгийн нийтлэг байдлаар товчдуу авч үзсүү. Тэхдээ энэ жагсаалтад харь үгийг тэмдэглэх галиг үсгийн махбодыг оруулаагүй, зөвхөн монгол хэлнээ хэрэглэгддэг үндсэн үсгээр хязгаарласан болно.

А. Үсгийн махбод:

1.  **Титим.** Үгийн эхинд эн тэргүүнээ эгшиг бүрийн толгойд орно. Энэ нь эхинд орсон эгшиг үсгийн толгойн ацаг буюу богино шүднээс харьцангуй хожуу буй болжээ. Авиазүйн хувьд эрт цагт үгийн эхинд байсан гийгүүлэгчийн ул мөр болсон амьсгалын түрэлтийг тэмдэглэсэн гэж үзэх үндэс буй³⁹.
2.  **Үсгийн гол буюу нуруу.**
3.  **Ацаг, шүд | богино шүд, өргөс.**
4.  **Шилбэ** (голдуу эгшиг үсэг дээр), **урт шүд, урт ацаг, урт өргөс** (гол төлөв гийгүүлэгч дээр). Үгийн эцэст тохиолдох () үед **сүүл** гэж нэрлэх нь буй. Үүнээс монгол бичгийн *г, у, в* (  ) гийгүүлэгчийн хэлбэрийг үүсгэсэн гэж үзэж болно.
5.  **Гэдэс.** Гэдэс нь дотроо **хатуу гэдэс** () , **зөөлөн** буюу **хөндий гэдэс** ( ) гэх зэрэг хэдэн зүйл ялгаатай.
6.   **Жавиж.** Үүнийг монгол хэлний зарим нутгийн аялгуутан өөр өөрийнхөө дууддагаар нэрлэх нь буй. Тухайлбал: монгол бичгийн *ж* () гийгүүлэгчийг *с* гэж дууддаг аялгуутан монгол бичгийн *с* () -ээс ялгахын тул дүрс

³⁸ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Дэд дэвтэр, Авиан зүй, Улаанбаатар, 1966, 12-р тал; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 40-68.

³⁹ Ж. Лувсандорж, *Эртний монгол бичигт үгийн эхний Алеф үсгээр ямар авиа тэмдэглэсэн бэ?* – МУИС, Эрдэм шинжилгээний бичиг, Улаанбаатар, № 3 (87), 35-44.

байдал хийгээд бичгийн гол тэнхилигт эзлэх байраар нь тусхайлан нэрлэдэг байна. Үүнд: Хори буриадад **арын са**, Горлост **хэвтээ са** хэмээмүй.

7.  **Эвэр.** Үүнийг монгол хэлний зарим нутгийн аялгуутан өөр өөрийнхөө дууддагаар ялган нэрлэх нь буй. Жишээ нь: монгол бичгийн **с** () -г **с** -ээр дууддаг аялгуутанууд монгол бичгийн жинхэнэ **с** () гийгүүлэгчээс ялгахын тул дүрс хийгээд бичгийн гол тэнхилигт эзлэх байдлаар нь тусхай нэр өгчээ. Үүнд: Хори буриадад **өврийн са**, Горлост **босоо са** хэмээдэг уламжлал буй.

8.  **Нум.**

9.  **Дэгээ.**

10.  **Босоо t / d**

11.  **Хэвтээ d / t**

12.  **Хөндий h**

13.  **Сүүл | (хойшоо) орхиц.** Дотроо учир ялгаатай. Үүнд: үгийн эцэст дэвсгэрлэж ордог -ү гийгүүлэгчийн сүүлчийн зурам, мөн үгийн эцэст орсон -s гийгүүлэгчийн хувилбар махбодыг **богино сүүл** хэмээмүй.

14.  **Цацалга / (урагшаа) цацалга**

Б. Үсгийн нэмэлт тэмдэгийн зүйл:

15. **Цэг.**

 **Нэг цэг.** Амьтай **n** гийгүүлэгчийн өмнө тохиолдоно.

 **Хоёр цэг.** Үүнийг амь авсан ү гийгүүлэгчийн өмнө, мөн **с** гийгүүлэгчийн ард тус тус тавьдаг.

16.  **Эвэр.** Дотроо хоёр зүйл. Үүнд: **l** гийгүүлэгч дээшээ эвэртэй, **m** гийгүүлэгч доошоо эвэртэй.

В. Цэг тэмдэгийн зүйл:

17.  **Бярга буюу эгчим.** Гол төлөв сударласан номд хуудас бүрийн өвөр талын эхинд тавьдаг тэмдэг. Дэвтэрлэсэн номын тухайд их төлөв зүйл зүйл эхлэхэд хэрэглэсэн байдаг тул арай өөр үүрэгтэй гэж хэлж болно.

18.  (нэг) **Цэг.** Монгол бичвэрийн дотор өдгөөгийн таслалын үүрэгтэй.

 **Давхар цэг.** Одоогийн цэгийн үүрэгтэй.

 **Дөрвөлжин цэг | дөрвөн цэг.** Энэ нь их төлөв тодорхой бөлөг, зүйл ангийн эцэст тохиолдоно.

Жич тэмдэглэх нь: ном зохиолын бүр эцэст дөрвөлжин болоод давхар цэгийг дараалж хослуулан хэрэглэсэн байх нь цөөнгүй тохиолддог.

Дээр дурдсан махбодуудаас монгол бичгийн уугуул үсэг бүтсэн⁴⁰ байх бөгөөд харин гадаад үг авиа тэмдэглэхээр зохиосон галиг үсэгийн ялгах зартиг, бинд, гогцоо зэрэг нэмэлт тэмдэгийг дүрс өвөрчлөх зорилгоор харьцангуй хожуу үед нэмсэн гэж үзэх үндэстэй юм.

Монгол үсгийн махбодын дээр дурдсан лугаа адил нэр ус нь цагаан толгой бүрт төдий л байдаггүй, харин монгол бичиг эхлэн сурах багачуулд давын өмнө үзүүлдэг "Монгол үсэг хялбар сурах болтугай" гэх зэрэг сургалтын цагаан толгойд олонтаа тохиолддог нь монгол бичгийг махбод бүтэцээр нь тайлбарладаг монголчуудын заах аргатай холбоотой хэрэг. Энэ талаар үүнээс өмнө хэдэн удаа хөндөн өгүүлсэн билээ⁴¹.

Сургалтын чанартай цагаан толгой доторхи үсгийн махбод болон зурамын нэр томъёо нь газар газарт бага зэрэг хувилбар ялгаатай боловч үндсэн чанартаа нэг гэж үзэх үндэс буй. Тэдгээр нэр томъёоны зүйлийг авч үзвэл өрөнхийд нь доорхи гурван ангид хувааж болно. Үүнд:

1. Үсгийн махбод, зурамыг заасан нэр томъёоны зүйл. Эдгээр нэр томъёонд холбогдох гол зарчим гэвэл гадаад дүрс байдалд дулдуйдсан байдаг бөлгөө. Тухайлбал:

- асуу / асау / агау-а / örgesün / sidün
boᠠuni асуу / boᠠuni örgesün / boᠠuni sidün
urtu асуу / urtu sidün

- сацуу-а
- сөг¹ (үсэгзүйн төвшинд)
emün-e nigen сөг¹
emün-e qoyar сөг¹
qoyin-a qoyar сөг¹

- сөг² (өгүүлбэрзүйн төвшинд)
dabqur сөг²
dörben сөг² / dörbeljin сөг²

- degege
- gedesün
kōndei gedesün
qataᠢᠣ gedesün

- youl
- jabiji
- jartiy
- numun
- orkiča
- segül

⁴⁰ Монгол цагаан толгойн үндсэн бүх үсэг хэрхэн бүтсэн байдлыг Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, (тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1981) номын 16-19-р талаас лавлан үзнэ үү.

⁴¹ Ц. Шагдарсүрэн, *Об одном букваре монгольского письма*, Rocznik Orientalistyczny, Т. XXXVII, z. 2, Warszawa, 1975, pp. 101-112; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1981, 19-25-р тал; Ц. Шагдарсүрэн, *Традиционные монгольские фонетические термины*, - Исследования звуковых систем языков Сибири, Новосибирск, 1984, стр. 193-194.

- *sidün*

- *silbi*

- *tasuluysan* ... (Жишээ нь: *tasuluysan la: al-a, bal-a, qal-a;*
tasuluysan na: an-a, ban-a, qan-a;
tasuluysan ya: aγ-a, baγ-a, qaγ-a...)

2. Бие даасан үсгийг бүхэлд нь заасан нэр томъёоны зүйл. Үүнд гол төлөв дэвсгэр гийгүүлэгчийн нэр хамаардаг бөгөөд өгүүлэх эрхтэний оролцох байдалд дулдуйдана.

- *aγsily-a* буюу (-γ)

- *am-a qamjily-a / am-a qamjiqu* буюу (-m)

- *arayan-u čilügen / arayan-u seyigen* буюу (-š)

- *čingγ-a am-a qamjily-a / qatayu am-a qamjily-a* буюу (-b)

- *darsily-a* буюу (-r)

- *egsilge* буюу (-g)

- *ingkelig / ingke*

baγ-a ingkelig буюу (-n)

yeke ingkelig / yeke ingke буюу (-ng)

keyiskeber ingkelig буюу (yi+n)

- *jayibar / keyiskeber* буюу (-y)

- *kele aγu* буюу (-n)

- *kele tulγ-a / kele tulqu* буюу (-l)

- *köndei* буюу (-u~-w)

- *küčün* буюу (-γ)

- *qatayu am-a qamjily-a / čingγ-a am-a qamjily-a* буюу (-b)

- *qatagu gedesün / tanglai deledkü* буюу (-d)

- *sidün čilüge / sidün seyigen* буюу (-s)

- *tanglai deledkü / qatayu gedesün* буюу (-d)

3. Үгийн нөхцөл хийгээд зарим дагаварыг бүхэлд нь заасан нэр томъёоны зүйл. Сургалтын явцад нийлмэл бүтэцтэй нөхцөлийн махбод бүрийг дараалан нурших шаардалгаас зайласхийж ийм нэр томъёо буй болсон гэж үзэх үндэс буй.

- *kengker* буюу (-i)

- *keyiskeber* буюу (-yin)

- *küngkür* буюу (-u/-ü)

- *orkiča* буюу (-a/-e)

- *qongsil / qongsily-a* буюу (-un / -ün)

türgen qongsily-a буюу (-ud / -üd)

Үүнээс гадна сургалтын зарим цагаан толгой, сурах номын тайлбарт -*yi* нөхцөлийг *qangqari* буюу *γangγari*; -*uu* / -*üü* -г *urtu kengker* буюу *urtu küngkür* гэх зэрэг хувилбар нэрээр тохиолддогийг дурдсу⁴². Бас нутаг нутагт хэрэглэж дадсан хувилбар нэр цөөнгүй байдаг боловч бид энд бүгдийг нь хамрах зорилго тавьсангүй.

Монгол үсэгзүйн холбогдол бүхий нэр томъёо ийнхүү ном бичгийн дотор тохиолдохоос гадна багачуулд бичиг үсэг заахдаа сурах дөхмийг бодолцон, цээжлэхэд хялбар болгож толгой холбосон нэр томъёоны зүйл аман уламжлалаар дамжин

⁴² *Mongγol kelen-ü sinjilel-ün durasqal biäg*, II, Kökeqota, 1986, 28.

хэрэглэгддэг байсныг судлагчид нэг бус удаа тэмдэглэжээ⁴³. Аман уламжлал дахи тэдгээр нэр томъёог үзэхүл зөвхөн үсэгзүйгээр хязгаарлагдсангүй, зөв бичихзүй, хэлзүйн төвшинд ч хамаарч байжээ. Үүнд: дэвсгэр үсгийг цээжлүүлэх зорилгоор зохиосон *baḡarsad, namlang, nebertsel, yaḡan molor* гэх зэрэг сургалтын нэр томъёог дурдаж болно.

Дээр бидний өгүүлсэн сургалт, танин мэдэхүйн нэр томъёо нь гол төлөв иргэний хүрээнд хамаарна. Харин шашин, сүм хийдийн хүрээнд монгол бичиг үзэх, заах явдал багагүй байсан бөлгөө. Үүнд: иргэний аргаас арай өөрөөр, тухайлбал шашны мэдлэг ухаанд дулдуйдан тайлбарлах явдал илүүтэй байжээ. Тухайлбал: цагаан толгойн эгшиг гийгүүлэгч бүх үсгийн дэс даралдаа, амь авах тэргүүтнийг шүлэглэн цээжлүүлдэг уламжлал буй болжээ. Жишээ нь: долоон эгшигээр амь авсан *N(a)* гийгүүлэгчийн тухайд:

Na: *naran sar-a-yin gegen kücün-iyer tedkügsen*
Ne: *negegdegsen nabā ãēãeg-ün ür-e jimis simetei*
Ni: *nigülesküi-yin yeke sang-tu mergede бүкүн āḡulḡan*
No: *nom-un qur-a-yin rasiyan-i ürgelḡide baḡulḡan*
Nu: *nutalḡu joriḡsan-u irügel-ün kücün-iyer*
Nö: *nöküd-üd-ün aman-a-ãa suralãḡāḡ biligten*
Nü: *nüke-ügei erdeni-yi ün-e- ügei abumui...*⁴⁴

Үүнээс гадна монгол бичгийн хүмүүсийн аман уламжлал хийгээд хэрэглээний талаас үзвэл тухайн нэг үсгийн махбодыг ч хэлбэрээр нь ялган нэрлэдэг ёсон элбэг байжээ. Зөвхөн бичгийн сүүл гэхэд л бичмэл, дармал буюу хичээнгүй, бийрийн, барын, хулсан үзгийн гэх буюу тэдгээр нь дотор зуураа өргөх бичгийн сүүл, шаантаг сүүл, өвсөн сүүл, хялгасан сүүл, шодон сүүл, жад сүүл, мухар сүүл, соёо сүүл, заргын сүүл, сэлмэн сүүл гэх зэрэг 20 орчим ялгаатай, тэр ялгаа нь яв явсаар бичих зорилготой холбоотой, тодорхой зорилгод хэрэглэгдэх болсон ажээ. Тухайлбал: өргөх бичиг болон айлтгах бичиг зэрэг өөрөөс ахмад буюу дээд тушаалтанд явуулах бичигт соёо сүүл, заргын сүүл, жад сүүл, хялгасан сүүл бичдэг ёсонгүй, зөвхөн хичээнгүй, тогтуун хэлбэртэй бичдэг байжухуй. Заргын болон соёо сүүлийг зөвхөн арцалдсан буюу заргалдаж тэмцэлдсэн бичиг захианд хэрэглэдэг байжээ. Ийм уламжлал харьцангуй түрүү үед буй болсон бололтой. Солонгос хүнд зориулан 1790 онд зохиосон *Ch'õphae Mongõ* гэдэг монгол хэлний сурах бичгийн эхний хуудсанд л

...*Biãküi-dür tamaḡ-a segül, soyuḡ-a segül, güyilgekü segül*
kemegã gurban jüyil bui . biçiju masi bolbasurayuluyḡan
*qoyin-a sayi biãḡ-ün uār jüi-yi nige nigen-iyer oyilamui...*⁴⁵

гэж дурдсан байдаг нь үүний нутлагаа буюу.

Монгол үсгийн галигийн тогтолцоог улам боловсронгуй болгох талаар хэдэн зүйлийг өгүүлэх хэрэгтэй бөгөөд үүний тул давын өмнө үгчлэн буулгах (дуудалгын) галиг буюу транскрипци, үсэгчлэн буулгах галиг буюу транслитерацийн гол зарчмын тухай авч ярьсугай. Дуудалгын галигийг дотор нь хоёр хуваан үзэж болно. Нэгд, тухайн авиаг тухайн хэл аялгуугаар хэрхэн дуудах байдлыг тусгасан байж болох бөгөөд үүнийг авианы галиг гэж нэрлэх нь ч буй. Монгол хэлний тухайд үүний эртний жишээ гэвэл нангиад, араб зэрэг үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний хэрэглэгдэхүүн болно. Хоёрт, тухайн бичвэрийг хэрхэн зөв дуудах байдлыг тусгасан галиг байж болох бөгөөд үүнийг дуудалгын галиг гэх нь бий.

⁴³ Ch. Luvsanbaldan, *Deux syllabaires oirats*, Acta Orientalia Hung., Tom. XXV, Fasc. 1-3, Budapest, 1972, pp. 209-212; Я. Цэвэл, *Чин сүзэгт номун хан хутагтын шавь*, Түүхийн судлал, 25-р боть, 1-14-р дэвтэр, Улаанбаатар, 1990, 147-148-р тал.

⁴⁴ Профессор Д. Төмөртогтоогийн цуглуулга дахи гар бичмэлээс авлаа.

⁴⁵ *Ch'õpai Mongo*, I, 1.a-1.b.

Монгол бичгийг дуудалгаар нь галиглах явдал нэлээд эрт үеэс эхлэсэн гэж үзэх үндэс буй бөгөөд бидний үед хүрэлцэж ирсэн "Монголын нууц товчоон"⁴⁶, "И-юй" маягийн толь бичиг болон түүнд хавсаргасан бичвэр, мөн түүнчлэн "Сударын чуулган" тэргүүтэн нь даруй монгол бичгээрхи хэрэглэгдэхүүний хэрхэн зөв дуудах байдлыг хятад, араб (перс) үсгээр галигласан баримт гэж үзэх үндэс буй. Бас харьцангуй хожуу үеийн томоохон дурсгал гэвэл солонгос хүнд зориулж солонгос үсгээр галиглан хадсан монгол хэлний *Lao Kida* (老乞大) маягийн *Mongᡔ nogᡔltae*, *Mongᡔ yuhae* зэрэг сурах бичиг, *И-юй* (譯語) маягийн *Ch'ōphae Mongᡔ* зэрэг сургалтын толь бичгийг нэрлэж болно.

Харин XX зууны эхин үеэс монгол бичгийн (дуудалгын) латин галиг (The transcription) үсэг буй болж дэлхийн монголч эрдэмтдийн хувьд одоо болтол онц өөрчлөлтгүй хэрэглэгдсээр байна. Гэвч эх судлал (The Textology)-ын үүднээс авч үзвэл дуудалгын галигийн дотор зарим тохиолдолд үсгийн галиг (The transliteration)-ийн зарчим ямар нэгэн байдлаар холилдсон зэрэг эргэж харууштай зүйл буй. Жишээлбэл: *ᡤ* дуудалга бүхий, эгшиг үсэгтэй нэгэн адил нийлмэл махбодоос бүтсэн *yeke ingkelig* –ийг дуудалгын галигт *ng* (*nūn* + *kāph*) хэмээн тэмдэглэж заншсаныг хэлж болно. Гэтэл зарчимын хувьд үүнтэй адил, нийлмэл махбод бүхий дэвсгэр *-d* (*waw* + *nūn*) гийгүүлэгчийг дээрхийн адил нийлэмж буюу хоёр үсгээр галигладаггүйг бид мэднэ.

Монгол бичгийн үсгийн галигийн тухайд, өнөөдрийн эх бичгийн судлалын төвшин хийгээд үсгийн галигийг хэрэглэх шаардалга зэргээс үүдүүлэн авч үзэхэд эргэж хармаар зүйл ч буй. Үүнд: эх бичгийн судлагааны тал гэвэл: тухайн бичвэрийн цаг үе, газар орон, бичигч этгээдийн чадвар мэдэлгэ зэрэгт холбогдох онцлогийг илэрхийлж чадахуйц баримт нутлагааг гаргах, мөн түүнчлэн бичвэрийн доторхи бусад онцлог, тухайлбал: үг тасласан байдал, тасласан хэсэгт сүүлийн үсгийг дунд буюу эцэст орсон байдлын алинаар төгсгөсөн болох, мөн таслуулсан хэсэгт эхний үсгийг эхинд буюу дунд орсон байдлаар эхлүүлсэн эсэх гэх зэрэг онцлог байдлыг гаргах нь орчин цагийн бичвэр судлалд чухал судлагдахуун болж өгнө. Үүнээс гадна судлагааны явцад юу гэсэн нь мэдэгдэхгүй үг үсэг, эс бөгөөс тогтсон дүрэмээс өөрөөр бичсэн үг, түүнчлэн тогтсон дүрэм ёсоор нэмэлт тэмдэг хэрэглэсэн эсэх, нэг үсгийн хэд хэдэн хувилбарын чухам алийг нь хэрэглэж вэ? гэх зэрэгээр тухайн үгийг тэмдэглэсэн үсэг бүрийн дуудалгыг биш, зөвхөн махбод, хэлбэрийг өөр нэгэн үсгийн тогтолцоогоор дамжуулан үзүүлэх шаардалгаар үсгийн галигийг хэрэглэдэг бөлгөө. Ийм учраас үсгийн галигийг хэрэглэх тохиолдолд дуудалгыг орхиж, зөвхөн хэлбэрийг анхаарах зарчмыг чанд баримтлаж хэвлэлийн боломж зэргээс шалтгаалан, аль нэгэн бичгээр байгаа зүйлийг өөр нэгэн бичгээр буюу хэлбэрийг хэлбэрээр галиглах шаардалгатай. Нэгэнт мөн чанар ийм болохоор үсгийн галиг нь тухайн үгийг уг бичгээр нь сэргээн тэнхрүүлэх боломж олгодог тул дуудалгад шууд холбогдолгүй, зөвхөн хэлбэрт холбогдолтой бөгөөд эх бичвэр дэхи үсгийн махбодын тоо нь түүнийг дамжуулан буулгаж байгаа үсгийн болзмол тэмдэгтэй адил байна гэсэн хэрэг юм.

Монгол бичгийн тухайд хэрэглэж ирсэн үсгийн галигийг 1929 онд анх академич Б.Я. Владимирцов үйгурын 14 үсгийн хэлбэрт дулдуйдаж латин-герег бичгийн тэмдэгтээр боловсруулсан гэж хэлж болно⁴⁷. Гэвч энэхүү үсгийн галигт олон зүйл дээр дуудалга тэмдэглэх зарчмыг хутгасан явдал илэрхий байдаг тул орчин цагийн эх бичгийн судлагаа хийгээд монгол бичгийн үсэгзүйн судлагааны шаардалгаар эргэж нягтлууштай зүйл цөөн бус гарах болжээ гэж үзэх үндэс буй. Тийм ч учраас Мажарын монгол судлалын дэгийнхин монгол бичгийн дурсгалын судлагаандаа үсгийн галигийн зарчмыг дуудалгын галигт давхар харгалзах боломжийг эрэлхийлсэн нь түрүүчийн үед хэрэглэж ирсэн үсгийн галигийг илүү боловсронгуй болгох гэсэн эрмэлзэлтэй холбоотой хэрэг. Гэхдээ цөөн бус тохиолдолд дуудалгын галигийн дотор үсгийн галигийн онцлогийг нэгэн дор тусгах боломж тэр болгон бүрдэж чаддаггүйг үгүйсгэх аргагүй.

⁴⁶ Ts. Shagdarsuren, *On the question of the First original of SHM*, - Mongolian Studies, (The Korean Association for Mongol Studies) N. 2 (1994), Seoul, 1995, pp. 120-123; Ц. Шагдарсүрэн, "Монголын нууц товчоон"-ы уг эхийн талаар эрэгцүүлэх нь, - Эрдэм шинжилгээний бичиг (МУИС), N. XIV (151), Улаанбаатар, 1999, 10-19-р тал.

⁴⁷ Б.Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Ленинград, 1929, стр. 79-89.

Энэ мэтийн шалтгаанаар монгол бичгийн дуудалга хийгээд үсгийн галигийг боловсронгуй болгоход дараахи хэдэн бөлөг асуудлыг зайлашгүй анхаарах нь зүйтэй гэж бодогдоно. Үүнд:

1. Үсгийн махбодын бие даасан хийгээд хувилбар хэлбэрийг газар нутаг, цаг үеэс шалтгаалан тогтсон хэм жишигээс өөрөөр тэмдэглэх явдал олонтаа тохиолддог. Жишээлбэл: үгийн дунд тохиолдох *-yi-* үеийг хэмжүүр болсон дүрэм ёсоор хоёр шилбээр (*yod + yod*) тэмдэглэдэг боловч өвөрлөгч нутаг болон монголын зүүн талын аймагт нэг богино нэг урт шүдээр (*áleph + yod*) бичдэг ёсон буй. Жишээ нь:

ᠪᠢᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨ Тс. *sayin bayin-a*

ᠪᠢᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨ Тс. *sayin bayin-a*

Ийм тохиолдолд дуудалгын галигийн хажуугаар үсгийн галигийг хавсаргаж бичилгийн онцлогийг гаргах нь эхбичиг судлалын хувьд газар орныг тодруулах давхар ач холбогдолтой юм.

2. Монгол бичигийн тогтсон дүрэмд нэгэнт хэрэглэж заншсан нэмэлт тэмдэгийн зүйлс, тухайлбал: амьтай *л-* гийгүүлэгчийн өмнө нэг цэг, амь авсан *γ-* гийгүүлэгчийн өмнө хоёр цэг тавьдаг журамтай боловч харьцангуй түрүү үеийн бичгийн дурсгал, модон барын уламжлалд огт цэг тавихгүй байх буюу *q-* гийгүүлэгчийн өмнө, зарим тохиолдолд дэвсгэр - *γ* гийгүүлэгчийн өмнө хоёр цэг тавьдаг явдал захаас аван дайралддаг. Жишээ нь:

ᠨᠢᠭᠡ Тс. *nige*

ᠠᠨᠠᠨᠳᠠ Тс. *Ananda*

ᠠᠮᠤᠵᠤᠯᠠᠩ Тс. *amuḡulang*⁴⁸

ᠴᠠᠶᠠᠨ Тс. *qayan*

ᠴᠠᠭ Тс. *ḡay*

Иймд тухайн бичвэрийн цаг үе, газар орныг тодруулахад дээрхи онцлогийг үсгийн галигаар зайлашгүй тэмдэглэх шаардалга буй.

3. Ном сударын дотор нэг үгийг таслаж бичих явдал цөөн бус. Тасласан байдлыг үзэхэд, нэгэн мөрийн дотор, эсэхүл хоёр мөрийн хооронд тасласан байх бөлгөө. Хоёр мөрийн хооронд нэг үгийг таслах нь голдуу сударчилсан номын дотор цаасны хэмжээ дамжаанаас үүддэг хэмээн хэлж болно. Аль ч тохиолдолд гэсэн, тухайн тасласан үгийн сүүлчийн үсгийг, таслуулсан хэсгийн эхний үсгийг (эцэст, дунд, эхинд ордог байдлын алинаар нь) хэрхэн яаж бичсэн байдал нь эх бичгийн судлалд чухал болох тухай дээр хөндөж өгүүлсэн тул дэмий олныг нуршсангүй. Тухайлбал:

Нэгэн мөрийн дотор:

ᠪᠣᠳᠢ ᠴᠡᠳᠡᠭᠡᠨ ᠠᠳᠤ ᠢᠷᠡ... *...bodi qutu-ᠭun aḡ üre...*

⁴⁸ *Siluyun budaqun üy-e onoqui neretü sudur* – (“Үлгэрийн далайн судар”, Акад. Йөншөөбү Ринчений хувийн цуглуулга. Цаашид *SBÜONS* гэж товчлоно.) 2.b, 11.b, 194.b; (C. Šagdarsüren, *Le Damamūkonāmasūtra, texte mongol du Toyin Guišā*, Budapest, 1989).

..... *baṣay eb-deregsen*....⁴⁹

Хоёр мөрийн хооронд:

..... *qariyulu-*
..... *yad*.....

..... *ayaγu-*
..... *Gad*.....⁵⁰

Мөн хоёр мөрийн хооронд үгийг таслахдаа нийлмэл махбодтой нэг үсгийг дундуур нь тасласан байх тохиолдол ч буй. Ийм нөхцөлд тийнхүү тасласан байдлыг дуудалгын галигт шингээн үзүүлэх боломжгүй тул үсэгчилсэн галигийг эрхгүй шаардана. Жишээ нь: нийлмэл махбод бүхий дэвсгэр -d гийгүүлэгчийг гол төлөв дараахи байдлаар

..... *sed-*
..... *kimüi*.....⁵¹

гэж нэг дор оруулж тасладаг боловч цөөн бус тохиолдолд доорхи байдалтай тохиолдож байна. Тухайлбал:

..... *ebe½d-*
..... *½dkui*.....⁵²

гэж тасласан байх жишээтэй. Ийм тохиолдолд үүнийг үсэгчлэн буулгах галигаар л тэрхүү онцлогийг харуулж болно.

Энэ мэтийн санамсаргүй гэж хэлж болмоор онцлог зүйл тохиолддог нь бичгийн хүмүүс монгол үсгийн махбодын бүтэцийг сайтар мэддэг байсны баримт тул эх бичиг судлалын үүднээс анхааралгүй орхих аргагүй билээ.

Монгол бичгийн дурсгалд үг таслахын эсрэг тохиолдолд, жишиг дүрэм ёсоор салангид бичдэг үг болон нөхцөлийн зүйлийг хамт бичсэн байх явдал цөөнгүй буй тул үүнийг дуудалгын болон үсгийн галигт аль болохуйц тодорхой тусгахыг эрмэлзвэл зохино.

4. Монгол бичгийн хувьд голдуу үгийн дунд адагт *d/t*, *s* үсэг хэд хэдэн хувилбартай бөгөөд дуудалгын галигт тэр бүрийг шингээн гаргах боломжоор хязгаарлагдмал тул үсгийн галигаар дагалдуулан үзүүлэхээс өөр аргагүй. Жишээлбэл: жишиг дүрэм ёсоор

гэхийг	гэхийг	гэхийг
гэхийг	гэхийг	гэхийг
гэхийг	гэхийг	гэхийг
гэхийг	гэхийг	гэхийг

⁴⁹ SBÜONS, 16.a, 18.b.

⁵⁰ SBÜONS, 18.a, 16.b.

⁵¹ SBÜONS, 15.b.

⁵² SBÜONS, 15.a.

ᠠᠨᠠᠨᠠ

гэхийг

ᠠᠨᠠᠨᠠ

ᠠᠨᠠᠨᠠ

гэхийг

ᠠᠨᠠᠨᠠ

хэмээн бичсэн баримт захаас аван гардаг тул үсгийн галигийн болзмол тэмдэгт шүтэхээс өөр аргагүйд хүрнэ.

Учир иймээс монгол бичгийн үсгийн галигийн болзмол тэмдэгийг улам боловсронгуй болгох шаардалга гарч байгаа тул эхний хувилбараар нэгэн төслийг танилцуулж байна (1-2-р хавсралтыг товч тайлбарын хамт үзмүү). Нэмэн тэмдэглэхэд үсгийн галигийн ийм зарчим нь зөвхөн монгол бичигт төдийгүй дөрвөлжин, тод зэрэг бусад бичгийн тогтолцоонд ч цаашид анхаарваас зохилтой асуудлын нэг бөлгөө.

Монгол бичиг нь хэрэглэгдэж ирсэн цаг хугацааны хувьд зарим хүний муулдагчилан түүний "хуудам сул тал"-ыг засах зорилгоор хожуу зохиогдсон бусад монгол бичигтэй харьцуулахад хамаагүй урт удаан буюу буй болсон цагаасаа өнөөдрийг хүртэл, орон зайн хувьд илүү өргөн буюу нийт монгол туургатан даяар, хэрэглээний хувьд нийгмийн бүхий л хэрэгцээ хангасан буюу улс төр хийгээд шашин номын хүрээнд тогтвортой хэрэглэгдэж ирсэнийг хэн бүхэн сайн мэдэх билээ. Үүний гол үндэс нь юу байв? гэдэг асуулт эрхгүй гарна. Энэ хариуг уг бичгийн үсэгзүй-хэлшинжлэлийнхи нь үндэслэлээс нь олж болно гэж бодож байна.

1. Монгол бичиг нь зарим хүний хэлдэгээр "хуудам" байгаагүй, харин ч үсэгзүйн ухааны үүднээс *a/e, o/u, d/ü, d/t, q/γ, j/y* зэрэг хэлбэр нэг бөгөөд хос дуудалгат үсгээр нутгийн аялгуунуудад харилцан сэлгэдэг дээрхи авиануудыг тэмдэглэсэн нь хэл шинжлэлийн хувьд хамгийн ухаалаг шийдэл байсан гэж үзэх үндэстэй. Энэ зарчим нь бичгээр дамжуулан аль нэгэн зонхилох гол аялгууны онцлогийг бусад аялгуутанд тулгаж хүлээлгэх бус харин нутаг нутагийн аялгууны онцлогийг эрх тэгш тусгах боломжийг бүрдүүлэн өгчээ (3-р хавсралтыг үзмүү). Жишээлбэл:

ᠰᠣᠶᠤᠯ

soyul
suyul

ᠨᠠᠶᠢᠰᠢᠯᠠ

nayislal
neyislel

ᠥᠨᠳᠦᠷ

öndür
ündür

ᠲᠠᠲᠠᠭᠤ

tataqu
dataqu

ᠴᠠᠲᠠᠭᠤ

qatayu
yatayu

ᠵᠠᠰᠠᠭᠤ

jasaqu
yasaqu

гэж унших боломжтой бөгөөд энэ бүх хувилбар нь төв халх, баруун халх, буриад, дариганга, баруун монголын нутгийн аялгуунд цөм эзэдтэй өөрөөр хэлбэл тэдгээр аялгуутан өөр өөрийхөө аялгуугаар уншин дуудаж, цөм ялгалгүй нэгэн адил ойлгож чаддаг бөлгөө. Монгол бичгээр буй бичвэрийг нутаг нутгийнхаа аялгуугаар унших өргөн боломжтой. Өөрөөр хэлбэл аль нэг аялгууны дуудалгыг бусад аялгуутанд хүчээр тулган хүлээлгэдэггүй. Жишээ нь: монгол бичгээр буй *ᠡᠭᠡᠮ* *egem* гэсэн үгийг халхад эгэм гэж уншиж байхад баруун монголчууд маань ээм гэдгээрээ л уншиж цөм нэгдмэл нэг утгаар ойлгодог. Үндэстнийг нэгтгэж өгдөг ийм үүрэг зөвхөн монгол бичигт ч байдаг зүйл биш. Араб, хятад бичиг ч мөн тийм үүрэгтэй. Монголтой харьцуулахад хятад хэлний нутгийн аялгууны ялгаа үлэмхэн их, зарим нь орчуулагчгүй бол нэвтрэлцэхгүй. Гэвч хятад бичиг нь тэднийг нэгтгэн өгдөг тул нэгдмэл хятад хэл гэж дэлхий нийтээр зөвшөөрөн хүлээдэг.

2. Дөрвөлжин, тод, соёмбо, вагиндра зэрэг бичигтэй харьцуулахад монгол үсгийн цөөн бус махбодын хувьд хялбарчлаж бичих боломжтой байдаг нь уг бичгээр түргэн

(татлаж) бичих чадварыг бүрдүүлж өгдөг ажээ. Тэгэхдээ тэрхүү чадвар нь европ дахинаа хэрэглэгддэг, тусхай сургууль хийж байж сая сурдаг *stenography* хэмээх түргэн бичигийн зарчимтай огт адилгүй, монгол бичиг мэддэг хүн бүр аяандаа түргэн бичих дадал суудаг билээ. Монгол бичгээр ийнхүү түргэн (татлаж) бичихэд хоёр гол хүчин нөлөөлдөг ажээ. Үүнд: нэгд, дунд орсон амьтай *d* гийгүүлэгчээс бусад бүх үсгийг нэгэн зүгт буюу нар зөв эргүүлж бичдэг, хоёрт үсгийн махбод дотроос хамгийн олонтаа давтагддаг ацаг (') –ийг өрийн зураасаар хялбарчлан орлуулж болдог явдал болно. Жишээ нь:



Харин тийнхүү ацаг шүдгүй татлан бичих тохиолдолд *n, γ, l, m* зэрэг үсгийн нэмэлт тэмдэг болох *цэг, гэзэг* тэргүүтэн чухал хэрэг болдогийг дурдахад илүүдэх нь юун.

Монгол бичгийн бичээч нарын хувьд *түргэн бичиг, таталган бичиг* гэдэг хоёр өөр ухагдахуун байсан бөлгөө. Бичгийн хүмүүс түргэн бичихийг нэгэн чухал эрдэм гэж үздэг бөгөөд харин таталган бичгийг төдий л таашаадаггүй. Тийм ч учраас нэртэй нэртэй бичээч нарт “гурван чаддаггүй юм” гэж байсан гэлцнэм. Тэр нь юу буй хэмээвээс, удаан бичиж чаддаггүй, буруу бичиж чаддаггүй, ацаг шүдгүй бичиж чаддаггүй, энэ гурав болой. Албан бичгийн зүйл болон дээш өргөсөн бичиг зэрэгт ацаг шүдгүй татласан бичгийг хэрхэвч явуулахгүй. Гэвч ажил төрлийн шаардалга, түргэн шахамдуу байдлаас үүдэж хувийн тэмдэглэл, навтарга ноорог тэргүүтэнд татлаж бичих хэрэг захаас аван гарна. Түргэн бичиж сурсан хүн хэний ч хэлсэн үг, ярьсан яриаг “*ийн уунгүй*” (Мо. –*yin, -un ügei* буюу “юуг ч орхиж гээлгүй”) зэрэг бичиж амждаг байсан нь монгол бичгийн түргэн бичих тогтолцоо ямаршуу боловсронгуй байсныг илтгэх хэмжүүр бөлгөө.

Монгол бичгээр буй хэрэглэгдэхүүнийг үзэхэд хам болоод цуваа цагийн хүрээнд халх, буриад, өвөрлөгчийн гэх зэргээр газар газрын бичгийн хэлбэр нэлээд ялгаатайгаас гадна дотор зуураа бас салбарлан танигддаг тул туршилгаатай хүмүүс жишээлэхэд: халхын бичгийг хараад аймаг хошуугаар нь ялгаж чаддаг байсан гэнэм. Цуваа цагийн үүднээс авч үзэхэд Халхын Цогт хун тайжийн хадны бичээсийн хэлбэр нэлээд өвөрмиц⁵³ (*8-а-р хавсралтыг үзмүү*). Бас 1260-аад оныхи гэж үздэг Каракийн захирагчийн монгол захидлыг зэрвэсхэн харахад араб бичигэрхүү байдаг нь тухайн нутагт өргөн дэлгэр хэрэглэгдэж байсан араб бичгийн нөлөө буй заа гэж үзэх үндэс буй (*11-р хавсралтыг үзмүү*).

Манай уншигдын хувьд харьцангуй бүгт мэдэгдэж буй энэ захидлын талаар товчхон дурдахад, XIII зууны дундуур монголын цэрэгт эзлэгдэж байсан Сири-Палестиний холбогдол бүхий баримт сэлт нэн ховор, гэвч энэхүү монгол бичгийн ховор дурсгалыг 1962 онд францын монголч эрдэмтэн Лүй Амби (Louis Hambis 1906-1978) Франц улсын номын санд 1899 онд орж ирсэн араб дурсгалын дотроос энэхүү захидлыг олж анх эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан төдийгүй тайлан уншиж франц орчуулгыг нь хавсаргасан билээ⁵⁴.

Уг дурсгалын он цагийн талаар проф. Дидиер Газагнаду (Didier Gazagnadou) судлаж тухайн цагийн түүхэн сурвалж, болон судлагааны хэрэглэгдэхүүнд тулгуурлан үзээд лал буюу хиджра тооллын 658 он, аргын 1260 оны хоёрдугаар сараас есдүгээр сарын хооронд болсон үйл явдалтай шууд холбоотой гэж үзсэн бөгөөд цааш нь нарийвчлаж 1260 оны гуравдугаар сарын нэгнээ Монголчууд Дамаскийг авсаны дараахан Хулуугуугийн нэгэн

⁵³ Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1981, 34-р тал.

⁵⁴ L. Hambis, *La lettre mongole du gouverneur de Karak*, - Acta Orientalia Hung. Tom. XV. 1, Budapest, 1962, pp. 143-146;

захирагч-жанжин эсбөгөөс нэгэн бичгийн сайдын зарлиг бичиг хэмээн үзсэн нь буй⁵⁵. Монгол бичвэртэй яг залгуулаад арабаар бичсэн зүйлийг орчуулбал: "Ал-Каракийн захирагч сайд Сайф Ад-Дин эмирийн бичиг" хэмээсэн үг ажээ.

Энэхүү дурсгалын бичгийн хэлбэрийг тэр үеийн монгол бичгээр хоцорсон бусад дурсгалтай харьцуулахад нэлээд ялгаатай арабархуу боловч цэг тэмдэг хэрэглэсэн байдал нь Төв монголын уламжлалтай ойр, албан бичгийн хэл найруулга нь хэдийнээ тогтворжсон байдалтай ажээ.

Ийнхүү монгол бичиг буй болж, өнөөдрийн өдрийг хүртэл хэрэглэгдэж, хөгжин хувисаж ирсэн нь монголчуудын хувьд хүмүүн төрөлхитөний соёлын их санд оруулсан нэгэн хувь нэмэр бөлгөө. Үүний учир гэвэл, эртний арамей гаралтай согд бичгээ VIII зуунд арабуудын шахалтаар, эзэн нь болсон Согдууд өөрснөө мартаж оронд нь араб бичиг хэрэглэх болж, бас согд бичгийг монголчуудтай зэрэг авсан Уйгурууд даан их удалгүй христусын тооллын II мянган жилийн дунд үе гэхэд уйгур бичгээ орхиж мөн л араб бичигт орсон билээ. Ийнхүү согд бичгийн уугуул эзэн нь согд бичгээ, тэднээс уламжлаж авсан уйгур нар ч гэсэн уйгур бичгээ орхин мартажээ. Согд гэдэг үндэстэний нэр зөвхөн түүхэнд л үлдэж, өвтөгш мандаж байсан Уйгур улс ч үгүй болжээ. Хэрэвзээ монголчуудад тийм тавилан тохиолдсон бөгөөс наад зах нь хүн төрөлхитөний буй болгосон нэгэн салбар бичгийн тогтолцоо орхигдон мартагдах байсан нь маргаангүй. Харин монголчууд согд бичгийг эх хэлэндээ тохируулан гайхалтай нарийн боловсруулан хөгжүүлж хэрэглэсээр өнөөдөрийг хүрчээ. Үүнээс гадна тэрхүү монголжин бичигт үндэслэсэн хэд хэдэн монгол бичиг буй болжээ. Бас монгол бичгийг манж нар нэгэн хэсэгтээ хэвээр нь хэрэглэж байсан төдийгүй манж хэлэндээ зохицуулсан манж бичгийг боловсруулахад монгол бичиг үндэс болж өгсөнийг ч мартаж аргагүй. Солонгосчууд үндэснийхээ бичгийг боловсруулахдаа монгол бичгийн тогтолцоог аль нэгэн хэмжээгээр анхаарсан гэж газар газрын цөөн бус судлагчид хүлээн зөвшөөрсөөр байна.

Монгол бичгийн хувьд гадаад үг, нэр томъёог тэмдэглэх бие даасан галигийн тогтолцоог 1587 оны орчим харчины Аюуш гүүш боловсруулсанаар төвөд, самгард, хятад зэрэг харь хэлний үг хэлэлгийг бичих бүрэн боломжтой болсон байна. Нэгэнт самгард хэлний үгийг тэмдэглэнэ гэдэг бол энэдхэг-европ хэлний үгийг тэмдэглэх боломжтой болно гэсэн хэрэг. Ийм ч учраас төвөд, самгард, хятад, орос, франц, англи, герман, латин зэрэг олон хэлнээс орчуулсан уран зохиол, улс төр, шинжлэх ухааны олон салбарын зохиол бүтээл, "Библи" судар тэргүүтэн цөм монгол бичгээр хэдэн зуун ботиор байдаг нь үүний баримт бөлгөө.

Монгол бичгээр үлдэж ирсэн зүйл гэвэл, он цагийн саалт, улс төрийн хямралаар үүдэж үлэмжхэн нь үрэгдсэн гэдэг нь маргаангүй боловч бас чамлахааргүй дурсгал бидний үетэй золгосон билээ. Одоо мэдэхийн хирээр хамгийн эртнийхи гэгдэж буй "Чингисийн чулууны бичиг"(1224/1225) -ээс аваад Ватиканы нууц архивт буй Гүюг хаанаас Их Паптант илгээсэн захидал дээрхи тамгийн дардас (1246), 1240 оны монгол хятад бичээс хэмээгддэг Өгөөдэй хааны зарлиг, Абага хааны захидал (1279), Ил хан Аргун, Гасан нараас Пап ламтан IV Николас болон VIII Николаст илгээсэн албан захидал (1290, 1302), Парис хотноо хадгалагдаж буй Ил хан Аргун, Өлзийт нарын захидал (1289, 1305), Монголын эзэмшилд байсан Сири-Палестины монгол захирагчийн зарлиг (хиджрагийн 658 он буюу 1260 он), мөн Техеранд хадгалагдаж буй хэдэн захидал...⁵⁶; "Зүрхэний толта" хэмээх хэлзүйн бичгүүд, XIII-XIV зууны үед самгард, төвөд, хятадаас монголчлосон "Тахумдуу бичиг", "Бодичарияавадара, түүний тайлбар", Македоны Александрын тухай "Сулхарнайн тууж", "Субашида", "Бурханы арван хоёр зохионгуй" зэрэг иргэний болоод шашны агуулга бүхий сонгодог зохиолуудын орчуулга ..., Юан улсын үед бичсэн худалдааны гэрээ бичиг⁵⁷ (4-р

⁵⁵ Didier Gazagnadou, *La lettre du Gouverneur de Karak*, Relations entre Mamelouks et Mongols au XIIIe siecle, - Etudes mongoles ... et siberiennes, Cahier 18, Paris, 1987, pp. 128-132.

⁵⁶ L. Ligeti, *Preklasszikus emlékek*, Vol. I-II, Budapest, 1963/1964.

⁵⁷ *Chinese History - From Primitive Society Down Through the Qing Dynasty*, Great Wall Books, Beijing, 1988 (Хавсралт дахи гэрэл зураг).

хавсралтыг үзмүү) гэх зэргээр өдгөөг хүртэл жагсаахад агад барагдахгүй олон дурсгал монгол бичгээр байсан нь бидний үед бараг цөмөөрөө үлдэж иржээ. Мөн тухайн үеийнхээ шинжлэх ухааны оргил гэгдэж байсан их бага таван ухааны хэдэн мянган зохиолыг багтаасан 108 боть "Ганжуур", 225 боть "Данжуур", зурхайн гол үндэс "Солбоцон барих бодрол бичиг" зэрэг орчуулгын бүтээлийн дүнд сонгодог монгол бичгийн хэл бүрэлдэн буй болсоноос гадна монгол хүний бичсэн өдий төдий зохиол туурвилыг хэд чулуу, цаас, бөс, үйс, элдэв төмөрлөг тэргүүтэн дээр монгол бичиг тээн авчирсан юм. Харь улсын зүгээс ч монгол бичгийг анхаарч байсан биет баримт буй. Тухайлбал: Манжийн үед Дээд эрдэмтийн 4-р он (буюу 1640) онд Солонгосын нийслэл Сөүл хотноо босгосон *Samjōn-do*⁵⁸-гийн хөшөөний бичгийг манж, монгол, хятадаар бичсэн нь үүний нутлагаа буюу.

Ийм ч учраас монгол бичиг хэдэн зууны туршид нийт монголчуудын тэгш хэрэгцээг бүрэнээ хангаж иржээ. Гэвч энэхүү байдал нь 1930-аад оны үеэс В.И. Сталины зор эзэрхэх бодолго хийгээд түүний *Divide et impera!* буюу *Divide ut regnes!* гэдэг зарчимд нь саад болсоны учир Монгол Улсын албан ёсны бичиг байхаа больж, монгол бичгийн мөн чанарыг мэддэг ярьдаг хүн бүхэн "нармай монголын үзэлтэн" болж амь насаа гээн, түүний "сургамж" нь монгол бичгийн мөн чанарыг хар муйхраар мушгин гуйвуулсан, шинжлэх ухааны үндэслэлгүй тайлбарыг хөхиүлэн дэмжихэд хүргэж яв явсаар хэдэн үеийн туршид олон нийтийг төөрөгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Монгол бичгийг орчин цагийн ярианы хэлнээс холдсон тул өөрчлөх хэрэгтэй гэж хамгийн ихээр буруутгадаг. Тэгээд ч оросжин бичиг авч орчин цагийн ярианы хэлэндээ ойртуулсан гэх боловч хэлшинжлэлийн нарийн мэргэжилтэн нарын үзсэнээр монгол хэлний онцлогийг монгол бичгээс илүү чанд тусгасан гэж үзэхэд эргэлзээтэй ажээ⁵⁹ (*Оросжин бичгийн тухай холбогдох бөлгөөс тодруулан үзмүү*). Аливаа бичгийн хэлийг ярианы хэлтэй тохируулна гэдэг бол хэлшинжлэл, үсэгзүйн ухааны үүднээс чухамдаа боломжгүй асуудал. Үүнийг англи, франц, герман, орос гэх зэрэг дэлхийн олон улсын бичиг үсгийн түүх гэрчлэнэ. Одоо манайхины хошуураад зах зухаас нь мэддэг болсон, дэлхий дахинаа өргөн дэлгэрсэн англи хэлээр жишээ авсу. 1950-1960 оны үед англи хэлний зөв бичихзүйг орчин цагийн англи хэлний дуудалгад ойртуулан засах тухай яриа багагүй дэгдсэн бөгөөд англиар хэлэлцэгч олон орны хэлшинжлэлч нар удаа дараа хэлэлцээд тийнхүү засах аваас англи хэл бичгийн уламжлал үгүй болж, англи хэлний тансаг сайхан аялгуу аажимдаа алдарахаас гадна Британийн англи, Америкийн англи хэлний ялгаатай дуудалга өдий төдий байдаг тул тус тусад нь бичих дүрэм гарч ирсэнээр нэгдмэл англи хэл яваандаа үгүй болоход хүрнэ гэж үзсэн учраас тийм өөрчлөлт хийх шаардалгагүй гэж нийтээр хүлээн зөвшөөрсөн гэдэг.

Үүнтэй жишиж үзвэл хуучин нэгдмэл нэг монгол бичигтэй байсан олон монголчууд 1940-өөд оноос БНМАУ, ЗХУ-д Буриад, Халимагт орос кирилл үсэгт үндэслэсэн гурван өөр зөв бичихзүйтэй болсоноор БНХАУ-ын ӨМӨЗО-ны монголчуудыг оролцуулан үзвэл өнөөдөр нийтдээ дөрвөн өөр зөв бичихзүйтэй болсон нь монгол туургатан хэл, бичгийн хувьд цаашдаа улам уламаар холдох үүд хаалгыг нээсэн бөлгөө. Тэгээд ч олон монгол хэл гэдэг нэр томъёо буй болсон нэгэн шалтгаан нь энэ буй заа. Гэтэл бидний дээр жишээлэн өгүүлсэн англи бичгийн хэлний зөв бичихзүй нь орчин цагийн англи хэлний дуудалгатай огт нийцдэггүй тул англи хэлний толь бичигт толгой үг бүрийн ард хэрхэн зөв дуудах байдлыг тусгай галиг үсгээр хадаж өгдөгийг манай хүүхэд залуучууд саяханаас бүрэн мэдэж эхлэсэн буй заа. Англи хэлний *morning, talking, garden, literature* гэх зэрэг хэн бүхний мэдэх үгийн дуудалга нь бичсэнтэйгээ огт тохирдоггүй бөгөөд яагаад тийнхүү бичих болов гэвэл англи бичгийн хэл эхлэн төлөвшиж байсан тэр үеийн англи хэлний онцлогтой даруй холбоотой ажээ.

⁵⁸ Francis Woodman Cleaves, *The Mongolian Text of the Tri-lingual Inscription of 1640*, (part I), -Mongolian Studies, Vol. XVIII, Bloomington, 1995, pp. 3-47; Francis Woodman Cleaves, *The Mongolian Text of the Tri-lingual Inscription of 1640*, (part II: Notes to the translation), -Mongolian Studies, Vol. XIX, Bloomington, 1996, pp. 3-49.

⁵⁹ Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959; Ш. Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний зүй*, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1967, 125-р тал;

Монгол бичгийн мөн чанарыг мушгин гуйвуулагчид монгол бичигт *a/e, o/u, ö/ü, d/t, q/ɣ, j/y* гэх зэрэг олон авиаг нэгэн үсгээр тэмдэглэдэг нь түүний томоохон сул тал гэж үздэг. Гэвч тэрхүү “сул тал” нь монгол хэлний нутгийн аялгуунуудын онцлогийг жигд тусгаж тэдгээр олон аялгууг эрх тэгш авч үзсэн хэрэг гэж бид дээр өгүүлсэн билээ. Тэгвэл ийм “сул тал” бусад хэл бичигт ямар байдаг вэ? гэдгийг авч үзье. Англи хэлний *bus, bush, business, union, turn, culture* гэдэг зургаан үгэнд орсон *u* эгшиг зургаан өөр дуудалгатай гэдгийг англи хэл үзэж судлаж байгаа хэн болгон мэдэх болсон гэдэгт эргэлзэх нь юун. Зөвхөн англит ч ийм байгаа юм биш, франц, герман зэрэг бүх хэл бичигт нийтлэг байдаг, хэлшинжлэлийн үндэслэлтэй зүйл.

Бусад хэл бичгийн хувьд өрийн байж болдог энэ мэтийн зүйлийг монгол хэл бичиг дээр болохоор “хоцрогдсон” буюу өөрчлөх ёстой “сул тал” гэж буруутгах нь утгагүй бөгөөд шинжлэх ухааны үндэслэлгүй гэдэг нь харагдаж байгаа биш үү.

Сүүлийн үед зарим нэг хүн тус улсад шинэ үсэг хэрэглэх нь монгол бичиг хэрэглэхээс илүү мэдээлэл авах боломжтой гэж сурталдсан нь ч буй. Энэ нь хэний ч бодоожоор бас л гуйвуулсан суртал. Учир нь монголд хэрэглэж байгаа орос шинэ үсэгт суурилсан бичгийн хэл монголоос өөр хаана ч байхгүй. Хэдийгээр бичгийг нь мэддэг боловч Орос хэл мэдэхгүй бол орос хэрэглэгдэхүүн уншаад мэдээлэл авах аргагүй. Буриад, халимагийн “шинэ” бичиг нь орос үсэгт суурилсан боловч огт өөр бичгийн хэлтэй. Гэтэл монголчуудын хувьд нийтлэг монгол бичгийн хэлээр БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орон, Шинжаан-Уйгурын өөртөө засах орон, Ганьсү зэрэг олон мужид асар их хэрэглэгдэхүүн гарсаар байгаа тул харин “шинэ” бичгээс илүү мэдээлэл авах боломжтойг үгүйсгэх аргагүй. Энэ мэтээр монгол түмнийг бодох ухаан, ухах сэхээгүй гэж дорд үзэн монгол бичгийг ёсон бусаар гүжирдэн гуйвуулах явдал монголчуудын дундаас гарсаар байгаа төдийгүй “нохой чихээ хагалсан хүнд янаг” гэдгийн үлгэрээр тэднийгээ дэврээн өөгшүүлсээр байгаа нь нэн хачирхалтай.

Монгол бичгийн хэл хэдийгээр монгол хэлний хөгжлийн эртий үеийн онцлогийг тусгасан боловч мөхсөн хэл огт биш бөгөөд энэ ч чанараараа монгол хэлний сэтгэлгээний мөн чанар хийгээд монгол хэлний хөгжлийн зам мөрийг бидний үед тээн авчирсан гэдгийг тэмдэглэвэл зохино. Үгийн үүсэл, бүтэц, хэлбэр, утгыг тэнхрүүлэн сэргээх, ялангуяа одоо, тухайн аль нэгэн үгийн зөв буруу бичилгэ тэргүүтнийг ялган салгахад монгол бичиг хамгийн найдвартай тулгуур баримт болж өгдөг. Тэхдээ энэ нь зөвхөн монгол бичигт байдаг давуу тал биш ээ. Англи, франц, герман, хятад зэрэг бичгийн хэл нь зөв бичих зүйгээрээ дамжуулан тухайн тухайн хэлнийхээ үүх түүхийг өдгөө болтол хадгалсаар ирсэн юм. Монгол хэлний ийм онцлог байдлыг гадаадын нэртэй нэртэй монголч нар хүлээн зөвшөөрсөөр бөлгөө.

Н. Поппе (N. Poppe) “Монгол бичгийн хэлний зүй”-дээ “...хэдийгээр монгол бичгийн хэл нь ярианы хэл биш боловч мөхсөн хэл огт биш...”⁶⁰ гэж тэмдэглэжээ. 1926 онд Б.Я. Владимирцов академич монгол бичгийн хэлний нийгмийн үүрэг одоо хүртэл хэвээрээ байсаар ирсэн тухай болон монгол бичгийн хэлний бусад онцлогийн талаар тэмдэглэн бичиж байсаныг 1986 он хүртэл дарагдуулан нуусаар ирсэний цаад учир холбогдол тэр үеийн сталинч нарын бодолготой холбоотой байсан гэдэгт одоо эргэлзэх хэрэг нэгээхэн ч үгүй. Түүний бичиж үлдээсэн нь:

“...Монгол бичгийн хэл нь хэдийгээр өдгөөгийн аялгуунаас ялгаатай боловч монголчуудын хувьд нийт даяар нийтлэг үйлчлэж чаддаг нэгэн өвөрмиц онцлогтой юм... Арабуудын тухайд, тэд нар олон улсад хуваагдан аж төрж, монголчуудтай жиших бөгөөс хоорондоо үлэмжхэн илүү зөрөө ялгаатай олон аялгуугаар хэлэлцдэг бөлгөө. Гэвч тэдгээр арабуудын хувьд нэгдмэл бичгийн хэл нь тэднийг нэгтгэх хүчин зүйл болж өгдөг... Монгол бичгийн хэл харьцангуй түрүү үеийн байдалтай тул түүнийг уншиж болох уу? гэдэг асуулт гарах аваас “болно” гэдэг хариулт өгнө. Монгол бичгээр байгаа зүйлийг монголчууд өөр өөрийнхөө аман аялгууны онцлогт тохируулан өөр өөрийнхөөрөө л уншдаг...Монголчууд яруу сайхан ярия гэхээрээ

⁶⁰ N. Poppe, *Grammar of Written Mongolian*, Wiesbaden, 1964, p. 2.

монгол бичгийнхээ хэлэнд л шүтэмүй. Монголын уран яруу илтгэгчид халхын аялгуугаар бус, монгол бичгийнхээ хэлээр л ярьдаг бөлгөө...”⁶¹

гэж тов тодорхой хэлж байсан нь тэмдэглэгдэн үлджээ.

Орчин үед монгол хэл, бичиг болоод ярианы найруулга эрс муудсан тухай олон хүн ярьж яагаад ийм болов? хэмээн асуулт тавьж байна. Эргэцүүлэн бодохул, үүний хариултыг Б.Я.Владимирцовын дээр өгүүлсэн дүгнэлттэй холбон үзэх хэрэгтэй бөгөөд нийт монгол түмнийг хэл болоод бичгийнхи нь хувьд нэгтгэн өгч, тансаг яруу найруулгы нь тээсээр ирсэн монгол бичгийг, монгол бичгийнхи нь хэлтэй өөрчилөсөнтэй давын өмнө холбогдохын сац 1960-аад оны үеэс монгол хэлний нийгмийн үүргийг сааруулж улмаар үгүй хийх гэсэн эрмэлзэл давхар нэрмээс болсон гэж үзэх үндэс бий.

Түүхэн баримтыг сөхөж үзвэл монголчууд эх хэлнийхээ талаархи төрийн бодолгоо цааз хуулиндаа тусгай зүйл болгон оруулдаг байсан тухай баримт буй. Тухайлбал: 1640 оны “Их цааз” хэмээх монгол-ойродын хуулинд:

“...Сайдуудын хөвгүүд монголд (=монгол бичигт Ц. Ш.) эс сэхээрхүнээ эцгээс нь гунан морь аваад (=торгоод Ц. Ш.) хөвүүний нь багшид өгч сурга... Олонд танигдах хүмүүний (+хөвүүд Ц. Ш.) монголд эс сэхээрхүнээ гунан хонь, олонхи мууг (=ер энгийн хүнийг Ц. Ш.) 15 мөнгө...; хөвүүний нь багшид өгч сургах нь урд мэт; Хөвүүний нас 15 хүртэлээ эс сэхээрхүнээ цаазтай...”⁶²

гэх зэргээр хуульчласан байдаг бөлгөө. Харин одоо бол...???

⁶¹ Г.И. Михайлов, *Из наследия академика Б.Я. Владимирцова*, - Mongolica, Памяти академика Бориса Яковлевича Владимирцова (1884-1931), Москва, 1986, стр. 13.

⁶² К.Ф. Голстунский, *Монголо-ойратский закон 1640 года*, Санкт-петербургъ, 1880, текст 25 стр, перевод: 62 стр.

Монгол бичигийн цагаан толгой

No.	м о н г о л ү с э г			дуудалгын (tc.) болон үсгийн (tl.) галиг			
	эхин	дунд	адаг	(tc.)	(tl.) эхин	дунд	адаг
01	ᠠ	ᠡ	ᠢ	a e	'	'	/ (-) / \
02	ᠡ	ᠢ	ᠣ	i	'i	i	k
03	ᠢ	ᠣ	ᠤ	o u	'w	w	b
04	ᠣ	ᠣ	ᠤ	ö ü	'wi	w	b
05	ᠣ	ᠣ	ᠣ	n	n	n '	n- \
06		ᠣ	ᠣ	ng	-	'k	'i/
07	ᠣ	ᠣ	-	q	q	'	-
08	ᠣ	ᠣ	ᠣ	γ	γ	γ ''	γ ''
09	ᠣ	ᠣ	ᠣ	b	b	b	b w/
10	ᠣ	ᠣ	ᠣ	p	p	p	p
11	ᠣ	ᠣ	ᠣ	s	s	s	s '
12	ᠣ	ᠣ	-	š	š	š	-
13	ᠣ	ᠣ	ᠣ	d	t	d w'	d w \
14	ᠣ	ᠣ	-	t	t	d	-
15	ᠣ	ᠣ	ᠣ	l	l	l	l
16	ᠣ	ᠣ	ᠣ	m	m	m	m
17	ᠣ	ᠣ	-	č	č	č	-
18	ᠣ	ᠣ	-	j	i	j	-
19	ᠣ	ᠣ	ᠣ	y	i y	i y	k
20	ᠣ	ᠣ	-	k	k	k	-
21	ᠣ	ᠣ	ᠣ	g	k	k	i/
22	ᠣ	ᠣ	ᠣ	r	r	r	r
23	ᠣ	ᠣ	-	v (w)	v	v	-
24	ᠣ	ᠣ	-	h	'h	h	-

**Согд арван дөрвөн үсгийн толгойг
латинаар үсэгчлэн буулгах ёсон**

No.	Үсгийн махбод	үсэгчилэн буулгах галиг	галигийн нэр
o1	ا	' (/ \')	aleph
o2	و	y (i ²)	yod
o3	و	w	waw
o4	ن	n	nūn
o5	ك	k	kāpt
o6	ه	γ	héth
o7	پ	p (b ³)	pé
o8	س	s	šin
o9	ت / د	t / δ (d ⁴)	taw, dáleth
10	ل	l	lámeth
11	م	m	mém
12	چ	c (č ⁵)	sádhé
13	ر	r	rés
14	و	v	béth

Тэмдэглэл: Энэхүү хүснэгтнээ согд, уйгур бичигийн толгой үсэгт зориулж эрдэм шинжилгээний хүрээнд олон улсад даган мөрдөж хэвшсэн галиг, нэр томъёог хамарсан бөгөөд академич Б. Я. Владимирцов монгол бичигийн Үсгийн галиг (Transliteration)-ийг боловсруулахдаа үүнийг үндэс болгосон билээ. Гэвч үүнээс хойш багагүй хугацаа өнгөрч, монголын судлал, тэр дундаа монгол хэл, монгол бичигийн салбарт урд өмнө мэдэгдээгүй байсан олон баримт хэрэглэгдэхүүн судлагааны эргэлтэд орж, бусад аливаа шинжлэх ухааны нэгэн адил хуучин дүгнэлт саналыг эргэн нягтлах шаардалга ч гарч яг энэ тухай тусгай өгүүлэл ч нийтлэгджээ (Nicolas Poppe, *Vladimirtsov's grammar forty-five years later*, - Mongolian Studies, Vol. 2, 1975, Bloomington, pp.115-131).

Иймд эхбичиг судлалын үүднээс монгол бичигийн Үсгийн галигийг улам боловсронгуй болгох зорилгоор зарим нэгэн өөрчлөлт оруулах саналыг дугуй хаалтад нэмж хавсаргав.

1. Янз бүрийн бичвэрт үгийн эцэст орсон а/е эгшигийг урагшаа цацалга (و) болон хойшоо сүүл (<) маягаар хоёр янз бичсэн баримт захиас аван дайралддаг бөгөөд энэ нь эхбичигийн судлалд хүртээлтэй учир Үсгийн галигт ялгах нь зүйтэй гэж үзсэн болно.

2. Монгол бичигийн "шилбэ"-ийг "у"-гээр тэмдэглэж байсныг "i"-гээр солих санал оруулж байгаа нь харьцангуй хожуу үеийн бичилгэд олонтаа хэрэглэгддэг "у" гийгүүлэгчээс ялгах зорилготой бөлгөө.

3. Монгол хэлний авиазүйн онцлогт тохируулж "b"-ээр тэмдэглэх нь илүү тохирмжтой гэж үзэв.

4. *dáleth* -ыг бичих хэвлэх тэргүүтэнд багагүй бэхшээлтэй гэж үзээд оронд нь "d"-ээр тэмдэглэхэд самуурах зүйлгүйгээс гадна хэвлэх, бичихэд хялбар болох тул ийнхүү солих нь зүйтэй гэж үзлээ.

5. Ийнхүү "č"-ээр тэмдэглэх нь монгол хэлний түүхэн авиазүй болон монгол бичгийн дуудалгад түшсэн хэрэг бөгөөд түрүүн хэрэглэж ирсэн уламжлалтай зөрчилдөх зүйлгүй гэдгийг хэлэх нь зүйтэй.

Эцэст нь тэмдэглэхэд, монгол бичигт зориулсан Үсэгийн галигийн шинэ тогтолцоонд нэмэлт тэмдэг бүхий "n", "γ", "š" зэрэг үсгийг нийлмэл байдлаар нь буюу үндсэн дуудалгаар нь, харин нэмэлт тэмдэггүй үсгийн тухайд махбодоор нь салгаж тэмдэглэх нь зүйтэй гэдэг гол зарчмыг баримласан болно

Үсэгийн галигт зөвхөн хэлбэр дүрсийг анхаардаг гол зарчмыг баримтлаж дээр дурадсан еөрчлөлтийг монгол үсэгийн махбод бүрээр хэрхэн тэмдэглэж болох байдлыг жагсаан үзүүлвэл дараахи мэт болно.

Монгол бичигийн үсэгийн галиг

Үсэгийн үндсэн махбод

ᠠ	(ацаг / шүд)	[ʼ]
ᠠ	(гэдэс)	[w]
ᠠ	(шилбэ / урт шүд)	[i]
ᠠ	(цацалга / урагшаа хаялга)	[/] [ʼ]
ᠠ	(орхиц / сүүл)	[\] [ʼ]
ᠠ	(q)	[q]
ᠠ	(k / g / ng / -i / -y)	[k]
ᠠ	(b / -o, -u, -ö, -ü)	[b]
ᠠ	(p)	[p]
ᠠ ᠠ ᠠ	(s)	[s]
ᠠ	(t / d)	[t]
ᠠ	(t / d)	[d]
ᠠ ᠠ	(č)	[č]
ᠠ ᠠ	(j)	[j]
ᠠ ᠠ ᠠ	(r)	[r]

ᠠ	(y)	[y]
ᠡ	(v)	[v]
ᠢ	(h)	[h]
ᠣ	(-s / - $\frac{1}{2}$ q / - $\frac{1}{2}$ γ)	[']

Нэмэлт тэмдэг бүхий үсэг

ᠨ	(n)	[n]
ᠣᠷ	(γ)	[γ]
ᠰ	(š)	[š]
ᠯ	(l)	[l]
ᠮ	(m)	[m]

**Монгол бичвэрийг дуудалгын болон үсэгийн галигаар
тэмдэглэх зарим үлгэр:**

tl. s'il
tc. sayin

tl. s'il
tc. sayin

tl. 'il'w'd
tc. ilede

tl. 'il'dd
tc. ilede

tl. 'čik/
tc. ečige

tl. 'čik/
tc. ečige

tl. č'
tc. čay

tl. č'
tc. čay

tl. y'k's
tc. yekes

tl. i'k'
tc. yekes

tl. 'd
tc. ed

tl. 'w
tc. ed


tl. 'bw
tc. abu

tl. 'b /
tc. aba


tl. 'b
tc. ab

tl. b'db
tc. batu

Mo. $\text{ᠲ} > t/d$; Mo. tata-, tasiyur




Mo. $\text{ᠬ} > k/x/g$; Mo. köke




Монгол бичиг, монгол нутагийн аялгуутай
шүтэлцсэний зарим жишээ

Mo.  > ö/ö/ü; Mo. öndür
Mo.  > g/x; Mo. bayan-a




Монгол бичиг, монгол нутагийн аялгуутай
шүтэлцэний зарим жишээ

4-р хавсралт



Их Юан гүрний үед "Эдлэн газараа зарсан батламж бичиг"-ийн зураг.
Chinese History - From Primitive Society Down Through the Qing Dynasty,
Great Wall Books, Beijing, 1988 [Хавсралт дахи гэрэл зураг].



"Чингисийн чулууны бичиг"-ийн ерөнхий байдал
(1224/1225 он)

کتابخانه
کتابخانه
حاجی

[illegible]

تَوَلَّى مَا كُنَّا لَهُ بِأَمْرٍ إِلَّا حَقٌّ

ان اساتذہ کی ساری باتیں

در اسلام برای تکوا اسد حق است

ہر ایک اور ایک تیرہ املاح کے ساتھ

الحمد لله الذي جعلنا من عباده الصالحين
والمؤمنين الذين هم خير خلق الله

دوره و احاطه

در تشویش و اندوه و غم

۷۱

۱۰۰

الحمد لله الذي جعل القرآن الكريم
موسمًا من موسمي القرآن

محمد ابراهيم بن محمد
بن محمد بن محمد بن محمد

ایک ایسی رسم ہے جس سے

حدای کائناتی امور

و جانوری که در میان

الحمد لله الذي هدانا لهذا
ما كنا لنهتدي لولا أن هدانا الله

دانشگاه تهران
کتابخانه مرکزی

مجلس شورای اسلامی

کتابخانه ملی افغانستان

وَالْحَمْدُ لِلّٰهِ الَّذِي


رسالة الامام احمد بن حنبل

ॐ नमो भगवते वासुदेवाय ॥
 श्रीगणेशाय नमः ॥
 श्रीकृष्णाय नमः ॥
 श्रीरामाय नमः ॥
 श्रीशिवाय नमः ॥


1246 онд Гүюг хаантанаас Ромын Папад илгээсэн захидал дээрхи тамгын дардас (Уг эх захидал Ватиканы Архивт буй)



1305 онд Ил хаан Өлзийтөөс Францын Гоо Филипп вантанд илгээсэн захидлын эхний хэсэг (Уг захидал Франц Улсын Архивт буй)



Цогтын хадны "Их бичээс"-ийн байдал (1624 он)



Тайлбар:

- I: Цогтын хадны "Их бичээс"-ийн баримт
 II: Цогтын хадны "Дунд бичээс"-ийн баримт
 III: Цогтын хадны "Бага бичээс"-ийн баримт
 1, 2, 7... Тухайн бичээсийн мөрийн дугаар

Цогтын чулууны бичиг дэх үсэгийн зурам байдал



"Бурханы арван хоёр зохионгуй"
хэмээх номын модон барын хэвлэл (XIV зуун)

ХЯТАН БИЧИГ

Хүн төрөлөхитөний нийгэмлэг үүсэн буй болсон цагаасаа өдий төдий үсэг бичгийг салбарлуулан зохиож, хэрэглэж ирсэн бөгөөд нэлээд зарим нь түүхэн нөхцөл, улс төрийн шалтгаан хийгээд он цагийн саалтад арга буюу мартагдахад хүрдэг ажээ.

Ийнхүү нэгэнт мартагдсан олон зүйл үсэг бичиг нь тухайн улс түмний утга соёлын их ололт төдийгүй түүхийн бодот баримт сэлт болдогийн хувьд олон эрдэмтний мэдэлгэ ухаан, тэвчээр зоригий нь шалгасаар ирсэн билээ. Мартагдсан буюу үл мэдэгдэх үсэг бичгийг тайлж уншихад хүч хөдөлмөрөө зориулсан олон эрдэмтний дотроос 1828 онд Мисирийн үсэг бичгийг тайлан уншсан Францын эрдэмтэн Ж.Ф. Шампольён (J.F. Champollion, 1790 - 1832), Орхон-Енисейн бичиг хэмээн нэрлэдэг эртний түрэг бичээсийг 1893 онд тэнхрүүлэн уншсан Данийн эрдэмтэн В.Л. Томсен (V. Thomsen, 1842 - 1927), нэн эрт цагт Америк тивд өвөрмиц соёл иргэншлээ бүтээн цогцлосон Майа хэмээх Индей нарын бичгийг 1955 онд тайлж уншсан оросын эрдэмтэн Ю.В. Кнорозов (1922 -) нарын судлагаа дэлхийд алдаршсан нээлт болсоныг бид мэдэх бөлгөө.

Аливаа нэгэн үл мэдэгдэх буюу мартагдсан үсэг бичгийн дурасгалыг хэлшинжлэлийн үүднээс ерөнхийд нь гурав ангилаж үздэг бөлгөө. Үүнд: нэгд, ямар хэлээр бичсэн нь мэдэгдэхгүй боловч ямар бичгээр байгаа нь мэдэгдэж байгаа дурасгал; ийм тохиолдолд хэлий нь эхлэж тогтоох хэрэгтэй болно. Хоёрт, ямар хэлээр бичсэн нь мэдэгдэж байгаа боловч ямар бичгээр байгаа нь үл мэдэгдэх дурасгал; ийм нөхцөлд эхлээд бичгий нь тайлж унших шаардалга гармуй. Гуравт, ямар хэл, ямар бичгээр байгаа нь мэдэгдэхгүй дурсгал; энэ тохиолдолд хоёр үл мэдэгдэхүүний нь тайлж байж сая унших ёстой болдог тул учир шалтгааны өдий төдий холбоог тайлах бэрх бөгөөд хүчир шаардалга тулгардаг байна¹.

Харин үл мэдэгдэх буюу мартагдсан үсэг бичгийн дурсгалын нэлээд зарим нь азаар өөр аль нэгэн хэл бичгээрхи орчуулгатай хадмал байдаг нь тайлж унших төвөгтэй ажлыг их бага аль нэгэн хэмжээгээр хялбарчлаж өгдөг

Монголчууд бидний хувьд ч харьцангуй хожуу үед, тухайлбал ХТ-ын тооллын Х зууны эхээр хятан бичгийг зохиосон нь дэлхийн мартагдсан үл мэдэгдэх бичгийн тоог нэгээр ахиулж, түүнийг тайлж унших гэсэн олон орны эрдэмтний анхааралыг татаж, хүчий нь сорьсоор байна.

Энэ нь Төв Азийн нүүдэлчдийн нөлөө түлхээсээр Хятадын өвөг дээдсийнхний нөр их хөдөлмөр, хүч хөлсөөр цогцлож дэлхийн гайхамшигт бүтээлийн нэгд зүй ёсоор тооцогддог Их цагаан хэрэмийн архан биеэр аж төрж 906 - 1125 оны хооронд Их Ляо хэмээх төр улсаа байгуулж 1125 онд түүхэн нөхцөл шалтгааны эрхээр Зөрчидийн Алтан улсад цохигдоход орж өгөөгүй хэсэг нь өрнө зүг рүү нүүж Баруун Ляо улс буюу зарим түүхэнд Хар Хятан гэж тэмдэглэгдсэн улсаа байгуулж явсан, монгол угсааны Хятан нарын зохион хэрэглэж байсан хоёр зүйл бичиг үсэг болой.

¹ J. Friedrich, *Entzifferung verschollener Schriften und Sprachen*, Berlin, 1954; И. Фридрих, *Дешифровка забытых письменностей и языков*, Москва, 1961; Ц. Шагдарсүрэн, *Нэн эртний бичиг үсгийг тайлан унших нь*, - Шинжлэх ухаан амьдрал, 1977, N. 6, Улаанбаатар, 66 - 69 х.

Шинэ тутам бичиг үсэг зохиосон тэр цагт Хятан нар хүчирхэгжиж тухайн үеийнхээ олон улсын жишигээр нутаг газраа тэлж, дотоодтоо соёл боловсрол, эрдэм ухааныг үлэмжхэн хөгжүүлж хэд хэдэн дээд сургууль болоод шинжлэх ухааны байгуулга бүхий таван том хоттой байсан ажээ. Үүний хэрээр ч хятаны эдийн боловсрол (The Material culture)-ын хажуугаар утга соёл (The Spiritual culture) нь цэцэглэж түүхийн зохиол хийгээд олон төрөл зүйл бүхий уран зохиол ихэд гарч, ялангуяа замын тэмдэглэл бичих явдал хэв заншил болж хэвлэлийн ажил хөгжсөн нь Төв Ази дахины бусад улс орны анхаарлыг зүй ёсоор татах болжээ. Тухайлбал: 925 онд Цагаан Солонгосоос хятан хэл бичиг сурахаар сурагчид бөөнөөр ирж байсан тухай баттай мэдээ хийгээд XII зуунд Зерчидүүд, XV зууны эхин хагаст Солонгосууд үндэснийхээ бичгийг боловсруулахдаа хятан бичгийн тогтолцоог аль нэгэн хэмжээгээр харгалзсан зэрэг баримтыг энд сөхөн дурдаж болно². Энэ мэт бодат баримтаас үзэхэд цоо шинээр бичиг үсэгтэй болмогц дорхоноо соёлын хувьд ийм өндөр хөгжилд хүрсэн гэж үзэх нь эргэлзээтэй тул өмнө нь ямар нэгэн бичигийн багагүй боловсролтой, тогтсон уламжлалтай байсныг харуулж байгаа хэрэг.

Төр улсаа тулгар байгуулж, соёл боловсролоо үлэмжхэн өрнүүлсэн Ляо улсын хувьд төр улсын гэх үсэг бичиг шинээр зохион гаргах шаардалга эрхгүй тулгарсан буй заа. Юан улсын үед монголын түүхч То-то нарын зохиосон "Ляо ши" буюу "Ляо улсын судар"-ын хоёдугаар бөлөгт буй мэдээнд:

"...Шэн-цэ буюу Гэгээн өргөмжитийн 5-р оны тэргүүн сарын И-чоу хэмээх хөхөгчин үхэр өдөр хятаны "их бичиг"-ийг зохиож эхлэсэн бөгөөд 9-р сарын Жэн-ин хэмээх хар барс өдөр дуусчухуй. Түүнийг хэрэглэх дээдийн зарлиг буувай..."

хэмээжүхүй. Энэ нь аргын тооллын 920 онтой тохирно. Энэхүү "их бичиг" хэмээгч нь хэдэн мянган тэмдэгтэй гэх тул нэг дүрс нь нэг тодорхой утга илэрхийлдэг санаа бичгийн шинжтэй гэж үзэх үндэстэй бөлгөө³.

Бас түүнээс таван жилийн дараа буюу 925 онд хятаны "бага бичиг"-ийг зохиосон тухай нэлээд тодорхой баримт "Ляо улсын судар"-ын 64-р бөлөгт буй. Түүнийг утгачлан өгүүлвэл: Хятаны нөлөө бүхий Елүй овогоос гаралтай нэр нь И, өргөсөн цол нь Абоожи, багын нэр нь Ми-хи, оны цол нь Тайзү, орос түүхийн ном зохиолд Аньбацзянь, монголын шинэ цагийн түүхийн ном дэвтэрт Амбагянь хэмээгч 916 - 926 онд Ляо улсын хаан ширээнд сууж байсан билээ. Нэгэн удаа Уйгур улсаас элчин төлөөлөгч Тайзү хаантанд бараалхах болохуйяа тэдний хэлийг мэдэх хүмүүн үгүй тул Улсын хатанаас Тайзү хаанд "Де-ла ухаалаг сэргэлэн хүн. Тэр утгаар очиг!" хэмээн айлтгасан гэдэг. Тэгээд Де-ла утгаар эчиж тэдэнлүгээ хориод хоноод хэл, бичгийг нь сурч ирсэн бөлгөө. Сүүлд тэр хятаны "бага бичиг"-ийг зохиожухуй. Тэр бичгийн тэмдэгт нь цөөн, ердөө хэдхэн зуу боловч бүхий л зүйлийг багтаасан нь нэвтэрхий сайн гэх зэргээр товтойёо тэмдэглэжээ.

Тийнхүү 925 оны мэдээнд удаа дараа гардаг Де-ла хэмээгч нь Тайзү хааны удмын хүмүүн бөгөөд хожимдоо хаан төрийн эсрэг үгсэн хуйвалдагч, оргуул урвагч болсон гэх боловч эзэн хаанаас төрийн төмөр нүүр гаргалгүй удаа дараалан өршөөсөн тухай баримт ч бас тохиолддог.

Хятаны "их бичиг" зохиосны дараа тавхан жил болоод чухам юуны учир "бага бичиг" зохиох болов? гэдэг асуулт аяндаа гарна. Хариуг түүхэн тэмдэглэлээс хайвал зохино. Учир шалтгааны хувьд үүнд холбогдож болохуйц хоёр сонирхолтой мэдээ "Таван

² Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх, тэргүүн боть, Улаанбаатар, 1966, 163; Б.Сумьяабаатар, ХШ - Х1Ү зууны монгол солонгос харилцааны бичгүүд, тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1978; Ц.Шагдарсүрэн, Монгол солонгос бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд, - Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), N. 4, 1996, Seoul, pp. 169-191; Ts. Shagdarsuren, A Study of Relation between the Korean and Mongolian Scripts (The Research Paper for Korean Foundation), Seoul, 1998.

³ Д. Кара, Книги монгольских кочевников, Москва, 1972, стр. 9-10.

төрийн хуучин түүх"-нээ тэмдэглэгдсэн нь буй. Юун хэмээвээс; Елүй Амбаянь хэмээгч Тайзү хааны удаа дараа хэлсэн үгийг эшлээ:

"...Би хятад хэл сайн мэдэмүй. Гэлээ ч нүүдэл иргэн намайг дууриах болуужин хэмээж хятадаар би хэзээ ч ярия гэдэггүй. Тэгэх бөгөөс дайчин эрс маань аймхай гулчгар болох авай..."

гэсэн гэдэг. Мөн сурвалжийн дотор хэдхэн хуудасны дараа уг санааг арай өөрөөр:

"...Би хятад хэл мэднэ. Гэвч түүнийгээ нүүдэл ардад мэдүүлдэггүй. Юун хэмээвээс тэд нар хан үндэстнийг дууриах бөгөөс аймхай гулчгар болуужин хэмээж болгоомжломуй..."

хэмээн давтсан нь буй⁴.

Энэ бүхнийг эргэцүүлэн бодохул, хятаны "их бичиг" нь хятад үсэгт дулдуйдаж зохиогдсон, дүрс үсэгтэй байсан байж болох бөгөөд хэрэвээ тийм бөгөөс Тайзү хаан үүнд сэтгэл үл түвдэж, өөрийн гэсэн өвөрмиц бичигтэй болох бодолго баримтласан байж болзошгүй юм. Тэгж үзвэл хятан "их бичиг" нь "бага бичиг"-ээсээ тодорхой ялгарах ёстой болно. Чухам ямар ялгаа байж болох вэ? гэдэг асуулт гарч ирэх ёстой.

Нэгэн хэсэг эрдэмтэн, түүний дотор манай түүхчдийн дунд хятан "бага бичиг"-ийг уйгур цагаан толгойг үндэслэн зохиосон гэж таамаглан тэмдэглэдэг явдал буй бөгөөд үүний учир начирыг мөшхин үзвэл дээр эшлэн дурадсан зүйлд уг "бага бичиг"-ийг зохиосон гэх Де-ла хэмээгч Уйгур нарын дунд хориод хонож тэдний хэл бичгийг сурсан гэдэг мэдээнээс улбаалсан тул тийнхүү таамаг дүгнэлт гаргасан⁵ болов уу? гэж бодогдоно.

Одоогоор бидний мэдэж буй хятан "их бичиг", "бага бичиг"-ийн дурсгалуудыг авч үзэхэд уйгур үсгийн хэлбэрт шүтэж зохиосон гэмээр баримт, тухайлбал үсгийн хэлбэр байдал, тэдгээрийг холбон бичих ёсон хийгээд хятан бичгийн талаар өнөөг хүртэл гарсан судлагааны дүнд сэргээн тэнхрүүлсэн дуудалга зэрэгт нэгээхэн-бээр ч харагддаггүй билээ.

Хятан хэлний гарал, онцлогийн талаар саяхан болтол нэгдмэл саналтай болж чадаагүй байсан бөгөөд нэгэн хэсэг нь монгол төрлийн гэж байхад нөгөө зарим нь манж хамниганы бөлөгт хамааруулж, бас зарим нь Нийт Алтай хэл (The Common Altaic Languages)- ний дундынхи гэж үздэг байсан явдал буй.

Ляо улс тухайн цагтаа Төв Азийн олон хэлийн улсыг нэгтгэж байсан нь маргаангүй боловч гол мөхлөг нь монгол угсааны, төрийн албан ёсны хэл нь эртний монгол хэлний нэгэн салбар байсан гэдгийг П.Пеллио (Paul Pelliot), Б. Лауфөр (B. Laufer), Л. Лигети (L. Ligeti) нар үзсээр ирсэн бөгөөд энэ үзэл баримтлал нь улам бүр лавшран батлагдсаар байгаагийн зэргэцээ хятадын түүхэн тэмдэглэлд нангиад галигаар тэмдэглэгдэж үлдсэн *nair* "нар", *sair* "сар", *tau* "тав", *jau* "зуу", *šawā* "шувуу", *qašū* "төмөр", *po* "он", мөн түүнчлэн энэ хир тайлж уншисан хятан бага үсгийн дуудалгаар тэнхрүүлэн сэргээсэн *taula* "туулай", *sau(u)lga* "суулга-", *yau(u)lga* "явуулга-" гэх зэрэг нэлээд хятан үг нь өдгөөгийн дагуур монголчуудын хэлний онцлогтой их л ойр болох нь тодорхой харагддаг⁶.

⁴ Материалы по истории древних кочевых народов группы Дунху, Москва, 1984, стр. 178, 192.

⁵ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх, Улаанбаатар, 1984, 137.

⁶ L. Ligeti, *Mots de civilisation de la Haute Asie en transcription chinoise*, - AOH, Tomus. I, Budapest, 1950, pp. 141-185; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 10; Engkebatu, *Daγur kelen- ü teüken-dü qolbuγdaqu kedün asaγudal*, - Erdem sinjilgen-ü ögülel-ün tegübüri, III emkidkel, Kökeqota, 25-41; Nangrub, *Kitan kelen-ü γarul-un tuqai*, - Neyigem-ün sinjiiekü uqayan, 1986, N. 2 (21), Kökeqota, 97-130; G. Kara, *On the Khitan writing systems*, - Mongolian Studies, Tom. X, 1986-1987, Bloomington, Indiana, pp. 19-24.

Хятан бичгийн дурсгалыг ерөнхийд нь авч үзэхүл цаг хугацааны хувьд Х зууны сүүл үеэс XII зууныг хүртэл буюу зуу гаруй жилийг хамарна. Үүнд: Гутайшиминшизи-гийн бичээс, эзэн хаан Синзүн, улсын хатан Сюан-и, Жэн-и, Даозүн болон төрийн түшмэдийн дурсгалд зориулсан гэрэлт хөшөө зэрэг 20 гаруй томоохон бичээсүүдээс гадна дүгрийг, наймалжин хүрэл толийн бичиг, загас хэлбэртэй тамгын бичиг, зоос хийгээд тоосго, пайз, шаазан савын ёроолын бичээс зэрэг 40-өөд дурсгал одоогийн БНХАУ-ын умард нутгаас олдсон билээ⁷.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Хятан улсын үеийн 10 шахам хот балгадын туурь үлдэгдэл буйгаас гадна хятан бичгийн дурсгал бүхий газар тийм ч цөөнгүй бөгөөд үүнээс Орхоны эрэг дээрхи Алтан Индэр уулын ойролцоохи Елүй Амбаганы байгууламж - Чин толгойн балгас орчмоос олдсон хятан бичээс бүхий дээврийн ваар (ийм ваар байдаг тухай ХШ зууны эхээр монгол нутгаар явж Дундад Ази хүрсэн хятадын бумба Чанчүн тэмдэглэлдээ бичсэн нь буй) болон монголын нэрт түүхч Х. Пэрлээгийн тэмдэглэсэнчлэн монголын дорнод нутгаар тархсан 20 орчим дурсгалыг дурдаж болно⁸. Үүнд давын өмнө Хэнтий аймгийн Салбарын бичигт ханан хад, Рашаан хадны бичээсийг дурдах нь зүйтэй буй заа.

Цаашид сайтар сурвалжлан эрвээс Монгол хийгээд БНХАУ-ын нутаг дэвсгэрээс хятан бичгийн дурсгал нэмж олдох боломж буй. Тухайлбал: 1983 онд Хятадын Ляонинг мужаас хятад орчуулга хадмал бүхий 70 мөр хятан бичээс олдсон байна. Энэ дурсгал нь хэмжээгээрээ түрүүн олдож байсан бичээсүүдээс том төдийгүй агуулгын хувьд ч өргөн бөгөөд илүү иргэнлиг чанартай, хэлний хувьд зарим нутгийн аялгууны онцлогийг тусгасан өвөрмиц байдалтай болохыг нангиад орчуулгаас нь мэдэж болно.

Энэ дурсгал нь хятаны дээдэс язгууртнуудын гардаг алтан ургийн Елүй овогийн Renxian гэгчийн гэрэлт хөшөө белгөө. Уг дурсгалыг Ляо-нинг мужийн Бичгийн дурсгал судлах газрын ажилтан Хан Бао-шинг үсэгзүйн талаас нь, мөн мужийн Нийгмийн Шинжлэх ухааны академийн ажилтан Жи ши эхбичиг судлалын талаас нь судлаж 1991 онд Өвөр монголын Их сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүлд тус тус нийтлүүлжээ⁹.

Ер нь хятан бичгийн дурсгалыг нийтлэж судлах ажил XIX зууны дунд үеэс эхлэжээ. Үүнд: 1842 онд Иакинф (Н.Я. Бичурин)¹⁰, 1860 онд А. Уайли (A. Wylie)¹¹ нарын хэвлүүлсэн дурсгал нь Европ дахинд хятан бичгийн хэрэглэгдэхүүнийг анх танилцуулсан гавъяатай юм. Харин монголын болоод гадаадын судлагчдын бүтээлд зөрчид бичгийн дурсгалыг хятан бичгийнхи гэсэн буюу хятан бичгийн дурсгалыг зөрчид бичгийнхи гэх зэргээр андуурсан явдал нэг бус тохиолддог гэдэгийг санахад илүүдэхгүй.

Харин хятан бичгийн дурсгалыг тайлан унших гэсэн олон эрдэмтний оролдолго нь 1933 онд гарсан Ло Фү-чэн, Ман Цин-жү нарын тус тус бичсэн судлагаагаар эхлэсэн гэж үздэг¹². Хэдий тийм боловч үүнээс өмнө хятан хэл, бичгийн талаар германы Клапрот (J.

⁷ Cinggeltei, *Kidan bay-a üsüg-ün suduluγan-u bayidal-ača* (Nökübürilekü materiγal) Гарбичмэл; 清格尔泰 刘凤翥 陈乃雄 于宝林 邢复礼, *契丹小字研究*, 北京 一九八五年.

⁸ Х. Пэрлээ, *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*, Улаанбаатар, 1959.

⁹ 韓寶興 契丹小字 “耶律仁先墓志” 考釋 (Han Baoxing, *Textual Research on an Inscription in Chitan Small Characters Discovered on a Memorial Tablet within Yelu Renxian's Tomb*); 即寶, “*契丹墓志*” 校抄本及其它 (Ji shi, *A Collated version of Yelu Renxian's Tomb inscription*), 內蒙古大學, 學報. - Öber Mongyol-un Yeke surγayuli, Erdem sinjilgen-ü sedkül, Hohhot (呼和浩特), 1991, N. 1, 70-78, 79-106.

¹⁰ Иакинф (Н.Я. Бичурин), *Статистическое описание китайской империи*, Санкт-Петербург, 1842, ч. 2, приложение.

¹¹ A. Wylie, *On an Ancient Inscription in the Neu-chin Language* - The Journal of the Royal Asiatic Society of the Great Britain and Ireland, 1860, pp. 331-345.

¹² 羅福成, *遼宣懿皇后哀冊釋文*, 滿洲學報. (Mansyu Gakuho) No. 2, 1933; 王靜如, *遼道宗及宣懿皇后契國字哀冊初釋*, 國立中央研究院歷史語言研究所集刊. t. III, 4, Peipin, 1933.

Klaproth), польский О. Ковалевски (O. Kowalewski), В. Котвич (W. Kotwicz) зэрэг эрдэмтдийн бичсэн өгүүлэл¹³ удаа дараа гарч байсныг хэлэх ёстой.

Мөн оросын Л.Н. Рудов, францын Л. Амбис (L. Hambis), японы Мурайама (Sh. Murayama), Ж. Тамүра, (J. Tamura), Ю. Кобайаши (Yu. Kobayashi) нар хятан хэл бичгийн судлагаанд холбогдох шинэ хэрэглэгдэхүүнийг эрдэм шинжилгээний гүйлгээнд оруулж, сонирхолтой санал дүгнэлтийг дэвшүүлжээ¹⁴.

Тэдгээр судлагаанаас үзэхэд Л.Н. Рудов хятан хэлийг хамниган гаралтай гэж¹⁵ үзсэн байх ба С. Мурайама хятан бичгийг Орхон-Енисейн түрэг бичигтэй харьцуулан судлажээ¹⁶. П.Пеллио, Л.Лигети, Л.Амбис нар хятаны Ляо улсын төрийн хэл нь монгол хэлний салбарт багтана хэмээн үзжээ¹⁷.

1960 хэдэн оноос зөвлөлтийн эрдэмтэд хятан хэл бичгийн судлагаанд нэлээд анхаарч В.С. Таскин, Э.В. Шавкунов нарын өгүүлэл гарснаас гадна В.С. Стариков, В.М. Наделев нарын удирдалгаар М.А. Пробст, М. Арапов нарын эрдэмтэд хятан бичгийн дурасгалыг цахим тооцоолуурт оруулж үсгийн тэмдэгтийн толийг гаргах оролдолго хийсэн бөгөөд үүний дүнд хятан хэл нь хэвшинжийн хувьд залгамал бөгөөд монгол гарлын хэл гэдэг нь нутлагдсанаас гадна хятаны "бага бичиг" нь залгамал хэлний зүйд тохирсон буюу өөрөөр хэлбэл үгийн утгат хэсэг бүрийг хойно хойноос нь цувуулан нэгэн цогц болгон бичдэг нь тодорхой болсон билээ¹⁸.

1975 оны үеэс БНХАУ-ын профессор Чингэлтэйн удирдалгаар Өвөр Монголын Их сургууль хийгээд Хятадын ШУА-ийн цөөн тоот үндэстнийг судлах газрын хэсэг эрдэмтэн, мэргэжилтэн нар хятан бичгийг судлах хамтлаг байгуулан ажиллаж буй нь хятан судлалд ихээхэн хувь нэмэр оруулсаар байгааг тэмдэглэвэл зохино¹⁹.

¹³ Klaproth, *Asia Polyglotta*, Paris, 1823; О. Ковалевски, *Кидань (Династия восточных монголов)*, - Журнал Министерства народного просвещения, 1839, чв XXIV, отд. 2, стр. 80-92; W. Kotwicz, *Les "Kitais" et leur ecriture*, - Rocznik Orientalistyczny, T. II, 1925, pp. 248- 250.

¹⁴ L. Hambis, *Premier essai deshiffrement de la langue Khitan*, -Comptes Rendus de l'Academies des Inscriptions et Belles-lettres, Paris, 1953, pp. 121-134;

村山七郎, *契丹文字解讀 方法, 語言研究*. (Kengo kengyu), N. 17-18, Tokyo, 1951, 47-70; Jitsuzo Tamuro, Yukio Kobayashi, *Tombs and Mural Paintings of Ch'ing-Ling, Liao Imperial mausoleum of Eleventh Century A.D. in Eastern Mongolia*, vol. I (Text), II (Plates), Kyoto, 1953, 1952.

¹⁵ Л.Н.Рудов, *Проблемы киданьской письменности*, - Советская этнография, Москва, 1963, N. 1, стр. 89-98.

¹⁶ 村山七郎, *契丹文字解讀の方法, 語言研究*. (Kengo kengyu), N. 17-18, Tokyo, 1951, 47-70.

¹⁷ W. Kotwicz, *Les "Kitais" et leur ecriture*, - Rocznik Orientalistyczny, T. II, 1925, pp. 248- 250; L.Ligeti, *A Kitai nep es nyelv, Magyar Nyelv*, Budapest, 1927; Л.Лигети, *Рецензия на книгу Г.Д. Санжеева "Сравнительная грамматика монгольских языков", том. 1, Москва, 1953, - Вопросы языкознания, 1955, 5, Москва, стр. 134, 138; L. Hambis, *Premier essai deshiffrement de la langue Khitan*, -Comptes Rendus de l'Academies des Inscriptions et Belles-lettres, Paris, 1953, pp. 121-134;*

¹⁸ В.С. Таскин, *Опыт дешифровки киданьской письменности*, - Народы Азии и Африки, N. 1, Москва, 1963, стр. 127-147; Э.В. Шавкунов, *К вопросу о расшифровке малой Кидань-чжурчженьской письменности*, - Эпиграфика Востока, т. XV, Москва, 1963, стр. 149-153; В.С.Стариков, В.М. Наделев, *Предварительное сообщение о дешифровке киданьского письма*, Москва, 1970, стр. 2-26; М. А. Пробст, *О машинной разработке киданьских текстов*, - Предварительное сообщение о дешифровке киданьского письма, Москва, 1970, стр. 27-34; *Материалы по дешифровке киданьского письма*, Книги I, II, Москва, 1970.

¹⁹ 清格尔泰 刘凤翥 陈乃雄 于宝林 邢复礼, *契丹小字研究*, 北京 一九八五年.

Мажарын монголч эрдэмтэн Д.Кара профессор тал талын өргөн далайцтай мэдэлгэдээ тулгуурлаж хятан бичгийн дурсгалыг үсэгзүй, хэлшинжлэл, түүхийн талаас нь нарийвчлан судлаж шинэ санал дүгнэлт бүхий бүтээлээ нийтлүүлсээр байна²⁰.

Хятан үсэг бичгийн талаархи дээр дурдсан судлагаанд тулгуурлахын сац монгол нутагт буй хятан бичгийн дурсгалыг нүдээр үзэж танилцан явсны учир зарим нэгэн бодол саналаа товч танилцуулсуу. Төв Азийн олон ард түмний бичиг үсгийн дурсгалын дотор хятад зэрэг өөр хэлний орчуулга хаддаг заншил нэлээн өргөн байдаг боловч тэр болгон дурсгалыг бүхэлд нь орчуулалгүй, зөвхөн магнай болон төгсгөлийн хэсгийг орчуулан хадсан байх буюу эс бөгөөс бүхэлд нь орчуулсан тохиолдолд орчуулгын тогтсон уламжлалын дагуу үгчилэж хадалгүй, орчуулж буй хэлний зүй, найруулгын өнгө аясад таацуулж утгачлах явдал дэлгэр тохиолддог билээ. Ингэх нь ч тухайн хоёр хэлний хэлзүйн ялгаатай байгуулалт, орчуулгын уламжлалтай холбоотой хэрэг. Ийм байдал ч хятан бичгийн дурсгалд нэгэн адил хамаарна. Ийм болохоор тухайн дурсгалын бүрэн орчуулга байв ч хүн хийгээд газар усны оноосон нэр, тоо зэргээс бусад ерийн үг хэлэлгийг тэр бүр дүйлгэн тэнхрүүлэх аргагүйд хүрдэг бөлгөө.

Энэ ташрамд нэмэн тэмдэглэхэд дурдсан хоёр ном нь дундад үеийн хятад хэлний байдал төлөвийг сэргээхэд үнэт хэрэглэгдэхүүн болохын сац, дундад үеийн монгол хэлний дорнод аялгууны судлал, ялангуяа хятад үсгээр монгол хэлээр тэмдэглэгдэж үлдсэн гайхамшигт дурасхал болох *"Монголын нууц товчоон"* хийгээд монгол хэлний *"И-юй"* маягийн толь бичигт галигийн үүргээр хэрэглэгдэж ирсэн ханз үсэгтэй харьцуулж тухайн үеийн монгол хэлний онцлогийг тэнхрүүлэн сэргээхэд чухал баримт болох давхар давхар ач холбогдолтой бөгөөд энэ нь одоо болтол судлагчаа хүлээсээр буй нэгэн чухал сэдэв болно.

"Зуун гэрийн овог" хэмээх хятад хадмал бүхий тэрхүү монгол дөрвөлжин бичгийн дурсгалыг хятад хэлний судлагдахуун болохын үүднээс Хажиме Ошибучи, А. Драгунов нар 1930-аад оноос судласан⁴⁵ бөгөөд уг судлагааг монгол дөрвөлжин бичгийн онцлогийн үүднээс улам нарийсгасан бүтээлээ академич Л. Лигети 1956 онд нийтлүүлж⁴⁶ түүнээс нь бид дөрвөлжин үсгийн махбод болон монголын дөрвөлжин үсгээр нангиад үгийг хэрхэн тэмдэглэх тухайд удаа дараа нэг бус эшлэл авч хэрэглэсэн бөлгөө⁴⁷.

"Зуун гэрийн овог" гэдэг нь хятад хэлний 398 дан үе, 21 давхар үе, нийт 419 үеийг дөрвөлжин үсгээр хэрхэн тэмдэглэхийг жагсаан үзүүлсэн ном бөгөөд академич Л. Лигети авгайн судлагаандаа ашигласан эхээс гадна хэд хэдэн хувилбартай. Энэнүү дурасгалыг монголын судлалын хүрээнд улам нарийвчлан үзэх шаардалгатай тул цаашид судлах хүн

⁴³ Уг захидалд тамга гэдэг үгийн оронд *nišan* гэдэг үгийг хэрэглэж *"al nišan -tu ...biāg"* гэсэн нь буй. Манж хэлнээ "тамга"-ыг *doron* гэдэг боловч бас "тамга, тэмдэг, толбо" гэсэн утга бүхий *nišan* хэмээх үг буй (И. Захаровъ, *Полный маньчжурско-русский словарь*, Санктпетербургъ, 1875, стр. 231). Иймд *nišan* гэдэг үг нь зөвхөн манж хэлнийхи үү, эсбөгөөс алтай хэлтэнд нийтлэг байсан үг үү гэдгийг сайтар нягтлавал зохилтой.

⁴⁴ G. J. Ramstedt, *Mongolische Briefe aus Idikut-Schähri bei Turfan*, - Sitzungsberichte der Königlich Preussischen Akademie der Wissenschaften, 1909, XXXII, ss. 838-848 and taf.

⁴⁵ Oshibuchi Hajime, *Chūgen on-in chū no paspe ji nite utsusaretaru kanji on ni tsuite*, - *Mélanges Ogawa Takuji*, Kyōto, 1930, pp. 601-641; A. Dragunov, *The hPhags-pa script and Ancien Mandarin*, - Известия АН СССР, Москва, 1930, pp. 627-647, 775-797.

⁴⁶ L. Ligeti, *Le Po Kia sing en écriture 'Phags-pa*, - AOH, Tom. VI, Fasc. 1-3, Budapest, 1956, pp. 1-52.

⁴⁷ Ц. Шагдарсүрэн, *Дөрвөлжин бичгийн үсэгзүйн нэгэн онцлог хослол*, Хэл зохиол судлал, XIII боть, VII дэвтэр, Улаанбаатар, 1978, 57-64; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 38-57.

тэр бүрий олж үзэхэд бэрхшээлтэй байх болуужин гэж хэдэн зүйл барын хэвлэлээс нэгийг сонгож бүрэн эхээр нь хавсаргав (5-р хавсралтыг үзмүү).

Одоо “*Měng gū zì yǎn*”⁴⁸ буюу “Монгол хэлний үе хаасан үсэг”-ийн толь бичгийн талаар товч танилцуулая. Энэхүү толь нь дотроо хэдэн анги бөгөөд зохиосон байдлыг үзвэл монголын дөрвөлжин үсгээр хятад хэлний дуудалгыг хэрхэн тэмдэглэхийг гаргахдаа үе хааж ордог арав гаруй дан болоод давхар гийгүүлэгчээр бөлөглөж олохуйяа хялбар болгон жагсаажээ. Энэ дурасхалд дөрвөлжин үсгээр нийт 855 үеийг хэрхэн тэмдэглэж болохыг жагсааж, тэрхүү үе тус бүрт дүйх дуудалга бүхий хятад хэлний 1-107 ханз үсгийг цувуулан хадаж өгчээ. Үүнээс үзвэл уг дурасхал нь хятад хэлний хэдэн мянган үе, дуудалга буюу ханз үсгийн дуудалгыг багтааснаараа “*Зуун гэрийн овог*”-оос хамаагүй өргөн хэрэглэгдэхүүнийг хамарсан бөгөөд зөвхөн дунд үеийн хятад хэлний төдийгүй нэн эрт цагаас хятад үсгээр галиглан тэмдэглэж ирсэн монгол хэлний хэрэглэгдэхүүнийг судлахад багагүй үүрэгтэй бөлгөө.

Дээр өгүүлсэн бүх зүйлийг нэгтгэн авч үзвэл, монгол дөрвөлжин бичиг нь нийгэм, соёл, шинжлэх ухааны хувьд доорхи хэдэн ач холбогдолтой. Үүнд:

Монгол дөрвөлжин бичиг нь Юан гүрний бүрэлдэхүүнд багтаж байсан олон хэлийн улс үндэстнийг бичгийн хувьд нь нэгтгэж өгсөн төдийгүй, өөр өөрийнхи нь хэлээр бичих бололцоог аль нэгэн хэмжээгээр олгож тухайн үеийнхээ нийгмийн хэрэгцээг олон талаар хангаж иржээ.

Монгол дөрвөлжин бичиг нь Төв Ази дахины бүхэл зуун жилийн түүхэнд холбогдох баримт сэлтийг бидний үед тээн авчирчээ.

Хэлшинжлэлийн хувьд, дөрвөлжин бичиг нь дундад үеийн монгол хэлний онцлогийг бүрэнээ тусгаснаас гадна авианы бичиг мөний хувьд дүрс бичиг бүхий хятад хэлний судлалд чухал хэрэглэгдэхүүн болж чадна. Тийм ч учраас монголын дөрвөлжин бичигээр тэмдэглэсэн хэрэглэгдэхүүнд тулгуурласан дундад үеийн хятад хэлний судлагаа ч удаа дараа гарсаар байна⁴⁹. Түүнчилэн уг бичиг албан ёсоор хэрэглэгдэхээ больсон хойноо ч гэсэн Төв Азийн бусад улс үндэстний бичиг үсгийн хөгжилд нөлөө үзүүлсээр байсаны учир начрыг хэлшинжлэл, үсэгзүйн үүднээс тайлбарлах хэрэгтэй бөгөөд үүний чухалыг ч олон орны эрдэмтэд хүлээн зөвшөөрдөг бөлгөө.

⁴⁸ 照那斯圖 楊耐思 蒙古字韻校本 北京，1987年

⁴⁹ И. Т. Зограф, *Среднекитайский язык* (становление и тенденции развития), Москва, 1979.
楊耐思 中原音韻音系 北京，1981年

1. Эгшиг үсэг

No	Эгшиг үсэг		Үсэгийн галиг (tl.)		дуудалгын
	эхин	дунд / адаг	эхин	дунд / адаг	галиг (tc.)
o1	ᠠ	-	"	a ₀	a
o2	ᠡ	ᠡ	"e / e	e	e
o3	ᠢ	ᠢ	"ë ₁ / 'ë ₂	ë ₁ / ë ₂	é
			"e ₁ / 'e ₂		è
o4	ᠣ	ᠣ	"i	i	i
o5	ᠤ	ᠤ	"o ₁ / 'o ₂	o ₁ / o ₂	o
o6	ᠥ	ᠥ	"u / 'u	u	u
o7	ᠦ	ᠦ	"eo ₁ / "eo ₂	eo ₁ / eo ₂	ö
o8	ᠦ	ᠦ	"eu	eu	ü

1. а. Тал (буюу хагас) эгшиг (харь үгнээ тохиолдоно)

o9	ᠠ	ᠠ	"u	u	u
10	-	ᠡ	-	i	i

1. б. Эгшигийн нийлмэл хэлбэр (харь үгнээ тохиолдоно)

11	-	ᠠᠢ	-	eí	î
12	-	ᠠᠡ	-	eé ₂	ê
13	-	ᠠᠢ	-	hi	î

2. Гийгүүлэгч үсэг

No.	Үсэг	tl.	tc.	No.	Үсэг	tl.	tc.
14	ᠮ	k(a)	ka	15	ᠬ	k'(a)	ka
16	ᠩ	g(a)	ga	17	ᠨ	q(a)	qa
18	ᠯ	γ(a)	γa	19	ᠰ	᠋ᠨ(a)	᠋ᠨa
20	ᠪ	č(a)	ča	21	ᠬ	č'(a)	ča
22	ᠢ	j(a)	ja	23	ᠨ	᠋ᠨ(a)	᠋ᠨa
24	ᠳ	t(a)	ta	25	ᠪ	t'(a)	᠋ᠪa
26	ᠳ	d(a)	da	27	ᠨ	n(a)	na
28	ᠷ	p(a)	p̄a	29	ᠷ	p'(a)	pa
30	ᠪ	b(a)	ba	31	ᠮ	m(a)	ma
32	ᠴ	c(a)	ca	33	ᠴ	c'(a)	ca
34	ᠰ ᠰ	ʒ(a)	ʒ(a)	35	ᠬ ᠬ	w(a)	wa
36	ᠵ	ž(a)	ža	37	ᠰ	z(a)	za
38	ᠷ	·(a)	·a	39	ᠶ	y(a)	ya
40	ᠷ	r(a)	ra -	41	ᠯ	l(a)	la
42	ᠰ	š(a)	ša	43	ᠰ	s(a)	sa
44	ᠰ	h(a)	ha	45	ᠰ	hu(a)	fa / hu

Тэмдэглэх нь: Монгол бус бичвэрийг судлах хүмүүст хэрэг болуужин гэсний учир энэхүү жагсаалтад харь үгэнд ордог тал буюу хагас эгшиг, эгшиг болон гийгүүлэгчийн нийлмэл хэлбэрийг тус тусад нь бие даалган оруулсан тул дугаар нь түрүүчийн нэгбүрчилэн жишээ хадсан цагаан толгойн дэс дараатай тохирохгүй гэдгийг анхаарах ажаамуу.


ᠰ	-	a
ᠬ	ᠠ	o
ᠬ	ᠡ	u
ᠬ	ᠢ	e
ᠬ	ᠣ	é
ᠬ	ᠤ	:o
ᠬ	ᠥ	ü
ᠬ	ᠦ	i

(N. Poppe, Wiesbaden, 1957, p. 24.)

	c	d	a		b	
			c	d	c	d
35	ᠰ	-	"a	-	a	-
36	ᠰᠤ	ᠤ	"ä	ä	e	e
37	ᠰᠤ	ᠤ	"ö	ö	ö	ö
38	ᠰᠤ	ᠤ	"ü	ü	ü	ü
39	ᠰᠤ	ᠤ	"u	u	u	u
40	ᠰᠤ	-	"è	-	é	-
41	ᠰ	ᠦ	"i	i	i	i
42	ᠰ	ᠦ	"o	o	o	o
43	ᠰ	ᠦ	"ô	ô	ô	ô
44	ᠰᠤ	-	"ô	ô	ô	ô

(L. Ligeti, Budapest, 1972, pp. 15-19.)

Профессор Н. Поппе, Л. Лигети нарын номд
Дөрвөлжин бичигийн үндсэн эгшиг үсгийг жагсаасан байдал



Дөрвөлжин бичгээр түрэг хэлээр бичсэн тамгын дардас
бүхий албан захидлын зураг

山百可家姓又家可省文
 趙錢孫李周吳鄭王
 陳褚衛將呂施張孔
 尤計何呂施張孔
 華金魏陶姜戚謝
 柏水寶章雲蘇潘
 范彭郎魯韋昌馬
 花方俞任袁柳鄭
 唐費廉岑薛雷賀
 滕殷羅畢郝邱安
 于時傳皮卞齊康
 元卜顧孟卓黃計
 戴又談朱又茅龍熊
 項祝薰梁杜阮藍
 席

Л. Лигети профессорын судлагаандаа ашигласан
 “Po kia sing”-ийн нэг хуудас

平

平農震儂懷

筭侗 酤彤 泐 鑿 愠 佟 上 勳 恫 恫 慟

平

平同仝童僮銅桐筒瞳撞潼鐘董種峒

平

平通恫侗 兒 犬 上 桶 桶 去 痛 統

平

平東凍冬竦零 兒 兩 上 董 竦 懂 鐘 去 凍 棟

平

平空塋崆恠恠 兒 恠 恠 上 孔 恠 恠 去 控 恠 空 鞞

貢贛 兒 也 蟻 瀨 虹 墳 鷄

平

平公功工攻觥觥肱刈 也 刈 珏 珏 上 礦 鑛 去

平

一東

蒙古字韻

蒙古字韻

Ia

II IO 9 8 7 6 5 4 3 2 I

山	百	古	家	又	姓	又	蒙	古	古	文
三	法	趙	三	錢	三	孫	三	李	三	周
三	鄭	三	王	三	馮	三	陳	三	褚	三
三	蔣	三	又	沈	三	韓	三	楊	三	朱
三	法	尤	三	許	三	何	三	呂	三	施
三	孔	三	法	曹	三	又	嚴	三	華	三
三	法	陶	三	姜	三	又	戚	三	謝	三
三	人	柏	三	三	法	寶	三	章	三	雲
三	潘	三	人	葛	三	又	奚	三	范	三
三	魯	三	又	韋	三	昌	三	又	馬	三
三	花	三	方	三	俞	三	又	任	三	又
										表
										已
										云
										柳

蒙註

"Po kia sing" -ийн өөр нэгэн хувилбар эх

22 21 20 19 18 17 16 15 14 13 12

鄴 匏 史 唐 費 康
薛 雷 賀 倪 湯
滕 殷 羅 畢 郝 郭
安 常 樂 于 時 傅
皮 卞 齊 康 伍 金
元 卜 何 五 平 黃
計 伏 成 戴 談 宋
茅 龐 熊 紀 舒 屈
項 祝 董 梁 杜 阮
藍 閔 席 季 麻 強
賈 路 姜 危 江 童

I
2
3
4
5
6

33 32 31 30 29 28 27 26 25 24 23

1

2

3

4

5

6

山以顔至去郭以梅三或已之林至去刀
 三鍾三徐至去丘曰云駘三云高以夏
 以蔡下以田至以樊四胡已三凌至去霍
 以虞至萬亡以支至人柯至以咎至以管
 以盧至去莫三經至房至去裘至以經
 以干至以解至應至宗至丁至以實
 以貴至鄧至以都至早至以杭至以法
 以去包至諸至人左至石至以崔至以去
 以去鈕至龔至程至以密至以那至以沂
 以裴至以陸至以榮至以翁至以荀至以羊
 以於至以惠至以甄至以麴至以家至以封

1
2
3
4
5
6

[illegible]

崇生

III

66 65 64 63 62 61 60 59 58 57 56

司	大	戈	回	因	廖	昌	庚	終	刀	人	暨	西	回	居
衡	己	回	步	回	都	回	耿	不	回	滿	回	弘		
匡	回	國	回	文	回	冠	回	廣	回	後				
開	回	東	回	歐	回	及	回	沃	回	利				
蔚	回	越	回	夔	回	隆	回	師	回	登				
庫	回	聶	回	昆	回	勾	回	教	回	融				
冷	回	訾	回	辛	回	關	回	人	回	那	回	簡		
饒	回	空	回	曾	回	母	回	沙	回	又	回	七		
養	回	鞠	回	須	回	豐	回	去	回	巢	回	關		
崩	回	相	回	查	回	去	回	後	回	荆	回	紅		
游	回	空	回	權	回	回	還	回	只	回	蓋	回	蓋	

I
2
3
4
5
6

77 76 75 74 73 72 71 70 69 68 67

I 2

公

覆姓

司馬

諸葛

長原

申屠

尉遲

字文

令


廣而篆隸之制作其跡皆古也其後真草之書

篆生


I 2 3

雜行于世大元世祖命帝師八合思八製蒙古
新字其母四十有一其相闢紐而成字今以其
字書百家姓于左以見一代之文字云

丙寅年十二月廿日景元本重刊羅福成識



Турфанаас олдсон дөрвөлжин бичигээр монгол хэлээр барласан
 "Subhāṣitaratnanidhi"-ын тасархай



Дөрвөлжин бичигээр хятад хэлээр дэлдсэн зоос



Монгол хэлээр дөрвөлжин бичигээр бичсэн
бичээс бүхий *Bogotol* -ын (ширмэн) пайз

Бичвэр нь:

Үсэгчилсэн галиг

- I. mo₂h-k'a₀ de₂h-ri
- II. yin k'u-č'un-dur
- III. qa₀'a₀-nu ja₀r-liq k'en
- IV. 'e₁-se bu-ši-re₀'e-su
- V. "l-da₀-t'u-qa₀-yi

Дуудалгын галиг

- mön-ke (*) deñ-ri-
- yin kü-čün-dür (*)
- qa'a-nu jar-liq ken
- é-se bu-ši-re'e-sü
- al-da-tu-qa-yi

(*) Цагаан толгойн 12-рт буй (tl. k' / tc. k) гийгүүлэгчийн тайлбарыг үзмүү.

Жич: Д. Төмөртоогоо, *Монголын дөрвөлжин бичгийн "Мөнх" хэмээх үгийн бичлэгийн тухай* (Монголын судлал, Том. VI, Fasc. 9-14, Улаанбаатар, 1966/67, 11-17-р тал) гэдэг тусгай өгүүлэл буйг анхаарна уу.

ТОД БИЧИГ

Ойродын Зая бандида Огторгуйн далай буюу Намхайжамц (1599-1662)-ын шавь Раднаабадараагийн зохиосон " *Rabjamba Āy-a bandida-yin tuḡuji saran-u gerel kemekü ene metü bolai*" гэдэг номд:

"...tere jil-ün ebül Abalai tayiji Āüi-dü ebüljibe: tere quluyan-a jil-ün ebül (Āy-a bandida Ц. Ш.) todurqai üsüq jokiyan üyiledbei..."¹

гэсэн мэдээ байдаг бөгөөд хулгана жил гэдэг нь аргын тооллоор даруй 1648 он болой².

Тод бичигийг зохиосон XVII зуун бол нийт Монголын хувьд Манжийн байлдан дагуулах бодолгын эсрэг эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө өрнөж байсан эрчимтэй тэмцлийн үе байсан бөгөөд энэ үед монгол бичигт дулдуйдсан тод бичигийг зохиосон нь юуны өмнө дөрвөн ойродыг улс төрийн тэмцэлд нэгтгэх, мөн шашин номыг дэлгэрүүлэх зорилготой байснаас гадна цаашдаа уг бичгийг нийт монгол даяар хэрэглэх болно гэсэн эрмэлзэлтэй давхар давхар холбоотой бөлгөө³. Тэгвэл үүний ямар батлагаа байна вэ? гэж асууж болно.

Тухайн үеийн нийгэм-улс төрийн байдал⁴, тод бичгийн авиазүйн онцлог⁵ хийгээд Зая Бандидын зохиосон "*Üzügiyin nayiralḡa*"⁶-ын Төгсгөлийн үгнээ тод үсгийг зохиосон тухай

"... Omoq mongḡol ulusiyin xubitan-du kilbar bolḡoxuyin tula ::
Olon adili dürsütei üzüq nogoudi:
Onco tusabüri angkida xolicol ügei geyigüülen ilḡaji:
Olḡuya kilbar mongḡol üzüq yasa kemēn duraduqsan-du:
Xamuq-i medeqči Šakya-müni Zongkapayin šajin-du tusa bolxui kigēd:
Xatan zürketei xaril ügei süzüqtendü tusa bolxuyin tula:
Xayiratu zarligiyin tobči üzügiyin nayira(l)ḡa öüni:
Xamsan zöblöji Rab 'byam za ya pandida nayiroulbai :: ..."

¹ Radnabhadra, *Rabjamba Āy-a bandida-yin tuḡuji saran-u gerel kemekü ene metü bolai*, CSM, Tom. V, Fasc. 2, Ulan-Bator, MCMLIX, p. 12; *Biography of Āy-a Pandita in oirat characters*, CSM, Tom. V, Fasc. 3, Ulan-Bator, 1967, pp. 31, 69 (7b-8a).

² Х. Лувсанбалдан, *Ойрдын Зая бандидын орчуулгын тухай мэдээ*, ХЗС, Боть Ү1, дэвтэр 6, Улаанбаатар, 1969, 91-р тал; Х. Лувсанбалдан, *Тод үсэг түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975, 16-р тал.

³ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, Улаанбаатар, 1965; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972; Х. Лувсанбалдан, *Тод үсэг түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975.

⁴ Х. Лувсанбалдан, *Тод үсэг түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975, 19 - 25-р тал.

⁵ Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 82.

⁶ *Üzügiyin nayiralḡa* - гар бичмэл цагаан толгой, (Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Тод номын хөмрөг, 416, хэмжээ: 23,4 x 13,5 см) Төгсгөлийн үг.

хэмээн өгүүлсэн зэргээс үзвэл нийт монголчуудад зориулан зохиосон нь тодорхой мэдэгдэнэ.

Намтарт дурдсанчилан "тодорхой үсэг" гэж нэрлэсний учир нь нэгэн талаас монгол үсгийн олон дуудалгыг үгүй болгож дуудалга тус бүрийг ялган тэмдэглэх болсоноор, нөгөө талаас тод бичгийн хэлийг тухайн үеийнхээ аман ярианы хэлэнд ойртуулсанаар тайлбарлагдана. Тэгэхдээ энэ хоёр талын "шинэчлэлт"-ийн эцсийн үр дүн нь уг бичгийг анх зохиож байсан үеийн зорилготойгоо бүрэн тохирч чадаагүй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд энэ талаар хойно тодруулан өгүүлэх болно.

Үүнээс гадна тод үсгийг зохиогч бүр түрүү үед монголоор нэгэнт орчуулагдсан олон ном бичгийг дахин монголчлож тод бичмэлээр, мөн цөөн заримыг тод бичгээр модон бараар⁷ гаргаж ирсэн байдлыг харахад нэгд, түрүү түрүүчийн орчуулгуудыг улам боловсронгуй болгох, хоёрт, тод бичгээ дэлгэрүүлэх гэсэн зорилготой нь шууд холбоотой хэрэг буй заа. Энэ ташрамд дурдахад түрүү түрүү үеийн орчуулгуудыг улам боловсронгуй болгох, шашин бурханы номыг улам дэлгэрүүлэх зорилгоор дахин орчуулах явдал зөвхөн Намхайжамцын тухайд ч биш, монголын бичгийн мэргэдийн дотор нийтлэг байсан хэрэг бөгөөд шашны гол гол томоохон ном бүтээлүүдийн хэд хэдэн монгол орчуулга байдаг нь үүнтэй л холбоотой болохоос биш зарим хүний өнөөдөрийн ойлголтоор үздэг шиг хөлс мөнгө, ашиг оролгын ямар нэгэн сонирхолтой огтхон ч холбоогүй бөлгөө⁸.

Раднаабадараагийн зохиосон " *Rabjamba Čay-a bandida-yin tuγuji saran-u gerel kemekü ene metü bolai*" -д гарч буй Зая Бандид Намхайжамцын орчуулгад холбогдох мэдээг үзвэл:

"...tobčilaqula bars jil-eče qoyitu bars-tür kürtel-e Qoşud, Torγud, Dörbed, Jegün γar, Qoyid terigüten dörben Oyirad бүгүдө-dü sudur, üндүсү, jarlig, šastir olan-i orčiyuluγsan anu:

(1) *Itegel,*

(2) *Itegel-ün kötülbüri...*

(177) *Amilan sayitu orosiγulaqui*

terigüten-i orčiyuluγsan bui. Ene inü sedkil-dür oroγsan tedüi mön. Basa busu ese medegsen olan bui-ja..."⁹

гэж санаандаа үлдсэн 177 номын орчуулгыг дурдчихуй.

Тэдгээр жагсаалтад буй орчуулгыг үзвэл түрүүн монголчилосон ном зохиол нэн олон бөгөөд тоймтой заримыг дурдваас:

Altan gerel (tib. gser-'od dam-pa; sans. Suvarnaprabhasa) - Шаравсэнгийн орчуулга¹⁰;

⁷ Х. Лувсанбалдан, *Тод үсэг түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975, 112 - 122-р тал.

⁸ Walther Heissig, *Toyin gousi / guisi alias Cogtu Guisi: Versuch einer Identifizierung*, ZAS, N. 9, Wiesbaden, 1975, ss. 361-446;

Walther Heissig, *An Inscribed Stele from T'ien-shan with a Fragment of the Mongol Translation of the Vajracchedikā by Siregetü guosi čorje*, - East and West, IsMEO, New Series, Vol. 26, Nos. 3-4 (Sep-Dec, 1976), Rome, pp. 463-467.

C. Šagdarsüren, *Le Damamūkonāmasūtra Texte mongol du Toyin Guiš*, - Monumenta Linguae Mongolicae Collecta, X, Akadémiai Kiadó, Budapest, 1989. pp. V- XVII.

⁹ Radnabhadra, *Rabjamba Čay-a bandida-yin tuγuji saran-u gerel kemekü ene metü bolai*, CSM, Tom. V, Fasc. 2, Ulan-Bator, MCMLIX, pp. 13-14; *Biography of Čaya Pandita in oirat characters*, CSM, Tom. V, Fasc. 3, Ulan-Bator, 1967, pp. 8-9; 43-44 (9a-11a).

¹⁰ N. Poppe, *The Twelve Deeds of Buddha*, Washington, 1967, pp. 11-20; Ц. Дамдинсүрэн, *Монгол уран зохиолын тойм*, 1-р дэвтэр, Улаанбаатар, 1957, 115-119.

Bančarayā (tib. bñca-rkṣa; sans. Pancarakṣā) - Чойжи-одсэрийн орчуулга (1308)¹¹;
Bodhicaryāvatāra - Чойжи-одсэрийн орчуулга¹²;
Thar-pa chen-po - Аюуш гүүшийн орчуулга¹³;
Subhāṣitaratnanidhi (tib. sa-skya'i legs-bṅad) - Сономгараа, Цахар гэвш Лувсанчүлтэм
 нарын удаа дараагийн орчуулга бий¹⁴;
Üliger-ün dalai (tib. mdo-'jañs-blun) - Тойн гүүш, Гүүш цорж нарын зэрэг 3 орчуулга¹⁵;
Bilig barimid-un jirüken (tib. ṣer-sniñ)¹⁶;
Irüger-ün qaṣan (tib. bzañ-spyod smon-lam)¹⁷;

гэх мэтийн олон номын монгол орчуулга өмнө нь гарч байсан билээ.

Тод бичигийн цагаан толгойн бүрэлдэхүүнийг үзэхүл¹⁸ үндсэн 26 үсгээс гадна монгол, дөрвөлжин бичгийн нэгэн адил гадаад үгийг тэмдэглэхэд зориулсан тусгай галиг үсгийн бөлөгтэй.

Үндсэн үсгийн уламжлалт цагаан толгойн бүтэц (Тод бичигийн цагаан толгой гэсэн хүснэгтийг үзмүү)-ийг монгол бичигтэй жишин үзэхэд дараахи хэдэн зүйлийн төстэй хийгээд ялгаатай тал харагддаг. Үүнд:

1. Үсгийн махбод, холбон бичих ёс, үгийн эхин, дунд, адагт дүрсээ өөрчлөх зэрэг ерөнхий байдлаараа монгол бичгийн үндсэн зарчмыг баримтласан нь тодорхой харагдана.

2. Монгол бичгийн үсэгзүйн хувьд гол онцлог гэж үздэг буюу нэгэн үсгээр монгол хэлний олон аялгуунаа сэлгэдэг авиануудыг тэмдэглэдэг зарчмыг тод бичигт "боловсронгуй" болгож бичилгийг тухайн цагийнхаа ярианы хэлэнд ойртуулахыг зорьсон

¹¹ Ц. Дамдинсүрэн, *Монгол уран зохиолын тойм*, 1-р дэвтэр, Улаанбаатар, 1957, 115-116;
 Д. Цэрэнсодном, *ХIХ зууны үеийн яруу найрагч Чойжи-одсэр*, Улаанбаатар, 1969, 78-80.

¹² Б. Я. Владимирцов, *Bodhicaryāvatāra Cantideva - Монгольский перевод Chos-kyi 'od-zer'a*, ВВ. XXVII, Ленинград, 1929; Д. Цэрэнсодном, *ХIХ зууны үеийн яруу найрагч Чойжи-одсэр*, Улаанбаатар, 1969, 86-87.

¹³ Rona-Tas András, *A megszabadító Thar-pa chen-po*, MN XI, Budapest, 1967.

¹⁴ G. J. Ramstedt, *Ein Fragment mongolischer Quadratschrift*, JFSOu, XXVII, Helsinki, 1912; L. Ligeti, *Subhāṣitaratnanidhi mongol, un document du moyen mongol*, Partie I, Le manuscrit tibeto-mongol en reproduction phototypique avec une introduction, BOH. VI, Budapest, 1948; Pentti Aalto, *Altaistica I, The Mannerheim Fragment of Mongolian Quadratic Script*, SO. XVII, Helsinki, 1952; Pentti Aalto, *A second fragment of Subhāṣitaratnanidhi in Mongolian Quadratic Script*, JSFOu. LVII, Helsinki, 1953-1954; Erich Haenisch, *Mongolica der Berliner Turfan-Sammlung I*, Berlin, 1954, p. 4; Erich Haenisch, *Mongolica der Berliner Turfan-Sammlung II*, Berlin, 1959, pp. 53-59; James E. Bosson, *A Treasure of Aphoristic Jewels: The Subhāṣitaratnanidhi of Sa Skya Pandita in Tibetan and Mongolian*, UAS, Vol. 92, Indiana, Bloomington, 1969; Ц. Дамдинсүрэн, *Монголын уран зохиолын тойм*, 1-р дэвтэр, Улаанбаатар, 1957, 120-122; *Эрдэнийн сан Субашид*, Улаанбаатар, 1990.

¹⁵ C. Sagdarsüren, *Le Damamūkonāmasūtra Texte mongol du Toyin Guišā*, - Monumenta Linguae Mongolicae Collecta, X, Akadémiai Kiadó, Budapest, 1989. pp. V- XVII.

¹⁶ Ч. Алтангэрэл, Д. Цэрэнсодном, *Турфаны цуглуулгын ТМ - 38*, *Studia Mongolica*, Tom. V, Fasc. 18, Улаанбаатар, 1966, 113-122.

¹⁷ Ч. Алтангэрэл, Д. Цэрэнсодном, *Турфаны цуглуулгын ТМ - 8, Т - П, Т - 662*, *Studia Mongolica*, Tom. VI, Fasc. 18, Улаанбаатар, 1967, 38 - 42.

¹⁸ А. Бобровников, *Грамматика монгольско-калмыцкого языка*, Казань, 1849; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972; Ch. Luvsanbaldan, *Deux syllabaires oirates*, АОН, Tom. XXV, Fasc. 1-3, Budapest, 1972, pp. 209-219; Х. Лувсанбалдан, *Тод үсэг түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 58-70-р тал.

бөгөөд үүнийгээ ч тодорхой тунхагласаныг нь бид дээрхи эшлэлээс мэдэж авсан¹⁹. Энэ зорилгоос үүдэж тод бичигийн зөв бичихзүйд эгшигийн тэмдэглэгээ, урт болон хос эгшигийг тэмдэглэх ёсон, дэвсгэр гийгүүлэгчийн асуудал гэх зэрэг хэд хэдэн зүйл дээр монгол бичгийнхнээс илэрхий ялгаатай.

3. Самгард, төвөд зэрэг харь үг болон харь нэр томъёог тэмдэглэхэд зориулсан тод бичгийн галигийн тогтолцоог авч үзвэл үүнээс өмнө монгол бичигт зориулан зохиосон Аюуш гүүшийн Али-галийн үсгийг бараг анхаараагүй, харин төвөд, самгардын үсэгзүйн нөлөө хэлбэрийг авсан байдал бэлхэнээ харагддаг. (Энэ талаар галиг үсгийн тухай бөлөгт өгүүлэх болно.)

Дээр дурдсан хэдэн зүйл ажиглалтандаа тулгуурлаж тод бичигийн үсэгзүйн үүднээс бидний судлагдахууны зорилгод давын өмнө чухал гэж үзсэн зүйлээс арай дэлгэрүүлэн авч яриа.

Тод бичигийн цагаан толгойн бүрэлдэхүүнийг нарийвчлан ажиглавал хэлний арын урт *ā*, *ō*, *ū* эгшигийн өмнө тохиолддог, тагнайн хамжих гийгүүлэгчийг тэмдэглэдэг *K* үсэг л зөвхөн ойрод аялгууны онцлогийг тусгасан гэж үзэж болно. Жишээ нь:



tl. taka

tc. takā (Cf. Mo. takiy-a)



tl. zokūl

tc. zokōl (Cf. Mo. jokiya)

Дээр дурдсан хамжих *K* -ээс бусад бүх үсэг нь нийт монгол хэл аялгуунд бүрэнээ тохирох бөгөөд энэ нь тод бичгийг нийт монгол туургатанд зориулж зохиосон гэж үзэх үсэгзүйн үндэслэл болж өгөх ба үүнийг ч профессор Д. Кара нарийн ажиглан тэмдэглэжээ²⁰.

Тод бичигийн зөв бичихзүйд *y/x*, *g/k*, *k* зэрэг хэлний байрлалаар ялгаран бичигддэг гийгүүлэгчийн дараа орсон өргөстэй бүх гэдэс буюу *o*, *u*, *ō* эгшигийг ялгалгүй ганц *ū*-гээр буюу өргөсгүй гэдэсээр тэмдэглэсэн байдаг нь дөрвөлжин бичигт иймэрхүү тохиолдолд хялбарчлан хэмнэх зарчим хэрэглэдэгтэй үндсэндээ адил гэж үзэж болно. Жишээ нь:



tl. xūtuqtu

tc. xutuqtu



tl. kül

tc. kōl



tl. küddöl-ügei

tc. kōddöl-ügei

Дөрвөлжин болон тод бичигийн зөв бичихзүй дэхи энэ зарчим нь монгол хэлний эгшиг зохицох ёсонд үндэслэсэн хэрэг бөгөөд чухамдаа эр эмээр буюу хэлний байршилаар ялгаран бичигддэг гийгүүлэгчийн дараа мөн тийм эгшиг орох нь мэдээж тул заавал ялган бичилгүй, өөрөөр хэлбэл төвөгтэй буюу нуршуу бичилгийг хялбарчилсан хэрэг гэж тайлбарлах бүрэн үндэс буй.

Үүнээс үүдэн тэмдэглэхэд, тод бичгийг монгол бичигтэй жишин үзвэл тод бичгээр түргэн татлаж бичих, эвхэж бичих боломжоор нэн хязгаарлагдмал. Өөрөөр хэлбэл, ялангуяа бичих явцад хамгийн олонтаа давтагдан ордог эгшигийн махбодууд монгол бичигт ялгамжаа тун бага, зарим нь үгийн дунд, адагт ижил хэлбэртэй тул татлах, эвхэх тохиолдолд нэн тохиромжтой байдаг ахул тод бичигт эгшиг тус бүрийг хэдэн зүйл өргөс тэргүүтэнээр нарийн ялгасан учир тэр ялгаа бүрийг эрхгүй гаргах шаардалгатай; тийнхүү тэр бүх ялгааг гаргахад хичээнгүйлэн бичихээс өөр арга байхгүй гэсэн үг. Тэгээд ч тод

¹⁹ *Üzügiyin nayiralʻa* - гар бичмэл цагаан толгой, (Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Тод номын хөмрөг, 416, хэмжээ: 23,4 x 13,5 см) Төгсгөлийн үг.

²⁰ Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 82.

бичгээр татлаж бичсэн буюу эвхэж бичсэн хэрэглэгдэхүүн энэ хир олдоогүй нь чухам үүнтэй холбоотой буй заа.

Түүгээр ч үл барам, тод бичигийн хувьд дээр өгүүлсэнчилэн үсэг бүрийн хэлбэрийг ялгах гэсэн эрмэлзэл, түүнээс үүдсэн хэрэглээний хязгаар нь уг бичгийг монгол бичиг шиг өргөн хүрээнд, урт удаан хэрэглэгдэх боломжийг нь ямар нэгэн хэмжээгээр сааруулсан гэж хэлэх үндэстэй юм.

Тод бичгийн цагаан толгой²¹ болон баруун монголчуудын аман уламжлалд үндэслэж тод үсгийн махбод, тэдгээрийн нэр томъёог жагсаан үзүүлэе.

А. Үсгийн махбод:

1.  aray-a
2.  γool
- 3₁.  segül / silbi
- 3₂.  degege segül
4.  keyiskebüri segül
- 5₁.  moyulčag gedesü (= ü)
- 5₂.  dörbeljin gedesü (= o)
6.  bitegü toluyai (=b-)
7.  köndei gedesü (= -u / -ü)
8.  degege
9.  uruyu toluyai
10.  tariyan toluyai / sinay-a toluyai / bögerengkei toluyai
- 11₁.  čačayu eregü (z + [a, e, o, u, ö, ü] / j + [i])
- 11₂.  dutayu eregü (c + [a, e, o, u, ö, ü] / č + [i])
12.  imayan qangsiyar (y)
13.   köndülen toluyai
14.   orkiča
15.  čačuly-a

Б. Үсгийн нэмэлт тэмдэг:

- 16₁.  čeg / nigen čeg

²¹ Ch. Luvsanbaldan, *Deux syllabaires oirates*, AOH, Tom. XXV, Fasc. 1-3, Budapest, 1972, pp. 209-219

- 16₂.  qoyar čeg / jadayai čeg
- 16₃.  dügürig čeg / bitegü čeg
17.  küčülig
18.  udayan
- 19₁.  örgesün
- 19₂.  ögede-ben tataysan örgesün
- 19₃.  uruyu-ban tataysan örgesün
- 20₁.  uruyu-ban tataysan darčay (= -m-) / matiyar toluyai (=M-)
- 20₂.  ögede-ben tataysan darčay / üker eber (= -l-) / lantuyar toluyai (= L-)

В. Цэг тэмдэгийн зүйл:

21.  egčim / biry-a
- 22₁. - čeg
- 22₂. : qoyar čeg / dabqur čeg
- 22₃.  dörben čeg

Тод бичигийн зөв бичихзүйн дагуу 14 дэвсгэр гийгүүлэгч байдаг нь монгол бичгийнхитэй харьцуулахад даруй 3-аар илүү бөгөөд тэдгээрийг нягтлан үзэхэд нэгд. ойродуудын хувьд тухайн үедээ зонхилож байсан гэж үзэх бүрэн үндэстэй Зая Бандидын унаган аялгуу болох хошуудын аялгуунд суурилсан²² тод бичгийн хэлийг ярианы хэлэнд ойртуулах гэсэн зорилготой, хоёрт, шашин номын уг үндэс болсон төвөд-самгард бичгийн уламжлалтай холбоотой нь бэлхэнээ харагддаг. Тод бичигийн зөв бичихзүйд 14 дэвсгэр үсэг тус бүрт хэлшинжлэлийн үндэс бүхий, тухайлбал, өгүүлэх эрхтэний оролцоог илэрхийлсэн нэр томъёог тусхайлан оноож бичиг сургах явцад өргөн хэрэглэдэг байсан²³ нь бичиг болон аман уламжлалд өнөө хүртэл хадгалагдсаар байна. Үүнд:

- | | | |
|----|----|------------------------|
| 1. | ā | - udayan |
| 2. | ao | - kōndei |
| 3. | ai | - jayiburi |
| 4. | ar | - darsily-a |
| 5. | al | - kele tulqu |
| 6. | am | - am-a qamjiqu |
| 7. | ab | - čingy-a am-a qamjiqu |
| 8. | ad | - tanglai deledkü |
| 9. | ag | - kücün |

²² Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 82.

²³ Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 63.

Ц. Шагдарсүрэн, *Монгол, тод бичгийн дэвсгэр үсгийн нэр томъёоны тухай*, - Хэл зохиол судлал, ХҮ1 боть, 1Х дэвтэр, Улаанбаатар, 1983, 86 - 91 х.

Ц. Шагдарсүрэн, *Традиционные монгольские фонетические термины*, - Исследования звуковых систем языков Сибири, Новосибирск, 1984, стр. 193 - 194.

10. aq - küčülig
11. as - sidün-ü čilüge
12. aš - arayan-u čilüge
13. an - kele ayu / bay-a ingkelig
14. ang - yeke ingkelig / (дөрвөд: xürgäs)²⁴

Энэ жагсаалтаас үзэхүл, бидний сонирхолыг зүй ёсоор татсан хэдэн зүйл байна.

Үүнд: *köndei* буюу *ao* дэвсгэрийн тухайд, хоёр эгшиг давхарлаж ордоггүй хэмээн үздэг монгол бичгийн уугуул зарчимтай холбоотой хэмээж болох бөгөөд монгол бичигийн зөв бичих зүйд ийм тохиолдолд эгшигийн дараа орсон "гэдэс"-ийг *w* (*β) дэвсгэрээс үүсэлтэй гэж үздэгтэй уламжлал нэг буюу.

[Mo. činu-a < * t inβa] гэдэгээс үүдэж
 Mo. taulai < * taβlai (turc. tabısqa / taušan)²⁵;
 Mo. čooqur < * čuβaqr (turc. čubar)

буюу эгшигийн дараахи гэдэс нь угтаа эртний *β дэвсгэрээс үүссэн гэлцдэг.

Монгол бичигийн хувьд байдаггүй *arayan-u čilüge* хэмээх *aš* дэвсгэрийн тухайд гэвэл тод бичигийн хэлийг тухайн үеийнхээ ярианы дуудалгад ойртуулах гэсэн зорилготой шууд холбоотой буй заа.

Харин тод бичигт тэмдэглэдэг "эгшигийн урт"-ын тэмдэгийг дэвсгэр гийгүүлэгч гэж үзсэн нь багагүй сонирхолтой юм.

Тод бичгийн зөв бичихзүйд эгшигийн уртыг дэвсгэр гийгүүлэгчид багтаасан нь судлагчдын зөвшөөрдөгчлөн самгард-төвөдийн нөлөө гэж үзэх үндэстэйн²⁶ зэргэцээ монгол хэлний үеийн тогтолцоотой харшлах зүйлгүй юм. Тухайлбал:

Sans.	अ	आ	इ	ई	उ	ऊ	ऋ	ॠ
Tib.	ཨ	ཨ	ཨ	ཨ	ཨ	ཨ	ཨ	ཨ
Oirat.	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
Tс.	a	ā	i	ī	u	ū	ᠠ (ᠠ)	ᠡ (ᠡ)

²⁴ Ch. Luvsanbaldan, *Deux syllabaires oirates*, АОН, Tom. XXV, Fasc. 1-3, Budapest, 1972, pp. 209-219; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 63.

²⁵ N. Poppe, *Introduction to Mongolian comparative Studies*, Helsinki, 1955, pp. 68, 71-72.

²⁶ Ш. Лувсанвандан, *Дөрвөлжин, тод үсгийн зөв бичих дүрэмд монгол хэлний эгшигийг хэрхэн тэмдэглэсэн нь*, ХЗС, VII боть, 2-р дэвтэр, Улаанбаатар, 1970, 103-113; Г. Жамъян, *Тод үсгийн зөв бичих дүрэмд урт эгшигийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудалд*, SM, Tom. VII, Fasc. 20, Улаанбаатар, 1970, 257-270; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 77-84; Х. Лувсанбалдан, *Тод үсэг түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975, 39-49.

Sans.	ᠯ	ᠭ	ᠡ	ᠢ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠠ
Tib.	ལ	ᠭ	ᠡ	ᠢ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠠ
Oirat.	ᠯ	ᠭ	ᠡ	ᠢ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠠ
Tс.	! (li)	! (li)	e	ē	o	ō	am	aḥ

Төвөд үсгийн ангилалаар, эгшигийн уртыг тэмдэглэдэг шанаган "а" буюу 'a-chun (ᠠ) -ыг гийгүүлэгчийн бөлөгт багтаадаг тул тод бичигийн эгшигийн уртыг төвөдийн жишигээр дэвсгэр гийгүүлэгч гэж үзсэн байдал дээрхи хүснэгтээс тодорхой харагдаж байна гэж үзэх үндэслэл байна.

Тод бичигт эгшигийн урт богинотой холбоотой асуудлыг тайлбарласан ном зохиолоос үзвэл гурван зүйл ялгаатай ажээ. Үүнд:

о х о р,
урт,
м а ш у р т

гэж дурдсан байх бөгөөд үүний тайлбарыг эшлэн дурдсугай.

"...tere-čü axur üzügi nigeni öni-dü ungšiqdaxu kemekü: urtu xubitu kigēd 'dren-po, nara ügei üzüg бүгүдө axur mön: nidü jirmelkü buyu xurγu deledkü nigeni önidü ungšixu: urtu-yi xoyor-yin öni-dü ungšixu kemebei: urtutai kā (ᠠ), kē (ᠡ), kuu (ᠢ), krī (ᠣ), klī (ᠤ) noγoud 'gren-po narotai ke, kü terigüüten noγoud xoyori-yin önidü ungšixu: maši urtu-yi yurbani önidü ungši kemebei: ee (ᠢ), oo (ᠣ), kee (ᠡ), koo (ᠣ) terigüüteni yurbani önidü ungši..."²⁷

Хэдийгээр энд тарни унших аргын тухай дурдаж байгаа боловч тод бичигт эгшигийн гурван зүйл уртыг хэрхэн тэмдэглэх арга хийгээд түүнийг хэрхэн унших талаар тодорхой өгүүлсэн нь бидний хувьд сонирхолтойн хажуугаар самгард-төвөдийн уламжлалтай шууд холбоотой болохыг давхар харуулж байна. Тод бичигт дээр дурдсан гурван янзын уртыг хэрхэн тэмдэглэдэг байдлын жишээг үзүүлбэл:

1. (V + udayan):

ᠵᠠᠭᠠᠨ

zurgān

ᠵᠢᠭᠡᠳ

kigēd

2. (V + gedesün):

ᠥᠭᠡᠳᠡᠰᠦᠨ

öüden

ᠵᠥᠨ

zöün

²⁷ Tarni ungšixui arγa xurāqsan kemekü orosibo (Tib. snags kyi glog thabs), pp. 6a - 6b. Лавшпуулан үзнэ гэвэл: Radnabhadra, *Rabjamba Čay-a bandida-yin tuγuji saran-u gerel kemekü ene metü bolai*, CSM, Tom. V, Fasc. 2, Ulan-Bator, MCMLIX, pp. 45; *Biography of Čaya Pandita in oirat characters*, CSM, Tom. V, Fasc. 3, Ulan-Bator, 1967, pp. 8, 44 (10. a); Če. Damdinsüreng, *Mongγol-un uran jokiyal-un degeji jaγun bilig orosibai*, CSM, Tom. XIV, 1959, p. 331.

3. (V + V [=e/o] + udayan):

ᠠ ee⁽⁻⁾ (tib. ཡ) ᠠ oo⁽⁻⁾ (tib. ཡ) ᠠ kee⁽⁻⁾ (tib. ཡ)

гэж тэмдэглэдэг байжээ. Үүнд: (1), (2) нь хоёр "өнид"²⁸-ийн хугацаанд, (3) нь зөвхөн тарни (Sans. dhāraṇī)-ийн хэлэнд тохиолдох бөгөөд гурван "өнид" үргэлжлэдэг байна.

Тод бичигийн дурсгалыг үзэхэд наад зах нь хэдэн зүйл онцлог ажиглагддаг. Нэгд, /x/-ийн дараа орсон u эгшиг хийгээд g/k-ийн дараа орсон ᠋ эгшигийг бичилгэ хялбарчилахын үүднээс дүрс ялгалгүй гол төлөв ü -гээр бичдэг; хоёрт, тод бичигийн зөв дуудах зүйгээр i эгшигийн өмнө тохиолдох c гийгүүлэгчийг c̄ -ээр, z гийгүүлэгчийг j -ээр дууддаг зэрэг амь авсан эгшиг гийгүүлэгчээс шалтгаалж дуудалга хувирдаг; гуравт, эгшигийн урт буюу тухайн эгшигийг хэлэх үргэлжлэцийг дээр өгүүлсэнчилэн гурван янзаар тэмдэглэдэг зэрэг нэлээд онцлог харагддаг тул эрдэм шинжилгээний хүрээнд тод бичигийн дуудалгын галигийн хажуугаар тод бичгийн үсгийн галиг (transliteration)-ийн тогтолцоог боловсруулах ажил эрхгүй тулгарч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Тод бичгийг судласан эрдэмтэд эгшигийн уртыг тэмдэглэсэн аргын талаар хоёр зүйлийн саналтай байдаг²⁹ бөгөөд эрдэм шинжилгээний хүрээнд өдгөө болтол нэгэн тийш шийдэж чадаагүй гэж хэлж болно.

Тод бичигт эгшигийн уртыг тэмдэглэсэн аргын талаар судлагч Г. Жамъян далан хэдэн оноос нэгэн өвөрмиц санал дэвшүүлсэн нь академич Ш. Лувсанвандан, Ц. Дамдинсүрэн нарын дэмжилгийг хүлээсэн байна³⁰.

Г. Жамъянгийн үзэж байгаагаар тод бичигт буй эгшигийн уртыг тэмдэглэсэн "удаан" хэмээх нэмэлт тэмдэг нь эгшигийн уртыг зааж байгаа хэрэг биш, богино эгшигийн дараа тохиолдож байгаа урт a буюу e эгшиг юм³¹.

Гэвч энэ талаар цөөн бус хэлшинжлэлчид сөрөг саналтай байсаар ирсэн гэдгийг хэлэх хэрэгтэй.

²⁸ Мо. ᠋nidü - нь цаг хугацааны нэгж бөгөөд нүд ирмэх буюу инчдэх төдийн хугацаа болой.

²⁹ А. Бобровников, *Грамматика монгольско-калмыцкого языка*, Казань, 1849, стр. 1-37; А. Попов, *Грамматика калмыцкого языка*, Казань, 1851; Б. Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Тэргүүн дэвтэр, Удиртгал, Улаанбаатар, 1964, 160-167; Б. Ринчен, *Тод монгол бичиг, түүний соёлын ач холбогдол*, SM, Tom. VIII, Fasc. 22, Улаанбаатар, 1971, 291-295; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 77-84; Ш. Лувсанвандан, *Дөрвөлжин, тод үсгийн зөв бичих дүрэмд монгол хэлний урт эгшигийг хэрхэн тэмдэглэсэн нь*, ХЗС, VII боть, 2-р дэвтэр, Улаанбаатар, 1970, 103-113; Г. Жамъян, *Тод үсгийн зөв бичих дүрэмд урт эгшигийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудалд*, SM, Tom. VII, Fasc. 20, Улаанбаатар, 1970, 257-270; Д. А. Павлов, *Зая-Пандита - создатель старокалмыцкой письменности и литературного языка*, - 320 лет старокалмыцкой письменности, Элиста, 1979, стр. 40-80; Х. Лувсанбалдан, *Тод үсэг түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975, 39-49; Г. Д. Санжеев, *Лингвистическое введение в изучение истории письменности монгольских народов*, Улан-Үдэ, 1977.

³⁰ Г. Жамъян, *Обозначение долгих гласных в ойратском ясном письме*, - Народы Азии и Африки, Москва, 1970, N. 5, стр. 150-152; Г. Жамъян, *"Ясное письмо" в сравнительном освещении*, - Диссертации на соискание ученой степени кандидата филологических наук, Улаанбаатар, 1988; Ш. Лувсанвандан, *Монголын дөрвөлжин үсгийн их "А", шанаган "А"-гийн тухай асуудалд*, Монголын судлал, 6-р боть, 6-р дэвтэр, 1978, Улаанбаатар; Ц. Дамдинсүрэн, *"Рамаяна" в Монголии*, Москва, 1979, стр. 71.

³¹ Г. Жамъян, *Обозначение долгих гласных в ойратском ясном письме*, - Народы Азии и Африки, Москва, 1970, 5, стр. 150-152; Г. Д. Санжеев, *Лингвистическое введение в изучение истории письменности монгольских народов*, Улан-Үдэ, 1977.

Г. Д. Санжеев доктор Г. Жамъянгийн саналыг анх бүрэн дэмжиж байсан бөгөөд харин 1977 онд нийтлүүлсэн номдоо заримдаг зөвшөөрөх болсон нь харагддаг³².

1985 онд халимагийн профессор П. Ц. Биткеев Г. Жамъяны саналд зориулж "Проблемы долготности в фонологической системе ойратского языка" гэдэг өгүүлэл нийтлүүлж, нийт монгол хэл аялгууны ерөнхий зүй тогтол болон авиабарсудлалын үүднээс нарийвчлан үзээд:

"...үсэгзүйн хувьд жинхэнэ урт эгшиг (долгие монофтонги)-ийг тод бичигт "удаан"-ы тэмдэгээр, бас эгшиг үсгийг давхарлан бичих аргаар тэмдэглэн илэрхийлдэг байжээ..."³³

гэдэг дүгнэлтийг хийсэн байдаг.

Г. Жамъян тод үсгийн эгшигийн "удаан" () хэмээх тэмдэгийг холбогдол бүхий бусад бичиг, тухайлбал, самгардын (), төвөдийн бяцхан "а" (), дөрвөлжин үсгийн " 'a-chun " (), соёмбо үсгийн () -тай тус тус харьцуулж дээрхи дүгнэлтийг хийсэнд нь эргэлзэх зүйл бас бий. Самгард, төвөд, дөрвөлжин, соёмбо бичиг дэх эгшигийн уртыг эгшигийн дараа орсон урт а буюу е гэж үзэх үсэгзүйн баттай баримт байхгүйн дээр тод бичигийн тухай уламжлалт зохиол бүтээлд эгшигийн уртын тэмдэгийг "дэвсгэр гийгүүлэгч"-д багтааж ирсэн талаар дээр нэгэнт өгүүлсэн нь үүний нутлагаа болж өгнө.

Үүнээс гадна Г. Жамъян монгол бичиг авахаас өмнө монгол хэлнээ үгийн тэргүүн үед о, ө эгшиг ховор тохиолдож байсан тул эрт цагт монгол хэлэнд о, ө эгшиг байгаагүй гэдэг дүгнэлт хийгээд XVII зуун гэхэд ойродын олон аялгуунд урт о, ө эгшиг байгаагүй³⁴ гэж үзжээ. Тэгээд үүнийхээ батлагаа болгож боол гэдэг үг нь буугуйч гэдэг үгээс үүссэн, ойродын зарим аялгуунд "хоёр" гэдэг үгийг "хуяр" гэж дууддаг тул монгол хэлний хоёр гэдэг үгийн эртний дуудалга нь хуяр гэж байсан бөгөөд энэ нь худалч, хувирах, хуралдах, хугас, худ худгуй, хутгалдах гэх зэрэг олон үгтэй язгуур нэг юм³⁵ гэх зэргээр батлахыг оролдсон нь хэлшинжлэл болон монгол хэлний түүхэн судлагааны үүднээс хүлээн зөвшөөрөх аргагүй юм. Наад захын жишээ гэхэд л "хоёр" гэдэг үгийг тод бичигээр *хоуар / хоуог* гэж дандаа о эгшигтэй бичдэг нь л гэхэд үүний сөрөг баримт болж өгнө. Бас XVIII зууны эхээр Шибир болон Монгол газраар аялсан Жон Бэлл(John Bell 1691-1780)-ийн тэмдэглэлээс үзвэл лавтайяа тэр үед Халимаг нарын хэлэнд "хоёр" гэдэг үгийг "у" эгшигтэй биш, "о" эгшигтэй дууддаг байсны нутлагаа тодорхой харагдана³⁶.

Түүнчилэн гэдэс давхарлаж эгшигийн уртыг тэмдэглэдэг аргын тухайд ойрод аялгуунуудын түүхэн судлагааг зайлашгүй анхаарах шаардалгатай гэж бодож байна. Ийнхүү харьцуулан үзвэл тод бичигт хоёр өөр гэдэс давхарлан бичиж эгшигийн уртыг илэрхийлсэн нь ямар нэгэн хосорхог уртыг биш жинхэнэ уртыг тэмдэглэсэн гэж үзэх баримт илүүтэй харагддаг. Тухайлбал: 1730 оны Strahlenberg-ийн халимаг монгол толь болон бусад судлагааны хэрэглэгдэхүүнийг авч үзье. Тодор *noür* буюу *nuür* 'нуур', *ariün* 'ариун', *oula* 'уул', *teriün* 'тэргүүн ~ түрүү' гэж бичдэг цөөн хэдэн үг ойрод аман аялгуундаа ямар байсан хийгээд ямар байгааг харьцуулая.

³² Г. Д. Санжеев, *Лингвистическое введение в изучение истории письменности монгольских народов*, Улан-Үдэ, 1977.

³³ П. Ц. Биткеев, *Проблемы долготности в фонологической системе ойратского языка*, - Вопросы языкознания, 1985, N. 5, Москва, стр. (111-120) 119.

³⁴ Г. Жамъян, "Ясное письмо" в сравнительном освещении, - Диссертации на соискание ученой степени кандидата филологических наук, Улаанбаатар, 1988, 24-31.

³⁵ Г. Жамъян, "Ясное письмо" в сравнительном освещении, - Диссертации на соискание ученой степени кандидата филологических наук, Улаанбаатар, 1988, 21-32.

³⁶ Pentti Aalto, *John Bell's (1692-1780) Notes from his Journey in Siberia and Mongolia*, - International Journal of Central Asian Studies, Vol. 1, Editor in Chief Talat Tekin, Institute of Asian Culture and Development, Seoul, 1996, pp. (141-164), cf. p. 153.

Тод бичигт:	Stralenberg ³⁷ :	G. J. Ramstedt ³⁸ :	G. Kara ³⁹ :
ᠨᠠᠷᠠ / ᠨᠠᠷᠠ	nurr ~ nuur	nūr	nūr
ᠠᠷᠢᠨ	arion	ārūn	ārūn
ᠣᠯᠠ	ola ~ ula	ūl ~ ūl	ūl
ᠲᠦᠷᠦ	...turu(m)	tūrū(n)	-

Үүнээс үзэхэд хоёр өөр гэдэс давхарлаж эгшигийн уртыг тэмдэглэсэн нь хосорхог урт эгшигийг илэрхийлсэн хэрэг биш, ерийн урт эгшигийг тэмдэглэсэн, бичилгийн зарчим байжээ гэж хэлэх үндэстэй юм. Ингэж үзэх нь, Зая бандид нийт монгол туургатанд зориулж, монгол бичигтэй харьцуулахад ярианы хэлэнд ойртуулсан, илүү тодорхой бичиг буй болгох зорилгоор тод бичигийг анх зохиосон гэдэг дүгнэлттэй ч харшлахгүй.

Гэвч уг бичиг нь, монгол бичигтэй харьцуулбал, дөрвөлжин, соёмбо бичигтэй нэгэн адил үсэгзүйн хувьд монгол хэлний нутаг нутгийн аялгууны онцлогийг тэгш тусгаж чадаагүй, бичихэд төвөгтэй, түргэн бичих боломж хязгаарлагдмал зэргээс үүдэж нийт монгол даяар жигд түгж чадалгүй, зөвхөн баруун монголчуудын хүрээнд хэрэглэгдэж ирсэн юм. Үүнд бас тод бичигийн хэлний талаар академич Б. Я. Владимирцовын тэмдэглэсэнчилэн "ойродын бичгийн хэл нь хуучирсан болон монгол үг хэлэлгэ олонтой, ардын амьд ярианаас ялгаатай, зохиомол шинжтэй хэл бөгөөд зөв бичихзүй нь үгийн гарлын зарчмыг ёсчилон баримтлажээ"⁴⁰ хэмээн тодорхойлсон байдал нь ч ямар нэгэн хэмжээгээр нөлөөлсөн буй заа.

Тод бичиг болон түүн дээр суурилсан тод бичигийн хэл нь монгол туургатны түүхнээ чухал байр суурь эзлэж баруун монгол түмний хэл аялгуу, аж төрөл, түүх, шашин суртал, соёл боловсролд холбогдох хангалттай баримт дурсгалыг тээж бидний үетэй золгуулсан⁴¹ ач холбогдолтой юм.

³⁷ John R. Krueger, *The Kalmyk - Mongolian Vocabulary in Stralenberg's Geography of 1730*, Stockholm, 1975.

³⁸ G. J. Ramstedt, *Kalmückisches Wörterbuch*, Helsinki, 1953.

³⁹ G. Kara, *Notes sur les dialectes oirat de la Mongolie Occidentale*, AOH, Tom. VIII, Fasc. 2, Budapest, 1959, pp. 111-168.

⁴⁰ Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Ленинград, 1929, стр. 25-26.

⁴¹ Б. Ринчен, *Тод монгол бичиг, түүний соёлын ач холбогдол*, SM, Tom. VIII, Fasc. 22, Улаанбаатар, 1971, 291-295;

Тод бичигийн цагаан толгой

No.	Т о д ү с э г			галиг
	Эхин	дунд	адаг	(tc.)
01	ᠠ	ᠡ	ᠢ	a
02	ᠡ	ᠢ	ᠣ	e
03	ᠢ	ᠣ	ᠤ	i
04	ᠣ	ᠤ	ᠥ	o
05	ᠣ	ᠤ	ᠦ	u
06	ᠣ	ᠤ	ᠦ	ö
07	ᠣ	ᠤ	ᠦ	ü
08	ᠬ	ᠬ	-	x
09	ᠭ	ᠭ	-	k
10	ᠭ	ᠭ	ᠭ	γ (q)
11	ᠭ	ᠭ	-	k
12	ᠭ	ᠭ	ᠭ	g (q)
13	ᠨ	ᠨ	ᠨ	n
14	-	ᠨ	ᠨ	ng
15	ᠮ	ᠮ	-	c / ċ
16	ᠮ	ᠮ	-	z / j
17	ᠮ	ᠮ	ᠮ	y
18	ᠮ	ᠮ	-	t
19	ᠮ	ᠮ	ᠮ	d
20	ᠮ	ᠮ	ᠮ	b
21	ᠮ	ᠮ	ᠮ	s
22	ᠮ	ᠮ	ᠮ	š
23	ᠮ	ᠮ	ᠮ	l
24	ᠮ	ᠮ	ᠮ	m
25	ᠮ	ᠮ	ᠮ	r
26	ᠮ	ᠮ	(ᠮ)	v

1-р хавсралт
 Тод бичгээрхи Даваач хааны захиа
 127



Тод бичигээр буй анагаах ухааны
орчуулгын номын хэсэгээс

СОЁМБО БИЧИГ

Монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсгийн дотроос монгол хүний ил бодотой зохиосон бас нэгэн шинэ бичигийн тогтолцоо нь соёмбо ~ сойомбо (< Sans. svayambhu; Tib. ran-byun snan-ba; Mo. öber-iyen boluγsan¹ /=γaruγsan² /=bütügsen³ gegen) хэмээх бичиг бөлгөө.

Соёмбо бичигийг анхдугаар Жебзундамба хутагт (Jebjundamba qutuγtu) Занабазар (Jana-bajar) буюу Өндөр гэгээн (Öndür gegen 1635-1723) эртний Энэдхэгийн ланз⁴ хэмээх үсэгт дулдуйдаж 1686 онд⁵ улс төр хийгээд шашин номын тусгай зорилгоор зохиожээ. Улс төрийн учир холбогдол гэвэл, Манжийн эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг үндэсний тусгаар тогтнил, өнө мөнхийн бие даасан байдлыг бэлгэдэж⁶, шашин номын тухайд, тэр цагийн

¹ *Soyangbu juyadi kemegdekü mongγol üsüg-ün gүн udq-a-yi teyin böged negegä Janabajar-un taγalal-un ämeg kemegdekü orosibai* (Улсын Төв Номын сан, гарбичмэл).

Rintchen, *Zwei unbekannte mongolsiche Alphanete aus dem XVII Jahrhundert*, АОН, Tom. II, Fasc. I, Budapest, 1952, p. 63;

G. Kara, *Un texte mongol en écriture soyombo*, АОН, Tom. IX, Fasc. I, Budapest, 1959, pp. 3-4.

² *Soyangbu üsüg-ün tobā uār - e wam-un udq-a kiged soyangbu üsüg-ün uār tobā tedüi*, (Улсын Төв Номын сан, гарбичмэл, Хайх тэмдэг нь: 494, 21. С. 527, 77902).

³ *Öber-iyen bütügsen gegen-dür sitügsen āqula kereglekü ubadis orosibai*, (Улсын Төв Номын сан, гарбичмэл).

⁴ "...boyda gegenten-eče lanja üsüg-lüge qubi adaii nigen šin-e mongγol üsüg sva-yan-bhu čiuwa-di böged öber-iyen garuγsan gegen kemegdekü-yi jokiyabai..." - *Soyangbu üsüg-ün tobā uār, e-wam-un udq-a kiged soyangbu üsüg-ün uār tobā tedüi* (Улсын Төв Номын сан, гарбичмэл). Бас Сарат Чандра Дасын бүтээлд: "...During the fourth period when the study both of the Sanscrit and Chinese was encouraged by the rulers of Tibet, the Svayambhu or Ranjun characters of Magadha were introduced into Tibet..." - Sarat Chandra Das, *The Sacred and Ornamental Characters of Tibet*, JASB, LVII, Part I, 1888, p. 44; G. Kara, *Un texte mongol en écriture soyombo*, АОН, Tom. IX, Fasc. I, Budapest, 1959, p. 1; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 91.

⁵ "...ilangγuy-a temür bars jil-ün ebül-ün dumdatu sar-a-yin sin-e-yin arban γurban-dur γadaysi jalaraqui-dur arluγsan üjel-ün dotur-a oyγoryui-dur langja-yin üsüg adali üsüg-ün dürsü olan-iyar urγuγsan-i üjeged Bangčün ringbüči-dür ayiladqaysan-a nom-un üsüg oyγaryui-yin čindamani metü mön tula ta oron nutuγ-dayan tegüs qubitan-u čiyulγad-tur delgeregülgütün kemen jarliγ bolju esi kiged onul-un бүрин tegüs sajin-u ejen-dür erkesiyebai. Tende-eče tabin qoyar següder deger-e γal bars jil mongγol-un dokiγ-a-luγ-a jokildayulju delgeregülgүн jokiyaysan amui..." - *Soyangbu juyadi kemegdekü mongγol üsüg-un teüke-yi tobālan quriγaju üjegülügsen tusa amuγulang-un lingqu-a-yi delgeregülgä oyγaryui-yin ādamani kemegdekü orosibai* (Улсын Төв Номын сангийн хайх тэмдэг нь: 494, 21. С. 527, N. 77903)

⁶ Ринчен, *Из нашего культурного наследия*, Улан-Батор, 1958, стр. 12-16; B. Rintchen, *Le soyemba, emblème de la liberté et de l'indépendance*, La seconde épopée mongole (Démocratie nouvelle, numéro spécial, Octobre, 1965), Paris, pp. 23-24.

монгол бичгийн мэргэдийн хувьд номын гурван гэгээн хэл⁷ болж байсан монгол, самгард, төвөд хэлний үгийг бүрэнээ тэмдэглэж чадахуйц бичгийн тогтолцоог буй болгосон ажээ.

Энэ талаар тодруулахад "*Soyangbu üsüg-ün tobā uār*" хэмээх номын мэдээ болон Улаанбаатар хотын Gangdantegcingling (tib. dga'-ldan theg-chen-glin) хэмээх Төгс баясхалант их хөлгөний хийдийн гавж Данзан-Осор, Иштавхай ламтан нарын аман уламжлалаас үзэхүл түрүү гарсан монгол Ганжуур (tib. bKa'-gyur)-ын орчуулга ба түүнд буй тарни (saps. dharani)-ийн үсгийн алдаа мадагийг хянан тохиолдуулж улмаар соёмбо бичгээр дахин хэвлэх зорилготой байсан гэдгийг хялбарханаа мэдэж болно.

Соёмбо бичиг тэр цагийнхаа судлаач нарын анхаарлыг их л татаж байсан бөгөөд энэ талаар бичсэн цөөн бус ном бидий үеийг хүрч ирсэн байх ба олонхийг нь Йөншиөбү Ринчөн багштаны дурадхаргсанаар аграмба Гомбожав нарын зэрэг төвөдөч эрдэмтэд монголчложээ. Тоймтой заримаас нь олон эрдэмтний анхааралд толилуулбал:

1. *Soyangbu juyadi kemegdekü mongγol üsüg-ün udq-a-yi teyin böged negegegä Janabajar-un tagalal-un āmeg kemegdekü orosibai*.

Төгсгөлийн үг нь:

"...үүнийг мөнхүү өөрийн сүсгээр чухал дурадхан умар зүгийг бүтээлийн үндэслэл шашины журмыг баригч их богд Лувсандагвадаржаагийн гэгээнтэн тэргүүтэн дээд лам нарын өлмийн тоосыг оройгоор олсон Ширбазар нэрт дэмий нэгэн-бээр *margü āngcā*-а мэт язгуур тайлбарт дулдуйдсанаас язгуур номлолыг бариулагч ламын увдисаар чимж жагсаасны бичээч шавь Самдүбдорж болой. Энэ ч тэнцэл үгүй дээд ламын зохиол өнид тэтгэхийн шалтгаан болох болтугай; Үүнийг төвөд бичгээс монгол хэлэнд орчуулагч нэр хүлээсэн аграмба Гомбожав."

2. *Evam-un dürsü бүтүгекү yosun ba belgedügsen udq-a-yin nomlal orosibai*.

Төгсгөлийн үг нь:

"...хэмээхүй үүнийг *čan yangdaybar jodba*-гийн их дэлгэр номлол *dorji-yin naljor-ji de qon-a nangvar jidbiy nim-a čingboo* хэмээгдэхээс тавдугаар бөлөгийн Тийн номлолоос түүсэн болой; Үүнийг төвөд хэлнээс монгол бичигт орчуулагч Гомбожав"

3. *Soyangbu-yin udq-a-yi tobā üjegülүgsen biāgeā Čorji-yin jokiyal orosibai*.

Төгсгөлийн үг нь:

"...тойн дүрсэт *Aγvan-bar* болой.

Үүнийг төвөд бичигээс монгол бичигт орчуулагч аграмба Гомбожав"

4. *Amuγulang qoγusun-u uy mör ür-e γurban бүридүgsen tamaγ-a-yin belgedel ba ānar-i üjegülүgsen maγtaγal-un silүglel orosibai*.

5. *Soyangbu joyadi kemegdekü mongγol üsüg-ün teūke-yi tobālan quriyaju üjegülүgsen tusa amuγulang-un lingqu-a-yi delgeregүlүgā oγtarγui-yin āndamani kemegdekü orosibai*.

⁷ "...öber-iyen boluγsan gegen kemen nereyidүgsen mön-kü ene Enedkeg, Töbed, Mongγol γurbayulun-u kele-ber bičiju umsiju bolquyiča sonin-tai nigen mön-kü böged dotur-a jayur-a mongγol-un öber-ün kele-lүge jokildaju üsüg a, ā terigүten arban jiryuyan egesig, γa (ka), ka (kha), ga, n (na) terigүten qorin dörben geyigүlүgči, dүri urbaγči arban qoyar üsüg-nүgүd bayiqu böged sačarliγ-a r, r terigүten-inү enedkeg-ün kele ba mongγol-dur-ču dotur-a jayur-a döčin yisün yeke qosiyun jüg-ün kele-ber bičikү umsiqu-du kereglegdekү-yin tuqai jokiyaysan metү üjegdebči uči-i үlү medeyү..." - *Soyangbu-yin udq-a-yi tobā üjegülүgsen bicigeā čorji-yin jokiyal orošibai* (rap бичмэл); G. Kara, *Un texte mongol en écriture soyombo*, AOH, Tom. IX, Fasv. I, Budapest, 1959, pp. 2.

Төгсгөлийн үг нь:

"...үүнийг Балданбарайбүнгийн цорж лам Сабдүн эрдэнэ билигт мэргэн дайчин, хэбэй амбан гүн, баатар мэргэн дайчин тэргүүтэн шар хар их бага олон хүмүүст эш авшиг увидас нийт ба, ялангуяа энэ зүйлийн номыг номлохуй үес, тэдгээрт тус болох горилох санаагаар мөнхүү дээд өөрийн зохиолоор өчүүхэн итгэмж олсон гэлэн Лувсандамбадаржаа-баар өөрийн жаран зургаан насны түнтүв хэмээгдэх шорой хонин жилийн хаварын гуравдугаар сар шинийн гурванд түргэн бичсэний бичээч нь Соднамванчуг болой.

Үүнийг төвөд бичигээс монгол бичигт орчуулагч Гомбожав"

6. *Öber-iyen бүтүgsen gegen-dür sitügsen āqula kereglekü ubadis orosibai.*

Төгсгөлийн үг нь:

"...үүнийг Шадбийдорж нэрэт-бээр Бүтэд-янжин, Намжалдорж эх хөвүүн хоёр увдисласан болой.

Үүнийг төвөд бичигээс монгол бичигт орчуулагч аграмба Гомбожав"

7. *Soyangbu-yin tamaγ-a-dur jirγuγan urbalta-ügei-yin egüden-eče maγtaju jalbarilγ-a talbilta orosibai.*

Төгсгөлийн үг нь:

"...үүнийг Хасбазар-баар төмөр бэчин жилийн цагаан сарын хорин гурванд Эвамгачилд найруулсны бичээч нь Цэрэндаш болой.

Үүнийг төвөд бичигээс монгол үсэгт орчуулагч Шашины захиргааны эрхилсэн дарга Гомбожав бишрэлт."

8. *Soyangbu joyadi kemegdekü ubadis-un ijaγur ba damjiγuluγsan blam-a-(nug)ud-tur jalbiralta adisted uriqu egüden kemegdekü orosibai.*

Төгсгөлийн үг нь:

"...үүнийг ч, Чин сүзүгт номун хан хутагтын сойвон хурц билигт Шаравданзан-лугаа, аль тэдэний хувраг гэлэн Лувсанданзан хоёр-баар дурадхагсан урамд нэгэн үе лам хийгээд Дараната тэргүүтэн ламын увидасаас түүж дээдэсээр даган баригдсан галзуу авир ёсон баригч-дур хүрхэрэгсэн Хасбазар нэрт-бээр шаргагчин хонин жилийн мичид сарын шинийн арван гурванд аглаг орон Эвамгачилд найруулсны бичээч нь Цэрэндаш болой.

Үүнийг төвөд бичигээс монгол бичигт орчуулагч аграмба Гомбожав."

9. *Angqaduγar Jebjüngdamba Lubsangdambijalčan gegegen-ten-eče jokiyaγsan mani-yin түbdeb sabamu-yin tayilburi sabamunangva-ača tusqarlaju γarγaγsan soyangbu-yin udq-a-yin nomlal orosibai.*

10. *Soyangbu üsüg-ün tobā uār, E-Vam-un udq-a kiged soyangbu üsüg-ün uār tobā tedüi.*

11. *Tamaγ-a-yin soyangbu üsüg-ün uār.*

Төгсгөлийн үг нь:

"...үүнийг Шадбийдорж нэрт-бээр бичивэй.

Үүнийг орчуулагч Бишрэлт"

12. *Tamaγ-a-yin udq-a-yi bisilγaγsan-u segül-dür talbiqul irügel orosibai.*

Төгсгөлийн үг нь:

"...үүнийг Шадбийдорж бичивэй. хэмээн үүнийг дөрвөн хэлний үсгээс орчуулагч Бишрэлт мөн болой."

Соёмбо бичигийн судлалаар буй дээр дурдсан зохиолуудын төгсгөлийн үгэнд Шадбийдорж, Хасбазар гэдэг нэр нэг бус удаа дайралдаж байна. Энэ хоёр нэр нь даруй

нэгэн хүний нэр бөгөөд энэ талаар баттай баримт буйгаас гадна соёмбо бичгийн судлалаар дээрхи жагсаалтад ороогүй лавтайяа таван бүтээл байсан ажээ⁸. Үүнд:

1. *sva-yam-bhu jyo-ti zei-bya-ba'i mon-gol-gyi yi-ger bčas-ba bstod phyag-byas-pa ka-la-ping'i sgra dpyans.*

2. *sva-yam-bhu jyo-ti'i phyags-rgya-la gsol-'debs chul.*

3. *rjè-bcun bla-ma dam-pa'i man-nag sog-yig-gi skor-blo'i mun-sel.*

4. *sva-yam-bhu jyo-ti'i phyag-rgya gsol-debs sgo-nas bla-ma'i mal-'byor bsgom-chul.*

5. *sva-yam-bhu jyo-ti dar-mthun-pa'i man-nag zab-mo*

эдгээр болно.

Үүнээс гадна соёмбо бичгийн талаар бичсэн өөр хүмүүс ч буй ажээ. Тухайлбал: Их хүрээний Дүйнхорын аймагийн аграмба Лувсансодважамцобалсангийн сүнзом буюу "Зарлиг зохиолын гарчиг сүвд эрх" хэмээх гарбичмэл товъёгт:

"...(N. 63) *sva-yam-bhu jyi-ti'i yig-bsad e-vam phyag-rgya rnam-gsal / de'i gsol-'debs-kyi sgo-nas zab-lam bla-ma'i rnal-'byor bsgom-chul / sog-yig ran-byun snan-ba yis // e-vam phyag-rgya-bzens-chul-gyi bri-re'i*"

гэж байх жишээтэй.

1952 онд академич Б. Ринчен "ХҮГ зууны монголын үл мэдэгдэх хоёр бичиг"⁹ гэдэг өгүүлэлдээ соёмбо бичигийн цагаан толгойг барын соёмбо "Итгэл"-ийн хамт нийтлэж анх европ дахинаа шинжилгээний хүрээнд оруулсан бөгөөд дараахан нь 1955 онд акад. Л. Лигети авгай:

"...Монгол хэлшинжлэлийн тулгамдсан зорилтуудын тухайд гэвэл орчин үеийн монгол хэл аялгууны түүхийг судлах нь нэн чухал юм гэж бид хэлмээр байна. Ийм судлагаа хийхэд нэлээд их бэрхшээлтэй тулгарах нь яриангүй гэлээ ч эдгээр хэл аялгууны талаар эмх цэгц муутай хэсэг бусагхан баримт эрхбиш бий юм... Халх аялгууны хувьд гэхэд соёмбо үсгээр бичсэн ном зохиол үнэндээ байдаг уу гэдэгийг нарийвчлан үзвэл зохилтой байна. Ийм ном зохиол уг аялгууны онцлогийг хэсэг бусаг ч болсон үзүүлэх бөгөөд энэ тухай Б. Ринчен бичиж байна..."¹⁰

гэжээ.

⁸ Халхын Эрдэнэ-зуу хийдийн ширээт лам Дагвадаржаагийн намтараас үзэхүл: Багын нэр Хасбазар, увш санваарын нэр нь Лувсандагва, тойн санваарын нэр нь Лувсандагвадамбадаржаа, алдаршсан нэр нь Балганшадвийдорж (1734-1803). Тэрээр Очирай түшээт хаанаас Номч чорж хэмээх цолыг авсан бөгөөд дээр дурдсан ном зохиолоос гадна соёмбо бичгийн тухайд 1789 онд Соёмбо үсгээр сахиулсны бар сийлж, 1796 онд мөн үсгийн тухай ном бичиж, 1802 онд соёмбо үсгийн магтаалын шүлгийг зохиосон хэмээн дурджээ. Мөн энэ хүн олон гүр дуу зохиож, цам дэглэж байсан буюу өөрөөр хэлбэл тэр цагтаа шашин ном, соёл урлагийн талаар их л бүтээлтэй хүн байсан ажээ. Сүүл үеийн зарим судлаач энэ хүний гүр дууны талаар дурдахдаа олон нэрийг нь самуурч хэд хэдэн хүн мэтээр бичсэн явдал ч буй.

⁹ Rintschen, *Zwei unbekannte mongolische Alphabete aus dem XVII. Jahrhundert*, - АОН, Tom. II, Fasc. I, Budapest, 1952, pp. 63-67.

¹⁰ Л. Лигети, Г. Д. Санжеев, - *Сравнительная грамматика монгольских языков*, - Вопросы языкознания, Москва, 1955, N. 5, стр. 135 (Монгол орчуулга: Хэл зохиол судлал, VIII боть, 11-р дэвтэр, Улаанбаатар, 1970).

1959 онд барын "Итгэл"-ийн хэлний судлагааг Мажарын нэрт монголч эрдэмтэн Д. Кара хийж уг бичвэрийн франц орчуулгыг хавсаргажээ¹¹. 1975 онд энэ номыг бичигч соёмбо барын "Итгэл"-ийн орчуулгын хэлний онцлогийг бусад монгол, тод, буриад орчуулгатай харьцуулан судласан бөлгөө¹².

Энэ завсар харьцангуй цөөн боловч соёмбо бичгээр буй хэд хэдэн зүйл цагаан толгой, тамгын бичээс, бага дунд гарын монгол ном судлагчдын цуглуулгад хэдийнээ орсон тул дээр дурдсан барын "Итгэл"-ээс гадна монгол ном, бичвэрийн зүйл соёмбоор байдаг эсэхэд эргэлзэх явдал одоо нэгэнт хэрэггүй болжээ. Энэ ташрамд тэмдэглэхэд, 1973 оны 8-р сарын 13-нд Төв аймгийн Баянжаргалан сумнаа ШУА-ийн Хэлзохиолын хүрээлэнгийн Шинжээний ангийнхиныг Гандантэгчинлинг хийдийн гавж Данзан-осор авгайг хөдөөлж байхад нь уулзахад, их ламтан тэр зун Эрдэнэ-зуугаас захиж авчруулсан хоёр соёмбо номоо бидэнд (доктор Д. Цэрэнсодном, Ц. Шагдарсүрэн) үзүүлсэн бөгөөд бид ч их л олзуурхаж нэрий нь тэмдэглэж авсан билээ. Энэ тухай одоогийн хамба лам Чойжамц гавжтан сайн мэдэх бөлгөө. Тэр хоёр номын нэр нь:

1. "O-be-sun tö-rög-san u-kān ne-re-tü kan-nu tu-ji o-ro-si-gā "

2. "Kal-ka mon-go-lun u-las-dür sa-jin del-ge-rig-sa-nu ug u-ca-ri i-led-keg-san ö-bö-sün tö-rög-san ge-ge-nu kan-nu ge-rel ke-me-kü o-ro-si-gā "

хэмээж байсан бөгөөд үүнээс үзэхэд уран зохиол болон түүхийн ном гэдэг нь тов тодорхой харагдаж байна. Иймд энэ мэтчилэн барын болон бичмэл олон ном сударын зүйл байсан боловч цагийн саалт, улс төрийн эрхээр нэлээд нь үрэгдсэн гэж үзэх бүрэн үндэслэл буй. Манж нарын зүгээс монголчуудын тусгаар тогтнолын бэлгэдэл болгож зохиосон соёмбо бичгийн дурсгалыг, ялангуяа дан монгол хэлээр байсан дурсгалыг яав ч хадгалан уламжлуулахыг бодоогүй нь лавтай. Тийм ч учраас монгол хэлээр бус, самгард, төвөд, соёмбо хадмал шашны ном зохиол болон сахиулсан, шар дарцаг зэрэг харьцангуй олон зүйл бард гарч нэлээд нь бидний үе хүртэл үлдэж ирсэн¹³ нь чухам үүнтэй холбоотой буй заа.

Соёмбо бичигийн цагаан толгойн талаар арай тодруулан ярих нь зүйтэй болов уу гэж бодож байна. Соёмбо бичгийн бичмэл болон барын цагаан толгой нэлээн хэд буй боловч хоёр янзын барын цагаан толгой нэлээд сонирхол татдаг. Нэг нь: 9 x 23,5 см хэмжээтэй, сударчирсан дөрвөн хуудастай, "sva-yam-phu jyo-ti ge-me-kü mon-gol-un ü-süg o-ro-si-ga" нэртэй; нөгөө нь: нэр болон төгсгөлийн үггүй, 8 x 55 см, хоёр тал хуудастай. Энэ хоёр цагаан толгой нь агуулгын хувьд онцын ялгаагүй. Мөн Төв Азийг судлагч олон эрдэмтний анхаарлыг татсаар ирсэн бөгөөд модон бараар хэд хэдэн хэмжээгээр удаа дараа хэвлэгдсэн "Rgya-dkar-nag rgya-ser ka-smi-ra bal-bod hor-gyi yi-ge dan dpe-ris tam-grans man-ba bzugs-so"¹⁴ гэдэг номд соёмбо бичгийн эгшиг үсгээс монгол хэлнээ ордог хэлбэрүүдийг түүн жагсааж, холбон бичих жишээ болгож тарнийн жишээг хавсарган үзүүлсэн баримт буй.

Соёмбо бичгийн цагаан толгой



Хуудас эхлэсний тэмдэг. Номд бярга буюу эгчим ()-тэй адил үүрэгтэй. Соёмбо бичгийн энэ тэмдэг монголчуудын хувьд тусгаар тогтнолын бэлгэдэл болжээ.

¹¹ G. Kara, *Un texte mongol en écriture soyombo*, - AOH, Tomus. IX, Fasc. 1, Budapest, 1959, pp. 1-38.

¹² Ts. Chagdarsureng, *Sur quelques traductions mongoles du Nāha*, - Studia Mongolica, T. 2(10), Fasc. 11, Ulan-Bator, 1975, pp. 143-183.

¹³ Соёмбо үсгээр буй номын цуглуулгын дотор "Жамбалсанжид" бүхлээрээ, "Эмийн дөрвөн үндэс" зэрэг ном сударуудын эхний хэсэг соёмбо хадмалтай байдаг бөлгөө.

¹⁴ Sarat Chandra Das, *The Sacred and Ornamental Characters of Tibet*, JASB, T. LVII, Part I, 1888, pp. 41-48; G. Tucci, *Tibetan painted scroll*, I, Rome, 1949; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972.

1.  **tl.** A; **tc.** mong., tib., sans. a
Энэ хэлбэр нь а эгшигийн бие даасан (IF) буюу үгийн (зарим тохиолдолд үеийн) эхинд тохиолдоно. Жишээлбэл:

 **tl.** A-li;
tc. a-li.

(Ø) **tl.** a_o; **tc.** a. Энэ нь а эгшигийн гол хэлбэр (MF) буюу үгийн (зарим тохиолдолд үеийн) дунд болоод адагт тохиолдох нууц буюу тэг (Ø) хэлбэр. Жишээлбэл:

 **tl.** Ga_o-Ja_or;
tc. ga-jar


1.a.  **tl.** ā; **tc.** ā. Урт а эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Жишээ нь:

 **tl.** A-Da_or;
tc. ā-dar.

 **tl.** a_o; **tc.** ā. Энэ нь угтаа эгшигийн уртын тэмдэг. а эгшигтэй тохиолдвол, тэрхүү а эгшиг нь нууц буюу "тэг" (Ø) хэлбэртэй байдаг. Жишээлбэл:

 **tl.** Kā_on;
tc. kān.

2.  **tl.** i; **tc.** mong, tib., sans: i. Энэ нь i эгшигийн (IF) хэлбэр. Жишээлбэл:

 **tl.** I-Te-Gel;
tc. i-te-gel.

 **tl.** i₁; **tc.** i. Энэ нь i эгшигийн гол хэлбэрийн нэг буюу (MF₁) хэлбэр. Зөвхөн гийгүүлэгч (C)-ийн дараа буюу (C + i₁) нөхцөлд л тохиолдоно. Жишээлбэл:

 **tl.** A-Ci₁-tu;
tc. a-*ci*-tu.

 **tl.** i₂; **tc.** i. Энэ нь i эгшигийн гол хэлбэрийн нэг буюу (MF₂) хэлбэр. Зөвхөн эгшиг (V)-ийн дараа буюу (V + i₂) нөхцөлд тохиолдолдоно. Жишээлбэл:

 **tl.** Bol-Tu₁-Ga_oi₂;
tc. bol-tu-gai.

2.a.  **tl.** ī; **tc.** mong., sans: ī. Урт i эгшигийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:

 **tl.** ī-Me;
tc. ī-me.



tl. $\bar{a}_1$; tc. $\bar{a}$. Урт $\bar{a}$ эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. $\bar{U}-S\bar{u}-G\bar{a}_1g$;
tc. $\bar{u}-s\bar{u}-g\bar{a}g$.



tl. i_1i_2 ; tc. $\bar{i}$. Урт $\bar{i}$ эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. $Ma_0-Ni_1i_2n$;
tc. $ma-n\bar{i}n$ 'харъяалахын тийн ялгалд буй *маани*'



tl. $\bar{i}_1i_2$; tc. $\bar{i}$. "Маш урт"-аар дуудагдах $\bar{i}$ эгшигийн (MF) хэлбэр. Энд тусхайлан тэмдэглэх нь: үүний өмнө, "Тод бичиг"-ийн бөлөгт самгард хэлний эгшигийн *охор, урт, маш урт* гэсэн гурван янзын үргэлжлэц бүхий урт эгшигийг хэрхэн тэмдэглэх тухай арай дэлгэрэнгүй өгүүлсэн билээ. Иймд энэхүү "маш урт" $\bar{i}$ нь зөвхөн тарнийн хэлнээ тохиолдоно. Жишээ нь:



tl. $Bo-D\bar{i}_1i_2$;
tc. $bo-d\bar{i}$.

3.



tl. E ; tc. mong., tib.: $e / sans.$; (diphthongue) e . Энэ нь монгол, төвөд хэлний ерийн e , самгардын хос e эгшигийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. $E-Ne$;
tc. $e-ne$.



tl. e ; tc. e . Энэ нь e эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээлбэл:



tl. $Sei-Te$;
tc. $sel-te$.

3.а.




tl. $\bar{E}$; tc. mong., $\bar{e}$; sans. (diphthongue) ai . Энэ нь монгол хэлний ерийн урт e , самгардын хос ai эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. $\bar{E}-ri_1g-Ci_1$;
tc. $\bar{e}-rig-ci$.



tl. $\bar{e}$; tc. $\bar{e}$. Энэ нь урт e эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. $Ke-J\bar{e}$;
tc. $ke-j\bar{e}$.

4.



tl. $\bar{U}$; tc. mong., tib. $\bar{u}$; sans. u . Энэ нь монгол, төвөд хэлний $\bar{u}$, самгард хэлний u эгшигийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. $\bar{U}-N\bar{e}r$;
tc. $\bar{u}-n\bar{e}r$.



tl. $\bar{ü}$; tc. $\bar{ü}$. Энэ нь $\bar{ü}$ эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. $\bar{Ün-Dü-Sü}$;
tc. $\bar{ün-dü-sü}$.

4. а.



tl. $\bar{Ü}$; tc. mong. $\bar{ü}$, sans. $\bar{ü}$. Монгол хэлний урт $\bar{ü}$, самгардын урт $\bar{ü}$ эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Жишээ нь:



tl. $\bar{Ür}$;
tc. $\bar{ür}$.



tl. $\bar{ü}$; tc. $\bar{ü}$. Монгол хэлний урт $\bar{ü}$, самгардын урт $\bar{ü}$ эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. $\bar{Ü-Jü-Lüg-Sen}$;
tc. $\bar{ü-jü-lüg-sen}$.

5.



tl. U ; tc. mong. u . Монгол хэлний u эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Жишээ нь:



tl. $U-sun$;
tc. $u-sun$.



tl. u_1 ; tc. u . Энэ нь u эгшигийн гол буюу (MF) хэлбэрийн нэг. Зөвхөн гийгүүлэгчийн дараа буюу ($C + u_1$) нөхцөлд тохиолдоно. Жишээ нь:



tl. $Ya_0-Bu_1-Da_0l$;
tc. $ya-bu-dal$



tl. u_2 ; tc. u . Энэ нь u эгшигийн гол буюу (MF) хэлбэрийн нэг. Зөвхөн эгшигийн дараа буюу ($V + u_2$) нөхцөлд тохиолдоно. Жишээ нь:



tl. $Jo-Ri_1u_2l-Ji_1u_2$;
tc. $jo-riul-ju$.



tl. $Ya_0-Ga_0u_2l$;
tc. $ya-gaul$ 'шалтгаан, үндэс'¹⁵

5.а.



tl. $\bar{Ü}$; tc. mong., sans. $\bar{ü}$. Энэ нь монгол болон самгардын урт $\bar{ü}$ эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Жишээ нь:

¹⁵ Соёмбо бичгийн "Имгэл"-д төвөд хэлний tib. rgyu гэдэг үгийг ya-gaul (<Мо. *yaγayul) хэмээн орчуулсан нь буй. Энэ үгийг Ойродын Зая Бандидын орчуулсан тод "Имгэл"-д ündüsün гэж, буриад бичмэлд siltayan хэмээн орчуулжээ. Энэ тухай G. Kara, *Un texte mongol en écriture soyombo*, - АОН, Tomus. IX, Fasc. 1, Budapest, 1959, pp. 1-38 болон Chagdarsureng, *Sur quelques traductions mongoles du "Natha"*, - Studia Mongolica, Tom. 2 (10), Fasc. 11, Ulan-Bator, 1975, p. 183 (N. 86) -д үзмүү.



tl. ū-Da₀m;
tc. ū-dam.



tl. ā; tc. ā. Урт ā эгшигийн (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. A-Rül;
tc. ā-rül.

6.



tl. O; tc. mong., tib. o, sans. diphtongue o. Энэ нь монгол, төвөд хэлний ерийн о эгшиг, самгард хэлний хос о эгшигийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. O-Ron;
tc. o-ron.



tl. o; tc. o. Энэ нь о эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. Oi-Ro;
tc. oi-ro.

6.a.



tl. ō; tc. mong. ō, sans. diphtongue au. Энэ нь монгол хэлний урт о болон самгард хэлний au хос эгшигийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. ō-sor;
tc. ō-sor.



tl. ō; tc. ō. Энэ нь урт о эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. Kō-son;
tc. kō-son.

7.



tl. Ö; tc. mong. ö. Энэ нь ö эгшигийн бие даасан (IF) хэлбэр бөгөөд зөвхөн монгол хэлнээ тохиолдоно. Жишээлбэл:



tl. Ö-mög;
tc. ö-mög.



tl. ö; tc. ö. Монгол хэлний ö эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. Ö-mö-nö;
tc. ö-mö-nö.

7.a.



tl. Ö; tc. mong. ö. Монгол хэлний урт ö эгшигийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Ör;
tc. ör.



tl. ö; tc. ö. Урт ö эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:



tl. Bör;
tc. bōr.



tl. Au₂; tc. mong. au буюу diphtongue 'waw'. Энэхүү хос эгшигийн талаар цагаан толгойн жагсаалтын 5-ын u₂-аас лавшруулан үзнэ үү.



tl. Ai₂; tc. mong. ai буюу diphtongue 'yod'. Энэхүү хос эгшигийн талаар цагаан толгойн жагсаалтын 2-ын i₂-аас лавшруулан үзнэ үү.



tl. mong. G(a), tib., sans: K(a); tc. mong. ga, tib., sans; ka. Энэ нь монгол хэлний g(a), төвөд, самгардын k(a) гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр.



tl. Ga₀-Ja₀r;
tc. ga-jar.



tl. g; tc. g. Энэ нь монгол хэлний гийгүүлэгчийн гол (MF) хэлбэр бөгөөд амьгүй буюу дэвсгэрлэж ордог хэлбэр. Жишээ нь:



tl. Ka₀-mu₁g;
tc. ka-mug.



tl. sans. k; tc. sans. k. Зөвхөн самгард хэлнээ тохиолдоно. Жишээ нь:



tl. kKa₀;
tc. kka.



tl. mong. K(a), tib., sans.: KH(a); tc. mong. ka, tib., sans.: kha. Монгол хэлний ka; төвөд, самгард хэлний гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Ka₀-mu₁g;
tc. ka-mug.



tl. (k) / kh; tc. (k) / kh. Энэ нь (k) / kh гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр. Монгол бичгийн хэлний зөв бичих зүйд энэ гийгүүлэгч дэвсгэрлэж ордоггүй. Харин Тод бичигт дэвсгэрлэж ордог ёсон буй.



tl. tib., sans: N(a); tc. tib., sans.: na. Энэ нь төвөд, самгард хэлний гүн угийн гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. Монгол хэлнээ эл гийгүүлэгч нь үгийн болон үеийн эхинд тохиолддоггүй учир монгол бичвэрт ийм хэлбэр хэрэглэгдэхгүй.



tl. mong. n / tib., sans.: ṅ; tc. mong. n / tib., sans.: ṅ. Энэ нь n/ṅ гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр. Монгол хэлнээ зөвхөн үеийн эцэст тохиолдоно.



tl. Ji₁ r-Ga₀-La₀ n;
tc. jir-ga-lan.

13.  **tl.** mong. J(a), tib., sans.: C(a).
tc. mong. ja (i -гээс бусад эгшигийн өмнө) / ja(i эгшигийн өмнө), tib., sans.: ca. Энэ нь монгол хэлний ja/ ja, төвөд, самгардын са гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Ja₀r-Li₀g;
tc. jar-lig.



tl. Ji₁ r-Ga₀-La₀ n;
tc. jir-ga-lan.

14.  **tl.** mong. C(a), tib., sans.: CH(a);
tc. mong. ca (i -гээс бусад эгшигийн өмнө) / ца (зөвхөн i эгшигийн өмнө); tib., sans.: cha. Энэ нь монгол хэлний са / ца, төвөд, самгард хэлний cha гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Ca₀γ -ga₀-ca₀;
tc. ca-ga-ca (<Mo. čay-ača).



tl. Ci₁-Na₀r;
tc. čī-nar.



tl. Ci₁u₂l-Ga₀-Nu₁;
tc. čīul-ga-nu
 (<Mo. ciyulγan-u).

15.  **tl.** tib., sans.: N(a);
tc. tib., sans.: na. Төвөд, самгард хэлний гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр.

16.  **tl.** mong. D(a), tib., sans.: t(a);
tc. mong. da, tib., sans.: ta. Монгол хэлний da, төвөд самгард хэлний ta гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Da₀-ga₀n;
tc. da-gan (< Mo. daya-).



tl. mong. d, tib., sans.: t;
tc. mong. d, tib., sans.: t. Монгол хэлний d, төвөд, самгард хэлний t гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Ki-Ged;
tc. ki-ged (< Mo. kiged).

17.  **tl.** mong. T(a); tib., sans.: TH(a);
tc. mong. ta, tib., sans.: tha. Монгол хэлний ta, төвөд, самгард хэлний tha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Ta₀-Ra₀g-Sa₀n;
tc. ta-rag-san (< Mo. tara-).

18.  **tl.** mong., tib., sans.: N(a);
tc. mong., tib., sans.: na. Монгол, төвөд, самгард хэлний na гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр. Жишээ нь:



tl. Na₀-Ra₀;
tc. na-ra.

tl. n.

tc. n. Монгол, төвөд, самгард хэлний n гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр. Жишээ нь:

tl. Na₀-Ya₀n;
tc. na-yan.

19.

tl. mong. B(a), tib., sans.: P(a);

tc. mong. ba, tib., sans.: pa. Монгол хэлний ba, төвөд, самгард хэлний pa гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. Жишээлбэл:

tl. Ba₀-Ri₁-
tc. ba-ri- (Mo. bari-).

tl. mong. b, tib., sans.: p;

tc. mong. b, tib., sans.: p.

Монгол хэлний b, төвөд, самгард хэлний p гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр. Жишээлбэл:

tl. El-Deb;
tc. el-deb.

20.

tl. mong. P(a), tib., sans.: PH(a);

tc. mong. pa, tib., sans.: pha. Монгол хэлний pa, төвөд, самгард хэлний pha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр нь.

21.

tl. mong., tib., sans.: M(a);

tc. mong., tib., sans.: ma. Монгол, төвөд, самгард хэлний ma гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр. Жишээ нь:

tl. Ma₀-Ši₁;
tc. ma-si.

tl. m;

tc. m. Энэ нь m гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр. Жишээлбэл:

tl. Er-Dem;
tc. er-dem.

tl. tib., sans.: (O)m;

tc. tib., sans.: (o)m. Энэ нь төвөд, самгард бичвэрт, тарнийн хэлнээ тохиолдоно. Уугуул монгол хэлнээ тохиолдохгүй.

22.

tl. mong., tib.: Y(a), sans.: semi-vowel Y(a);

tc. mong., tib., ya, sans.: semi-vowel ya. Монгол, төвөд хэлний y гийгүүлэгч, самгард хэлний заримдаг (тал) y эгшигийн бие даасан (IF) хэлбэр.

tl. Ya₀-Ga₀u₂l;
tc. ya-gaul (Энэ бөлөгийн 15-р зүүлтээс тодруулна уу.)



tl. tib., sans.: y(a);

tc. tib., sans.: ya. Хэдийгээр энэ нь монгол, төвөд хэлний хувьд у гийгүүлэгч, самгард хэлний тухайд заримдаг (буюу тал) у эгшигийн гол (MF) хэлбэр мөн боловч хэрэглээ нь хязгаартай. Үүнд: соёмбо бичигийн цагаан толгойгоос үзэхэд нэгд, монгол хэлний дэвсгэр гийгүүлэгчид багтаагаагүй ажээ; хоёрт, төвөд болон самгард хэлнээ зүүлтэт үсэгт тохиолдохоор тэмдэглэжээ.



tl. Kya₀;
tc. kya.

23.



tl. mong., tib., sans.: R(a);

tc. mong., tib.: ra, sans.: semi-vowel ra. Энэ нь монгол, төвөд хэлний га гийгүүлэгч, самгард хэлний га хэмээх заримдаг (буюу тал) эгшигийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:




tl. Ja₀u₂-Ra₀-Da₀;

tc. jau-ra-da (< Mo. jayuradu ~ jayurada)



tl. mong., tib.: r, sans.: (semi-vowel) r;

tc. mong., tib.: r, sans. (semi-vowel) r. Монгол, төвөд хэлний г гийгүүлэгч, самгард хэлний г хэмээх заримдаг (буюу тал) эгшигийн гол (MF) хэлбэр нь. Монгол хэлнээ дэвсгэрлэж орохдоо энэхүү гол хэлбэрийг дундуур нь таллаж, тал гурвалжин хэлбэрээр тэмдэглэнэ. Жишээ нь:



tl. Er-Dem;
tc. er-dem.

Харин төвөд, самгард хэлний давхар үсгийн тухайд, г гийгүүлэгч (буюу заримдаг эгшиг)-ийн гол хэлбэрийг хялбарчлахгүй, яг хэвээр нь толгой, зүүлт болгож бичдэг. Жишээлбэл:



tl. Kra₀;
tc. kra.



tl. rKa₀;
tc. rka.

24.



tl. tib., V(a), sans.: (semi-vowel): V(a);

tc. tib. va, sans.: (semi-vowel): va. Төвөдийн ва гийгүүлэгч, самгардын заримдаг (буюу тал) ва эгшигийн бие даасан (IF) хэлбэр нь.



tl. tib., sans.: v(a);

tc. tib., sans.: va.

Энэ нь төвөд, самгардын давхар үсэгт v(a) зүүлт болж ордог гол (MF) хэлбэр. Үүнийг эл бөлөгийн No. 63-аас тодруулан үзмүү.

25.



tl. mong., tib.: L(a), sans.: (semi-vowel): L(a);

tc. mong., tib.: la, sans.: (semi-vowel): la. Энэ нь Монгол, төвөд хэлний л гийгүүлэгч, самгард хэлний л хэмээх заримдаг (буюу тал) эгшигийн бие даасан (IF) хэлбэр нь. Жишээлбэл:



tl. Nom-La₀g-Sa₀n;
tc. nom-lag-san.



tl. mong., tib.: l, sans.: (semi-vowel): l;

tc. mong., tib.: l, sans.: (semi-vowel): l.

Энэ нь монгол, төвөд хэлний l гийгүүлэгч, самгардын заримдаг (буюу тал) l эгшигийн гол (MF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Bel-ge;

tc. bel-ge.

Харин энэхүү (MF) хэлбэр нь төвөд, самгардийн давхар үсэгт толгой болж орохдоо ганц хөндлөн зураас болж ордог. Тухайлбал:



tl. lKa₀;


tc. lka.

26.



tl. mong. Š(a), tib., sans. Ç(a) / Ś(a).

tc. mong. ša, tib., sans.: ца / śa. Энэ нь монгол хэлний ša, төвөд, самгард хэлний ца буюу śa гийгүүлэгийн бие даасан (IF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Teg-še;

tc. teg-še.



tl. mong. š;

tc. mong. š. Энэ нь š гийгүүлэгчийн монгол хэлэнд тохиолдох гол буюу (MF) хэлбэр. Соёмбо бичигийн цагаан толгойноос үзэхэд үүнийг монгол хэлний дэвсгэр үсэгт багтаажээ (Тод бичигт ч бас ийм буй). Тухайлбал:



tl. Aš;

tc. aš.

Самгард хэлнээ, давхар үсэгт энэ гийгүүлэгчийг толгой болгож залгахдаа (MF) хэлбэрийг таллаж арай хялбарчлан тэмдэглэдэг бөлгөө.



tl. čKa₀;

tc. čka.

27.



tl. mong., tib., sans. S(a);

tc. mong., tib., sans. sa. Sa гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр.



tl. Sa₀-Ra₀;

tc. sa-ra.



tl. s; tc. s. Энэ нь sa гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр. Монгол хэлний тухайд дэвсгэрлэж орох хэлбэр гэсэн үг. Жишээлбэл:



tl. Te-güs;

tc. te-güs.

Төвөд, самгард хэлний давхар үсэгт sa толгойг бичихдээ бяцхан гурвалжин болгож доорхи байдлаар тэмдэглэнэ.



tl. sKa₀;
tc. ska.

28. **tl.** mong., tib., H(a), sans.: (semi-vowel): H(a);
tc. mong., tib. ha, sans.: (semi-vowel): ha. Энэ нь монгол, төвөд хэлний ха гийгүүлэгч, самгард хэлний заримдаг (буюу тал) ха эгшигийн бие даасан (IF) хэлбэр.
29. **tl.** sans. (compound consonant): KS(a);
tc. sans. (compound consonant): ksa. Самгард хэлний нийлмэл гийгүүлэгч ksa -гийн бие даасан (IF) хэлбэр.
30. **tl.** mong., Ag, tib., sans.: Ak;
tc. mong. ag, tib., sans.: ak. Монгол хэлний дэвсгэр -g гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 10-аас тодруулан үзнэ үү).
31. **tl.** mong. Ak, tib., sans.: Akh;
tc. mong. ak, tib., sans. akh. Дэвсгэрлэж орох -k гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 11-аас тодруулан үзнэ үү).
32. **tl.** mong. Añ, tib., sans.: Añ;
tc. mong. añ, tib., sans. añ. Монгол хэлний дэвсгэр -n гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 12-аас тодруулан үзнэ үү).
33. **tl.** mong. Ad, tib., sans.: At;
tc. mong. ad, tib., sans.: at; Монгол хэлний дэвсгэр -d гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 16-аас тодруулан үзнэ үү).
34. **tl.** mong. An, tib., sans.: An;
tc. mong., an, tib., sans.: an. Монгол хэлний дэвсгэр -n гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 18-аас тодруулан үзнэ үү).
35. **tl.** mong. Ab, tib., sans.: Ap;
tc. mong. ab; tib., sans.: ap. Монгол хэлний дэвсгэр -b гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 19-аас тодруулан үзнэ үү).
36. **tl.** mong., tib., sans.: Am;
tc. mong., tib., sans.: am. Монгол хэлний дэвсгэр -m гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 21-аас тодруулан үзнэ үү).
37. **tl.** mong., tib., sans.: Ar;
tc. mong., tib., sans.: ar. Монгол хэлний дэвсгэр -r гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 23-аас тодруулан үзнэ үү).
38. **tl.** mong., tib., sans.: Al;
tc. mong., tib., sans.: al. Монгол хэлний дэвсгэр -l гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 25-аас тодруулан үзнэ үү).

39.  **tl.** mong., tib., sans.: Aṣ;
tc. mong., tib., sans. aṣ. Дэвсгэрлэж орох -ṣ гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 26-аас тодруулан үзнэ үү). Монгол бичигийн зөв бичих зүйд энэхүү ṣ гийгүүлэгч дэвсгэрлэж ордоггүй; харин тод бичигт дэвсгэрлэдэг бөгөөд "арааны сийгээн" гэдэг тусгай нэр устай. Энэ талаар "Тод бичиг" хэмээх бөлөгийн холбогдох хэсгээс тодруулан үзмүү.
40.  **tl.** mong., tib., sans.: As;
tc. mong., tib., sans. as. Монгол хэлний дэвсгэр -s гийгүүлэгчийн хэлбэр (Уг үсгийн талаар жагсаалтын No. 27-аас тодруулан үзнэ үү).
41.  **tl.** mong. Aṅ; tib. A'ṅ (ཨᠩ).
tc. mong. āṅ, < (?) Mo. -iyan/-iyen; -ban/-ben.
42.  **tl.** sans. R̄ ~ R̄i;
tc. ṛ ~ ṛi. Самгард хэлний ṛ ~ ṛi эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  **tl.** sans. ṛ ~ ṛi;
tc. sans. ṛ ~ ṛi. Самгард хэлний ṛ ~ ṛi эгшигийн гол буюу (MF) хэлбэр.
- 42.a.  **tl.** sans. R̄ ~ R̄i;
tc. sans. ṝ ~ ṝi. Самгард хэлний урт ṝ ~ ṝi эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  **tl.** sans. ṝ ~ ṝi;
tc. sans. ṝ ~ ṝi. Самгард хэлний урт ṝ ~ ṝi эгшигийн гол буюу (MF) хэлбэр.
43.  **tl.** sans. L̄ ~ L̄i;
tc. sans. ḷ ~ ḷi. Самгард хэлний ḷ ~ ḷi эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  **tl.** sans. L̄ ~ L̄i;
tc. sans. ḷ ~ ḷi. Самгард хэлний ḷ ~ ḷi эгшигийн гол буюу (MF) хэлбэр.
- 43.a.  **tl.** sans. L̄ ~ L̄i;
tc. sans. ḹ ~ ḹi. Самгард хэлний урт ḹ ~ ḹi эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  **tl.** sans. ḹ ~ ḹi;
tc. sans. ḹ ~ ḹi. Самгард хэлний урт ḹ ~ ḹi эгшигийн гол буюу (MF) хэлбэр.
44.  **tl.** sans. Am̄ ~ Am̄;
tc. sans. am̄ ~ am̄. Самгард хэлний am̄-svara -гийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  **tl.** sans. m̄ ~ m̄;
tc. sans. m̄ ~ m̄.

Самгард хэлний anu-svara -гийн гол буюу (MF) хэлбэр. Жишээлбэл:



tl. Sva₀-ya₀m-bhü;
tc. sva-yaṃ-bhü.

45. tl. sans. AH;
tc. sans. aḥ. Самгард хэлний vi-sarga гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
46. tl. tib., sans.: G(a);
tc. tib., sans.: ga. Төвөд, самгард хэлний ga гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
47. tl. sans. GH(a);
tc. sans. gha. Самгард хэлний gha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
48. tl. tib., sans.: J(a);
tc. tib., sans.: ja. Самгард хэлний ja гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
49. tl. sans. JH(a);
tc. sans. jha. Самгард хэлний jha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
50. tl. sans. T(a);
tc. sans. ta. Самгард хэлний ta гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
51. tl. sans. TH(a);
tc. sans. tha. Самгард хэлний tha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
52. tl. sans. D(a);
tc. sans. da. Самгард хэлний da гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
53. tl. sans. DH(a);
tc. sans. dha. Самгард хэлний dha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
54. tl. sans. N(a);
tc. sans. ṇa. Самгард хэлний ṇa гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
55. tl. tib., sans.: D(a);
tc. tib., sans.: da.
Төвөд, самгард хэлний da гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.

56.  **tl.** sans. DH(a);
tc. sans. dha. Самгард хэлний dha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
57.  **tl.** tib., sans.: B(a);
tc. tib., sans.: ba. Төвөд, самгард хэлний ba гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
58.  **tl.** sans. BH(a);
tc. sans. bha. Самгард хэлний bha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
59.  **tl.** sans. Ṣ(a);
tc. sans. ṣa. Самгард хэлний ṣa гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
60.  **tl.** tib., sans. Ky(a);
tc. tib., sans. kya. Төвөд, самгард хэлний kya гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 22-оос лавлагтун!)
61.  **tl.** tib., sans.: Kr(a);
tc. tib., sans.: kra. Төвөд, самгард хэлний kra гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 23-аас лавлагтун!)
62.  **tl.** tib., sans.: Kl(a);
tc. tib., sans.: kla. Төвөд, самгард хэлний kla гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 25-аас лавлагтун!)
63.  **tl.** tib., sans.: Kv(a);
tc. tib., sans.: kva. Төвөд, самгард хэлний kva гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 24-өөс лавлагтун!)
64.  **tl.** sans. kK(a);
tc. sans. kka. Самгард хэлний kka гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 10-аас лавлагтун!)
65.  **tl.** sans. ṆK(a);
tc. sans. ṇka. Самгард хэлний нийлмэл ṇka гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 10, 12-оос лавлагтун!)
66.  **tl.** sans. ṆC(a);
tc. sans. ṇca. Самгард хэлний нийлмэл ṇca гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 13, 15-аас лавлагтун!)
67.  **tl.** sans. ṆṬ(a);
tc. sans. ṇṭa. Самгард хэлний нийлмэл ṇṭa гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 50, 54-өөс лавлагтун!)

68.  **tl. sans.** NT(a);
tc. sans. nta. Самгард хэлний нийлмэл nta гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 16, 18-аас лавлагтун!)
69.  **tl. sans.** MP(a);
tc. sans. mpa. Самгард хэлний нийлмэл mpa гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 19, 21-ээс лавлагтун!)
70.  **tl. tib., sans.:** lK(a);
tc. tib., sans.: lka. Төвөд, самгард хэлний lka гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 25-аас лавлагтун!)
71.  **tl. sans.** ʕK(a) ~ śK(a);
tc. sans. ʕka ~ śka. Самгард хэлний ʕka ~ ska гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 10, 26-аас лавлагтун!)
72.  **tl. tib., sans.:** sK(a);
tc. tib., sans.: ska. Төвөд, самгард хэлний ska гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 10, 27-оос лавлагтун!)
73.  **tl. tib., sans.:** rK(a);
tc. tib., sans.: rka. Төвөд, самгард хэлний rka гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр. (Энэ жагсаалтын No. 10, 23-аас лавлагтун!)
74.  **tl. tib.** Č(a);
tc. tib. ča. Зөвхөн төвөд хэлний ča гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
75.  **tl. tib.** ČH(a);
tc. tib. čha. Зөвхөн төвөд хэлний čha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
76.  **tl. tib.** J(a);
tc. tib. ja. Зөвхөн төвөд хэлний ja гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
77.  **tl. tib.** Ž(a);
tc. tib. ža. Зөвхөн төвөд хэлний ža гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
78.  **tl. tib.** Z(a);
tc. tib. za. Зөвхөн төвөд хэлний za гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.

79.



tl. tib. '(a);

tc. tib. 'а. Төвөд хэлний "шанаган а" хэмээх 'a-*chun* буюу 'а гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр.

80.



Номыг төгсгөх тэмдэг.

Уламжлалт цагаан толгойд төвөд болон самгард хэлний хувьд адил хэлбэр бүхий зарим гийгүүлэгчийг салгаж тус тус тэмдэглэсэн байдаг учир ном бүтээлд соёмбо бичгийг 90 үсэгтэй хэмээн тэмдэглэсэн зүйл буй. Дээрхи жагсаалтад бид тийнхүү салгаж тэмдэглэсэн үсгийг бусад тэмдэгтүүдийнхи нь адил нэгэн зарчимд оруулж нэгтгэсэн тул ийнхүү 80 тэмдэгт болсон гэдэгийг энэ ташрамд тэмдэглэсү.

Соёмбо үсгийн бүтэц нь энэхүү бичигийн цаашдын судлагаа болон хэвлэлийн боломжийг дээшлүүлж цахим тооцоолуурт оруулах зэрэгт чухал хэрэглэгдэхүүн болох учир махбодын бүтэцийг зүйлчилэн ангиласан жагсаалтыг (2-р хавсралт) үзүүлбэл доорхи мэт болно.

1. *toluγai* (1 - 79);
 1. a. (10 - 12; 28 - 29; 46 - 47; 60 - 65; 70 - 73);
 1. b. (64).
2. *silbi* (1 - 9; 13 - 27; 30 - 45; 48 - 59; 66 - 69; 74 - 79);
 2. a. (10 - 12; 46 - 47; 50 - 53; 55 - 56; 60 - 65; 70 - 73);
 2. b. (10 - 12; 28 - 29; 46 - 47; 69 - 65; 70 - 73);
 2. c. (28).
3. *Эгшигийн уртын тэмдэг*: (1а - 7а; 42а - 43а).
4. I. Эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэрийн махбодын нэгэн хэсэг (1 - 9; 42 - 45);
II. Гийгүүлэгчийн махбодын нэгэн хэсэг. Нэг гийгүүлэгчийг нөгөөгөөс нь тухайлбал: 20-ийг 19-өөс; 21-ийг 24-өөс; 58-ыг 57-гоос ялгах үүрэгтэй (20; 22 - 23; 58; 69; 77).
5. Эгшигийн бие даасан (IF) хэлбэрийн махбодын нэг хэсэг (1 - 9; 42 - 45).
6. I. *i* (2 - 2a) эгшигийн гол буюу (MF) хэлбэр.
II. *j + i = j* (No. 13); *c + i = č* (No. 14).
- 6a. Эгшигийн дараа орсон *i* эгшигийн гол буюу (MF) хэлбэр (2, 9).
7. *e* эгшигийн гол буюу (MF) хэлбэр (3 - 3a).
8. *ü* эгшигийн гол буюу (MF) хэлбэр (4 - 4a).
9. *u* эгшигийн гол буюу (MF) хэлбэр (5 - 5a).
- 9a. Эгшигийн дараа орсон *u* эгшигийн гол буюу (MF) хэлбэр (5, 8).
10. *o* эгшигийн гол буюу (MF) хэлбэр (6 - 6a).
11. *ö* эгшигийн гол буюу (MF) хэлбэр (7 - 7a).
- 12 - 12a - 12b. *qolbuγ-a* (10 - 12; 18; 28 - 29; 46 - 47; 54; 60 - 65; 68 - 68; 70 - 73).
13. I. *ga/ka* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (10; 29 - 30; 60 - 65; 70 - 73).
II. *da - dha*; *da - dha* гийгүүлэгчийг өвөр зуур нь ялгах махбод (52 - 53; 55 - 56).
- 13a. *ka/kha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (11; 31).
- 13b. *ha* гийгүүлэгчийн нийлмэл махбодын нэг хэсэг (28).
14. *pa/na* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (12; 32).
- 14a. I. *na* гийгүүлэгчийн гол махбодын нэг хэсэг (18).
II. *na* гийгүүлэгчийн гол махбодын нэг хэсэг (54).
- 14b. *ān* дэвсгэрийн гол буюу (MF) хэлбэр (41).
15. *ja* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (13; 66). *j + i = j* (13).
- 15a. *na* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (15; 66).
- 15b. *ja* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (48).
- 15c. *jha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (49).
16. *ča* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (74).
- 16a. *ja* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (76).

- 16b. *cha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (75).
- 16c. *ca* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр: $c + i = \bar{c}$ (14).
17. *da/ta* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (16; 33; 68).
- 17a. *ba/pa* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (19; 20; 35; 69).
18. I. *va* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (24; 63).
II. *ma, ta/tha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (21; 36; 69; 17).
- 18a. *m* дэвсгэрийн гол буюу (MF) хэлбэр (36).
- 18b. *'anu-svara* -гийн гол буюу (MF) хэлбэр (44).
19. *ta/tha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (17).
- 19a. *ya* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (22; 60).
20. *na* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (18).
- 20a. *ṣa* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (77).
- 20b. *ya* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (22; 60).
21. *ga* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (23; 61).
- 21a. *g* дэвсгэрийн гол буюу (MF) хэлбэр (37).
- 21b. *давхар gka* гийгүүлэгчийн *g* толгойн хэлбэр (73).
22. *la* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (25; 62).
- 22a. *l* дэвсгэрийн гол буюу (MF) хэлбэр (38).
- 22b. *давхар lka* гийгүүлэгчийн *l* толгойн хэлбэр (70).
23. I. *sa* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (26; 39).
II. *sa* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (59).
- 23a. *давхар ṣka* гийгүүлэгчийн *ṣ* толгойн хэлбэр (71).
24. I. *sa* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (27).
II. *sa* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (59).
- 24a. I. *da* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (55).
II. *dha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (56).
- 24b. *s* дэвсгэрийн гол буюу (MF) хэлбэр (40).
- 24c. *давхар ska* гийгүүлэгчийн *s* толгойн хэлбэр (72).
25. *g* эгшигийн гол буюу (MF) хэлбэр (42 - 42a).
- 25a. *l* эгшигийн гол буюу (MF) хэлбэр (43 - 43a).
26. *vi-sarga* - гийн гол буюу (MF) хэлбэр (45).
27. *ga* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (46).
- 27a. *dha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (47).
28. *sidūn: ta, tha, da, dha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (50 - 53).
- 28a. *na* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (54; 67).
- 28b. *tha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (51).
29. I. *ba/pa* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (57).
II. *bha/pha* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэрийн нэг хэсэг (58).
30. *za* гийгүүлэгчийн гол буюу (MF) хэлбэр (78).
31. *'a-chun* - гийн гол буюу (MF) хэлбэр (79).

Цэг тэмдэгийн зүйл

32. *бярга* буюу *эгчим*.
33. *цэг* (монгол бичигийн нэг цэгтэй утга дүйнэ).
34. *давхар цэг* (монгол бичигийн давхар цэгтэй утга дүйнэ).
35. *төгсгөх тэмдэг* (гол төлөв номын эцэст тохиолдоно).


Соёмбо бичгээр буй дурсгалын зүйлийг үзвэл бичсэн чиглэл нь дотроо хоёр зүйл байх бөгөөд нэгд, зүүнээс баруунш буюу хөндлөн бичсэн нь их л дэлгэр, үүнийг бичигтэн хүмүүс "хэвтээ соёмбо" хэмээнэ; хоёрт, дээрээс доош нь монгол бичигийн байдалтай байх нь бас буй, үүнийг "босоо соёмбо" хэмээмүй. Энэ хоёр нь өвөр зуураа баахан ялгаатай: "хэвтээ соёмбо"-оор бичихэд үгийг үе үеэр нь тус тус бие даасан толгойтой бичдэг дүрэмтэй бол "босоо"-гоор бичихэд ганц толгойн доор цувруулан бичих ба хэрэвзээ нэгэн анзын эгшиг байваас хурааж ганц удаа тэмдэглэх зэргээр аль болохуйц хялбарчлан хэмнэх байдлыг чухалчиламуй. Үүний жишээг Хуанли дээр дарсан "Нийслэл хүрээний Зурхай дацангийн тэмдэг" хэмээх тамгын дардас бичвэрээс лавлан ажина уу.



Энэхүү тамгын дардас дээрхи бичвэрийг латин галигаар сэргээн үзүүлбэл доорхи мэт болно.


- I. naya - selei
- II. kōr - yenu jūr - ka
- III. grva - chanun temedeg

Үүнээс харахул, "босоо" соёмбоор бичихэд монгол хэлний эгшиг зохицох ёсыг ашиглаж өгүүлэх эрхтэний ойр төстэй оролцоогоор нь нэгэн толгойд бөлөглөж бичдэг зарчим байсан нь харагдана. Тухайлбал: So. temedeg (<Mo. temdeg) гэдэг үгийг "босоо" болон "хэвтээ"-гээр хэрхэн бичих байдлыг харьцуулан үзүүлээ.



Соёмбо бичгээр хичээнгүйлэн дармаллаж бичихийн хажуугаар ер энгийн байдлаар татлан бичдэг бөгөөд аливаа бичиг үсэгт хэрхэн бичдэг *Үсэгийн дүрэм* байдагчилан соёмбо бичигт ч тусгайлан баримтлах тогтсон журам буй. Үүнийг "er-dem" гэдэг үгээр жишээлэн үзүүлсүгэй.

er-dem:



Соёмбоор буй монгол хэлний дурсгалын зүйлийг хэлний талаас авч үзэхүл соёмбо бичгээр монгол үгийг бичихдээ тухайн цагийн монгол хэлний аман дуудалгын байдал

харагдахын хажуугаар үлэмжхэн түрүү үеийн монгол хэлний онцлог ч харагддаг¹⁶ нь уг бичгээр аман аялгууны дуудалга болон бичгийн хэлний дуудалгын аль алианаар нь бичиж болдогтой шууд холбоотой хэрэг.

Энэ байдал нь соёмбо бичигийг зохиохдоо тэр цагийнхаа монгол хэлний аман дуудалгад ойртуулах гэхээсээ илүү гурван гэгээн хэлээр нарийвчилан бичих бололцоог сайжруулах гэсэн зорилготой байсныг харуулж байгаа хэрэг гэж үзүүштэй бөгөөд энэ тухай ч Бичээч Цорж тусгайлан тэмдэглэснийг бид дээр өгүүлсэн бөлгөө¹⁷.

Эцэст нь хэлэхэд, бид энэ удаад соёмбо бичгээр монгол хэлийг хэрхин тэмдэглэх ёсыг зонхилож ярилаа. Төвөд, самгард хэлийг хэрхин тэмдэглэж ирсэн тухайд гэвэл, угтвар, гол үсэг, дагавар тэргүүтнийг яг байгаагаар нь буюу тухайн хэл бичигээр хэрхэн бичдэг байдлыг ёсочилон дагадаг байсаныг өдгөөгийн хэлшинжлэлийн үүднээс авч үзвэл дуудалгын болон үсгийн галигийн эргэн сэргээх (The reversibility) зарчимыг чанд баримтласан байна гэж үзэх бүрэн үндэс буй. Учир иймээс соёмбо бичгээр монгол хэлийг тэмдэглэх ёс нь төвөд, самгард хэлийг тэмдэглэхээс ихээхэн ялгаатай байжухуй.

¹⁶ G. Kara, *Un texte mongol en écriture soyombo*, AOH, Tom. IX, Fasc. I, Budapest, 1959, pp. 1-38; Ts. Chagdarsureng, *Sur quelques traductions mongoles du Nātha*, Studia Mongolica, Tom. 2(10), Fasc. 11, Ulan-Bator, 1975, pp. 143-183.

¹⁷ Бичээч Цоржийн дүгнэлтийн талаар энэ бөлөгийн 7-р зүүлтээс лавшруулан үзмүү.

ᠠ ᠡ ᠢ ᠣ ᠤ ᠥ ᠦ ᠨ ᠬ

I I a 2 2 a 3 3 a 4 4 a 5

ᠭ ᠨ ᠬ ᠬ ᠬ ᠬ ᠬ ᠬ ᠬ ᠬ ᠬ

5 a 6 6 a 7 7 a 8 9 10 11 12

ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ

13 14 15 16 17 18 19 20 21 22

ᠷ ᠷ ᠷ ᠷ ᠷ ᠷ ᠷ ᠷ ᠷ ᠷ

23 24 25 26 27 28 29 30 31 32

ᠸ ᠸ ᠸ ᠸ ᠸ ᠸ ᠸ ᠸ ᠸ ᠸ

33 34 35 36 37 38 39 40 41 42

ᠹ ᠹ ᠹ ᠹ ᠹ ᠹ ᠹ ᠹ ᠹ ᠹ

42a 43 43a 44 45 46 47 48 49 50

ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ

51 52 53 54 55 56 57 58 59 60


ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ

61 62 63 64 65 66 67 68 69 70



ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ ᠰ

71 72 73 74 75 76 77 78 79






Соёмбо үсгийн махбодын жагсаалт



Барын соёмбо цагаан толгойн зураг



Олон-аа өргөгдсөн хэмээгдэгч "Шашин төрийг хослон баригч
наран гэрэлт Богд хааны тамга"-ын дардас
(Соёмбо, монгол, дөрвөлжин бичигээр бичжүхүй)



"Босоо соёмбо"-оор бичсэн тамга бүхий
 "Цаг улиралын тооны бичиг"-ийн эхний хуудас
 (1914 он)

ХЭВТЭЭ ДӨРВӨЛЖИН БИЧИГ

Модон барын "rJa-bcun blo-bzan bstan-pa'i rgyal-mchan gyi gsun-'thor-bu phogs-gcig tu-bsdud pa bzugs"¹ буюу Өндөр гэгээн Занабазарын "...хэсэг бусаг зарлигийн хураангуй" хэмээх номын эцэст нэгэн зүйл үсгийн цагаан толгойг хавсаргасан байдаг ба бас 1729 оны урт барын нэгэн сударын 261-р хуудсанд агуулгын хувьд үүнтэй яг адил бас нэгэн хувилбар цагаан толгой² байдаг нь судар номын хорхойтнуудын номын сан хөмрөгт цөөнгүй дайралддаг.

Энэ бичгийн цагаан толгойн тухай анхны мэдээг 1803 онд П. С. Паллас (P. S. Pallas) хоёдугаар Екатеринад зориулсан "*Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften*"³ гэдэг номдоо дурдаж Европ дахинаа соносгосон бөлгөө.

Ингээд И. Клапрот (J. Klaproth)⁴, Банзарын Дорж⁵, А. Бобровников⁶, А. Уайли (A. Wylie)⁷ нарын судлагаанд уг бичиг "Hor-yig" буюу "монгол бичиг" хэмээх нэрээр дайралддаг. Үүний дараа А. Позднеев "*Лекции по истории монгольской литературы*" гэдэг номдоо энэ бичгийн талаар хэн хэзээ зохиож, хэрхэн хэрэглэж ирсэний тухайд тодорхой мэдээ баримт байхгүй оньсого мэт зүйл⁸ гэж дурдсан нь буй.

1952 онд Йөншөөбү Бямбын Ринчен багштан тэрхүү "оньсого" мэт үсгийн түүхийн талаар анхны тодорхой мэдээг эрдэм шинжилгээний хүрээнд оруулж "хэвтээ дөрвөлжин" гэдэг энэ бичгийг 1686 онд буюу гал барс жил Өндөр гэгээн Занабазар соёмбо үсэгтэй нэгэн дор зохиосон тухай "*Zwei unbekannt mongolische Alphabete aus dem XVII Jahrhundert*"⁹

¹ Модон барын бага гарын энэ сударыг Улсын Төв Номын Сангийн төвөд номын хөмрөгөөс авч үзсэн болно. Тусгайлан ялгасан тэмдэг заалт үгүй.

² Ганц хуудаст багтаасан энэ цагаан толгой нь өргөн тархсан бөгөөд 10 x 55 см хэмжээтэй. Энэ цагаан толгойн талаар проф. Д. Кара "*Книги монгольских кочевников*" (Москва, 1972) номдоо тусгайлан дурдсан нь буй.

³ P. S. Pallas, *Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften*, II, St.-Peterburg, 1801, p. 358. platte XXII.

⁴ J. Klaproth, *Reise in den Kaukasus und nach Georgien unternommen in den Jahren 1807 und 1808*, Tome. II, Halle-Berlin, pp. 540-541.

⁵ Доржи Банзаров, *О двух среднеазиатских алфавитах*, - Собрание сочинений, Москва, 1955, стр. 104-111.

⁶ А. Бобровников, *Памятники монгольского квадратного письма*, ТВОИРАО, Том. XVI, St.-Petersburg, 1870, стр. 1-90.

⁷ A. Wylie, *On an Ancient Buddhist Inscription at Keu-yung-koan in North China*, JRAS, No.s. 5(I), London, 1870, pp. 14-44.

⁸ "...Алфавит этот во многом остается загадочным в отношении времени его составления и употребления, ровно как и в том, проводился ли когда дибо в практику этот алфавит у монгольских буддистов, у которых он отыскан, мы не имеем решительно никаких сведений..."

А. Позднеев "*Лекции по истории монгольской литературы*", Том. II, С.-Петербург, 1897, стр. 199.

⁹ Rintschen, *Zwei unbekannt mongolische Alphabete aus dem XVII Jahrhundert*, -АОН, Том. II, Fasc. I, Budapest, 1952, pp. 63-71.

гэдэг өгүүлэлдээ тодруулан өгчээ. Академич Ринчен ийнхүү тодруулахдаа Угалзын лам хэмээн олонд алдаршсан Лувсансодовжамц (1878-1961)-ын "Yig-bᠴad gsal bai'i me-long ᠵes bya ba bzugs-so" буюу хэвтээ дөрвөлжин бичгийн тайлбар болгож зохиосон "Үсэгийн номлол тодорхой толь хэмээх оршивой" гэдэг гар бичмэл номын¹⁰ мэдээнд үндэслэсэн буй заа.

Хэвтээ дөрвөлжин бичгээр үлдсэн дурсгал гэвэл 1972 оныг хүртэл хэдэн зүйл хэсэг бусаг цагаан толгой, нэгэн зүйл тарнийн үсгээс өөр тоймтой баримт олдоогүй байсан гэж хэлж болно. 1972 онд проф. Д. Кара "Книги монгольских кочевников" номдоо хэвтээ дөрвөлжин бичгийн цагаан толгойд үсэгзүйн ажиглалт хийж, дуудалгын латин галигийн хамт анхлан судлагааны хүрээнд танилцуулж Жамсраны Цэвээн авгайн цуглуулгаас олдсон монгол хэлээр, хэвтээ дөрвөлжин бичгээр буй "А-мү-гү-ла-н-тү та-ма-га"-ын дардасыг хавсаргажээ¹¹ (3-р хавсралтаас үзмүү).

Хэдэн жилийн дараа энэ номын зохиогч Гандан хийдийн ламтан Данзан-осор гуайн цуглуулгад байсан самгард хэл, бичгээрхи ханын чимэгийн эцэс дэхи хэвтээ дөрвөлжин бичгээр, монгол хэлээр буй бичвэрийг олж судлагааны эргэлтэнд оруулсан билээ¹². Монгол хэлээрхи эл дурсгалын талаар хойно арай дэлгэрүүлэн өгүүлэх болно.

1997 онд судлагч Р. Бямбаа хэвтээ дөрвөлжин бичгээр төвөд, монгол, самгард хэлээр буй дурсгалуудыг нэгтгэн судлаж "Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд" гэдэг бие даасан тусгай ном нийтлүүлсэн бөгөөд үүндээ уг бичигт холбогдох мэдээ баримтыг багтаан оруулжээ¹³. Энэ жишилэнгээр сүүлийн үес монгол, төвөд, самгард хэлээр хэвтээ дөрвөлжин үсгээр бичсэн дурсгалын зүйл мэр сэр нэмэгдсээр байна.

Хэвтээ дөрвөлжин бичиг, түүгээр үлдсэн монгол хэлний дурсгалын ач холбогдолын тухайд гэвэл түрүүчийн бөлөгт соёмбо бичгийн баримт дурсгал монгол хэлний түүхэнд хэрхэн холбогдох талаар Л. Лигети академичийн хэлсэнтэй агаар нэгэн мөр тул дахин нурших хэрэггүй. Харин үсэгзүйн үүднээс төвөд, самгард үсэг бичигтэй харьцуулан тодруулах зүйл багагүйгээр барахгүй бас 1444/1446 оны солонгос бичигийн зарчимтай төстэй зүйл харагддаг¹⁴ нь шууд буюу эсбөгөөс Төв Ази дахины бусад бичиг үсгийн уламжлалтай дам холбоотойн алин болохыг энэ хир шийдээгүй боловч бас анхааралгүй орхиж болохгүй гэж санаж байна.

Хэвтээ дөрвөлжин бичигийн цагаан толгой



Хуудас эхлэсний буюу хуудасны өвөр талын тэмдэг. Бярга буюу эгчимтэй адил үүрэг гүйцэтгэнэ.

1. 

tl. А;

tc. mong., tib., sans.: а. Энэ нь а эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхинд тохиолдоно.



tl. а₀;

tc. а. Энэ нь а эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адарт тохиолдох нууц буюу тэг хэлбэр.

¹⁰ Р. Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1997, х.22-38.

¹¹ Д. Кара, "Книги монгольских кочевников", Москва, 1972, стр. 93-96.

¹² Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1981, 108-110; Ц. Шагдарсүрэн, *Об одном новонайденном памятнике горизонтально-квадратного письма*, - Монгольский лингвистический сборник, Москва, 1985, стр. 150 - 154.

¹³ Р. Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1997, 90 х.

¹⁴ Ц. Шагдарсүрэн, *Монгол солонгос бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд*, - Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), N. 4 (1996), Seoul, 1997, 169-192 х; Ts. Shagdarsurung, *A Study of Relation between the Korean and Mongolian Scripts*, The Research Paper to The Korea Foundation, Seoul, 1998, pp. 1-27.

- 1.a.  tl. $\bar{a}$;
tc. mong., sans.: $\bar{a}$. Урт $\bar{a}$ эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  tl. $\bar{a}_0$;
tc. $\bar{a}$. Энэ нь урт $\bar{a}$ эгшигийн нууц буюу тэг ($\emptyset$) хэлбэр.
2.  tl. i ;
tc. mong., tib., sans.: i . Энэ нь i эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхинд тохиолдоно.
-  tl. i ;
tc. i . i эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.
- 2.a.  tl. $\bar{i}$;
tc. mong., sans.: $\bar{i}$. Урт $\bar{i}$ эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхинд тохиолдоно.
-  tl. $\bar{i}$.
tc. $\bar{i}$. Урт $\bar{i}$ эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.
3.  tl. E ;
tc. mong., tib.: e ; sans. (diphthong) e . Энэ нь монгол, төвөд хэлний e эгшиг, самгард хэлний хос e эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхинд тохиолдоно.
-  tl. e ;
tc. e . Энэ нь e эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.
- 3.a.  tl. $\bar{E}$;
tc. mong.: $\bar{e}$; sans: (diphthong) ai . Монгол хэлний урт $\bar{e}$, самгард хэлний хос ai эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхинд тохиолдоно.
-  tl. $\bar{e}$;
tc. $\bar{e}$ / ai ; Монгол хэлний урт $\bar{e}$, самгард хэлний хос ai эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.
4.  tl. mong., tib.: $\bar{U}$; sans.: U ;
tc. mong., tib.: $\bar{u}$; sans.: u . Монгол, төвөд хэлний $\bar{u}$ эгшиг, самгард хэлний u эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхинд тохиолдоно.
-  tl. mong., tib.: $\bar{u}$; sans. u ;
tc. mong., tib.: $\bar{u}$; sans. u ; Монгол, төвөд хэлний $\bar{u}$ эгшиг, самгард хэлний u эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.
- 4.a.  tl. mong. $\bar{U}$; sans.: $\bar{u}$;
tc. mong. $\bar{u}$; sans. $\bar{u}$; Монгол хэлний урт $\bar{u}$ эгшиг, самгард хэлний урт $\bar{u}$ эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхинд тохиолдоно.



tl. mong. ü; sans. ü;

tc. mong. ü; sans. ü. Монгол, хэлний урт ü эгшиг, самгард хэлний урт ü эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.

5.



tl. mong. u;

tc. mong. u. Монгол хэлний u эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхэнд тохиолдоно.



tl. mong. u;

tc. mong. u. U эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд болоод адагт тохиолдоно.

5.a.



tl. mong. ü;

tc. mong. ü. Монгол хэлний урт ü эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхэнд тохиолдоно.



tl. mong. ü;

tc. mong. ü. Монгол хэлний урт ü эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд болоод адагт тохиолдоно.

6.



tl. mong., tib. o; sans. (diphtongue) o;

tc. mong., tib. o; sans. (diphtongue) o. Энэ нь монгол, төвөд хэлний o эгшиг, самгард хэлний хос o эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхэнд тохиолдоно.



tl. mong., tib. o; sans. (diphtongue) o;

tc. mong., tib. o; sans. (diphtongue) o. Энэ нь монгол, төвөд хэлний o эгшиг, самгард хэлний хос o эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд болоод адагт тохиолдоно.

6.a.



tl. mong. ō; sans. (diphtongue) AU;

tc. mong. ō; sans. (diphtongue) au. Энэ нь монгол хэлний урт ō эгшиг, самгард хэлний хос au эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхэнд тохиолдоно.



tl. mong. ō; sans. (diphtongue) au;

tc. mong. ō; sans. (diphtongue) au. Энэ нь монгол хэлний урт ō эгшиг, самгард хэлний хос au эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд болоод адагт тохиолдоно.

7.



tl. mong. ö;

tc. mong. ö. Энэ нь монгол хэлний ö эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр. Үг буюу үеийн эхэнд тохиолдоно.



tl. mong. ö;

tc. mong. ö. Энэ нь монгол хэлний ö эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд болоод адагт тохиолдоно.

- 7.a.  **tl.** mong. $\bar{O}$;
tc. mong. $\bar{o}$. Энэ нь монгол хэлний урт $\bar{o}$ эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр хэлбэр. Үг буюу үеийн эхинд тохиолдоно.
-  **tl.** mong. $\bar{o}$;
tc. mong. $\bar{o}$. Энэ нь монгол хэлний урт $\bar{o}$ эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд болоод адагт тохиолдоно
8.  **tl.** Au₁;
tc. mong. au (буюу diphtongue waw). Монгол хэлнээ тохиолдоно. (Энэ хэлбэрийг жагсаалтын No. 5-д дурдсан и эгшигтэй харьцуулагтун).
9.  **tl.** Ai₁;
tc. mong. ai (буюу diphtongue yod). Монгол хэлнээ тохиолдоно. (Энэ хэлбэрийг жагсаалтын No. 2-т дурдсан i эгшигтэй харьцуулагтун).
10.  **tl.** mong. G(a); tib., sans.: K(a);
tc. mong. ga; tib., sans. ka. Монгол хэлний ga, төвөд, самгард хэлний ka гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
11.  **tl.** mong. K(a), tib., sans.: KH(a);
tc. mong. ka, tib., sans.: kha. Монгол хэлний ka, төвөд, самгард хэлний kha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
12.  **tl.** (mong. $\bar{n}$), tib., sans.: $\bar{N}$ (a);
tc. mong., tib., sans.: $\bar{n}$ a. Монгол хэлнээ үгийн буюу үеийн эхинд тохиолддоггүй. Төвөд, самгард хэлний $\bar{n}$ a гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр. Монгол хэлний тухайд зөвхөн гол буюу (MF) хэлбэрээр тохиолдоно.
13.  **tl.** mong. J(a), tib., sans.: C(a);
tc. mong. ja, tib., sans.: ca. Монгол хэлний ja, төвөд, самгард хэлний ca гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
14.  **tl.** mong. C(a); tib., sans.: CH(a);
tc. mong. ca, tib., sans.: cha. Монгол хэлний ca, төвөд, самгард хэлний cha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
15.  **tl.** tib., sans.: $\bar{N}$ (a);
tc. tib., sans.: $\bar{n}$ a. Төвөд, самгард хэлний $\bar{n}$ a гийгүүлэгчийн бие даасан (IF) хэлбэр.
16.  **tl.** mong., D(a), tib., sans. T(a);
tc. mong. da, tib., sans.: ta. Монгол хэлний da, төвөд, самгард хэлний ta гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
17.  **tl.** mong. T(a), tib., sans. TH(a);
tc. mong. ta, tib., sans. tha. Монгол хэлний ta, төвөд, самгард хэлний tha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.

18.  **tl.** mong., tib., sans. N(a);
tc. mong., tib., sans. na. Монгол, төвөд, самгард хэлний на гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
19.  **tl.** mong. ba, tib., sans.: P(a);
tc. mong. ba, tib., sans.: pa. Монгол хэлний ба, төвөд, самгард хэлний ра гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
20.  **tl.** mong. P(a), tib., sans. PH(a);
tc. mong. pa, tib., sans.: pha. Монгол хэлний ра, төвөд, самгард хэлний pha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
21.  **tl.** mong., tib., sans. M(a);
tc. mong., tib., sans. ma. Монгол, төвөд, самгард хэлний та гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
22.  **tl.** mong., tib.: Y(a), sans. (semi-vowel) Y(a);
tc. mong., tib.: ya, sans. (semi-vowel) ya. Монгол, төвөд хэлний ya, самгард хэлний тал (буюу харас) ya гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
23.  **tl.** mong., tib.: R(a), sans. (semi-vowel) R(a);
tc. mong., tib.: ra, sans.: (semi-vowel) ra. Монгол, төвөд хэлний га, самгард хэлний тал (буюу харас) га гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
24.  **tl.** mong., tib., L(a), sans.: (semi-vowel) L(a);
tc. mong., tib., la, sans.: (semi-vowel) la. Монгол, төвөд хэлний la, самгард хэлний тал (буюу харас) la гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
25.  **tl.** mong., tib., V(a), sans.: (semi-vowel) V(a);
tc. mong., tib., va, sans.: (semi-vowel) va. Монгол, төвөд хэлний va, самгард хэлний тал (буюу харас) va гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
26.  **tl.** mong. Š(a), tib., sans.: Ç(a) / Š(a).
tc. mong. ša, tib., sans.: ça / sa. Монгол хэлний ša, төвөд, самгард хэлний ça / sa гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
27.  **tl.** mong., tib., sans. S(a);
tc. mong., tib., sans. sa. Монгол, төвөд, самгард хэлний sa гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
28.  **tl.** mong., tib. H(a), sans.: (semi-vowel) H(a);
tc. mong., tib., ha, sans.: (semi-vowel) ha. Монгол, төвөд хэлний ha, самгард хэлний тал (буюу харас) ha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
29.  **tl.** sans. KS(a);
tc. sans. ksa. Самгард хэлний ksa гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.

30.  **tl. sans.** T(a);
tc. sans. ta. Самгард хэлний ta гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
31.  **tl. sans.** TH(a);
tc. sans. tha. Самгард хэлний tha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
32.  **tl. sans.** D(a);
tc. sans. da. Самгард хэлний da гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
33.  **tl. sans.** DH(a);
tc. sans. dha. Самгард хэлний dha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
34.  **tl. sans.** N(a);
tc. sans. na. Самгард хэлний na гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
35.  **tl. tib.** Z(a);
tc. tib. za. Төвөд хэлний za гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
36.  **tl. tib.** Z(a);
tc. tib. za. Төвөд хэлний za гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
37.  **tl. tib.** 'a);
tc. tib. 'a. Төвөд хэлний 'a-chun буюу шанаган "a" гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
38.  **tl. tib., sans.:** G(a);
tc. tib., sans.: ga. Төвөд, самгард хэлний ga гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
39.  **tl. sans.** GH(a);
tc. sans. gha. Самгард хэлний gha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
40.  **tl. tib., sans.:** J(a);
tc. tib., sans.: ja. Төвөд, самгард хэлний ja гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
41.  **tl. sans.** JH(a);
tc. sans. jha. Самгард хэлний jha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
42.  **tl. sans.** S(a);
tc. sa (?). Самгард хэлний sa (?) гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.

43.  **tl. sans.** D(a);
tc. sans. da. Самгард хэлний da гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
44.  **tl. sans.** DH(a);
tc. sans. dha. Самгард хэлний dha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
45.  **tl. sans.** B(a) / P(a);
tc. sans. ba / pa. Самгард хэлний ba / pa гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
46.  **tl. sans.** BH(a);
tc. sans. bha. Самгард хэлний bha гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
47. 
 **tl. sans.** R / Ri;
tc. sans. r / ri. Самгард хэлний r / ri эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  **tl. sans.** r / ri;
tc. sans. r / ri. Самгард хэлний r / ri эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.
- 47 а. 
 **tl. sans.** R / Ri;
tc. sans. r / ri. Самгард хэлний урт r / ri эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  **tl. sans.** R / Ri;
tc. sans. r / ri. Самгард хэлний урт r / ri эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.
48. 
 **tl. sans.** L / Li;
tc. sans. l / li. Самгард хэлний l / li эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  **tl. sans.** l / li;
tc. sans. l / li. Самгард хэлний l / li эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.
- 48 а. 
 **tl. sans.** L / Li;
tc. sans. l / li. Самгард хэлний урт l / li эгшигийн бие даасан буюу (IF) хэлбэр.
-  **tl. sans.** L / Li;
tc. sans. l / li. Самгард хэлний урт l / li эгшигийн гол буюу (MF) хэлбэр. Үг буюу үеийн дунд, адагт тохиолдоно.
49.  **tl. tib., sans.** Kr(a);
tc. tib., sans. kra. Төвөд, самгард хэлний нийлмэл (буюу га зүүлтэт) kra гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.

50.  **tl.** tib., sans. KHy(a);
tc. tib., sans. khyā. Төвөд, самгард хэлний нийлмэл (буюу ya зүүлтэт) khyā гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
51.  **tl.** tib., sans. Gl(a);
tc. tib., sans. gla. Төвөд, самгард хэлний нийлмэл (буюу la зүүлтэт) gla гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
52.  **tl.** tib., sans. rK(a);
tc. tib., sans. rka. Төвөд, самгард хэлний нийлмэл (буюу ga толгойт) rka гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
53.  **tl.** tib., sans. sK(a);
tc. tib., sans. ska. Төвөд, самгард хэлний нийлмэл (буюу sa толгойт) ska гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.
54.  **tl.** tib., sans. lK(a);
tc. tib., sans. lka. Төвөд, самгард хэлний нийлмэл (буюу la толгойт) lka гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр.

Хэвтээ дөрвөлжин бичгийн уламжлалт цагаан толгойн эцэст, тоо болон дэс дарааны хувьд соёмбо бичгийнхитэй яг дүйх арван хоёр дэвсгэр гийгүүлэгчийг хэрхин тэмдэглэх аргыг жагсаан үзүүлсэн байдаг. Үүнд: тэдгээр гийгүүлэгч дэвсгэрлэхдээ соёмбо бичгийнхитэй адил "дүр урваж" жижигрэн зүүлт болж ордоггүй, бие даасан (IF) хэлбэрээрээ тэмдэглэгдэх боловч үе хаасны тэмдэг болох зураас буюу хэвтээ сүйхэлжин цэгийг доороо авдаг бөлгөө.

55.  **tl.** mong.: AG, tib., sans.: AK;
tc. mong. ag, tib., sans.: ak (Жагсаалтын No. 10-тай харьцуулагтун).
56.  **tl.** mong.: AK, tib., sans.: AKH;
tc. mong.: ak, tib., sans. akh (Жагсаалтын No. 11-тай харьцуулагтун).
57.  **tl.** mong.: AN, tib., sans.: AN;
tc. mong.: an, tib., sans. an (Жагсаалтын No. 12-тай харьцуулагтун).
58.  **tl.** mong.: AD, tib., sans.: AT;
tc. mong.: ad, tib., sans. at (Жагсаалтын No. 16-тай харьцуулагтун).
59.  **tl.** mong., tib., sans. AN;
tc. mong., tib., sans. an (Жагсаалтын No. 18-тай харьцуулагтун).
60.  **tl.** mong.: AG, tib., sans.: AK;
tc. mong. ag, tib., sans. ak (Жагсаалтын No. 19-тай харьцуулагтун).
61.  **tl.** mong., tib., sans. AM;
tc. mong., tib., sans. am (Жагсаалтын No. 21-тай харьцуулагтун).

62.  tl. mong., tib., sans. AR;
tc. mong., tib., sans. ar (Жагсаалтын No. 23-тай харьцуулагтун).
63.  tl. mong., tib., sans. AL;
tc. mong., tib., sans. al (Жагсаалтын No. 24-тай харьцуулагтун).
64.  tl. mong. Aᠰ, tib., sans.: Aᠴ / Aᠰ;
tc. mong. aᠰ, tib., sans.: aᠴ / aᠰ (Жагсаалтын No. 26-тай харьцуулагтун).
65.  tl. mong., tib., sans. AS;
tc. mong., tib., sans. as (Жагсаалтын No. 27-тай харьцуулагтун).
66.  tl. mong. ᠠᠨ;
tc. mong. āᠨ. Үүнийг соёмбо бичигийн цагаан толгойн 41-рт дурдсан тайлбар сэлттэй харьцуулан үзнэ үү (ᠠᠨᠠᠨ).

Хэвтээ дөрвөлжин бичигт Монгол, төвөд, самгард хэлнээ дэвсгэрлэж орсон гийгүүлэгчийг ийнхүү дор нь тусгайлан тэмдэглэдэг уламжлал Төв Азийн бусад үндэстний бичиг үсгийн тогтолцоонд ч харагддаг бөлгөө. Тухайлбал: солонгос бичигт гол төлөв харь үгийн дэвсгэр гийгүүлэгчийг иймэрхүү байдлаар тэмдэглэдэг тухай энэ номын зохиогчийн бичсэн зүйл буй¹⁵.

Дээрхи жагсаалтаас үзэхүл, хэвтээ дөрвөлжин бичигийг төвөд үсэг болон түүнээ үндэслэн зохиосон монгол дөрвөлжин бичигт тулгуурлаж, тэр цагийнхаа номын гурван хэл болж байсан монгол, төвөд, самгард хэлний үгийг тэмдэглэхэд зориулан таацуулж зохиосон болох нь тодорхой харагдана.

Одоо энэ хир хэвтээ дөрвөлжин бичигээрхи дурсгалын зүйл гэвэл тоо ширхэгийн хувьд тийм ч цөөнгүй, хэмжээний хувьд харьцангуй янз бүр, зарим нь тамгын дардас төдий байхад зарим нь 7-8 хуудас ар өвөргүй байх жишээтэй. Хэлний хувьд, төвөд болон самгардаар бие даалган бичсэн буюу хадсан дурсгал харьцангуй илүү боловч сүүлийн үес монгол хэлээр буй дурсгал нэмэгдэн олдсоор буй бөгөөд эдгээр дурсгалуудыг цуглуулах, судлах, хэвлэн нийтлэхэд Р. Бямбаа онцгой үүрэг гүйцэтгэснийг энэ ташрамд дурдалгүй орхих аргагүй.¹⁶ Үүнээс гадна Р. Бямбаа номдоо соёмбо бичгийн тайлбар болгон тусгай ном зохиож байсан "Угалзын лам" хэмээн алдаршсан Лувсансодовжамцын "Yig-bᠴad gsa/ ba'i me-long ᠵes bya ba bzugs-so" буюу "Үсэгийн номлол тодорхой толь хэмээх оршивой" гэдэг нэртэй бүтээлийг монгол орчуулгын хамт эрдэм шинжилгээний гүйлгээнд оруулсан нь хэвтээ дөрвөлжин бичгийн талаар энэ хир бидний үетэй золгосон цорын ганц уламжлалт тайлбар зохиол болж өгсөн ач холбогдолтой юм. Энэ номын мэдээнээс үзвэл нэлээд зүйл тодорхой болж өгнө. Тухайлбал:

- 1.6.: (3)... Ранжүн Ишдоржбалсамбуу-бээр зохиосон үсгээс өөрөө аяндаа гарсан "Соёмбо" хэмээх үсэг нь их алдаршсан бөгөөд үсэг бүсдыг зохиосон нь энэ богдын шавийн ахмад

¹⁵ Ц. Шагдарсүрэн, *Монгол солонгос бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд*, - Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), N. 4 (1996), Soeul, 1997, 169-192 х; Ts. Shagdarsurung, *A Study of Relation between the Korean and Mongolian Scripts*, The Research Paper to The Korea Foundation, Seoul, 1998, pp. 1-27.

¹⁶ Р. Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1997, 90 х.

(4) мэргэн шидэтийн эрх баялиг Зая бандида Лувсанпэрэнлэйбалсамбуу-бээр богд өөрийг нь (? Ц. Ш) зарлиг хэсэг бутархайг хамтад хурааж хэв(лэл)д (Ц. Ш.) гаргасан бөгөөд...¹⁷

гэж байгаа нь нэгд, Занабазартан "соёмбо"-оос гадна өөр бичиг зохиосон гэдгийг, хоёрт, "Хэвтээ дөрвөлжин бичиг" хэмээх эл бөлөгийн эхинд бидний дурдсан модон барын "rJa-bcun blo-bzan bstan-pa'i rgyal-mchan gyi gsun-'thor-bu phogs-gcig tu-bsdud pa bzugs" буюу Өндөр гэгээн Занабазарын "...хэсэг бусаг зарлигийн хураангуй" хэмээх номын эцэст нэгэн зүйл үсгийн цагаан толгойг хавсаргасан байдаг гэсэн мэдээг давхар давхар тодруулан өгч байгаа хэрэг.

Номынхоо зорилгод нийцүүлэн монгол хэлээр буй хэвтээ дөрвөлжин дурсгалын зүйлийг үсэгзүй болон монгол хэлний талаас нь арай дэлгэрүүлэн өгүүлсүгэй.

Үүнд: гандан хийдийн гавж Данзан-осор ламтаны Эрдэнэ-зуугаас олсон, шар торгон дээр хар бэхээр ланз, соёмбо, хэвтээ дөрвөлжин бичгээр төвөд, самгард, монгол хэлээр бичсэн 31 мөр бүхий ханын чимэг нь бидний хувьд нэгэн сонин судлагдахуун болж өгнө¹⁸. Эрдэнэ-зуугийн ширээт ламтан, номч чорж Лувсандамбадаржаагийн намтараас үзэхэд энэхүү дурсгал нь соёмбо бичгийг дэлгэрүүлэх зорилгоор түүний бүтээсэн бүтээлийн нэг нь буй заа гэж үзэх үндэс буй.

Уг дурсгалын хамгийн сүүлчийн мөрнөө хэвтээ дөрвөлжин бичгээр монгол хэлээр бичсэн ерөөлийн хэсэг нь хэдийгээр найман үгтэй боловч зөв бичих зүйн хувьд харьцангуй тогтсон байдалтай тул тухайн үеийн монгол хэлний ерөнхий төлөв хийгээд монгол хэлээр хэрхэн бичдэг журам тэргүүтнийг их бага аль нэгэн хэмжээгээр харуулах боломжтой гэж бодож байна (Эхийг 2-р хавсралтаас үзмүү). Уг бичвэрийг галиглавал:

tl. Ka₀-MuK A-Mi-Ta₀N El-DeB Jüi₁L Üi₁-Le-Dür ER-Kei₁-Gi Ol-Ku BoL-Tu-Ga₀I₁
tc. ka-muk a-mi-tan el-deb jüil üi-le-dür er-kei-gi ol-ku bol-tu-gai

Энэхүү монгол хэлээрхи ерөөлийн үгийн хэвтээ дөрвөлжин бичвэрийг монгол бичгээр сэргээн харьцуулбал доорхи мэт болно. Үүнд:

Хэвтээ дөрвөлжин бичиг

ka-muk
a-mi-tan
el-deb
jüil
üi-le-dür
er-kei-gi
ol-ku
bol-tu-gai

монгол бичиг

qamuy
amitan
eldeb
jüil
üyile-dür
erke-yi
olqu
boltuyai

Хэвтээ дөрвөлжин бичгийн хэлний заахын тийн ялгалын хэлбэр нь монгол бичгийнхээс ялгаатай байгаа нь тухайн цагийн төв халхын аялгууны онцлогтой холбоотой гэж үзэх бүрэн үндэс буй. Жишээлбэл:

bi-lig-gi (Mo. bilig-i)
bi-ye-gi (Mo. bey-e-yi)

¹⁷ Лувсансодовжамц, "Yig-bḡad gsal ba'i me-long ḡes bya ba bzugs-so" буюу "Үсэгийн номлол тодорхой толь хэмээх оршивой", 1. b.

Р. Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсгийн шинээр олдсон нэгэн дурсгалын тухай*, - *Studia Mongolica*, Том. XIII(21), Fasc. 18, Ulaanbaatar, 1985, 132-149; Р. Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1997, х. 30.

¹⁸ Шагдарсүрэн, *Об одном новонайденном памятнике горизонтально-квадратного письма*, - Монгольский лингвистический сборник, Москва, 1985, стр. 150 - 154.

ka-mug-gi (Mo. qamuy-i)

ta-yag-gi (Mo. tayay-i)

Мөн ийм хэлбэр соёмбоор бичсэн монгол хэлний дурсгалд дайралддаг бөгөөд энэ тухай профессор Д. Кара нарийн ажигласан байдаг билээ¹⁹. Тухайлбал: соёмбо бичгийн барын "Итгэл"-д i / yī нөхцөлийн оронд дандаа (-i) -gi хэлбэр дайралддаг бөлгөө²⁰. Жишээлбэл:

Mo. kilenče-yi

So. ki-len-cei-gi

Mo. bodi-yi

So. bo-dii-gi

Энэ мэтээр хэвтээ дөрвөлжин болон соёмбо бичгийн дурсгалд авиазүй, хэлбэрсудлалын хувьд адил төстэй зүйл нэг бус байгаа нь тухайн үеийн Төв халхын аялгууны онцлог тийм байсны давхар батлагаа буй заа.



Сүүлд олдсон хэвтээ дөрвөлжин бичгээрхи "Хутагт Жэбзин дамба ламай цадиг оршив" гэдэг харьцангуй томоохон гар бичмэл дурсгалын судлагаанаас үзвэл²¹ уг бичвэр нь нэгд, урт болон хос эгшиг тэмдэглэсэн хийгээд зарим гийгүүлэгчийг давхарлан бичсэн, bla-mai, a-bu-ra-lain, Na-gan-ji-nain гэх мэтээр харьяалахын тийн ялгалын -ai нөхцөл хэрэглэсэн байдал тэргүүтэн нь тэр цагийнхаа аялгууны онцлогийг тусгасан, хоёрт, эгшиг зохицох ёсыг алдруулсан буюу нэлээд үгийг алдаа мадагтай тэмдэглэсэн хийгээд нэг үгийг хэд хэдэн янзаар бичсэн зэрэг нь тухайн бичээчийн боловсролтой аль нэгэн хэмжээгээр холбоотой буй заа.

Хэвтээ дөрвөлжин бичиг нь тухайн цаг үедээ Төв халхын нутаг дэвсгэрт зохих хэмжээгээр хэрэглэгдэж байсан нь харагдаж байгаа ч чухам ямар зорилго шалтгаанаар соёмбо үсэгийн зэргэцээ зохиогдсон болохыг энэ хир үсэгзүйн үүднээс тодорхойлоход бэрх ажээ.

¹⁹ D. Kara, *Un texte mongol en écriture soyombo*, AOH, Tom. IX, Fasc. I, Budapest, 1959, p. 26 (pp.3-38).


²⁰ D. Kara, *Un texte mongol en écriture soyombo*, AOH, Tom. IX, Fasc. I, Budapest, 1959, p. 7 (pp.3-38). Chagdarsureng, *Sur quelques traductions mongoles du NATHA*, - SM, Tom. 2(10), Fasc. 11, Ulan-Bator, 1974, p. 155 (pp. 143-183).

²¹ Р. Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1997, х. 44-61.



Соёмбо, хэвтээ дөрвөлжин бичигээр буй туурганы чимэглэл

॥ ॐ नमो भगवते वासुदेवाय ॥ ॐ नमो भगवते वासुदेवाय ॥ ॐ नमो भगवते वासुदेवाय ॥ ॐ नमो भगवते वासुदेवाय ॥



Хэвтээ дөрвөлжин бичигээр буй зарим дурсгал.

1957 1958 1959 1960 1961

[illegible][illegible]

ВАГИНДРАГИЙН БИЧИГ

Орь залуу наснаасаа Ази, Европ дахинаар бядан жуулчилаж юм үзэн, нүд тайлж, түмэн рүпигээр толгойгоо үнэлүүлж, 85 насан дээрээ хар гэрт насан элсэн бөгөөд олны дунд Агваан лхаарамба, Агваан хамба, Агваандорж, Агваандоржиев, Буриадын Ханчен Агваан, Вагиндра гэх зэрэг олон нэрээр танил болсон Агваан (1853-1938) хэмээгч ламтан 53 насан дээрээ 1905 онд "Буриадын шинэ үсэг" буюу "Вагиндрагийн үсэг"-ээ монгол болон түүнээс салбарлан гарсан тод бичгийн хэлбэр дүрсэд шүтэн зохиожээ¹. Вагиндра гэдэг нь Агваан хэмээх төвөд нэрийнхи нь самгард орчуулга болой.

Энэ бичигийн тогтолцоог үзвэл ерөнхий байдал төлөв нь монгол бичгийг эрхгүй санагдуулах боловч монгол бичгийн а/е, о/у, ө/ү, q/γ, k/g, T/D, t/d зэрэг олон дуудалга бүхий дүрс ижил үсгүүдийг тод бичигтэй төстэй зарчимаар өвөрчлөн тодчилох оролдолго хийсэн байна. Тухайлбал:

Vag. 	e,	oir. 	e,	mo. 	a/e
Vag. 	u,	oir. 	o,	mo. 	o/u, ö/ü
Vag. 	t,	oir. 	t,	mo. 	T/D
Vag. 	d,	oir. 	d,	mo. 	t/d

Үүнээс гадна тухайн үед монгол бичигт байгаагүй ts, dz болон орос зэрэг бусад хэл аялгууны онцлогт тохирсон ї (ы) эгшиг, h, z, ž зэрэг хамжих, мөн нийлмэл šс (щ) гийгүүлэгч үсгийг нэмсэн байдал бэлхэнээ харагддаг.

Гэхдээ вагиндрагийн бичиг нь үгийн эхин, дунд, адаг буюу байршилаар дүр урвах явдал байдаггүй нь монгол болон тод бичгээс ялгарах нэгэн гол ялгаа хэмээн үзэж болох бөгөөд энэ онцлог нь өрнө дахины бичиг үсгийн тогтолцооны нөлөө буй заа.

Энэ бичигийг хэрэглэж ирсэн хүрээ гэвэл орон зай хийгээд цаг хугацааны хувьд төдий л өргөн дэлгэр бус; 1905-1910 оны хооронд Санкт-Петербург хотноо гол төлөв чулуун барын аргаар арав шахам товхимол хэвлэгдсэн² байх ба уг бичгийг тухайн цагийн буриад зоны дунд гол төлөв сэхээтнүүд түлхүү хэрэглэж байжээ.

¹ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, Улаанбаатар, 1964, 172-175-р тал. Д. Кара, *Книги монгольских языков*, Москва, 1972, стр. 95-98. Үүнээс гадна Агваандоржтан "Delekei-yi ergijü bidügsen domoy sonirqal-un biäg tedüi kemeküi orosiba" (1922) гэдэг шүлэглэсэн намтартаа бидний судлагдахууны тухай тодорхой баримт тайлбарын зүйлийг нэлээд оруулсан буй.

² Энэ хир бидний олж мэдсэний хирээр дараахи номуудыг дурдаж болно. Гэхдээ бүрэн гэж үзэх үндэсгүй. Үүнд: Vagindra, *Burād sine uzuxtu tārūhan zurxen tolto gež exilegdehen anxa debter orošbay*, С.-Петербург, 1905; Vagindra, *Sine qayūān üsüg terigüten-i biägsen debter orosiba*, ...(?); *Burād xur*, Turušin depter, "Narañ" gedeg mongol burād nom bišig γarγaxo oron, С.-Петербург, 1907; Surgūlin bagsi Bayarto Wampilay, Iharamba Nagvan Doržin, *Uxān hurgeji sedkil hayžrūlxo uligernud orosiba*, С.-Петербург, 1908; *Burxan bagšın gegēni xurāngoy namtar bolon Buyanto xān xubuni namtar orošbay*, С.-Петербург, 1906 (?)...

Дээр өгүүлсэн хэвлэмэл номын хажуугаар гар бичмэлээр үлдсэн мэр сэр хэрэглэгдэхүүн буй бөгөөд тухайлбал, академич Ринчен докторын тэмдэглэснээр Монгол улсын Төв номын сангийн хөмрөгт Гарма Санжеев профессорын залуудаа энэ бичгээр, Байгалын ар биеийн буриад аялгуугаар зохиосон нэгэн жүжгийн гар навтарга буй ажээ³. Бас вагиндрагийн бичгийн тухай болон уг бичгээр гарсан ном дэвтэрийн тухай мэдээ мэр сэр буй⁴.

Вагиндрагийн үсгийн цагаан толгойн хувьд орос үсэгтэй тулган хадсан зарим баримтыг эс тооцох бөгөөс нийтлэг хэрэглэгддэг латин галигаар тогтолцоотой оноосон зүйл бараг үгүй; энэ номыг бичигч 1981 онд "Монгол үсэг зүй" гэдэг ганц сэдэвт зохиолдоо орос кирилл үсгийн хажуугаар латин үсэгтэй онолдуулахыг чармайсан бөлгөө.

Вагиндрагийн бичгийн цагаан толгой

Эгшиг үсэг

1.	a (a)	2.	o (o)
3.	u (y)	4.	i (и)
5.	e (э, e)	6.	ё (ы, e)
7.	ö (ө)	8.	ü (ү)

Гийгүүлэгч үсэг

9.	b (б)	10.	p (п)
11.	γ (г)	12.	x (х)
13.	g (г)	14.	k (к, х)
15.	t (т)	16.	d (д)
17.	z (з)	18.	ž (ж)
19.	s (с)	20.	š (ш)
21.	c (ц)	22.	č (ч)
23.	m (м)	24.	n (н)
25.	n (н)	26.	l (л)
27.	r (р)	28.	h (h)
29.	y (j)	30.	w (в)
31.	f (ф)	32.	v (у)
33.	j (џ, дж)	34.	j (дз)
35.	šč (щ)	36.	ñ (нь)

³ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, Улаанбаатар, 1964, 173-р тал.

⁴ Чано-Батур, *Героическая поэма Иркутских бурят-ойратов*, С.-Петербург, 1910; Н. Амагаев и Аламжи-Мэргэн, *Новый бурятский алфавит*, Санкт-Петербург, 1910.

Үсэгийн нэмэлт тэмдэг

37. |о тагнайшсаны тэмдэг / бинт
38. |I эгшигийн уртын тэмдэг
39. .| цэг (6, 13, 14, 24, 33, 34, 35-р үсэгт орно)
40. ㄱ дэгээ (3, 30, 31-р үсэгт орно)

Цэг тэмдэгийн зүйл

41. ㄴ хуудас эхлэсний тэмдэг / бярга
42. " таслал
43. ㅈ цэг
44. ㅊ асуултын тэмдэг
45. ㅌ анхааруулгын тэмдэг
46. | зураас
47. ; цуваа цэг

Цагаан толгойн бүрдэцээс үзвэл европ дахины хэл, эн түрүүн слав хэлний авиазүйн онцлогийг тусгасан байдал илэрхий харагдахын сац монгол хэл болон монгол хэлний нутгийн аялгуунууд, давын өмнө буриад аялгуунд зориулсан болох нь тодорхой байна. Үүнд:

1. Монгол бичигийн үндсэн цагаан толгойтой харьцуулахад, монгол хэл, аялгуунд тохируулан нэмсэн үсэг нь:

1. а. Буриад болон түүнлүгээ ойр төрөл аялгууны онцлогийг тусгасан бөлөг үсэг: шүргэх z, ž, h тэргүүтэн үсэг;
1. б. Бусад монгол аялгуунд тохируулан нэмсэн бөлөг үсэг: j, j, c, ċ тэргүүтэн үсэг;

2. Монгол бичигийн үндсэн цагаан толгойтой харьцуулахад, орос слав хэлний авиаг тэмдэглэхэд тохируулан нэмсэн бөлөг үсэг: e, k, z, ž, f, c, ċ, šc тэргүүтэн үсэг

гэж тодруулан ангилаж болох бөгөөд дээр дурдсан үсэгзүйн судлганаанаас үзвэл давын өмнө монгол хэлний буриад аялгуу хийгээд орос слав хэлний авиаг бүрэн тэмдэглэх зорилгоор вагиндрагийн үсэгийг зохиосон гэж үзэх үндэслэл гарч ирнэ.

Энэхүү бичиг нь мөнгө хөрөнгийн шалтгаанаас гадна академич Ринчен профессорын ажигласанчилан⁵, монгол хэлний тодорхой нэгэн (тухайлбал: зөвхөн баруун буриадын⁶) аялгууны онцлогийг түлхүү анхаарсан хийгээд үсгийн зуралга нь нарийн ялгаа эрхгүй шаардах тул түргэн бичих боломжоор хязгаарлагдмал болсон зэрэг хэлшинжлэл, үсэгзүйн хэд хэдэн бодот шалтгаанаас үүдэж тод бичгийн нэгэн адил цаашид өргөн хэрэглэгдэх нөхцөл бүрдсэнгүй ажээ.

⁵ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, Улаанбаатар, 1964, 173-р тал.

⁶ Д-Н. Д. Доржиев, *Об орфографии старобурятского письма*, - Филологический сборник, Улан-Удэ, 1998, стр. (249-252) 252.

ᠠᠨᠭᠢᠨᠳᠣᠷᠠᠭᠢᠨ "ᠪᠦᠷᠠᠳᠤ ᠰᠢᠨᠡ ᠤᠯᠤᠰᠤᠲᠤ ᠲᠠᠷᠤᠯᠠᠨ ᠵᠢᠷᠦᠬᠡᠨ ᠲᠣᠯᠲᠤ
 ᠭᠡᠵᠢ ᠡᠭᠢᠯᠡᠭᠡᠬᠡᠨ ᠠᠨᠬᠠ ᠳᠡᠪᠲᠦᠷ ᠣᠷᠣᠰᠠᠪᠠᠶ" ᠨᠣᠮᠤᠨ ᠬᠡᠭᠣᠳᠠᠰᠤᠨᠠᠭᠠᠰ

ᠠᠨᠭᠢᠨᠳᠣᠷᠠᠭᠢᠨ "ᠪᠦᠷᠠᠳᠤ ᠰᠢᠨᠡ ᠤᠯᠤᠰᠤᠲᠤ ᠲᠠᠷᠤᠯᠠᠨ ᠵᠢᠷᠦᠬᠡᠨ ᠲᠣᠯᠲᠤ
 ᠭᠡᠵᠢ ᠡᠭᠢᠯᠡᠭᠡᠬᠡᠨ ᠠᠨᠬᠠ ᠳᠡᠪᠲᠦᠷ ᠣᠷᠣᠰᠠᠪᠠᠶ" ᠨᠣᠮᠤᠨ ᠬᠡᠭᠣᠳᠠᠰᠤᠨᠠᠭᠠᠰ

Багиндрагийн "Burād sine uzuxtu tāṛūhan zurxen tolto
 geṣi exilegdehen anxa debter oroṣābay" номын хуудаснаас

2007-2008 - « Ажлын үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх - үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх

2007-2008 - « Ажлын үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх
 үнэмлэх үнэмлэх үнэмлэх = үнэмлэх

2007-2008

1907 онд хэвлэгдсэн "Буриад хөөр" гэдэг эмхитгэлийн хуудаснаас.

[The page contains approximately 20 handwritten entries, mostly illegible due to extreme blurring.]

ЛАТИН ҮСЭГ

1921 оны Ардын хувьсгалын эхин үеэс ард түмнийг монгол үсэг бичиг хийгээд бусад олон зүйлийн эрдэмд боловсруулан сургах явдлыг туйлаас анхаарч ирсэн байдал Монгол Ардын Намын нэгдүгээр хурлын тогтоол, *"Түмэнд тунхаглан зарлах бичиг"* зэрэг түүхэн хэрэглэгдэхүүнээ туссан байдаг билээ¹.

Харин арваад жилийн дараагаас буюу 1930 оны 2-р сард болсон Намын 8-р Их хуралын заалтын 7-р хэсэгт:

"...мөн хуучны хүнд суртлын үлдэгдлийн нэгэн салбар бөгөөд шинэ соёл боловсролын хөгжилтөд дөхөмгүй болох монгол үсгийг халж боловсон соёлыг дэлгэрүүлэхэд дөхөмтэйг нийт дээр дэлгэрэх туршилтыг олсон латин үсгийг өөрийн монгол хэлэн дээр зохилдуулан үндсэн хэлний үсэг болгон хэрэглэх явдлыг богино хугацааны дотор гүйцэлдүүлж нийт соёл боловсролын ба санхүүд боогдол саатал бүхий байдлыг устгахыг чухалчлах..."

гэж заасан байна².

Чухам энэ үеэс монгол бичгийг "...хуучны хүнд сурталын нэгэн салбар..." гэж үнэлсэнээс үүдэн монгол хэл, монгол бичгийг шинжлэх ухааны үндэслэлгүйгээр элдэвлэн муучлах явдал ялангуяа боловсрол нимгэн бөгөөд нэр төр хөөцөлдөгч нарын дунд газар авсан билээ.

1940 оны 3-р сард болсон МАХН-ын X их хурал дээр Х. Чойбалсангаас илтгэсэн намын Төв Хорооны улс төрийн илтгэлийн *"Ардын сургууль соёлын талаар манай тавьж буй зорилгууд"* гэдэг хэсэгт:

"...Соёл боловсролын асуудал дээр онц болон тэмдэглэх нэгэн зүйл байх бөгөөд юу хэмээвээс, манай улс нь нэлээд хэдэн зуун жилд өөрийн бүхий л ажил хэргийг одоогийн хэрэглэж бүхий үсгээр явуулсаар ирэв. Энэ нь манай улсын одоогийн хөгжлөөс маш хоцрогдож буйн дээр ардын хэл ярианаас маш ондоогоор бичигддэг ба цагаан толгой нь 22, 27, 29 үсэгүүдтэй ч явдаг байна. Тэрчлэн жинхэнэ бичигт оруулан хэрэглэхэд нэг үсэг 3-4 хүртэл хувирдаг бөгөөд ийнхүү нэг үсэг дөрвөн янзын бие хэлбэртэй болдог нь даруй 120 гаруй болоход хүрүмүй. Нөгөө, талаар гадаадын нэр томъёо болон дэлхий нийтийн хэл ба техникийн нэр зэргийг бичихэд маш дутмаг буюу элдэв янзаар бүдүүлэгддэг болно. Ийм учраас манай хөгжилт ба соёл боловсролын зорилгоос хоцрогдсон бөгөөд тус улсын ирээдүйн хөгжилд саад болох хуучин монгол үсгийг сольж, латин үсгийг хэрэглэх болгох нь чухал байна... Эл зүйлийг хэрэг дээр биелүүлэх нь чухал байна. Түүнчлэн бид латин үсгийг нийтээр хэрэглэхэд таван жилээс илүү бэлтгэл явуулахгүйгээр биелүүлэн чадах болно..."³

хэмээн тэмдэглэжүхүй.

¹ Монгол Ардын Хувьсгалт намаас бүх нийтийг үндэсний бичиг үсэгт сургасан нь, Эх бичгийн эмхэтгэл 1921-1964, Улаанбаатар, 1967, 8-10-р тал.

² МАХН-ын ҮШ их хурлаас латин үсэг авч хэрэглэх тухай өгсөн заалт /1930 оны 4-р сарын 3-ны өдөр/, - МАХН-ын 8-р их хурлын товч тогтоол, Улаанбаатар, 1932, 40-41-р тал.

³ Хо. Чойбалсан, *Илтгэл, өгүүлүүд*, П боть, 1936-1948, Улаанбаатар, 1951, 389-390-р тал.

Х. Чойбалсангийн хэлсэн энэ үгийг авч үзэхэд нэг талаас, монгол бичгийн мөн чанарыг гуйвуулсан болох нь хэлшинжлэлийн наад захын боловсролтой хүнд тодорхой мэдэгдэх бөлгөө. Үүнд: үсгийн хэлбэр дурс хувиран өөрчлөгддөг ёс наад зах нь латин, кирилл бичигт ч (том гээд байгаа) *их*, (жижиг гээд байгаа) *бага* гэх зэргээр нэг үсэг 2-3 хэлбэртэй билээ. Бас лалын ертөнцийг нэгтгэж өгдөг араб үсэгт ч ийм зүйл буй. Хятад бичиг гэхэд олон мянган үсэгтэй. Ийм олон хэлбэртэй гээд тэдгээр үсгийг муучладаггүй билээ. Монгол бичиг нь төвөд, самгард, хятад зэрэг олон хэлний үг, аялгууг тэмдэглэдэг галиг үсгийн тогтолцоотой бөгөөд эртний энэдхэгийн ном судрын боловсорсон хэл - самгардаар бичиж болно гэдэг нь Энэдхэг-европын овог хэлэнд багтдаг бүхий л хэлний авиаг тэмдэглэх бүрэн бололцоотой гэсэн хэрэг юм. Бараг 100-аад жилийн өмнө "*Библи*" сударыг монгол бичгээр хэвлэсэн нь үүний нутлагаа бус уу? Аливаа хэлний зөв бичихзүй нь ярианыхаа хэлтэй тохирдог ёсон огт байдаггүй. Байх ч боломжгүй. Англи хэл гэхэд хамгийн их зөрдөг тул толь бичигт толгой үг бүрийн ард дуудалгыг нь хаалтанд тэмдэглэн хавсаргадагийг одоо нийтээр мэдэх болсон буй заа гэж найднам. Тэглээ гээд англи хэлтэн ус орнууд бичиг болоод зөв бичихзүйгээ өөрчлөх шаардалгагүй гэж үзсээр ирсэн билээ.

Нөгөө талаас, түүхч доктор Л. Бат-очир авгайн бүтээлээс үзэхэд монгол бичгийн олон хэлбэр гэдгийн талаар Х. Чойбалсанг Москвад байхад нь К. Е. Ворошилов жанжин яг ийм үг хэлж байсан тухай тэмдэглэгдэн үлдсэн баримт байдаг ажээ.

Дээр дурдсан хоёр хурлын шийдвэрийн дагуу латин үсгийн багш бэлтгэх түр сургуулийг хот хөдөөд байгуулж улмаар латин үсэг заах, туршилтын журмаар ном дэвтэр хэвлэх, сонин сэтгүүлд латин үсгээр булан гаргах зэрэг ажлыг 1930 оны дунд үеэс эхлэсэн байх бөгөөд харин Х их хурлаас хойш, Х. Чойбалсангийн илтгэлд дурдсанчлан таван жилийн бэлтгэл хийсэнгүй, жил хүрээгүй шахуу байхад буюу 1941 оны 2-р сарын 21-нд Шинэ латин үсгийг батлах тухай МАХН-ын Төв Хороо ба Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 17/13-р хурлын тогтоол гарчээ. Холбогдох хэсгийг нь эшлэн танилцуулбал:

"...Нэг. Латин үсгийн комиссоос төлөвлөн ирүүлсэн хорин есөн үсэг нь манай дууг тэмдэглэхэд хүрэлцэх ба тохирох тул хэвээр батласугай.

Хоёр. Монгол үгний урт эгшигийг давхарлан бичихийн оронд тусхай зураас тэмдэгийг авч хэрэглэсүгэй. Хэвлэлийн бололцоо нөхцөл бүрдэх хүртэл хэвлүүлэх зүйлд зураасны оронд апостроф хэмээх ташуу цэгийг түр хэрэглэж явуулахаар тогтоосугай.

Гурав. Эдгээрийн манай шинэ бичгийг ардын ярианы хэлэнд аль болохоор ойртуулах явдал нь монголын хуучин бичигт хэрэглэдэг балархай эгшигийг зөөлөн бичих буюу орхих явдал лугаа уялдсан байна. Иймд бүрмөсөн баларсан буюу бараг сонсогдохгүй болж бүрмөсөн баларахад хүрсэн эгшигүүдийг бичихгүй ба зөвхөн баларч яваа авч сонсогдож буй эгшигүүдийг бичихээр тогтоосугай. Ардын ярианы хэлэнд ойр ба сурахад төвөггүй хялбар шинэ дүрмийг сайтар боловсруулан гаргахыг Шинжлэх Ухааны Хүрээлэнд даалгасугай..."

Дөрөв. Үсгийн жинхэнэ дүрэм боловсруулагдан гартал сургууль бүлгэмүүдэд заах явдалд авлага болгох урьдчилсан түр дүрмийг 3-р сарын 30-ны янар боловсруулан гаргахыг Шинжлэх Ухааны Хүрээлэн ба Ардыг Гэгээрүүлэх Яаманд тус тус даалгасугай..."⁴

гэсэн байдаг.

Энэ тогтоолоос үзэхэд "Латин үсгийн дүрэм"-ийг боловсруулан гаргахаас өмнө ярьдагаараа бичих, монгол хэлний огцом эгшигийн асуудлыг хэрхэн тэмдэглэх талаар тусхай "чиглэл" өгсөн байдал илэрхий харагдаж байна.

⁴Монгол Ардын Хувьсгалт намаас бүх нийтийг үндэсний бичиг үсэгт сургасан нь, Эх бичгийн эмхэтгэл 1921-1964, Улаанбаатар, 1967, 32-33-р тал.

Бас дөрөвдүгээр зүйлд заасан түр дүрэм боловсруулан гаргах ёстой хугацаанаас таван өдрийн өмнө буюу 1941 оны 3-р сарын 25-нд *"Монголын шинэ үсгийг тогтоох тухай"* МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас гаргасан 22/28 дугаар хурлын тогтоолд

"...Монгол үсгийг латчилахад мөнхүү латин үсэгт монгол хэлэнд хэрэглэгдэх тэмдэг дутагдалтай ба мөн хэвлэлийн талаар дутагдах зэрэг техникийн бэрхшээл тохиолдож байна. Мөн тус орны соёл боловсролын цаашдын хөгжилт нь гагцхүү ЗХУ-ын ард түмэнтэй ах дүүгийн холбоог бэхжүүлэх, түүний баялаг соёлыг эзэмших замаар явах болно..."⁵

гэж тэмдэглээд ердөө ганцхан сарын өмнө "... (латин) 29 үсэг нь манай дууг тэмдэглэхэд хүрэлцэх ба тохирох тул хэвээр батласугай" гэж тэмдэглэсэн МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 17/13-р хурлын тогтоолыг хүчингүй болгосон байна.

Эдгээр баримтаас үзвэл *"Шинэ латин үсгийг батлах тухай"* тогтоол ердөө ганцхан сарын төдий хүчинтэй байсан бөгөөд 1930 оноос эхлэн латин үсгээр хэвлэн нийтлэсэн зүйл, бэлтгэсэн латин үсгийн багш нар, хот хөдөөгүй байгуулагдсан дугуйлан бүлгэм, түүнд зарцуулсан сүйтхэл мөнгө цөм ямар ч үр ашиггүй улсын хохирол болж өнгөрсөн юм.

Энэ далимаар тэмдэглэхэд, монгол бичгийг латинчлах явдал 1920 хэдэн оны эцсээс Зөвлөлтийн Буриад Монголд эхлэж туршилгын маягаар монгол, латин хадмал ном, сэтгүүл хэвлэн гаргаж байсан ажээ⁶. Энэ талаар академич Ц. Дамдинсүрэн авгай намтартаа сонин мэдээ тэмдэглэсэн байдагийг дор эшлээ.

"...31 онд Буриадын хэвлэлийн газар Ленин, Сталины зохиол орчуулах ажилд туслахаар очиж хэвлэлийн газар ба буриадын эрдэмийн хүрээлэнгийн газар орчуулгын зөвлөхөөр нэг жил ажил хийсэн болно. Тэр үед Сталины зохиол *"Ленинизмийн асуудлууд"* хэмээх зохиолыг буриад хэл дээр латин үсгээр хэвлэсэн болно. Гэтэл миний бие буриадын шинэ бичгийн хэлийг байгуулах асуудалд панмонголизмын үзлийг баримтлаж үл зохиолдоно хэмээн Мэргэн гүн Гомбожав, Базар Барадин нарыг⁷ шүүмжлэж буриадын "Үнэн" сонинд статья бичсэн тул тэдэнтэй тохирохгүй болж Монгол нутагт буцаж ирсэн бүлгээ..."

гэсэн нэгэн сонирхолтой хэсэг байдаг⁸.

⁵ *Монгол Ардын Хувьсгалт намаас бүх нийтийг үндэсний бичиг үсэгт сургасан нь*, Эх бичгийн эмхэтгэл 1921-1964, Улаанбаатар, 1967, 33-34-р тал.

⁶ *Опыт совершенствования алфавитов и орфографий языков народов СССР*, Москва, 1982, стр. 124.

⁷ Сонирхуулан дурдахад Базар Барадин бол буриадын нэрт зохиолч, түүхч, угсаатны зүйч, нийгэм соёлын зүтгэлтэн бөгөөд *"Монголын нууц товчоон"*-д гардаг IX зууны үеийн Хоридой мэргэний эцэг Барга баатарын удамын хүн юм (*Базар Барадин*, Докдады и тезисы научной конференции, Улан-Удэ, 1993, стр. 11-12.). Тэрээр 1937 онд "зөвлөлтийн эсрэг панмонголизм"-ын хэргээр яллагдаж цаазаар авуулсан байна. Энэ хэргийн хаялгад Ж. Цэвээн болон ерөнхий сайд асан А. Амар, Б. Гэндэн, Монголын хувьсгалт цэргийн зөвлөлийн дарга асан Жадамба, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга асан У. Бадрах, Д. Дамба нар өртсөн тухай, мөн олон баримтанд Х. Чойбалсангийн нэр гардаг боловч тухай бүр нь улаан харандаагаар дарсан байдаг тухай Ш. Б. Чимитдоржиев, Б. В. Базаров, Ю. П. Шагдуров нар судлагаандаа дурджээ (*Базар Барадин*, Докдады и тезисы научной конференции, Улан-Удэ, 1993, стр. 29-35). Мэргэн гүн Гомбожав нь Хөвсгөлийн Рашаантын хүн, Жамсраны Цэвээний гарын шавь байсан бөгөөд Францад Поль Пеллиогийн дэргэд сургууль хийсэн олон хэлтэй, боловсрол өндөр, хэлшинжлэлч байсан агаад Зөвлөлт Холбоот Улсад ажиллаж байхдаа 1937 оны 8-р сарын 11-нд буюу Ж. Цэвээн гуайн маргааш нь баривчлагдаж хоюулаа хамтдаа цаазын аманд амь үрэгдсэн байна (Г. Дүйнхэржав, *Буруугүй буруутан*, "Ил товчоон" сонин, 1993. 1X. 10-20, 13-р нүүр).

⁸ Ц. Дамдинсүрэн, *Өөрөө бичсэн намтар*, - "Үнэн" сонин, 1988. IX. 13, N. 220, 3-р нүүр.

Буриад газар энэ мэтийн ном товхимолоос гадна 1930-аад оноос өмнө монгол бичгээр гардаг байсан шашингүйн суртлын сар тутмын "Эрдэм ба шажан" ("Наука и религия") зэрэг сэтгүүлд латинаар хэвлэсэн хэрэглэгдэхүүний хувийн жин улам ихэсэж ирсэн байдал бэлхэнээ харагддаг.

Латин үсгийг батласан тогтоол сар хүрэхгүй хугацаанд хүчин төгөлдөр байсан учир уг тогтоолын заалтад дурдсан зөв бичихзүйн жинхэнэ болоод түр дүрэмийн аль аль нь эцсийн хувилбараараа гарч амжаагүй юм. Бидэнд мэдэгдэж байгаа баримтаар шинэ латин үсгийн "Хэлзүй"-н хэд хэдэн хувилбарыг Йөншөөбү Бямбын Ринчен, Боржгин Дашдоржийн Нацагдорж нар боловсруулж байсан баримт буй⁹.

Хэдийгээр албан ёсны зөв бичихзүй боловсорч гараагүй боловч 1930-1941 он хүртэл манай сонин сэтгүүлд хийгээд олон нийтийг зүгшрүүлэх зорилгоор туршилгын журмаар хэвлэн нийтлэж байсан латин үсгээрхи хэрэглэгдэхүүнээс товч танилцуулсу.

ᠰᠢᠨᠡ ᠶᠡᠰᠡᠭᠢᠨ ᠪᠤᠯᠠᠨ
(41 дугаар сониний үргэлзлэл)

Mongoliin kubiskal ulamaar gynzegii bolzi kamtaraliin ba azi yiledberiin baiguulalta nemegdezi iresen jabadal bol ene 2 дугаар тебшлтийн екний зилде дыгнегдекеден нам ебле, yiledberčinees temcesen ololto kiigeed azilčin zarca arad төмөнii sergezi kədelsen idebki yri bolno. Namaas kominternii udaridalgiig abči namaas olon niitiin azilda bijeer manlailan orolcoson oroldolgoо kezeеçig gyicedkeltei, kezeеçig bekiziltei çukal asuulta baika josotoi. Azi yiledberiin dutagdaliig arilgaka, azi akuin byteeliig deeši kegzyylke kereg bol zebken amaар keleke buyuu gojo togtool gargaad, olon dakizi jariaad dyyrgeke kereg biši gekiig bide bygedeereen medene...

{1932 оны 2-р сарын 23-ны өдрийн 45 (658) -р
ᠤᠨᠡᠨ сонины 4-р нүүрээс}

Биçig ysegiin duguilan

Manai kamtaralda biçig ysegiin duguilan baiguulba. Ulaan geriin erkelegçiig surgagçaар uribaa. Eregtei emegtei bygede niilezi arban taban kyn neree biçiyyleed duguilanda oroloo. Doloon konog byriiin migmar, baasan kojor өдериin oroi kiçieel kiideg болсон...

Teeke nebteryylke azil

Teeke nebteryylke azilda uuriin terege ylemziken kereglene. Zam jike zasana, gyыр tabina. Korinnegedygeer ondo taban saja kojor zuun korin taban minga naiman zuun jiren naiman puu juuma teene...

⁹ Ринчен, Монгол хэлний шинэ үсэгийн хэлзүй, (гар бичмэл): Удирдхал, Дууны сургаали гэсэн хоёр хэсэгтэй. Удирдхалд хэлзүй гэж юу болох, хэлний ёсзүйг шинжлэх - хэлзүйд дууны сургаали, үгийн сургаали (буюу хэлбэрсудлал), өгүүлбэрийн сургаали гэдэг 3 гол зүйл багтдаг тухай маш ойлгомжтой тайлбарлажээ. Дууны сургаали хэмээх бөлөгт үсгийн учир, дууны учир, эгшиг, эгшиг зохицох ёсон, гийгүүлэгч, зөв бичих тэмдэглэл, үеийн учир холбогдол гэх зэрэг асуудлыг жишээ загвартай оруулсан байдаг. Гол зарчим нь гэвэл урт эгшиг дээр зураас тавих, гийгүүлэгчийг дан болон давхар үсгээр тэмдэглэх, үгийн сургаалийг чухалчлах эдгээр болой.

Д. Нацагдорж, Монгол хэлний ба латинчлалын дүрэм (грамматика), Улсын түүхийн Төв Архив, Ф. 23, Д. 2, ХН. 50; А. Очир, Г. Дашням, Д. Нацагдорж: Нийгэм улс төр, эрдэм шинжилгээний үйлс, амьдрал, Улаанбаатар, 1996, х. 121.

...Ene jike aziliig uul zorilgaiin josoор gyicedkeked saad boomto bolko zyilyyd edii tedii bolno...

{*Mongᠣl kelen-ü ᠵaliᠭ* гэдэг чулуун барын жижиг товхимол, хэвлэсэн он тодорхойгүй. Дотор нь 1935 оны тоо баримт байдаг. Уг товхимолын 25, 59, 65-р хуудаснаас дээрхи 3 хэсгийг авав.}

Unen

Gazar byriin ygegyy nar negedegtyн!

Mongol Aradiin Kubiskalta Namiin Teб Koroo ba Yiledber᠑inii Teб zeblelees өдөр byri keblen niitelne...

᠑ine josonii kere᠑etenii ara᠑ilsan byren erekete bygede nairamdaka Mongol arad ulas mandatugai.

{*Unen*, No. 152 (765)
22 on, 7 sariin 3-nii өдөр
Ulaanbaatar koto
Yne 10 mөnge}

Дээр эшлэж хавсаргасан жишээ бичвэрээс үзэхэд шинэ латин үсгийн цагаан толгойн ерөнхий дүр байдал, мөн монгол хэлний үг бүтэх ёс (тухайлбал: үеийн бүтэц, огцом эгшигийн үүрэг зэрэг)-ыг харьцангуй нарийн тусгасан байжээ гэж хэлж болно.

Эдгээр баримтыг тухайн үед ЗХУ-ын Буриад Монголд латин үсгээр хэвлэж нийтлэсэн зүйлтэй харьцуулахын үүднээс буриад газар латин үсгээр хэрхэн бичиж байсны баримтыг авч үзээ.

Erdem gegeerei tukai zeblelyydiin 6 du᠑ar jike kural juu kelebe

...Bykeni surgaka ba nom bi᠑ig medeke ygiigi usdakaka jabadaluudta bidener tun jike gyisedkeltei gebe᠑igi tyyntee kamta dutamag zyilyyd jike olon baina. Zi᠑eelbel: surguuliin nasanii бага᠑уудиigi cym surguulia kanduulja ᠑адасан ygii, мөн насанаас kalisan nasatai бага᠑уудиigi surguulida bagtaaza ᠑адааdyi geke zergiin dutamag zyilyyd ali olon baina...

...Kaanta kara zasagiin baika ujedei одoo yjiigi zi᠑eeleed yzebel, adalidkasa ygii sain болsoni elirkei baina, kaanta kara zasagiin baikada azal᠑an aradiin tun olonki nom bi᠑eg medeke ygii, ganca negen kyn baiba᠑igi Cerkovno-prikoodsko geze burkanii nomtoi kolbootoi surguulida suralcasan baidag belee...

{*Erdem ba ᠑azan*, 1931, Ijuuni, N. 6, Верхнеудинск, х. 1.}

Үүнийг монгол хэлний хэрэглэгдэхүүнтэй харьцуулан үзэхэд цагаан толгойн бүрэлдэхүүний хувьд, тухайлбал одоогийн шинэ оросжин үсгийн дуудалгатай дүйлгэн үзүүлбэл доорхи мэт байна:

Монголын латин үсэг	Буриадын латин үсэг	Одоогийн дүйх дуудалга
о	о	о
u	u	у
ө	ө	ө
у	у	ү
з	z	з
ж	ж	ж
ц	с	ц
ч	ч	ч
с	с	с
ш	ш	ш
й	й	й(е)

гэх мэтээр үсгийн сангийн хувьд үндсэндээ дүйж байна.

Үүнээс үзэхүл, тэр үед Буриад газар латинаар хэвлэсэн зүйлийг өдгөөгийн буриад бичгийн хэлнийхитэй харьцуулахад тухайлбал: монгол хэлний *s* гийгүүлэгч буриад аялгуунаа шүргэх *h* болдог, *ts* гийгүүлэгч *s* болдог, *ts̥* гийгүүлэгч *š* болдог зэрэг буриад аялгууны өвөрмиц онцлогийг бус харин монгол хэлний нийтлэг онцлогийг тусгасан нь тодорхой харагдаж байна. Чухам энэ нь монгол бичгийн хэл шигээ, латин үсэгт суурилсан нэгдмэл бичгийн хэлтэй байх гэсэн тухайн үеийн буриад, монголын хэсэг эрдэмтэн сэхээтэн нарын хүсэл эрмэлзэлтэй холбоотой байсан хэрэг бөгөөд ярьдагаараа бичих ёстой гэсэн "зааварыг" үл дагасаны учир тэд нар "панмонголизм" буюу "нармай монголын үзэл"-тэн хэмээгдэхийн лавтай нэг шалтгаан болсон буй заа. Үүнээс үүдүүлэн бодвол монгол хэлний олон аялгуутныг өөр өөрийнхи нь хэлдэгээр тус тусад нь бичүүлэх гэсэн бодолго нь цаанаа нэгдмэл бичгийн хэлтэй байх явдлаас "сэргийлсэн" юм биш байгаа гэж эрхгүй санагддаг.

Бичигийн хэл хэдэн өөр болох нь овог язгуур нэг байсан хэл төд хуваагдахын үүдийг нээхийн эхийг тавьдаг байна. Монгол туургатны хувьд монгол, буриад, халимаг, өмнөд монгол, дагуур ... гэх зэрэг олон монгол хэл буй болсоны гол үндэс нь нэгдмэл бичигийн хэл үгүй болж, нэг монгол үгийг (монгол, халимаг, буриадад хэрэглэж буй орос кирилл бичиг шиг) нэг янзын үсгээр буюу эс бөгөөс (монголд орос-кирилл үсэг, өвөр монголд худам монгол үсэг хэрэглэдэг шиг) өөр өөр үсгээр харилцан адилгүй бичдэг зөв бичихзүй бүхий олон бичиг зохиолын хэлтэй болсонд л оршидог бөгөөд үүний дүнд тухайн нэг үндэстэн цаг хугацаа өнгөрөх тутам хэлний хувьд харилцан холдох зам руу эрхгүй тэмүүлдэг ажээ. Дэлхийн тив тивд тархан аж төрдөг англи, франц зэрэг хэлтэн, монголчуудын нэгэн адил аялгууны төвшинд ялгаатай боловч, уламжлалт нэг л бичгийн хэлтэй байдаг тул олон англи хэл, олон франц хэл гэж хуваагддаггүйн учир тэр буюу.

Үндсэн сэдэв рүүгээ эргэн орж дээр дурдсан баримт сэлтэд дулдуйдан 1930-1940 оны хооронд Монгол улсад хэрэглэж байсан латин үсгийн цагаан толгойг жагсаавал дараахи мэт болно. Тэхдээ явцын дунд зарим нэг өөрчлөлт, зөрөө гарч байсан боловч нийтээр хэрэглэхээр завдаж байсан албан ёсны хувилбар нь энэ гэж үзэх үндэс буй.

Шинэ латин үсэг	Тохирох кирилл үсэг	:	Шинэ латин үсэг	Тохирох кирилл үсэг
A a	А а	:	O o	О о
B b	Б б	:	Ө ө	Ө ө
C c	Ц ц	:	P p	П п
Ç ç	Ч ч	:	Q q	(кю)
D d	Д д	:	R r	Р р
E e	Э э	:	S s	С с
F f	Ф ф	:	Ş ş	Ш ш
G g	Г г	:	T t	Т т
H h	(Н н)	:	U u	У у
I i	И и	:	Y y	Ү ү
J j	Й й	:	V v	В в
K k	Х х	:	W w	(давхар В)
L l	Л л	:	X x	(кс)
M m	М м	:	Z z	З з
N n	Н н	:	Z z	Ж ж

Үүнээс ф, кю, давхар В, кс дөрөвийг гадаад үгнээ голлон хэрэглэнэ гэсэн тайлбартай байдаг бөлгөө.

Цэг цэглэлийн хувьд оросжин кирилл үсэгт одоо бидний хэрэглэж байгаатай онцын ялгаа байхгүй ажээ¹⁰.

Харин харьцангуй сүүл үеийнхи бололтой *Буриад Монголын шинэ үсэг* гэсэн цагаан толгой олддог бөгөөд үүнээс үзвэл бидний дээрхи жагсаалтаас нэлээд ялгаатай. Үүнд: цагаан толгойн үсгийн жагсаалтад *h* үсгийг дуудалгагүй нэмж оруулсан байх бөгөөд үүний учрыг нягтлавал дээрхи жагсаалтад буй *ж, ч, ш* авиаг тэмдэлэдэг латин үсгийн нэмэлт тэмдэгийг хэрэглэхээ больж оронд нь англи хэлнийхи шиг нийлэмж (диграммы) үсгээр *zh, sh, zh* гэж давхарлан тэмдэглэж хэрэглэхээр төлөвлөсөн байдаг. Энэ далимд хэлэхэд Еншөөбү Ринчен профессорын боловсруулсан *"Монгол хэлний шинэ үсгийн хэлзүй"*-н дотор *ч - г ch* - ээр, *ж - г j* - ээр, *ш - ийг sh* - ээр, *х - үсгийг k* - ээр биш *х* - ээр, *й - г у* - ээр тэмдэглэх нь зүйтэй гэж үзсэн байдаг бөгөөд энэ санал нь үндсэндээ саяын шинэчилсэн цагаан толгойтой зарчмын хувьд таардаг билээ. Энэ өөрчлөлт нь олон улсын хэмжээнд

¹⁰ *Mongᠭol kelen-ü ᠶалиᠭ*, Ulaanbaᠭatur, 193...? (Улсын Төв Номын сангийн: 49 мон, М 642 гэсэн тэмдэгтэй), 20-р тал.

латин үсгийг хэрэглэж ирсэн нийтлэг журамтай тохирохоос гадна техникийн хувьд ч элдэв олон нэмэлт тэмдэг шаардахгүй хялбар болох байсан бөлгөө.

Гэвч латин үсэг авахаар бэлтгэсэн бүхэл бүтэн арван жилийн хөдөлмөр ямар ч үр дүнгүй, ёстой "элсэнд асгасан ус" шиг ажил болсон юм.

Эцэст тэмдэглэхэд, чухам юуны учир тэр үед Зөвлөлт Холбоот Улс болон Монгол Улсад латин үсгийг авах асуудал сүр дуулиантай гарч, түүний үр дүн болсон арваад жилийн ажил талаар өнгөрөв? гэдэг нь бас сонирхол татдаг. Нарийвчилан хөөж үзэхүл В. И. Ленин "...Энэ (латин үсгийг хэрэглэх) явдал болбол Дорнодахины их хувьсгал мен..." - "Ene (latiin usyg keregleke) jabadal bolbol dornodakinii jike kublskal mōn"¹¹ гэж хэлсэнтэй холбоотойгоор сүр дуулиантай эхлэжээ. Харин 1930-аад оноос ийнхүү эрчтэй эхлэсэн латин үсэг хэрэглэх асуудлыг 1940-өөд оноос И. В. Сталин огт өөрөөр шийдэж орос үсэгт оруулсан юм. Энэ мэтээр В. И. Ленинийхээ хэлж сургасан олон зүйлийг И. В. Сталин огт өөрөөр биелүүлж ирсэний бодотой баримт захаас аван гарч ирдэг. Үүнд: орос хэлийг цэвэр ариун байлгах талаар В. Белинский, И. Тургенев, Л. Толстой, К. Паустовский зэрэг оросын гүн сэтгэгч нарын үзэл бодлыг В. И. Ленин бүрэнээ дэмжиж өөрөө тусгайлан өгүүлэл бичиж байсан боловч И. В. Сталин үүнийг нь огтхон ч анхаараагүйгээр үл барам харин ч эсрэгээр нь хэрэгжүүлж орос хэлийг бусад бүх хэлний дээр тавих үндэслэл болсон "хэл хутгалдахын онол"¹² гэгчээ гаргаж ирсэн нь бас нэгэн нутлагаа юм. Энэ тухай дараагийн холбогдох бөлөгт дэлгэрүүлэн өгүүлэх болно.

¹¹ *Sine mongol usygy surku debter*, Dugaar 2, Aradiig gegeeryyleke jaamanii dergede baiguulsan latiin usygiin zöblöldös niitelbe, Ulaanbaator, 1930 он, (Нүүр хавтасыг үзмүү).

¹² И. Сталин, *Хэлний шинжлэлд марксизмын холбогдох нь*, Улаанбаатар, 1950, 52-53-р талд үзмүү.

ОРОСЖИН "ШИНЭ" БИЧИГ

Монгол хэлний хөгжлийн түүхэн баримт сэлтийг үзэхүл монгол үг хүйсээр ялгардаг байсан ул мөр илэрхий харагддагийг олон эрдэмтэн санал нэгтэй тэмдэглэсэн нь буй. Үүнчилэн тоо хийгээд биеэр зохицдог ёсон дундад үеийн монгол хэлний хэрэглэгдэхүүнээс цөөнгүй олддог. Тэр ч бүү хэл, *бичиг, дур, дэвтэр, нугас, нум, сэтхил, туг, хонь, хэл, хэшиг* гэх зэрэг олон үг эм хүйсээр хэрэглэгдэж *монголжин дур, жирин сэтхил, сартагчин хонь, алагчин туг, шаргаачин нум, уйгуржин бичиг* гэх зэргээр өмнөхи тодотголоо зохицуулдаг байсан баримт буй билээ.

Одоо зарим хүн энд бидний судлагдахуун болж буй бичгийг орос биш, кирилл бичиг гэж нэрлэх ёстой хэмээн үзэж буй явдал байсаар буй. Гэтэл 1941 онд энэхүү "шинэ" үсэг авах тухай албан ёсны баримт бичигт "орос үсгээр үндэслэж" гэсэн үг байдагийг харгалзах ёстойн дээр цагаан толгойн бүрэлдэхүүн ч орос үсэгтэй яг тохирдог нь үүний бодтой нутлагаа болж байгаа хэрэг бус уу!

Чухам үүнээс уламжлаж кирилл гэлгүй *оросжин* гэдэг нэр томъёог хэрэглэсэн бөгөөд цаашид энд өгүүлэх бүх баримт сэлт уг нэр томъёо зөв болохыг батлаж өгнө.

Үүний түрүүчийн "Латин бичиг" хэмээх бөлөгт латин үсэг авах тухай МАХН-ын Төв Хороо, Засагийн газарын хамтарсан тогтоол нэгэн сар хүрэхгүй хугацаанд гэнэт хүчингүй болж латин бичигт шилжихээр бэлтгэж бүхэл бүтэн арван жилийн турш гүйцэтгэсэн их ажил, зарсан хүч хөрөнгө огт хоосоор өнгөрсөн тухай дурдсан бөлгөө. Энэ бүхэн бол ямар ч атугай тодорхой зорилго бүхий томоохон хүчний нөлөө гэдэг нь тодорхой байсан боловч чухам цаад шалтгаан нь тухайн үедээ олон нийтэд учир битүүлгэ үлдсэн юм.

1941 оны 3-р сарын 25-нд болсон МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас гаргасан 22/18 дугаар тогтоолын заалтад:

"...монгол бичгийг шинэ орос үсэг дээр шилжүүлэн авах явдал чухал хэмээн үзмүй..."

гэж тэмдэглээд уг шинэ үсгийн төлөвлөгөөг нэг сарын дотор МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчид ба Засагийн газарт оруулж батлуулахыг Ю.Цэдэнбал даргатай комисс (орлогч дарга Машлай, гишүүд Гонгоржав, Доржсүрэн, Лувсанвандан, Дамдинсүрэн, Сүрмаажав, Далхжав, Цэвэгмид, Тамжид, Лувсандорж)-т даалгасан байна¹.

Ингээд "Орос үсэг дээр үндэслэсэн монгол шинэ үсэг батлах тухай" Ардын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1941 оны 5-р сарын 9-ний өдрийн хамтарсан 25/27 дугаар тогтоолын 1-р заалтаар:

"...орос үсгээр үндэслэж монгол үсгийг бүгд 35 үсгээр..."

баталж, 2-р заалтад нь:

¹ Монгол Ардын Хувьсгалт намаас бүх нийтийг үндэсний бичиг үсэгт сургасан нь, Улаанбаатар, 1967, 33 - 34.

"...батлагдсан шинэ үсгийг бичих ба хэрэглэх урьдчилсан дүрмийг долоо хоногийн дотор боловсруулан гаргаж зарлах ба цагаан толгойн сурах бичгийг ойрын хугацаанд бэлтгэн гаргахыг Шинжлэх Ухааны Хүрээлэн, Ардыг Гэгээрүүлэх Яаманд даалгаж..."

уг тогтоолын 4-р даалтаар нь:

"...бага сургуулийн 1, 2-р ангиудад 31 - 32 оны хичээлийн жилээс эхлэн бүх хичээлийг шинэ үсгээр явуулсугай..."²

гэж тогтоожээ. Харин энэ завсар Дэлхийн 2-р дайны үйл явц нөлөөлсөн бөгөөд 1945 оны 5-р сарын 18-нд болсон БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны хамтарсан хурлын 31/27-р тогтоолын 1-р заалтаар:

"...Бүх хэвлэл ба улсын албан хэргийг 1946 оны 1-р сарын 1-нээс эхлэн шинэ үсгээр явуулсугай..."³

гэж заасан байдаг.

Шинэ үсгийн анхны дүрэм (хэлшинжлэлийн ухаанаар бол үсгийн дүрэм биш, зөв бичихзүй) 1942 онд хэвлэгдэж засвар оруулсан хоёдугаар хэвлэл нь 1946 онд "...товч дүрэм" нэртэйгээр гарчээ⁴. Энэхүү товч дүрэмд, дээр нь зураас тавьж урт эгшиг тэмдэглэж байсныг болиулж давхарлан бичихээр болгож, том (чухамдаа их) үсгээр бичих, харь үгийг бичих зүйл дээр өөрчлөлт оруулснаас гадна үг хураах тухай нэмэж оруулсан байдаг. Энэ ялгааг зарим нэгэн баримт дээр ажигласан судлагаа ч гарчээ⁵.

Энд тэмдэглэхэд, 1946 оны "Монгол шинэ үсгийн товч дүрэм" нь орос үсэгт үндэслэсэн бичгийн зөв бичихзүйн үндэс болж цаашдаа 40 гаруй жил хэрэглэгдсэн тул албан ёсны батлагдсан "товч" биш дүрэм гараагүй гэж үзэж болно.

1946 он хүртэл шинэ үсгээр гарсан хэрэглэгдэхүүнийг ажиглахад эхин үедээ монгол хэлний авиазүйн онцлогийг аль нэгэн хэмжээгээр тусгасан буюу орос хэлний авиазүй болон үсэгзүйгээс ялгарах зүйл нэлээд байснаа 1945 оны Октябрийн баярын дараагаас тэдгээр ялгаа бараг арилаж орос хэл бичгийн байдалд улам улам ойртуулан зассан явдал бэлхэнээ харагддаг. Үүнд: 1941 онд гаргасан мөнгөн дэвсгэрт дээрхи бичгийг 1945 онд дэлдсэн 5-тын задгай мөнгөн дээрхи бичигтэй харьцуулахад тодорхой мэдэгдэнэ. Бас "Үнэн" сонины ойрхоны хоёр дугаарын хэрэглэгдэхүүн ч үүнийг нутлана. Жишээ нь:

"Үнэн" (1945. X. 11, N. 233)

"Үнэн" (1945. X1. 13, N. 258)

е > э	шине	>	шинэ
дз > з	дзасгийн гадзар	>	засгийн газар
дж > ж	сурвалджлагч	>	сурвалжлагч
ии > ий	Токиогиин	>	Токиогийн
йө > е	йөрөнхий	>	ерөнхий

гэх мэт болно. Энэ бүгд нь 1941 - 1946 онд шинэ бичгийн хувьд зөв бичихзүйн тогтсон дүрэм байгаагүй болохыг харуулж байгаа юм.

² Монгол Ардын Хувьсгалт намаас бүх нийтийг үндэсний бичиг үсэгт сургасан нь, Улаанбаатар, 1967, 34-р тал.

³ Монгол Ардын Хувьсгалт намаас бүх нийтийг үндэсний бичиг үсэгт сургасан нь, Улаанбаатар, 1967, 37-р тал.

⁴ Ц. Дамдинсүрэн, Монгол шинэ үсгийн дүрэм, Улаанбаатар, 1942; Ц. Дамдинсүрэн, Монгол шинэ үсгийн товч дүрэм, Улаанбаатар, 1946.

⁵ Stéphane Grivelet, A Brief Note on an Extinct Diacritic, - Mongolian Survey, Issue Three, Bloomington, Indiana, 1996, pp. 51-53.

Ингээд "Монгол шинэ үсгийн товч дүрэм"-ийн гол гол зүйлийг бусад монгол бичгийн нэгэн адил үсэгзүйн үүднээс авч үзсүгэй.

Цагаан толгой

А а	Б б	В в	Г г	Д д	Е е	Ё ё
Ж ж	З з	И и	Й й	К к	Л л	М м
Н н	О о	Ө ө	П п	Р р	С с	Т т
У у	Ү ү	Ф ф	Х х	Ц ц	Ч ч	Ш ш
Щ щ	Ь ь	Ы ы	Ъ ъ	Э э	Ю ю	Я я

Энэхүү жагсаалтаас үзэхэд орос цагаан толгойн гучин нэгэн үсэг, хоёр тэмдэгтийг хэвээр нь авч дээр нь Ө, Ү-г нэмээд нийт 35 үсэг, тэмдэгтэй болгожээ. Дүрэмд үүнийг хувааж тайлбарласан нь:

"...Шинэ үсгийн а, о, у, э, ө, ү, ы, и, й, я, е, ё, ю энэ 13 нь эгшиг; б, в, г, д, ж, з, к, л, м, н, п, р, с, т, ф, х, ц, ч, ш, щ - 20 нь гийгүүлэгч үсэг, ь, ъ хоёр нь дуудлагагүй тул эгшиг ч биш, гийгүүлэгч ч биш зүгээр тэмдэг үсэг болно..."

гэсэн байдаг⁶. Зохиогч цааш нь тэмдэглэхдээ эгшиг үсэг 13 боловч монгол хэлний эгшиг дуун 7 юм гээд 13 эгшигээ дотор нь үндсэн (а, о, у, э, ө, ү, и) долоон эгшиг, туслах (я, е, ё, ю, ы, й) зургаан эгшиг гэж хуваагаад я, е, ё, ю дөрөв бол гийгүүлэгч эгшиг хоёр дуугаар бүтсэн бүхэл үеийг тэмдэглэх (я - йа, е - ѐ, ө - ѐө, ю - ѐу, йу) үсэг юм хэмээгээд энэ дөрвөн үсгийг я-гийн төрлийн үсгүүд гэнэ⁷ гэж тодорхойлжээ.

"...г үсгээр хоолойн г, хэлний г хоёр дууг...", "... н үсгээр хамрын н, хэлний н хоёр дууг тэмдэглэнэ..."⁸

гэж гийгүүлэгч үсгийн тухайд нэмэн тайлбарласан нь буй. Зохиогч шинэ үсгийн дүрмийг халх монголын ярианы хэлэнд үндэслэснийг тэмдэглээд:

"...дүрмийг зохиохдоо ер нь бидний шинээр боловсруулсан зүйл юү вэ? гэвэл балархай эгшигийн дүрэм мөн болно..."⁹

гэж онцлон дурдсан байдаг. Энэхүү балархай эгшигийн дүрэм гэдгийг зарим нэг хүн "шинжлэх ухааны дорвитой нээлт"¹⁰ гэж үздэг байжээ.

Дээр дурдсан зүйлийг үсэгзүйн судлагааны хүрээнд, хэлшинжлэлийн мэргэжлийн олон эрдэмтний санал дүгнэлтийг үндэслэж товч боловч тайлбарлах нь олон нийтийн танин мэдэхүй хийгээд бидний судлагааны зорилгод нийцнэ гэж бодном.

Үүнд: Я-гийн төрлийн үсгээс эхлэн ярия. Энэ дөрвөн үсэг нь бүтэцийн хувьд Г(ийгүүлэгч) + Э(гшиг) буюу энэ тохиолдолд а, о, у, ө, ү таван эгшигээр амь авсан хэлний дундуурхи Й гийгүүлэгчийг тэмдэглэж байгаа үеийн үсэг бөгөөд монгол хэлний үг бүтэх ёсны үүднээс амь өгч буй эгшиг нь төдий л гол бус, харин гийгүүлэгч "Й" нь голлох үүрэгтэй билээ. Тийм ч учраас тухайн язгуураас салбарлаж үг үүсэхэд арын эгшиг нь ямагт өөрчлөгддөг хуультай байдаг юм. Иймд "Я"-гийн төрлийн үсгийг хэрэглэснээр нэг язгууртай олон үсгийн бичилгэ язгуур нэгтэй гэхээргүй болтолоо өөрчлөгдөж үүсэл гарлыг нь танин мэдэхэд амаргүй болдог. Зарим нэгэн үгээр жишээ авч үзээ:

аянга - аймшиг - аюул ...
хоёр - хоюул | хоёул - хоймсон ...

⁶ Ц. Дамдинсүрэн, Монгол шинэ үсгийн товч дүрэм, Улаанбаатар, 1946, 15.

⁷ Ц. Дамдинсүрэн, Монгол шинэ үсгийн товч дүрэм, Улаанбаатар, 1946, 15 - 19.

⁸ Ц. Дамдинсүрэн, Монгол шинэ үсгийн товч дүрэм, Улаанбаатар, 1946, 15.

⁹ Ц. Дамдинсүрэн, Монгол шинэ үсгийн товч дүрэм, Улаанбаатар, 1946, 10.

¹⁰ Г. Осор, Шинэ бичгээ адлахгүй, - Ардын эрх, 1991. I. 30, N. 21 (93), 4-р нүүр.

Ийм учраас я-гийн төрлийн "туслах эгшиг" үсэг нь мөн чанарын хувьд үеийн үсэг тул залгамал хэвшинжийн монгол хэлний тухайд тохиромжгүйн учир хэлний дундуурхи Й гийгүүлэгчийг бусад бүх гийгүүлэгч үсгийн нэгэн адил зохих зохих эгшигээр нь амь өгч тэмдэглэсэн бол монгол хэлний онцлогт илүү тохирох байсан гэж Б. Ринчен, Ш. Лувсанвандан, Я. Цэвэл, Э. Вандуй, Б. Содном, Эрдэнэтогтох зэрэг хэлшинжлэлчид санал нэгтэй үзсээр ирсэн нь санамсаргүй хэрэг огт биш байлаа¹¹. 1941 онд анх шинэ үсэг хэрэглэж эхлэхэд ийм зарчим байсныг дээр бид цухас дурдсан. Монгол хэлтэй харьцуулахад я-гийн төрлийн үсэг илүү тохиромжтой байж болох орос хэлэнд ч "Я"-гийн төрлийн эгшигийн хажуугаар *йод, йемен, Йоркшир, йотирование* гэх зэргээр бичдэг нь дээр дурдсан монгол хэлшинжлэлчдийн санал эрдэм шинжилгээний үндэстэй болохыг давхар батлаж байгаа юм.

Үсгийн дүрэмийн зохиогчоос "...шинээр боловсруулсан зүйл бол балархай эгшигийн дүрэм мөн..." гэж онцлон тэмдэглэж зарим хүн үүнийг нь "...шинжлэх ухааны дорвитой нээлт..." гэж нэрлээд "...түүний амин сүнс нь эгшигт долоон гийгүүлэгч, заримдаг есөн гийгүүлэгчийг бичих дүрэм..." хэмээн үзэж ирсэн зүйлийг манай урдаа барьдаг хэлшинжлэлчид хэрхэн үзэж ирсэн нь эрдэм шинжилгээний хувьд сонирхол татдаг.

Академич Ш. Лувсанвандан:

"...Үгийн үндэсийг эвдэхгүйн тул эгшигийг шилжүүлэхгүй болгоё. Дагаварыг тогтвортой болгох нь зүйтэй..."¹²

"...Монгол шинэ үсгийн дүрэмд үе төгсгөх *д, с* хоёр гийгүүлэгчийг үе үл төгсгөх буюу заримдаг гийгүүлэгчийн бөлөгт багтаасан нь алдаа болсон байна... Орчин цагийн монгол хэлний гийгүүлэгч авиаг ардаа байнгын эгшигтэй, эгшиггүй байдаг талаас нь авч үзвэл харин одоогийн заримдаг гийгүүлэгч гэдэг нь эгшигт гийгүүлэгч, эгшигт гийгүүлэгч нь заримдаг гийгүүлэгч болох юм..."¹³

Академич А. Лувсандэндэв:

"...Хэрэв эгшигт долоо, заримдаг есийн дүрмийг хэрэглээд үгийн үндэс, дагаварыг тогтмол болгож чадвал их сайн юм. Гэвч энэ нь бүтэшгүй хэрэг бололтой. Иймээс эгшигт долоо, заримдаг есийн дүрмийг хэрэглэхээ болиё. Үгийн үндэс дагаварыг тогтмол болгоё..."¹⁴

Дэд эрдэмтэн Э. Вандуй:

"...Эгшигт долоо, заримдаг өс гэдэг нь зохиомол дүрэм юм. Хойшид үндэс дагаварыг тогтмол болгоё. Эгшигийн шилжүүлж гээхгүй болгоё..."¹⁵

Хэлшинжлэлч Я. Цэвэл:

"...Шинэ үсгийн хүнд бэрхшээлтэй болсон явдал нь нэгд, орос цагаан толгойн бүх үсгийг авах гэж хэрэгцээгүй олон үсэг авсанаас, хоёрт, халхын ярианы хэлэнд яг тохируулах гэж оролдсоноос шалтгаалсан гэж боддог. Учир нь нэгэнт хэрэгцээгүй илүү үсэг авсан болохоор тэр үсгээ эрхбиш хэрэглэх хэрэгтэй болсон. Бас тэгээд ардын ярианы хэлэнд яг тохируулах гэсэн болохоор гээгдэх, шилжих, гүйх зэрэг эгшиг байхаас өөр аргагүй болсон. Тэгээд гийгүүлэгчдийг эгшигт долоо, заримдаг өс гэх мэтээр ялгасан... Тэгэхээр олон янзын дүрэм, тайлбар хийх хэрэгтэй болжээ. Хэрэв тохирсон үсгээ сонгон авч түүн дээрээ дүрэмээ боловсруулсан бол манай дүрэм одоогийнхиос арай л хөнгөн хялбар, солиг саармаг зүйл багатай байхсан билээ..."¹⁶

БНХАУ-ын эрдэмтэн Эрдэнэтогтох:

¹¹ Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959.

¹² Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959, 8.

¹³ Ш. Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний зүй*, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1967, 125-р тал.

¹⁴ Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959, 9-р тал.

¹⁵ Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959, 6 - 7-р тал.

¹⁶ Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959, 12-р тал.

"...Энэ үсэг нь бичиг сурч хэрэглэгчид, ялангуяа хөдөлмөрчин түмэн үсэг бичгээ сурч хэрэглэхэд нь тэд нарын үүргийг улам хүндрүүлжээ. Манай нэг багшийн бүртгэлийг үндэслэвэл, 16 үсэг зөв хэрэглэж эзэмшихийн тулд 134 томъёололыг цээжлэх хэрэгтэй бөгөөд тэхгүй бол зөв хэрэглэж чадахгүй болдог..."¹⁷

гэх зэргээр үзэж дүгнэсэн байдаг. Энд дурдсан саналыг товчлон нэгтгэвэл доорхи хэдэн зүйлд эн тэргүүнээ хамаарна. Үүнд:

- Үгийн үндэс, дагаварын хэлбэрийг эвдэхгүй тогтвортой болгох;
- Шилжих, гээгдэх, балархай эгшигийн дүрмийг хэрэглэхээ болих;
- Эгшигт долоо, заримдаг есийн дүрэмийг хэрэглэхгүй болох;
- "Я"-гийн төрлийн үеийн үсгийг хэрэглэлгүй, бусад гийгүүлэгчийн нэгэн адил "Й" гийгүүлэгчид үндсэн эгшигүүдээр амь өгдөг болгох;
- Хатуугийн тэмдэг (ъ), зөөлний тэмдэг (ь)-ийг хэрэглэх шаардалгагүй

гэх зэрэг санал болно. Ингээд зарим нэгийнхи нь үндэслэлийг тодруулан тайлбарлая.

Үүнд: *ъ, ь* буюу хатуу зөөлний тэмдэгийн талаар ярилгүй орхих аргагүй. Дүрэмд "...эгшиг ч биш, гийгүүлэгч ч биш, дүгээр тэмдэг үсэг болно..." гэж тодорхойлсоныг дээр өгүүлсэн. Гэтэл хэрэглэгдэж буй нөхцөл, гүйцэтгэж буй үүргий нь хэлшинжлэлийн үүднээс авч үзвэл тэргүүн бус үеийн огцом эгшигийг орлосоор байгаа нь мэдэгдэнэ. Үүнд:

1. *морь, хонь, суурь, сургууль* гэх мэтийн үгэнд оруулж буй *ь* тэмдэг нь *хана, шинэ, сонгино, шөнө* гэх зэрэг үгийн эцсийн задгай үе төгсгөсөн огцом *а, э, о, ө* эгшигтэй зарчимын хувьд адил үүрэг бүхий огцом *и* эгшиг мөн бөгөөд *морь - моринд, захь - захидал, суурь - суурин* гэхэд мөнөөхи *ь* тэмдэг нь *и* эгшиг болж байгаа нь үүний батлагаа буюу. Ерийн аж амьдрал дээр ч "*Говь*", "*Арьсимпекс*" гэх зэрэг байгуулга нэрээ латинаар бичихдээ *Gobi, Arisimpex* гэх зэргээр *і* эгшигээр бичдэг нь ч давхар нутлагаа.

2. Я-гийн төрлийн үсгийг өмнөхи гийгүүлэгчээс нь саланги дуудах тохиолдолд *ъ, ь* хоёр тэмдэг нь салгах үүрэгтэй гэж "*Үсгийн дүрэм*"-д дурдаад *авъя, олъё, товъёё, хэлье, үзье, ирье* гэдэг үгийг жишээлэн авсан нь буй. Дурдсан хоёр тэмдэгийн "салгах" үүргийн тухай ярихад, үсгийн дүрмийн дагуу хэрэглэсэн байдал нь гийгүүлэгчийн ард я-гийн төрлийн үсэг залгасан мэт боловч, орчин цагийн монгол хэлний авиазүйн үүднээс бодвол "гээгдэх эгшиг" гэдэг дүрмээр бичилгүй орхисон огцом эгшиг бараг бүх үгэнд байгаа хэрэг бөгөөд ингэж бичих болсон нь я-гийн төрлийн үсгийг "эгшиг" гэж үзсэнтэй холбоотой буй заа. Гэвч я-гийн төрлийн үсэг нь дээр өгүүлсэнчлэн чухамдаа Г + Э гэсэн хослол билээ. "*Үсгийн дүрэм*"-ээр тийнхүү бичих болсон нь орос цагаан толгойн *ъ, ь* -ийг гүйцэтгэх үүргийнхи нь хамт яг хэвээр нь авчихсан болохоор ямар нэгэн "ажил үүрэг олж өгөх" хэрэгтэй болсонтой холбоотой юм. Гэтэл монгол хэлний хувьд, тэрхүү салгах үүрэг гэгч нь орос хэлэнд *объём, объединение, отъезд* гэх зэрэг үгэнд тохиолддог салангид дуудах шаардалгатай огт адилгүй зүйл бөлгөө. Тийм ч учраас монгол хэлний авиазүйн үүднээс энэ хоёр тэмдэг нь чухамдаа салгах бараг үүрэггүй, харин огцом эгшигийг тэмдэглэх огт өөр үүрэгтэй гэж үзэх бүрэн үндэс буй.

Иймд, *ъ, ь* тэмдэгийн оронд зохих зохих эгшигийг сэргээж *харая, хэлэе, үзэе, оёё* гэж бичдэг юм гэхэд бүрэн болохоос гадна монгол хэлний зөв дуудах ёсонд илүү зохицож "*Үсгийн дүрэм*" дэх олон зохиомол дүрэм, гажилт, тайлбар хэрэггүй болсноор уг "*Дүрэм*" хялбарших байсан билээ. Тийм ч учраас монгол хэлний гадаад дотоодын мэргэжилтэн нар ч энэ хоёр тэмдэгийг я-гийн төрлийн үсэгтэй хамтад нь хэрэглэхээ болиё гэхэд бүрэн бололцоотой бөгөөд дутагдах зүйл гарахгүй гэж удаа дараалан тэмдэглэсэн зүйл бий¹⁸.

Энэ бүхнээс үүдэж "балархай эгшигийн дүрэм"-ийн талаар товч боловч ярих шаардалга гарч байна. Авиагүйн үүднээс үгийн тэргүүн бус үеийн буюу өргөлтгүй үеийн богино эгшиг хэдийгээр хойшилох тусмаа улам огцомшдог боловч хоёр талынхаа

¹⁷ Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959, 8-р тал.

¹⁸ Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959.

гийгүүлэгчийг салгах үндсэн үүргээ гүйцэтгэсээр байдаг нь олон хэлнээ нийтлэг тохиолддог зүйл бөгөөд орчин цагийн монгол хэлэнд ч хүчин төгөлдөр үзэгдэл бөлгөө¹⁹. Лабораторийн нарийн багаж төхөөрөмжөөр хийсэн судлагаанаас үзэхүл халхын аялгуутай харьцуулахад илүү огцом, ерийн чихээр соносохуйяа бэрх мэт болсон халимаг болон баруун монголын аялгууны огцом эгшигүүд нь байгаагаар барахгүй, хэлний урдуур буюу араар гэдэг нь ч тодорхой танигддаг билээ²⁰.

Ийм учраас огцом эгшигийг үүрэггүй болсон гэж үзээд хасах буюу дураар хойш, урагш гүйлгэн шилжүүлэх нь хэлний хууль зүйг илэрхий зөрчсөн хэрэг болно. Хэвшинжийн хувьд нугармал хэлний бөлөгт багтдаг Англи, франц зэрэг хэлэнд ч өгүүлэх явцад үүрэггүй болсон мэт огцом эгшигийг байх ёстой байранд нь тэмдэглэсээр ирсэн нь утга учиргүй зүйл биш билээ. Шинэ үсгээр монгол хэлний *sonus*- гэдэг үгийн *-u-* эгшигийг гэж *сонс*- гэж бичихээр тогтоосон тул одоо бид *сонсох*, *сонсгол* гэх зэргээр тэмдэглэж буй боловч нэг үндэс бүхий *сонор* үг дээр арга буюу мөнөөхи гээсэн эгшигээ бичихээс өөр аргагүйд хүрдэг. Энэ тохиолдолд утга салахгүй байж болох авч хэл тогтолцоо гэдэг зарчимын дагуу бодож үзвэл *унагах* гэдэг үгийг *унгах* гэдэг хэлбэрээр бичсэнтэй агаар нэгэн буюу. Энэ тохиолдолд утга ялгана. Ийм жишлэнгээр *тэрэг* - *тэргэнд* гэх мэтээр огцом эгшигийг гээх, урагш хойш нь шилжүүлэх нь хэлний хууль зүйг бүдүүлгээр зөрчсөн хэрэг. Хэдий огцом боловч богино эгшиг тухайн байх ёстой байрандаа утга ялгах үүргээ тээсээр байгааг мартах аргагүй. Жишээлбэл:

<i>түргэдэх</i> (хэтэрхий түргэн байх)	- <i>түрэгдэх</i> (түрүүлэхэд хүрэх);
<i>хагсарах</i> (хатах)	- <i>хагасрах</i> (хагас дутуу болох);
<i>өргөдөх</i> (хэтэрхий өргөн байх)	- <i>өрөгдөх</i> (өрүүлэхэд хүрэх)

гэх мэт. Авиагүйн хуулиар (*m + c*) байх тохиолдолд шууд *c* болох ёстой бөгөөд монгол хүн *утсаар ярих* гэхэд *уцаар ярих* гэдэггүй нь энэхүү *утсаар* гэсэн хэлбэрийн *m*, *c* хоёр гийгүүлэгчийн завсар огцом эгшиг байж, хоёр талынхаа гийгүүлэгчийг салгаж, утга ялгах үүргээ гүйцэтгэсээр байгаагийн баримт бөлгөө.

Харин огцом эгшигийг ийнхүү шилжүүлэх, гээх зарчим нь *сон* - *сна*, *огонь* - *огня*, *вошь* - *вши*, *кошка* - *кошек* гэж хувирдаг орос зэрэг нугармал хэлний уг онцлогт нь бүрэнээ тохирохоос биш монгол зэрэг хэвшинжийн хувьд залгамал хэлнээ үл тохирох зарчим гэдэг нь хэлшинжлэлийн онолын үндэслэлтэй зүйл билээ.

Чухам иймээс академич Ш.Лувсанвандан 1967 онд хэвлүүлсэн номдоо тэргүүн бус үеийн огцом эгшиг байх ёстой газраа байж байхаар дүрэм тогтоох хэрэгтэй байсныг тэмдэглээд "*Үсгийн дүрэм*"-д эгшигт долоо, заримдаг есийн дүрмээр хоёр өөр дуудалгатай хоёр өөр үгийг ижил хэлбэрээр *дэвс*, *дэрс*, *нэрс*, *дүрс*, *элс*, *ард* гэх зэргээр бичих болсныг шүүмжлээд:

"...хэрэв *д*, *с* хоёр гийгүүлэгчийг эгшигт гийгүүлэгчийн бөлөгт багтаасан бол ширдэг дэвс,
эмээлийн дэвсэ,
гал дүрэс гээд асах,
амьтаны дүрсэ,
хүний нэрэс,
нэрсэ жимс,
гишүүнд элсэ-,
шороо элэс,
уулын арда,
арад түмэн гэж бичих байжээ..."

¹⁹ Ш. Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний зүй*, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1967, 27-р тал.

²⁰ *Опыт совершенствования алфавитов и орфографий языков народов СССР*, Москва, 1982, стр. 129.

хэмээн тодорхой тэмдэглэсэн нь эрдэм шинжилгээний хувьд ч, практик ач холбогдолын хувьд ч анхаарахгүй байхын аргагүй санал билээ²¹.

Монгол бичгийн хэлийг ярианы хэлнээс холдсон гэж дээд газраас гарсан тогтоол зарлигийн зүйлд шүүмжилсэн тул шинэ бичгийг ярианы хэлэнд ойртуулах гэсэн "эн тэргүүний" зорилгодоо зохиогч авгай итгэлтэй хөтлөгдөж шинэ үсгийн дүрэмдээ орос хэлний нэгэн адилаар авиазүйн зарчмыг илүүтэй баримтласан ажээ. Тийм ч учраас эгшигт долоо, заримдаг есийн дүрмийг зохиож, тэргүүн бус үеийн огцом эгшигийг гээх буюу шилжүүлдэг болгож, монгол хэлний хувьд ч, бусад хэлний хувьд ч нийтлэг шинжтэй байдаг бөгөөд тус тусдаа нарийн ялгаатай *н, з* хоёр гийгүүлэгчийг ялгалгүй орхих байдлаар дүрэмжүүлсэн нь хэлэхийн төвшинд ярианы байдалд ойртсон мэт санагдавч хэлний төвшинд үгийн үндэс, дагаварын тогтолцоог янз бүрээр эвдэхэд хүрч, монгол хэлний хувьд энэхүү сөрөг үзэгдэл нь яв явсаар ярьж байгаагаараа (галиглаж байгаа юм шиг) бичих явдлыг хөхиүлэн дэмжихэд хүргэсэн ажээ. Сүүлийн үеийн зарим нэгэн жишээг баримтаар дурдая.

"...хийнэ гарсан дугуй шиг..."²²

"...нэг их ач холбогдолгүй юм..."²³

"...нэг их итгэдэггүй..."²⁴

"...байх юм аа хөө..."²⁵

"...Ийм байж болохгүй ш тээ"²⁶

гэх зэргээр 1990-ээд оноос бичдэг болсон бөгөөд одоо үүнээс ч долоон дор болсон гэхэд маргах хүн гарахгүй буй заа. Дээрхи дөрвөн жишээндэхи хар дуудалгаар бичсэн үгийг залруулах бөгөөс

"...хий нь гарсан дугуй шиг..."

"... нэг их ач холбогдолгүй юм..."

"...нэг их итгэдэггүй..."

"...байх юм аа хөө..."

"...Ийм байж болохгүй шүү дээ"

гэсэн үг болно. Ингэж дур дураараа бичсэн хэлбэрийг мэдэхгүй буюу гадаадын хүн толь бичгээс эрнэ гэхэд жинхэнэ утгаараа хэзээ ч олдохгүй, хэлбэрийн хувьд дүйх үг олдсон ч огт өөр утгатай л байж таарна!

Монгол хэлний хоёр зүйлийн *н* гийгүүлэгчийг ялгахаа больж ганц үсгээр тэмдэглэх болсноор сүүлийн үед *Балданы, Ринчений, Ёндоны* гэх үү? *Балдангийн, Ринченгийн, Ёндонгийн* гэх үү? аль нь зөв бэ? гэдгийг ялгаж чадахгүйд хүрсэн билээ. Энэ явдал нь монгол хүн англи, солонгос зэрэг гадаад хэлээр тухайн хоёр авиаг зөв дуудаж бичихэд бэрхтэй болсныг ч хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Үүнчлэн орос хэлний *у* эгшигийн дуудалгыг шинэ бичигийн *ү*-д сольж оноосон нь анх орос хэл үзэж буй монгол хүний зөв дуудалгад хүндрэл учруулах нэг шалтгаан болсон бөгөөд үүнийг хэлээд буруутаж байсан баримт ч буй²⁷.

"*Фонологийн зарчмууд*" гэдэг алдарт бүтээлийн зохиогч, дэлхийн том хэлшинжлэлчийн нэг хэмээгддэг Н.С. Трубецкой (N.S. Troubetskoï) зөв бичихзүйд үл тохирох зарчим хэрэглэснээр үгийн язгуур, үндэс, хэлбэр хэрхэн "зэрэмдэглэгдэж", хэрхэн

²¹ Ш. Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний зүй*, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1967, 125-р тал.

²² "Утга зохиол" сонин, 1991. 1. 4, N. 1.

²³ "Үг" сонин, 1991, 4. 1-8, N. 12.

²⁴ "Ардчилал" сонин, 1991, 4. 1-7, N. 13.

²⁵ *Сэтгэлд шингэсэн дууны шилмэл түүвэр*, Улаанбаатар, 1991, 166-р тал.

²⁶ "Дээдсийн амьдрал" сонин, 1989, N. 01 (001), 6-р тал.

²⁷ *Намын Төв Хороонд ирсэн мэдээллээс*, - Цог, 1991, N. 6, Улаанбаатар, 120-р тал.

"ёсон бус бичилгэ" гарч ирдэгийг халимаг монгол хэлний жишээн дээр онцлон тэмдэглэсэн байдаг билээ²⁸.

Монгол уламжлалаасаа салж хагацчихсан хүмүүсийн тухайд энэ бүх зүйл санамсартай буюу санамсаргүй байдлаар ажиглагдахгүй байсан байж болох боловч, юмны цаад наад учрыг ялгаж чаддаг манай ухаалаг сэхээтэнүүд ажил амьдралынхаа туршилга дээр үүнийг аль хэдийнээс мэдэрсээр байсан бөлгөө.

Төрийн шагналт зохиолч Б. Явуухулан, Ч. Лодойдамба нар монгол бичгээр бичсэн бүтээлийг шинэ үсгээр буулгахад найруулга нь эрс мууддаг тухай²⁹, Н.Жанцанноров "Хөх торгон дээл" гэдэн дуун дээр жишээлэн шинэ үсгээр буй шүлгийн зохиолыг унших, дуулах явцад үеийн тоо нь бичилгэтэйгээ огтхон ч тохирдоггүй болсон тухай удаа дараалан ярьж байсан нь чухамхүү Н.С. Трубецкойн хэлсэнчлэн, монгол үгийн зэрэмдэглэгдсэн хэлбэртэй холбоотой хэрэг билээ.

Ийнхүү хэлний хууль зүйг анхааралгүй, хэлдэгээрээ бичих гэсэн зарчим нь өнгөцхөн харахад бодол шаардаж толгой зовоохгүй амархан мэт боловч цаагуураа ямар язгуурын, ямар үндэстэй, ямар үгийн, ямар хэлбэрийг хэрхэн хэрэглэж байгаагаа огтхон ч бодохоо больж, бодохоо больсоноор тархи толгой дахи эх хэлний бодол мэдрэмж сарнин саарахын үүдийг нээдэг ажээ. Захын жишээ дурдахад, одоо ихэнхи хүн *ажиллагчид - ажиллагсад, бохирдох - бохиртох* гэдгийг ялгааг ухахгүй болж, уугуул монгол үг, монгол нэр томъёогоо байсаар байхад хазгай дуудсан харь үгээр чамирхах явдал газар авлаа. Монгол хүн юм чинь монгол хэлээ мэдэлгүй яах вэ? гэж боддог хүн ч олширч, хэлшинжлэл гэдэг тусхай ухаан, тусхай мэргэжил байдагийг үл хайхарч, монгол бичигт д, т хоёр нэг хэлбэртэй юм чинь, *бохирдох, бохиртох* хоёр адил байх ёстой гэх зэргээр цээжний вангаар мэдэмхийрэн тайлбарлах болжээ. Гэтэл монгол бичгийн хэлнээ *бохирдох* гэдгийг *бохирдаху, бохиртох* гэдгийг *бохиртуху* гэж ялгаж бичдэг бөгөөд энэ хоёр хэлбэр нь *үсдэх* (гээзэг үснээс нь зуурах), *үстэх* (ямар нэгэн зүйл нэгшин муудсаны учир үс мэт зүйл ургах) гэдэгтэй адил утга ялгаж *бохирдох* нь бохирын учир тохиромжгүй болох, *бохиртох* гэвэл улмаар бохир болох гэсэн утга тус тус илэрхийлдэгийг Я. Цэвэлийн "*Монгол хэлний товч тайлбар толь*" бичгээс үзэж болно³⁰. Бас Ш. Лувсанвандан профессор ч эдгээр дагаварын тухай бүтээлдээ тусхайлан дурдсан байдаг билээ³¹. Үүнчилэн монгол хэлний бүтэцийн үүднээс эгшиг зохицохын ёсоор хоёр хувилбартай ганц дагаварыг найман хувилбартай болгосон зэрэг жишээ буй тул хэлшинжлэлийн олон эрдэмтэн үгийн язгуур, үндэс, үг бүтээх дагаварыг тогтвортой болгох санал тавьж байсан хэрэг.

Энэ мэтээр монгол хэлний зүй тогтоолыг гажиж буруу зөрүү ярьж бичсэн олон үг монгол хэл эхлэн сурч судлаж буй зарим хүнд ч нөлөөлж эхлэжээ. Тухайлбал: Китамүра Акихидэ гэдэг ажилсаг япон залуу монгол хэл сурч судлаж байхдаа "*Япон монгол англи толь*" бичгийг цувруулан гаргаж түүндээ Я. Цэвэл, Хангин Гомбожав, Ш. Озава, П. Фитце нарын толь бичигт ороогүй үгийг хамран багтаахыг эрмэлзжээ³². Уг тольд орсон үгийг ажиглахад түрүүн гарсан тольд буй *арман, баринтаг, биндэръя, гамбир* гэр зэрэг үг байгаагаас гадна *биднүүс, дээхэн* гэх мэтийн хар ярианы хэлбэр, *жаншил, шорлого* (шорлог) зэрэг нутгийн аялгууны тольд оруулмаар үг, түүнчлэн буруу хэвшсэн үгийн толь гэж зохиосон бол оруулж болохоор *байл, байзах, нуурхан, эрмэлзлэл* гэх зэрэг монгол хэлний зүйг гажсан хэлбэрүүд, онолдох монгол үгээр нь хэрэглэсээр байгаа *план, проспект, пудр* гэх зэрэг харь үг цөөнгүй тохиолдох ажгуу. Үүнээс гадна хар ярианы хазгай дуудалгаар гарч ирсэн цөөн бус үгийн хэлбэрийг тухайн үгтэй нь адилхан утгатай гэдэг тэмдэгээр заан оруулжээ. Үүнд:

²⁸ N.S. Troubetskoï, *Grundzüge der Phonologie*, Prague, 1939; П.Ц. Биткөөв, *Языки и письменные системы монгольских народов*, Москва-Элиста, 1995, стр. 159-160, 166.

²⁹ *Их Тэнгэрийн харшид болсон яриа*, - Цог, 1990, N. 5, Улаанбаатар, 129, 134-р тал.

³⁰ Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, 95-р тал.

³¹ Ш. Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний бүтэц*, Улаанбаатар, 1968, 144-145-р тал.

³² Akihide Kitamura, *Mongolian - Japanese - English Dictionary* (of words which are not contained in other dictionaries), Ulaanbaatar* 1993 ...

гэх зэрэг үгийг адил утгатай хэмээн үзжээ. Хэл тогтолцоо гэдэг зарчмын дагуу авч үзвэл, *ангаах анагаах* хоёр ижил утгатай бөгөөс *унгах унагах* хоёр адил болох ёстой.

Судлагааны бүтээлд тавих шаардалгын үүднээс залуу монголчийг зэмлэж болох боловч овоо босгоогүй бол шаазгай яаж суух вэ? гэдэгчлэн бидний монголчууд монгол хэлнийхээ зөв бичихзүй, зөв дуудахзүйг баримтлахгүй, монгол хэлнийхээ хууль зүйг өөрснөө эвдэж ийнхүү ёсон бусаар ярьж бичиж байгаа тул түүнийг буруутгах нь нэг бодлын утгагүй хэрэг бөгөөд харин ч түүний бүтээл нь ялангуяа залуучуудын дунд монгол хэлний зүй тогтол хэрхэн эвдэрч байгааг судлах хэрэглэгдэхүүн болж байгаагаараа зохих ач холбогдолтой гэж үзэх үндэс буй.

Орчин цагийн монгол хэлний иймэрхүү байдал нь нөгөө талаас улс төрийн учир шалтгаан буюу монгол хэлний нийгмийн хэрэгцээг байнга багасгаж, олон нийтийн эх хэлний боловсролыг үл хайхрах болсонтой холбоотой юм. Сүүлийн 40-өөд жилд бүх шатны сургуульд монгол хэлний хичээлийн эцсийн үр дүн ямагт буурч, сургууль төгсөх, их дээд сургуульд элсэх шалгалтанд мэргэжил үл ялган нийтээр нь орос хэлний шалгалт заавал өгүүлдэг, эрдмийн зэрэг хамгаалах зохиолыг хураангуйнхи нь хамт заавал оросоор бичүүлдэг, нам төрийн баримт бичгийг оросоор эхлэж боловсруулаад дараа нь монголчлодог, их дээд сургуулийн хичээлийг орос хэлээр заах тогтоол заалт гарч, албан тушаал дэвшихийн гол хэмжүүр нь орос хэлний мэдэлгэ болж ирсэн зэрэг нь үүний батлагаа бөгөөд энэ бүхэн нь эртнээс боловсруулсан алсын далд зорилгын хаялга байсан ажээ. 1990-ээд оноос хойш ч төр засагийн зүгээс монгол хэлний нийгмийн шаардалга хэрэгцээг дээшлүүлэх талаар ахиц бараг гарсангүй.

МАХН-ын ҮШ Их хурал дээр монгол бичгийг халан өөрчлөх яриа гарснаас хойш улс монголоо гэсэн төрийн зүтгэлтэн, үндэсний эрдэмтэн сэхээтэн нар ийм өөрчлөлт нь алс хэтдээ сайн юманд хүргэхгүй гэдгийг хэлж бичиж байсан боловч тухайн үеийн Сталинч бодолгод дулдуйдсан улс төрийн зүгээс нухчин дарахаа ил тэд тунхагласан байна. Тухайлбал: 1940 онд Ю. Цэдэнбал даргатай шинэ үсгийн комиссын илтгэлийг авч хэлэлцсэн хурал дээр Х. Чойбалсан хэлсэн үгэндээ:

"...Монгол бичгийг феодал лам нар болон харгис феодалийн засаг дарлагдсан ард түмнийг дарлан мөлжих зэвсэг болгон хэрэглэж байжээ... Шинэ үсгийг эсэргүүцэгч аливаа нэгэн үндэсний үзэлтэн, бутцохигдсон феодал лам нарын үлдэгдлийн эсэргүүчүүдэд хамгийн эрс хатуу цохилтыг өгч тэмцэх хэрэгтэй..."³³

гэж онцлон анхааруулсан байдаг. Маршал Х. Чойбалсаныг нас барсаны дараа ч, нэгэнт Ю. Цэдэнбал шинэ үсгийн комиссын дарга байсан тул түүний албан тушаалдаа байсан бүхий л үеийн туршид буюу бараг 1985 оныг хүртэл шинэ үсэгтэй холбогдсон аливаа асуудалыг түүний нэрээр түрий барьж "...1941 онд Ю. Цэдэнбал даргатай шинэ үсгийн комиссоос мөн дүрмийг батлаж гаргасан тогтоолын дотор "манай шинэ үсгийг зөв бичих дүрэм нь монголчуудын халхын төв аялгуун дээр дуун ухааны судлал ба үг бүтэх ёсыг баримтлаж ардын ярианы хэлэнд ойроор зохиогдож чадсан" гэж заасан юм..." гэх зэргээр өөр санал

³³ *Хорлоогийн Чойбалсан*, Үнэн сонин, 1989. XII. 23, N. 306, II нүүр. Зөвлөлтөд монгол бичгийг "феодално-теократическое письмо" гэдэг нэр хаяг зүүж байсныг *Вестник Института культура* (Москва, 1937, N. 2-3, стр. 15) гэдэг сэтгүүл болон Цэрэн-Анчик Дугар-Нимаевын докторын зэрэг хамгаалсан *Исследование литературных источников на уйгуро-монгольской письменности* (Улан-Удэ, 1992, стр. 25) гэдэг бүтээлийн хураангуйгаас тус тус үзэж болно.

бодлыг нухчин дарж ирсэн байдал илэрхий харагдах болсон³⁴ бөгөөд үүнийг ажиглан тэмдэглэсэн зүйл ч хэвлэлийн хуудаснаа гарч байлаа³⁵.

Гэвч жинхэнэ хэлшинжлэлч цөөн бус эрдэмтэн, багш нар үсгийн дүрэм (чухамдаа үсгийн дүрэм биш, зөв бичихзүй)-ийг засч сайжруулах, боловсронгуй болгох талаар санал бодлоо илэрхийлсээр ирсэн боловч ажил болсон нь нэгээхэн-бээр үгүй билээ. 1957 оны зун Монгол, Зөвлөлт,Хятадын хэлбичгийн эрдэмтэд шинэ үсгийн дүрмийн асуудлаар зөвлөгөөн хийж нийт 20 гаруй хүн үг хэлснийг үзвэл Зөвлөлтийн төлөөлөгч Г.Д. Санжеев, үсгийн дүрэм зохиогч болон дунд сургуулийн багш Цэвэгжав гурваас бусад нь тухайлбал: Б. Ринчен, Э. Вандуй, Эрдэнэтөгтох, Ш. Лувсанвандан, Б. Содном, А.Лувсандэндэв, Н. Жамбалсүрэн, Ц. Содном-юнрэн, Цэрэндулма, Б. Цыдендамбаев, Я. Цэвэл, Д. Чойжалсүрэн, Чингэлтэй, Л. Мишиг, Гэрэлцог, Н. Надмид, Т. Пагва нар уг дүрмийг засч сайжруулах шаардалгатай гэдгийг шинжлэх ухааны тодорхой үндэслэлээр тайлбарласан байдаг³⁶. Бид дээр дурдсан эрдэмтдийн хэлсэн үгийн зарим хэсгийг эшлэсэн тул энд нурших явдалгүй. Харин Г.Д. Санжеев авгай:

"...шинэ үсгийн гавъяа ихийг тэмдэглэх хэрэгтэй... Дүрэмд ямар бэрхшээл байгааг тодорхой баримтаар нотлож чадахгүй байна. Цагаан толгой ямар ч байсан яах вэ! Дүрмийг 5-6 жилийн дараа их шуугиангүйгээр хэл аялгуу ажлын туршилгаа судласны үндсэн дээр боловсруулж тогтоох нь зүйтэй..."

гэж хэлсэн нь дурдсан эрдэмтэдийн шинжлэх ухааны үндэслэл бүхий тодорхой саналыг огтхон тоогоогүйн батлагаа бөгөөд тэрхүү үг нь уг зөвлөгөөний эцсийн дүгнэлт болсон байна³⁷.

Үүнээс таван жилийн дараа 1962 онд МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю. Цэдэнбал:

"...Шинэ үсэгт шилжсэн нь нийт хөгжлийн хувьд дэвшилттэй хэрэг. Нам ингэж үзсээр ирсэн. Одоо ч хэлж байна....Ирээдүйд нэг бичиг, нэг хэлтэй болох онол бий шүү дээ! Энэ бол биелэгдэх зүйл..."³⁸

гэж мэдэгджээ.

Энэхүү мэдэгдэл болон бидний дээр өгүүлсэн зүйлийг нэгтгэж үзвэл, монгол бичгийг халуулсан, орос цагаан толгойг хэвээр нь авч, зөв бичихзүйн хувьд, монгол хэлний хэвшинжид үл тохирох зарчмыг баримтласан, монгол хэлний нийгмийн үүргийг бууруулсаар ирсэн зэрэг нь цөм нарийн боловсруулсан бодолгын удаа дараагийн үе шат болж байж уу даа гэсэн бодлыг эрхгүй төрүүлнэ.

Ю. Цэдэнбал авгайн дээр өгүүлсэн "онол" гэдэг нь мөн чанарын хувьд И.В. Сталины "хэл хутгалдахын онол" гэгчтэй яг таг тохирдог гэдгийг дурдвал зохино. Тэр онолын мөн чанар нь юу байв? гэвэл доорхи мэт болно. Үүнд:

"...Хэрэг дээрээ хэлний хутгалдахад уул хутгалдсан хэлний аль нэг нь ялж хэлнийхээ зүйн байгуулал хийгээд үсгийн үндсэн санг хэвээр хадгалж хөгжлийнхөө дотоодын хуулиар цааш хөгжиж, харин нөгөө ялагдсан хэл нь алгуурханаар чанараа алдаж яваандаа мөхдөг байна... Жишээлбэл: орос хэл түүхт хөгжлийнхөө явцад бусад олон угсаатны хэлтэй хутгалдаж хэзээд ингэж ялсаар иржээ..."

³⁴ Ц. Дамдинсүрэн, *Үгийг нэг мөр болгон бичиж журамлах асуудалд*, - Үнэн сонин, 1983. XI. 3, N. 211 (15547), IY нүүр;

³⁵ Ү. Чимэгбаатар, *Хэлний гэм хэдэн үеэ бүрэлгэнэ*, - Ардчилал, 1990. VIII. 21-31, N. 15. IY нүүр, Y эгнээ.

³⁶ Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959.

³⁷ Ш. Барайшир, *Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959, 14-р тал.

³⁸ *Их Тэнгэрийн харшид болсон яриа*, - Цог, 1990, N. 5, Улаанбаатар, 146-р тал.

"...Ийм нөхцөл байдлын дотор зөвхөн ялсан, ялагдсан хэлнүүд байж болох нь ойлгомжтой хэрэг юм. Хоёр хэл хутгалдсаны дүнд шинэ хэл бий болдоггүй харин нэг нь ялж, нөгөө нь ялагддаг..."

"...нийтийн нэгэн хэлэнд нийлэх явдалд холбогдсон томъёоллын тухай гэвэл: ...дэлхий дахинд социализм ялсны дараа, ... үед холбогдож байна..."³⁹

гэж онцлон тэмдэглэсэн байдал нь хэлний талаархи түүний бодолгын уг учирьг тодруулан өгч байгаа юм.

Энэ бүхнээс үзвэл бүх нийтээр ямаршүү нэг хэл, ямаршүү нэг бичигтэй болох тухай онол байсан нь тодорхой болж байна биш үү!

Халуун эх оронч, түүхч, Монгол Улсын Ерөнхий сайд агсан Анандын Амар гуай энэ бүх учир холбогдлыг эхнээс нь нарийн мэдэж байсан учир МАХН-ын IX Их хурал дээр:

"...Монгол бичгийг өөрчлөж халж болохгүй... Монгол үндэсний хэв журам, хэвшиж тогтсон зан заншлыг өөрчлөж болохгүй.... Хэрэв бид нар монгол хэлээ мартаад бусад улсын хэлэнд татагдан орох аваас Монголын үндэс угсаа мөхнө..."⁴⁰

гэж эрс хатуу хэлж байсан нь хилс хэргийн учир, хүний газар, гүжир цаазын аманд, амь биеэ гээх олон шалтгааны лав нэг нь болсон буй заа гэж эрхгүй бодогддог.

Шинэ үсгээр гарсан зүйлийг үзэхэд дүрмийн сүлжилдсэн олон заалтыг зөрчиж буруу бичсэн, хэдэн янзын бичилгэтэй болчихсон хэдэн зуун үг гарч ирсэн бөгөөд үүнийг нэгтэн засах зорилго бүхий улсын комисс удаа дараа байгуулагдаж байсан боловч хэсэг хугацааны дараа уг ажлыг хэн нэгэн том албан тушаалтан замхруулдаг байсныг тийм комисст нарийн бичгийн даргаар ажиллаж байсны хувьд энэхүү номын зохиогч одоо гэрч болж үлджээ. Ер энгийн жишээ татахад хүний нэр, тогтсон нэр томъёо, оноосон нэрийн эгшигийг шилжүүлэхгүй гэсэн дүрэм байдаг боловч ... "Үнэн" сонины толгойд ...*Засгийн Газрын сонин* гээд л гээчихдэг байсан билээ. Энэ мэтчилэн дүрэм зөрчисөн бас бус зүйлийг Шинэ үсэг зохиосон комиссын даргын гар бичмэлээс ч хялбархан олж болдог.

Шинэ үсгийг албан ёсоор хэрэглэсэн үеэс 1990 оныг хүртэлхи хугацаанд хэвлэн нийтлэсэн ном дэвтрийн зүйл асар их бөгөөд энэ үед бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгасан нь шинэ үсгийн ач гавъяа гэж үздэг хүн буй. Гэвч энэ үед хэвлэгдэн гарсан бүхий л зүйл нь агуулга сэдэвийн хувьд тухайн үеийн үзэл суртлын хэмжүүрт зохицсон зүйл л байсныг бид мэдэхээс гадна ХХ зууныг "шинжлэх ухаан-техникийн зуун" гэж нэрлэж ирсэн цаг үеийн үүднээс авч үзвэл монгол бичгээр ч бай, латин үсгээр ч бай, шинэ үсгээр ч бай тэр хэмжээний зүйл хэвлэгдэх бололцоотой байсан гэж хэлж болно. Үүнээс гадна, монгол бичгээр бидний үед тээн авчирсан өв сан гэвэл өнөөдөрийн мэдэхийн хирээр лавтайяа 800-аад жилийн туршид бүтээсэн тэр цагийнхаа аж амьдралын бүхий л салбарыг хамарсан асар их туурвил бий.

Хэрэвзээ нам төрийн зүгээс шинэ үсэгт тайлуулах гэж шахсан шигээ үндэснийхээ монгол бичигт сургах гэж хүчлэсэн бол, шинэ үсэгийг цоо шинээр дэлгэрүүлэх гэж зарсан шиг хөрөнгө хүчийг монгол бичигтээ зарцуулсан бөгөөс хуучин хэрэглэж ирсэн, үндэснийхээ уламжлалт бичгийг нийтээр сурах боломж илүү ч байж болохсон гэж бодогддог тул хүн хүн өөр өөрийнхөөрөө дүгнэх буй заа!

³⁹ И. Сталин, *Хэлний шинжлэлд марксизмын холбогдох нь*, Улаанбаатар, 1950, 52-53, 96-97-р тал.

⁴⁰ *Анандын Амар*, - "Засагийн газарын мэдээ" сонин, 1993. Х1. 26-30, N. 78, VII нүүр.

1945 он 1-р сар 18- өдөр
No 409

У.Б.Х Шинжлэх

уханы хүрэлэнгийн албан
хягч Ядамжав ны Цэвэл
улсын комиссын шалгалт ар шинэ үсэгт
сайн мэдэгчэр тайлагдаж улсын бичиг
мэдэгчийн тэнд оруулсан тул Ардыг

Гэгэрүүлэх Ямнās үнэмлэхийг олгов

Шалгалтын комиссын

Дарга Чулун Бат

Гишүүд Лутдо

Бүрнэ Батор

Шинэ үсэгт тайлагдагчдын үнэмлэхийн хуулбар



1941 онд оросжин кирилл үсгээр гарсан
анхны албан ёсны баримт - төгрөгийн бичээс

МОНГОЛ ҮСЭГ БИЧИГИЙН ЭВХМЭЛ ХЭЛБЭР

Монгол туургатны хэрэглэж ирсэн олон зүйл бичиг үсгийн дурсгалыг үзвэл бичих журмын хувьд хэрэглээний зорилго, тухайн цаг хугацааны шалтгаацилаас үүдэж хэдэн зүйл ялгаатай байжээ. Үүнд:

хичээнгүй бичиг,
таталган бичиг,
эвхмэл бичиг

хэмээн хувааж болох ажээ. Хичээнгүй хэлбэрээр албан ёсны зэрэг хүндэтгэлтэй зүйлийг бичнэ. Таталган хэлбэрээр эх зохиох, амин хувийн тэмдэглэл, навтарга ноорог зэргийг бичих ба цаг шахамдсан давчуу үед үг үсэг алдалгүй тэмдэглэх зэрэгт хэрэглэнэ. Таталган хэлбэр нь ацаг шүдтэй таталган, ацаг шүдгүй таталган гэсэн дотроо хоёр зүйл буй. Ацаг шүдгүй таталган хэлбэрийг бичгийн соёл боловсролын үүднээс төдий л таашаадаггүй бөгөөд сайн бичээчийн "чаддаггүй гурван зүйл"¹-ийн нэг нь энэ хэмээлцэмүй. Эвхмэл хэлбэрийг тамга, тэмдэг, захиралга, гарын тэмдэг (ex-libris), хос уянга, үгийн сүлжээ тэргүүтэн бичиг номын хэрэг болон хана туурганы хивсэн дээрхи үгийн сүлжээ зэрэг гоёл чимэглэлийн зүйлд хэрэглэнэ. Монголчуудын үсэг бичгийн эл хэлбэрүүд болон түүний зарчим, ёс журам нь хэдийгээр өвөрмиц боловч хэрэгцээ шаардалгын үүднээс авч үзэхүл бусад гадаадын улс түмний бичгийн соёлтой эгээ адилхан бөлгөө.


Номын энэ бөлөгт монгол үсэг бичгийн эвхмэл хэлбэрийн ерөнхий журам тогтолцоог гаргахын хамт бусад олон улсын хэрэглэсээр буй эвхдэг болон угалзладаг хэлбэрээс ялгарах байдлыг цухас ч болов дурдахыг хичээлээ.

Үүнд, монголчуудын хэрэглэж ирсэн олон зүйл бичиг үсгийн эвхмэл болон угалзан хэлбэр нь лавтайяа найман зуун жилийн уламжлалтай боловч харьцангуй хожуу үеэс анхааран судлаж улмаар баримтлаж ирсэн гол гол зарчмын нь гаргасан гэж хэлэх үндэс буй. Гэвч дурдсан бүх хугацаанд амьдрал ахуй дээр эвхэх уламжлал тасраагүйгээр үл барам тухайн бичээч-зураач нарын ур ухаанаар нарийсан хөгжиж баримтлан дагах тодорхой зарчим ч бүрэлдэн тогтжээ. Түүнээс гадна, шашин суртал, төр нийгэмийн шаардалга болон тухайн бичиг номын хүмүүсийн сонирхол зэргээс үүдэж самгард, төвөд, хятад, манж зэрэг харь үсгийг уран барилга, сүм хийдийн чимэг, ном судар, албан бичиг тэргүүтэнд эвхэж хэрэглэдэг уламжлал байсан гэдгийг дурдалгүй орхих аргагүй бөгөөд үүнд тухайн бичиг үсгийн эвхдэг журмыг даган мөрддөг байсан ажээ.

Лавтайяа бидний гарт хүрэлцэн ирсэн баримт сэлтээс үзэхэд монголчуудын хэрэглэж ирсэн олон зүйл бичиг үсгийн эвхэх, угалзлах уламжлалыг их л эртнээс судлаж хэрэглээний шаардалгаар үлгэр загварыг хэдийнээ буй болгожээ. Тухайлбал: Их Юан гүрний гэхэд "*Meng-gu zi-yun*" гэдэг номд дөрвөлжин бичгээр хэрхэн эвхэх байдлыг журамлан үзүүлсэн тусгай бөлөг байдаг (3-р хавсралтыг үзмүү) ба "*Yig rigs sna chogs kyi mo me tog phren ba zes ba zes ba bzugs so*" буюу "Үсэгийн аймаг элдэв зүйл цэцэгсийн

¹ Монголын бичигийн мэргэдийн дунд жинхэнэ бичээч хүний чаддаггүй гурван зүйл бол нэгд, бүрүү бичиж чаддаггүй, хоёрт, мүүхай бичиж чаддаггүй, гуравт, татлахдаа ацаг шүдгүй бичиж чаддаггүй эдгээр болой хэмээлцэнэ.


эрхэс" гэдэг сударын дотор төвөд үсэгийг хэрхин дөрвөлжлөж эвхэх загвар хийгээд монгол, хятад үсгийг угалзлан эвхэх байдалыг үзүүлсэн нь буй.



"Үсэгийн аймаг элдэв зүйл цэцэгийн эрхэс" гэдэг сударын хуудаснаас

Харин XIX зууны сүүл, XX зууны эхин үеэс монгол болон гадаадын эрдэмтэд монгол бичиг үсгийн эвхэх, угалзлах ёсыг анхааран судласан, дотоод зүй тогтолыг нь тодруулсан зохиол бүтээл ч цөөнгүй гарчээ².

Өнөөдөр бидний мэдэхийн хэрээр ийм биет баримт Хятан улсын үеэс эхлэн элбэг олддог боловч энэ нь үүнээс өмнө огт байгаагүйн батлагаа лав биш.



Дундговь аймагийн Эрдэнэдалай сумын төвд байсан уран барилгын чимэглэлийн нэгэн хэсэгт самгардаар эвхиж бичсэн байдал

² Batuvčir, *Mongᠣl ᠤᠰᠦᠭ-ᠤᠨ mᠣrden daᠵuriyaqu ᠤliger*, MKBSBO, Ulaanbaatur, 1934; Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй, дэд дэвтэр, Авиан зүй, Улаанбаатар*, 1966; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972; Gy. Kara, *Writing, symbols and ornaments on two Mongolian scrolls*, - *Tractata Altaica*, by Denis Sinor, Wiesbaden, 1976, pp. 345-353.

Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын бичиг үсгийн эвхмэл хэлбэр*, - *Studia Mongolica*, Tom. IV(12), Fasc. 15, Ulaanbaatar, 1976, pp. 339 - 360; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1981, х. 130-145.

Монголчуудын бичиг хэргийн түүхэнд холбогдох биет хэрэглэгдэхүүнээс үзэхэд лавтайяа XIII-XIV зууны албан бичигийн тамгыг эвхэж бичсэн баримт Европ, Ази дахинаа хадгалагдан буй нь бидний өнөөдрийн мэдэлгийн хэрээр эвхмэл бичгийн хамгийн эртнийхи гэж хэлж байгаа ч өмнө байгаагүй гэсний нутлагаа бас биш. Ийнхүү бичиг хэргийн хүрээнд эвхдэг, угалзалдаг уламжлал тэр үеэс өдгөө хүртэл үргэлжилсээр бөлгөө³. Дараа нь Юан улсын үед монгол дөрвөлжин хийгээд хятад үсгийг эвхэж бичсэн зүйл гэвэл тамга, тэмдэг, цаасан мөнгөн тэмдэгт, хөшөөний бичээс зэрэгт олон буй.

Монголчуудын эвхмэл бичгийн дурсгалыг үзэхүл монгол, дөрвөлжин, соёмбо болон монгол бичгээс эх авч, зарим нутагт хар худма⁴ хэмээгддэг манж үсгийн эвхмэл хэлбэр элбэг тохиолддог боловч энэ хэр тод үсгийн эвхмэл хараахан олдоогүй байгаа нь холбогдох бөлөгт дурдсанчилан уг бичигийн үсэгзүйн учир шалтгаантай холбоотой буй заа.

Монгол эвхмэл бичгийн хэв байдал нь янз янз боловч ерөнхийд нь авч үзвэл дараахи хоёр хэсэгт тухайлбал:

Дөрвөлжлөн эвхсэн бичиг;
Угалзлан эвхсэн бичиг

гэж хуваах бүрэн үндэслэл гарч ирдэг⁵.

Үүнээс дөрвөлжлөн эвхсэн бичгийг гол төлөв тамга, тэмдэг, захиралга, гарын тэмдэг зэрэг албан ёсны болон (харилцах) бичиг хэргийн зүйлд хэрэглэдэг байсан бөгөөд нийт даяар тогтсон журмаар эвхэн бичдэг учир уншихуйаа харьцангуй хялбар. Харин угалзлан эвхсэн бичгийг албан (харилцааны) бичиг хэргийн зүйлд тедийлөн хэрэглэдэггүй, харин зэрвэсхэн харахад хээ угалз мэт харагдах боловч лавлан үзвэл бэлгэ дэмбэрэлтэй ерөөлийн сайхан үгийг зураач бичээч хүний ур ухаанаар аль болох үзэмж төгөлдөр сайхнаар угалзлуулан бичиж чимэг болгон хэрэглэдэг уламжлалтай байсан ажээ.

Энэхүү хоёр зүйл эвхмэл хэлбэр нь өөр өөрийн тогтсон нарийн журамтай байж. Үүнээс дөрвөлжлөн эвхэх уламжлалыг эхлэн авч үзсүгэй. Нягтлан үзэхүл, монгол болон дөрвөлжин зэрэг бичгээр дөрвөлжлөн эвхэхэд:

Хэм тэгшийн зарчим;
Тэнцүү харьцааны зарчим

хэмээх хоёр үндсэн зарчим байсан нь бэлхэнээ харагдана⁶. Энэ хоёр зарчимын гол үндэсийг жишээ аван товч тайлбарлсу.


³ R. Bonaparte, *Les documents de l'époque mongole des XIII^e et XIV^e siècles*, Paris, 1895; Paul Pelliot, *Les documents mongols du Musée de Teheran*, - Athâr-E- Irân, annales du Service archeologique de l'Iran, Tome I, Fasc. 1, Paris, 1936, pp. 37-44; B. Rintchen, *Trois sceaux de bronze avec l'inscription carrée dans les collection du Musée national à Oulan-Bator*, AO, XXI, Praha, 1953, pp. 424-425.

⁴ Ойрод, халимагт манж бичгийг "хар худма" гэж нэрлэдэг тухай мэдээ Х. Лувсанбалдан, академич Д. Цэрэнсодном нарын бүтээлд буй. Х. Цэрэнсодном, *Монгол Данжуурын төгсгөлийн шүлэг*, - ХЗС, 8-р боть, 4-р дэвтэр, Улаанбаатар, 1970, 73-163-р тал,

⁵ Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын бичиг үсгийн эвхмэл хэлбэр*, - *Studia Mongolica*, Tom. IV(12), Fasc. 15, Ulaanbaatar, 1976, pp. 339 - 360; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1981, х. 130-145.

⁶ Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын бичиг үсгийн эвхмэл хэлбэр*, - *Studia Mongolica*, Tom. IV(12), Fasc. 15, Ulaanbaatar, 1976, pp. 339 - 340; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1981, х. 131.

Хэм тэгшийн зарчим нь гол төлөв дөрвөлжлөн эвхсэн тамга тэмдэгийн бичигт тодорхой харагддаг бөгөөд уг бичих зүйлээ гол төлөв ам дөрвөлжин зайд буюу эс бөгөөс тухайн товлосон хэмжээнд яг тохируулан бичих шаардалгаас үүссэн гэж үзэх бүрэн үндэс буй. Энэ зарчим нь уг бичвэрийг бүхэлд нь үзэхүйеэ гоо сайхан болгож илүү дутуу гарсан элдэв сондгой шугам зураасгүй, цалгардсан их зайгүй, хэм тэгш бичих шаардалгыг ханган өгдөг ажээ. Үүнээс үүдэж уг товлосон зайд хэрхин тохируулж бичихээ тухайн бичээч хүн нарийн бодож боловсруулдаг байна. Тухайлбал: ганц үг бичнэ гэвэл, монгол бичгээр өргөөш нь сунгах, дөрвөлжин бичгээр бол үе үеэр нь хоёр эгнээ болгох ч юм уу, аль болох яруу зохирлыг нь харж, зураас мөрийн тоог тэнцүүлэн шийднэ гэсэн үг.




Монгол бичигээр нэг үгийг ам дөрвөлжин зайд тааруулан эвхэх нь



Дөрвөлжин бичигээр нэг үгийг ам дөрвөлжин зайд тааруулах эвхэх нь

Уг бичих зүйл хэд хэдэн үгээс бүтэх бөгөөс хэдэн ч эгнээ болгож болох тул ам дөрвөлжин зайгаа мөн төчнөөн хувааж эгнээ тус бүрийн мөрийн тоог тэнцүүлэх нарийн журам буй.




"Монгол Улс" гэдэг үгийг монгол бичгээр ам дөрвөлжин зайд хоёр эгнээгээр мөр тэнцүүлэн бичих байдал

Монголын дөрвөлжин үсгийн тухайд үгийг үе үеэр нь хэд ч таслан эгнүүлэх нь хамаагүй, харин эгнээ бүрийн зараасын тоо харилцан тэнцүүлбэл зохино (4-р хавсралтыг үзмүү).


Ийнхүү эгнээ бүрийн мөр буюу зураасын тоог хэрхин тэнцүүлж болох вэ? гэдэг асуулт аяндаа гарч ирнэ. Үүнд монгол болон дөрвөлжин бичиг хувь хувийн өвөрмиц ялгаатай боловч аль алинд нь гэдэс буюу битүү гогцоо, бас бярга буюу эгчим, цэг тэмдэгийн зүйл нийтлэг бөгөөд онцгой үүрэгтэйг дурдах хэрэгтэй.

Монгол бичигийн тухайд гэдэс, сүүл, аливаа гогцоо (ϕ Da/Ta, α da/ta), бярга, цэг тэмдэгийн махбод гол үүрэгтэй. Тухайлбал: Гэдэс буюу гогцоо, сүүл буюу орхиц зэргийг үндсэн хэлбэрий нь алдагдуулалгүй хичнээн ч удаа нугасхийн сунгаж болно. Үүнд: 2, 4, 6 ... гэх зэргээр тэгш тоотой зураас нэмэх тохиолдолд гэдэс буюу гогцоог, 1, 3, 5... гэх зэргээр сондгой зураас нэмэх тохиолдолд сүүл, бярга буюу эгчим, цэг тэмдэгийн махбодыг давхарлаж эвхэн тоо тэнцүүлж өгдөг. Жишээ нь:



Монгол бичигийн эвхмэлд гэдэс, гогцоо, сүүл, бярга тэргүүтнийг тоо хэмжээ тааруулан эвхэх байдал

Монгол дөрвөлжин бичигийн тухайд эгшиг үсгийн гол хэлбэр (MF), мөн гэдэс гогцоо бүхий *ka, ga, sa, sa, sa, ta, na, ta* зэрэг гийгүүлэгч үсэгүүд дөрвөлжлөн эвхэх зарчимд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Үүнд:



Дөрвөлжин бичигт хэм тэгшийн зарчимаар зураасны тоо, зайг тэнцүүлэн эвхэх байдал

Дээр өгүүлсэн хэм тэгшийн зарчмыг хэмжээ зай таацуулан бичих шаардалга бүхий зүйлд л хэрэглэнэ. Харин томоохон зүйлийг эвхэж цувуулан бичих тохиолдолд эгнээ бүрийн зураасны тоог заавал тохируулах албагүй (5-р хавсралтыг үзмүү).

Тэнцүү харьцааны зарчим нь хэм тэгшийн зарчимаас багагүй ялгаатай. Өөрөөр хэлбэл хэм тэгшийн зарчим нь тодорхой хязгаарласан хүрээ хэмжээний дотор, монгол бичигийн хувьд хэд хэдэн үг, дөрвөлжин бичигийн тухайд хэд хэдэн үеийн харьцаан дээр гардаг бол тэнцүү харьцааны зарчим нь монгол бичигийн хувьд нэгэн үгийн дотор, дөрвөлжин бичигийн тухайд нэгэн үеийн дотоод харьцаан дээр илэрдэг юм. Энэхүү тэнцүү харьцааны зарчим нь гоо сайханы үүднээс уг эвхмэл бичвэрийн зураас хоорондын зай завсар нь хааш хаашаа аль болохуйц нэгэн хэмнэлтэй байх боломжийг бүрдүүлж өгдөг бөлгөө. Үлгэрлэвэл:



Эхний эвхмэлд тэнцүү харьцааны зарчмыг баримтлаагүйгээс дэл сул зай гарч жигд бус харагдаж байна. Хоёр дахи эвхмэлд уг харьцааг зөв гаргажээ.

Угалзлан эвхсэн бичмэлийн талаар товч ярилцая. Баримт сэлтээс үзэхүл угалзлан эвхсэн бичмэлийг, зарим нэг хүний гарын тэмдэгийг эс тооцвол албан харилцааны бичиг хэргийн зүйлд бараг хэрэглэдэггүй, зөвхөн гоёл чимэглэлийн зорилгоор хос уянга, ном болон барилгын чимэг, хөөргөний даалин, хавтага, хивс зэрэг эдлэл хэрэглэлийн зүйл дээр хээ угалзын адил хэрэглэж иржээ. Түүгээр үл барам, номын хавтасны "монгол үүл", дурсгалын аяганы алчуур, хөөрөгийн даалингийн "баяр", "давхар баяр" гэх зэрэг тодорхой зүйлд нийт даяар хэрэглэх болсон тусгай зориулалт бүхий угалзлан эвхсэн бичиг-хээ ч буй болсон байдал бэлхэнээ харагддаг.

Угалзлан эвхсэн бичмэл нь бичгийн учир холбогдлоос илүү эн тэргүүнээ урлагын үүрэгтэй байсан тул нарийн урлан зурсан буюу зүү ороон шаглаж оёсон байх нь олонтаа тохиолдоно. Ийм эвхмэлийн дотор сэхээтэн хүмүүсийн бичгийн гэрт чимэг болдог хос уянга (англиар Couplet, францаар Double strophes, германаар Doppelsprüche гэж нэрлэсэн нь буй)-ын урлаг онцгой үүрэг гүйцэтгэмүй. Хос уянга хэмээгч нь бичиг номын гэр, сүм дуган, номын сан зэргийн хаалганы хацар, цонхны хоёр тал, багана, туурга зэрэг олны нүд тусах газар хослон хаддаг чимэгийн зүйл бөгөөд түүн дээр бэлгэ дэмбэрэл төгссөн ерөөлийн үгийг хос мөрөөр шүлэглэн бичдэг бөлгөө. Үгийн тоо нь ч бас хамаагүй бус, гол төлөв эрхэмлэдэг тоогоор байдаг нь бэлгэдлийн учир холбогдолтой хэрэг. Түүнчилэн хос уянга нь "Цагаан сарын хос уянга", "Бурханы хос уянга", "Үүдний хос уянга" гэх зэрэгээр дотроо хэдэн зүйл байдаг нь цаг хугацаа, орон зайн ялгааг харуулдаг (6-р хавсралтыг үзмүү). Хуучин цагт бичиг номын хүмүүсийн хувьд гарын ураа гарган бичээд бие биедээ дурсгадаг байсан нэгэн бэлэгийн зүйл нь хос уянга байжээ. Үүнчилэн эмэгтэйчүүдийн хувьд эрхэм хүндтэй буюу сэтгэлт хүндээ үнэн сэтгэлээсээ ур ухаанаа гарган зүү ороож шаглан оёсон хос уянга, ерөөлийн сайхан үг үсэг бүхий номын баримтаг, аяганы алчуур, хөөрөгийн даалин зэргийг дурсгадаг нэгэн эрхэм уламжлал байсан бөлгөө⁷.

Тийм ч учраас монгол хос уянгын зүйлийг хэл болон урлагийнхи нь талаас судлагчид нэг бус удаа тусгайлан судлажээ⁸.

⁷ Жишээлбэл, хос уянгын үг: "Хүсэл мөрөөдөл биелэх цагт гал голомт бадарамуй"- Д. Намдаг, *Цаг төрийн үймээн*, 2-р хэвлэл, Улаанбаатар, 1967, 116-р тал.

⁸ Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972; Gy. Kara, *Writing, symbols and ornaments on two Mongolian scrolls*, - Tractata Altaica, by Denis Sinor, Wiesbaden, 1976, pp. 345-353. Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын бичиг үсгийн эвхмэл хэлбэр*, - Studia Mongolica,

Монголчуудын хэрэглэж ирсэн эвхмэл бичгийн дурсгалыг үзвэл үсгийн махбод бүрийг хэрхэн эвхэх тогтосон ерөнхий зарчим буй боловч бичээч хүний ур ухаанаар тухайн махбодын тэрхүү эвхэх ёсыг үл гажуудуулан, бичих зүйлийн байр байдал, хэмжээ дамжаа, дүрс зохицол зэрэгт таацуулан өөр өөрийн үзэмжээр яаж ч бичиж болдог тул үсэг бичгийн эвхмэл хэлбэр улам хөгжин боловсрох дотоод чадамжтай ажээ.



Нэг үгийг гурван янзаар
эвхсэн байдал

Харьцангуй түрүү үеийн монгол эвхмэл бичгийн дурсгалыг үзвэл *на*, *үа*, *ša* зэрэг нэмэлт тэмдэг бүхий үсгийн цэгийг тэр бүр тавьдаггүй уламжлал байсан нь харагдах бөгөөд энэ нь монгол хэлний нутаг нутагийн аялгуунд монгол бичиг зохицож ирсэнтэй холбоотой буй заа. Харин харьцангуй хожуу үе буюу XX зууны эхин үеийн эвхмэлд цэг тэмдэгийн зүйлийг түлхүү хэрэглэх болсон нь тэр үеэс төв халхын аялгуунд суурилан шинэчилсэн зөв бичихзүй тогтсонтой холбоотой хэрэг. Харин монгол бичигт үндэслэсэн манж эвхмэлийн зүйлд эхнээсээ нэмэлт цэг тэмдэгийг хэрэглэсээр ирсэн нь манж бичгийн онцлогтой холбоотой буюу тухайн бичигт дусал, бинтийг хэрэглэхгүй байхын аргагүй шаардалгад зохицсон гэж үзэх бүрэн үндэстэй юм (*1-р хавсралтыг үзмүү*).

Монгол үсэгт үндэслэсэн манж бичигт, өдгөө бидний мэдэхийн хэрээр манжаар "fügjingya xergen", монголоор "tulur-un üsüg" хэмээх дөчин нэгэн зүйл эвхмэл хэлбэр буй. Эдгээрийг үзэхүл, эвхэх ерөнхий зарчим нь монгол үсгийнхитэй адил боловч мөлгөрдүү өнцөгтэй байдагаараа бага зэрэг ялгардаг (*7-р хавсралтыг үзмүү*). Эл дөчин нэгэн зүйл "tulur-un üsüg"-ээр бичсэн номын хориод нь Монгол Улсын Төв Номын санд буй. Үзэж сонирхох хүнд дөхөмийг бодолцож нэр бүхий "tulur-un üsüg"-ийг цагаан толгойн дарааллын дагуу монгол манжаар дэслэж жагсаасугай.

1. Mo. Al segül terigütü tulur-un üsüg / Ma. Yadana üjüngya füyjingya xergen;
2. Mo. Altan menekei tulur-un üsüg / Ma. Eyixümengge füyjingya xergen;
3. Mo. Altan soličal tulur-un üsüg / Ma. Ayisin xiyaxalangya füyjingya xergen;
4. Mo. Bars kimusutu tulur-un üsüg / Ma. Tasxa ošoxongyo füyjingya xergen;
5. Mo. Belegtü čečeg-ün tulur-un üsüg / Ma. Sabingya senče-i füyjingya xergen;
6. Mo. Belgeligtü tulur-un üsüg / Ma. Sabindungya füyjingya xergen;
7. Mo. Bitegün mörtü tulur-un üsüg / Ma. Müwarüngya füyjingya xergen;
8. Mo. Čačaraltu tulur-un üsüg / Ma. Fi sürgebüxengge füyjingya xergen;
9. Mo. Čačagtu tulur-un üsüg / Ma. Süyixetü füyjingya xergen;
10. Mo. Čayan niskel tulur-un üsüg / Ma. Deyere sanyangya füyjingya xergen;
11. Mo. Čoyulburitai qoruqayiliy tulur-un üsüg / Ma. Čolixa ümiyaxangya füyjingya xergen;
12. Mo. Degedü yeke tulur-un üsüg / Ma. Dergi amba füyjingya xergen;
13. Mo. Egülen čoyča tulur-un üsüg / Ma. Borxošo tügingge füyjingya xergen;
14. Mo. Elgügsen jegütü tulur-un üsüg / Ma. Lakiyaxa ülmengge füyjingya xergen;

15. Mo. Ergigči galbingya-tu tulγur-un üsüg / Ma. Ergüwere γarüngγo füyjingya xergen;
16. Mo. Gayiqamsiytu čečeg-ün tulγur-un üsüg / Ma. Fergüwecüke sabingya füyjingya xergen;
17. Mo. Gayiqamsiytu tulγur-un üsüg / Ma. Fergüwecüke füyjingya xergen;
18. Mo. Galbingya garudi tulγur-un üsüg / Ma. Γarüngγü γarüdüngya füyjingya xergen;
19. Mo. Jüng ding tulγur-un üsüg / Ma. Jüngken müčixiyangya füyjingya xergen;
20. Mo. Köke bürkümel tulγur-un üsüg / Ma. Nioχon elbengge füyjingya xergen;
21. Mo. Labtayar sudul-un tulγur-un üsüg / Ma. Labdaχün sūdūli füyjingya xergen;
22. Mo. Luu kimusutu tulγur-un üsüg / Ma. Müdüri ošoχongγo füyjingya xergen;
23. Mo. Luu-tu tulγur-un üsüg / Ma. Müdüringya füyjingya xergen;
24. Mo. Majily-a-tu tulγur-un üsüg / Ma. Bokidangya füyjingya xergen;
25. Mo. Möritü bilayun tulγur-un üsüg / Ma. Genčexen müγšangya füyjingya xergen;
26. Mo. Naiman qubi narin tulγur-un üsüg / Ma. Jaqün übüi narxūngya füyjingya xergen;
27. Mo. Narin tulγur-un üsüg / Ma. Narxūngya füyjingya xergen;
28. Mo. Neyileltü tulγur-un üsüg / Ma. Ačabūngya füyjingya xergen;
29. Mo. Qan-u esitü tulγur-un üsüg / Ma. Gü-i čiytenge füyjingya xergen;
30. Mo. Qayiči dürsütü tulγur-un üsüg / Ma. χasaχangya füyjingya xergen;
31. Mo. Qoruqai dursutu tulγur-un üsüg / Ma. Ümiyaχangya füyjingya xergen;
32. Mo. Qoslaltu tulγur-un üsüg / Ma. χolbongya füyjingya xergen;
33. Mo. Següderi dusultu tulγur-un üsüg / Ma. Sabdara silenggingge füyjingya xergen;
34. Mo. Seyilümel nayirayultu tulγur-un üsüg / Ma. Foloχo ačangya füyjingya xergen;
35. Mo. Sibayud-un mörtü tulγur-un üsüg / Ma. Γasxai songqongγo füyjingya xergen;
36. Mo. Sibayun tulγur-un üsüg / Ma. Γasxangya füyjingya xergen;
37. Mo. Sinayan qoruqayiliγ tulγur-un üsüg / Ma. Qokingya füyjingya xergen;
38. Mo. Sudul nabčitu tulγur-un üsüg / Ma. Sūdūli abdaχa füyjingya xergen;
39. Mo. Toyuruu terigütü tulγur-un üsüg / Ma. Bülexen üjüngya füyjingya xergen;
40. Mo. Uda-yin nabčün tulγur-un üsüg / Ma. Fodoχo abdaχa füyjingya xergen;
41. Mo. Yabuqu udud modu tulγur-un üsüg / Ma. Sürdere üsiχa füyjingya xergen

эдгээр болно⁹.


Дөрвөлжин бичигийн эвхмэлийн тухайд, уг үсэг нь өөрөө дөрвөлжлөн эвхэхэд хамагийн тохиромжтой буюу дүрс өвөрчлөх онц шаардалгагүй. Гэвч самгард, төвөд үгийн бичилгийн байдлыг хэрхин тэмдэглэх тусхай тогтсон журам буй (2-р хавсралтыг үзмүү).

Монголчуудын хэрэглэж ирсэн үсэг бичигийн эвхмэл хэлбэрийн уламжлалыг бусад гадаад улсын эвхмэл болон угалзламал үсэгтэй харьцуулан үзэхэд үүргийн хувьд адил төстэй боловч хэрэглэгдэж ирсэн хүрээгээрээ илүү өргөн бөгөөд үсгийн махбод бүрт тогтсон хэлбэр бүхий бие даасан тогтолцоотой байсан нь харагддаг. Тухайлбал: дөрвөлжилөн эвхэх ёс нь монгол үсэгзүйд бүрэлдэн тогтсон өвөрмиц ёсон мөн бөгөөд түүний гол хоёр зарчим нь гадаадын эвхмэл бичигт төдий л харагддаггүй бөлгөө. Харин угалзлан эвхэх ёсон газар сайгүй байдаг боловч өөрийн өвөрмиц онцлогтой гэж хэлж болно. Жишээлбэл: Кирилл бичигийн тухайд нэлээд энгийн байдал харагддаг бол араб бичигийн угалзламал хэлбэр нь толийн тусгалд хоёр буюу дөрөв нугасхийсэн байдал харагддаг бөлгөө (8-р хавсралтыг үзмүү).

Бас нэгэн зүйл: Хятад, Япон, Солонгос зэрэг Ази дахины өндөр соёлт олон оронд өргөн дэлгэрсэн бийрийн уран бичилгэ хэмээх нэгэн салбар харьцангуй сүүл үеэс монгол бичгийн хүмүүсийн дунд буй болсон бөгөөд энэ нь тухайн үгийг бийрийн эрдэмээр шууд

⁹ *Tabun jüyil-ün üsüg-iyer qabsuruγsan manju ügen-ü toli bičg*, III, Begejing, 1957, 4623-4633.

татлан урлах, эсбөгөөс тодорхой хэлбэр дүрс оруулан бичих гэсэн хоёр чиглэлээр хөгжиж байна (9-р хавсралтыг үзмүү). Харьцангуй хожуу үед хөгжсөн гэдэгийн учир гэвэл, бүр эртний гэж үзэхээр монгол бичгээрхи бийрийн уран бичилгийн баримт дурасгал энэ хэр олдоогүй бөлгөө. Энэ нь Монголчууд хэдийгээр хятад, солонгос зэрэг орноос бийр, бэх, цаас авч байсан баримт буй боловч эрт үеэс барагцаалбал XVIII - XIX зуун хүртэл монгол ном судараа гол төлөв хулсан үзэгээр бичдэг байсантай холбоотой буй заа.



Туурганы хивсэн дээрхи эвхэж бичсэн үгийн сүлжээ

- | | | |
|------------|-----------|-------------|
| (1) nasu | (4) cōg | (7) jayay-a |
| (2) buyan | (5) masi | (8) arbin |
| (3) delger | (6) badar | (9) urtu |

Уг бичвэрийг сүлжилдүүлэн унших байдал нь:

- | | | |
|-------|--------|-------------------------|
| I. | 1-2-3: | nasu buyan delger |
| II. | 4-5-6: | cōg masi badar |
| III. | 7-8-9: | jayay-a arbin urtu |
| IV. | 1-5-9: | nasu masi urtu |
| V. | 2-5-8: | buyan masi arbin |
| VI. | 7-5-3: | jayay-a masi delger |
| VII. | 1-5-3: | nasu masi delger |
| VIII. | 7-5-9: | jayay-a masi urtu |
| IX. | 4-2-6: | cōg buyan badar |
| X. | 4-8-6: | cōg arbin badar |
| XI. | 1-2-6: | nasu buyan badar |
| XII. | 7-8-6: | jayay-a arbin badar ... |

Монгол бичиг болон түүнээс уламжлан зохиосон манж үсэгийн махбодыг эвхэх ерөнхий байдал

Үсэгийн махбод:

1.		шүд	шүд, араа, богино шүд, ацаг;
2. a.		шилбэ	шилбэ, урт шүд, сүүл, (i + ...);
b.		г	г;
c.		у	у;
		v	v буюу гадаад үгийн e;
3. a.		гэдэс	гэдэс, гогцоо;
		б	(b + гэдэс; g k + гэдэс;)
b.		хөндий	хөндий гэдэс;
4. a.		жавж	жавж (эхин);
b.		жавж	жавж (дунд);
c.		жавж	жавж (адагт);
5. a.		с	с буюу хурц эрүү;
b.		j	j буюу мөлүү эрүү;
6.		ү	ү буюу q;
7. a.		нум	нум;
b.		i	i (үгийн адагт);
c.		r	r (үгийн адагт);
8. a.		шүд	(урт) сүүл буюу хойшоо хаялга;
b.		шүд	богино сүүл;
9. a.		шүд	(урагшаа) цацалга (саланги);
b.		шүд	(урагшаа) цацалга (үргэлж);

10.   дэгээ;
11. a.   (босоо) t буюу d;
- b.   t(e) буюу d(e);
12. a.   (хэвтээ) t буюу d;
- b.   t(e) буюу d(e);
13.   (хөндий) h;

Нэмэлт тэмдэг:

14. a.   өмнө нэг цэг;
- b.   өмнө хоёр цэг
- c.   ард хоёр цэг
- d.   ард нэг цэг;
15.   бинт;
16. a.   l (үгийн эхинд) дээшээ эвэр
- b.   l (үгийн дунд) дээшээ эвэр
- c.   l (үгийн адагт) дээшээ эвэр
- d.   m (үгийн эхинд) доошоо эвэр
- e.   m (үгийн дунд) доошоо эвэр
- f.   m (үгийн адагт) доошоо эвэр

Цэг тэмдэгийн зүйл:

- | | | | |
|--------|--|--|-------------------|
| 17. | | | бярга буюу эгчим; |
| 18. a. | | | нэг цэг |
| b. | | | хоёр цэг |
| c. | | | дөрвөн цэг |

} цэг

Галиг үсэгийн махбод:

- | | | | |
|-----|--|--|-----|
| 19. | | | kh; |
| 20. | | | g; |
| 21. | | | s; |
| 22. | | | ch; |
| 23. | | | j; |
| 24. | | | z; |
| 25. | | | z; |
| 26. | | | d; |
| 27. | | | t; |
| 28. | | | th; |
| 29. | | | n; |
| 30. | | | p; |
| 31. | | | ph; |
| 32. | | | f. |

Дөрвөлжин үсгийн махбодыг эвхэх ёсон

Эгшиг үсгийн махбод

- | | | |
|----|--|---------|
| 1. | | a; |
| 2. | | e; é; |
| 3. | | u; |
| 4. | | o; |
| 5. | | i. |

Гийгүүлэгч үсэг

- | | | |
|-----|--|------|
| 6. | | ka; |
| 7. | | ka; |
| 8. | | ga; |
| 9. | | qa; |
| 10. | | ya; |
| 11. | | na; |
| 12. | | ca; |
| 13. | | ca; |
| 14. | | ja; |
| 15. | | na; |
| 16. | | ta; |
| 17. | | ta; |
| 18. | | da; |
| 19. | | na; |
| 20. | | pa; |
| 21. | | pha; |
| 22. | | ba; |
| 23. | | ma; |
| 24. | | ca; |

25.		ca;
26.		za;
27.		wa;
28.		za;
29.		za;
30.		'a;
31.		ya;
32.		ra;
33.		la;
34.		sa;
35.		sa;
36.		ha.

Цэг тэмдэгийн эвхмэл хэлбэр

37.		бяра;
38.		дан цэг;
39.		давхар цэг.

Давхар, зүүлтэт, толгойт үсэгийг эвхэх байдалаас

40.		kya (kya);
41.		kra;
42.		gla;
43.		rgya;
44.		lca;

45.



rcba;

46.




sha;

47.




bkra (bkra) ...



Юан улсын үеийн "Meng-gu zi-yun"-д дөрвөлжин үсгийн хэрхин
эвхэх байдалыг үзүүлсэн хэсэг.

ᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨ
 ᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨ
 ᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨ
 ᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨ
 ᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨ
 ᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨ
 ᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨ
 ᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨᠠᠨᠢᠭᠡᠨ




Тамгын бичвэр нь:

- | | | | | |
|----|----|------|-----|-------|
| 1. | | rdo | rje | 'c'an |
| 2. | ta | la'i | bla | ma' |
| 3. | yi | t'am | ka | rgyal |

Түмэдийн Алтан хаанаас анх "Далай лам" цолыг олгоход хамт өргөсөн зуун лангийн алтан тамгын дардас (1 x 1 хэмжээс)

Энэхүү тамгын холбогдох судлалаар Altangherel - Chagdarsureng, *Note sur un diplôme bilingue* [- Rocznik Orientalistyczny, Tom. XXXV, z. 2, Warszawa, 1973, pp. 33-42] гэдэг өгүүллээс лавлан үзмүү.




Эвхмэлийн бичвэр нь:

1. arban qoyar : tusa ulus-un olan arad-un erke
2. asig-i kündüdken qamayalaqu-yin tula :
3. kerbe ali nigen kümün buyu : keseg eteged-ner
4. öber-ün erke-yi ulus-un yabudal-dur qoortai
5. -bar kereglekü abasu : tede-ner-ün erke-yi
6. kijayarlaqu buyu : usudqabasu jokimui :

Монгол улсын анхны үндсэн хуулийг цувуулан эвхсэн байдал

Хос уянгын хэдэн жишээ



• Монгол эвхмэлийн бичвэр нь:

1. *Öljei kiged qutuγ-inu Sümbür aγula adali batudqu boltuγai;*
2. *Nasun ba buyan-anu Sün dalai metü arbidqu boltuγai.*

Манж эвхмэлийн бичвэр нь:

Dolo gūningγala eyiten bayita mütembi

Үүнийг монголчловол:

Дотор санасан бүх хэрэг бүтэмүй.

Монгол, манжаар угалзлан эвхсэн Хос уянга



Монгол бичвэр нь:

1. (Хар) *Naiman sakiγulsun jalaran irejū*
(Цагаан) *Nasun-u sidi-yi nemejū soyurqabai*
2. (Хар) *Isūn ejed eneren bayuju*
(Цагаан) *Ed-ün kesig-i ibegejū ögbei.*

(Энэхүү хос уянгыг Д. Кара судлаж тусхай өгүүлэл бичсэн тул түүнээс холбогдох зүйлийг тодруулан үзмүү: Gy. Kara, *Writing, symbols and ornaments on two Mongolian scrolls*, - *Tractata Altaica*, by Denis Sinor, Wiesbaden, 1976, pp. 345-353.)

Хар цагаанаар өнгө ялган давхарлаж бичсэн Хөс уянга



Mo. Uda-yin nabcin tulyur-un üsüg
Ma. Fodoxo abdaḡa füyjingya xergen



Mo. Čačaytu tulyur-un üsüg
Ma. Süyixetü füyjingya xergen

Манж тулгарын үсэг (füyjingya xergen) -ээр бичсэн ном.



РСТУФРЖНКНСТІАХУНІАРС
ДЮІОБДІІКІУЛІІХІАІІ



Орос, араб үсгийг эвхэх (буюу угалзлах) байдал



Монгол уран бичилгийн зарим жишээ



Монгол уран бичилгийн зарим жишээ

МОНГОЛ ҮСЭГ БИЧИГИЙН ГАЛИГЛАХ ТОГТОЛЦОО

Төв Ази дахины соёл иргэншлийн нэгэн өвөрмиц салбар монгол туургатны уугуул нутаг дэвсгэр дээр эрт цагаас бүрэлдэн хөгжиж, сүүлийн 700-800 жилийн туршид улс төр, шашин сурталын хүрээнд төвөд, самгард, манж, хятад зэрэг харь хэлний нөлөө тусгал хүчтэй болж ирсэн бөлгөө. Ялангуяа Бүддийн шашин хүчтэй нэвтрэхийн хирээр монголын бичиг соёлын мэргэдийн хувьд их бага таван ухаанаар¹ зохиол туурвилаа бүтээхэд нь номын хэлний үүрэгийг монголоос гадна төвөд самгард хэл багагүй гүйцэтгэх болжээ². Энэ бүхнийг ерөнхийд нь түүхэчилэн авч үзэхэд, академич Б. Я. Владимирцовын тэмдэглэсэнчилэн Төв Азийн хувьд нэгэн хэсэгтээ "Lingua Franca"³ болж байсан самгард хэлний үүрэгийг аажимдаа төвөд хэл гүйцэтгэх болсон боловч самгард хэлний нөлөө зохих хэмжээнд тухайлбал тарнийн хэлний хүрээнд хэрэглэгдсээр байсан гэдгийг тэмдэглэвэл зохино⁴. Тэгээд ч харьцангуй сүүл үе хүртэл буюу XX зуун болтол монгол сударын хэлнээ самгард нэр томъёо яг хэвээрээ өдий төдий тохиолдох боловч монголын нэрт орчуулагчдын сонгодог орчуулгад зарим оноосон нэрийг үл тооцвол, төвөдөөс орсон үгийн зүйл бараг байдаггүй, өөрөөр хэлбэл монголчилсон байдаг нь чухам үүнтэй холбоотой буй заа.

Их бага таван ухаанд боловсорсон монголын бичигийн мэргэд, бандида нарын зохиол бүтээлийн дотор дэлхий дахины эртний соёл иргэншилд холбогдох нэр томъёо, хүн

- ¹ "...tabun uqayan kemegci-inü: - gүн (dotuyadu) uqayan ,
- dayun uqayan,
- nutalaqu uqayan,
- anayaqu uqayan,
- uralaqui uqayan

- edeger-inü yeke tabun uqayan. - irayū nayiray,
- yoytu üges,
- ebelegülen nayirayulqu,
- odun jiruqai,
- dayun бүжиг edeger-inü bay-a tabun uqayan bolumui. gebci

edeger-ün irayū nayiray, yoytu üges, ebelegülen nayirayulqu yurba-anu degereki dayun uqayan-du, odun jiruqai, dayun бүжиг ene qoyar uralaqui uqayan-du baytamui..."

Gombujib, *Mongyolāud-un töbed kele-ber jokiyaysan jokiyal-un jüyil*, - SM, Tom. II, Fasc. 1-16, Ulaanbayatur, 1961, (18-49) 19.

² Y. Rinchen, *Sanscrit in Mongolia*, - SIAAC, vol. 3 (1973), New-Delhi, pp. 91-103; *Oirat version of Damumukonamasutra* - üliger-ün dalai, CSM, Tom. XVI, Fasc. 2, Ulan-Bator, 1970, IV.a; Gombujib, *Mongyolāud-un töbed kele-ber jokiyaysan jokiyal-un jüyil*, SM, Tom. II, Fasc. 1-16, Ulan-Bator, 1961, 18-49; Ш. Бира, *Монгольская тибетоязычная историческая литература (XVII-XIX)*, SH, Tom. III, Fasc. 1, Улан-Батор, 1960; Sh. Bira, *Mongolian historical literature of the XVII-XIX centuries written in tibetan*, MSOP, Bloomington, 1970.

³ Б. Я. Владимирцов, *Mongolica, Об отношении монгольского языка к индо-европейским языкам Средней Азии*, - ЗКВ, N. 1, Ленинград, 1925, стр. 305-341.

⁴ Y. Rinchen, *Sanscrit in Mongolia*, - SIAAC, vol. 3 (1973), New-Delhi, pp. 91-103.

болоод газар усны нэр тэргүүтэн гадаад үгийг уг дуудалгаар нь буулгах, бичих шаардалга захаас аван гарч үүний дүнд ч монголчуудын хэрэглэж ирсэн бараг бүх бичигийн хүрээнд галиг үсгийн тусгай тогтолцоо буй болсон бөлгөө. Түүнчилэн монголын бичиг номын хүмүүсийн хувьд зохиол бүтээлээ төвөд, самгард зэрэг харь хэлээр зохиох, хэвлэх уламжлал ерийн үзэгдэлийн хэмжээнд хүрсэний зэргэцээ түүнийгээ монголчуудын боловсруулан хэрэглэж ирсэн бичиг үсгээр гаргах явдал цөөнгүй байсан ажээ.

Тийм ч учраас бидний өнөөдөр мэдэхийн хэрээр монгол, дөрвөлжин, тод, соёмбо, хэвтээ дөрвөлжин, Вагиндрагийн үсэг цөм өөр өөрийн онцлогтоо тохирсон, тухайн зорилго, шаардалгадаа зохицсон галиг үсгийн тогтолцоотой байсан тухай бичиг тус бүрийн цагаан толгойн судлагааны хэсэгт аль нэгэн хэмжээгээр хөндөн ярьсан билээ.

Эл асуудлыг дэлгэрүүлэн ярихын өмнө галиг үсгийн ер нийт тогтолцооны тухай авч үзэх нь бидний судлагдахуун болох монгол бичиг үсгүүдийн галиглах онцлогийг тодруулахад аль нэгэн хэмжээгээр дөхөм болно гэж үзэж байна.

Монголын судлалын хүрээнд галиг үсгийг үүрэгээр нь дотор зуураа хошоод салбарласан хоёр гол анги болгон хуваан үзэж болно. Үүнд:

1. Дуудалгын (буюу авианы) галиг:

1. 1. бичигийн дурсгал буюу бичвэрийг зөв уншиж дуудах галиг;
1. 2. аман дуудалгыг зөв тэмдэглэх галиг;

2. Бичигийн (буюу үсгийн) галиг:

2. 1. тухайн (нэг) үсгийн нийлмэл махбодын бүтэцийг тэмдэглэх галиг;
2. 2. тухайн (нэг) үгийн бичилгийн бүтэцийг буулгах галиг

гэж хуваан үзэж болох бөгөөд энэхүү хуваарь нь бусад хэл, бичигийн хувьд ч ямар нэгэн хэмжээгээр холбогдоно. Үүнийг зүйл зүйлээр нь зарим нэг жишээгээр тодруулан тайлбарласу.

Дуудалгын (буюу авианы) галиг (1.)-ийн тухайд хэрхэн дуудах байдлыг тэмдэглэх нь хамгийн чухал болдог тул бичмэл зүйл (the text) дээр яаж бичсэн нь төдий л гол зүйл биш, харин яаж зөв дуудах байдлыг үзүүлэх нь (1. 1.) чухал байдаг. Зарим судлагч авиачилан тэмдэглэх галиг гэх нь буй. Монгол бичигийн дуудалгын галиг үүний нэгэн жишээ болно⁵.

Харин (аман) аялгууны зүйл дээр авиазүй (phonetic)-н болон авианы үүсэлзүй (phonic)-н нарийвчилсан галиг (1. 2.)-ийг учир ялгавартай хэрэглэх шаардалгатай болдог бөлгөө⁶.

Бичигийн (буюу үсгийн) галиг (2.)-ийн тухайд яаж дуудах байдал нь чухал биш, харин тухайн үгийг үсэгзүйн үүднээс ямар хэлбэрээр хэрхэн бичдэг нь хамгийн чухал болж өгнө. Үүнийг үсэгчилэн буулгах галиг гэж нэрлэж болно. Энэ нь дор хаяхад дотроо хоёр зүйл учир ялгаатай. Тухайлбал:

Нэгд, монгол бичгийн хувьд үгийн эхинд тохиолдох бүх эгшиг болон зарим гийгүүлэгч үгийн дунд адагт орохдоо нийлмэл махбодоос бүрддэг. Бас дөрвөлжин бичгийн эгшиг үсэг олон тохиолдолд мөн л нийлмэл махбодтой. Ийм тохиолдолд тухайн бичвэрийг хэрхэн бичсэн байдалыг үсгийн галиг (2. 1.)-аар тэмдэглэх шаардалга гардаг тул

⁵ Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Ленинград, 1929, стр. 66-89.

⁶ Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Ленинград, 1929, стр.53-65; В. М. Надеяев, *Проект универсальной унифицированной фонетической транскрипции*, Москва-Ленинград, 1960.

судлагчид монгол, дөрвөлжин, соёмбо, хэвтээ дөрвөлжин зэрэг бичгийн судлагаандаа дуудалгын галигийн хажуугаар бичигийн галигийг давхар хэрэглэсэн байдаг билээ⁷.

Хоёрт гэвэл, төвөд зэрэг хэл бичигт дуудалга бичилгэ үлэмжхэн зөрүүтэй байх нь ерийн үзэгдэл бөгөөд тухайн үг бүрийг дуудалгаар нь ялгахад бэрх, харин бичгээр ялгахуйяа хялбар тул хэрхэн бичдэг байдлаар нь буюу үсэгчилэн галиглах (2. 2.) ёсон нийт даяар хэвшсэн бөлгөө⁸. Бичилгэ, дуудалгын энэ мэтийн үлэмжхэн зөрөө монгол, англи, франц зэрэг олон бичигийн зөв бичих зүйд нийтлэг байдаг үзэгдэл бөгөөд ийм зөрөөг арилган ойртуулах гэсэн "гэнэхэн" эрмэлзэл эртнээс өдгөө хүртэл, хаа сайгүй гардаг байсан боловч бичилгэ дуудалга хоёрыг гарын үзүүрээр нүдэн балай ойртуулна гэдэг нь хэлшинжлэл гэдэг мэргэжлийн ухааны үүднээс авч үзвэл ухвар мөчид явдал болдог бөлгөө. Тухайлбал: монголчуудын хувьд монгол бичигийн дуудалгыг ярианы хэлэнд зохицуулах гэж бичгээ солих оролдолго удаа дараа хийсээр ирсэн боловч цаг хугацаа болон нийт монгол туургатны дунд нийтлэг хэрэглэгдэх хүрээ хязгаарын хувьд монгол бичгээс давж чадаагүй нь хэлшинжлэлийн үүднээс гүйцэд бодон боловсруулж чадаагүйн нутлагаа буюу. Бас одоо хүртэл англи, франц зэрэг хэлний зөвбичих зүйн бичилгэ нь эрт цагийнхаа байдал төлөвийг хадгалсаар, өдгөөгийнхөө аман дуудалгаас эрс ялгаатай хэвээрээ, түүнээс үүдэж тэдгээр хэлний тольд орсон толгой үг бүрийн дуудалгыг ард нь хаалтанд тусгай галиг үсгээр хадаж өгдөг нь чухам үүнтэй холбоотой бөлгөө. Үүнчилэн, орос хэлэнд ч бичилгэ дуудалга зөрдөг явдал захаас аван буй боловч уг зөрөөг арилгаагүйг буруутгадаггүй хирнээ монгол бичгийн тухайд хоцрогдсон бүдүүлгэ хэмээн муучлах нь хэлшинжлэл гэдэг ухааны талаар наад захын мэдэлгэгүйгээрээ "гайхуулсан" хэрэг болохоос цаашгүй юм.

Бидний гарт хүрэлцэн ирсэн баримт хэрэглэгдэхүүнээс үзэхүл XIII - XIV зуунаас эхлэн 1587 онд Аюуш гүүштэн монгол бичигийн галиг үсгийн тогтолцоог боловсруулах үе хүртэл "*Bodhisatv-a cary-a avatar*", "*Банзрагч*", "*Алтан гэрэл*", "*Тарба чэнбо*", "*Бурханы арван хоёр зохионгуй*", "*Субашид*", "*Үлгэрийн далай*", "*Ганжуур*"-ын "*Юмын аймаг*" тэргүүтэн Бүддийн шашны уншилга ном хийгээд уран зохиолын олон бүтээлийг лавтайяа орчуулахдаа самгард хийгээд хятад нэр томъёог монгол болон дөрвөлжин бичгээр тэмдэглэдэг уламжлал хэдийнэ тогтсоныг бэлхэнээ харж болно. Үүний зэргэцээ монголчуудын тухайд бичиг үсгээ улам боловсронгуй болгох гэсэн нэг бус оролдолго нь Бүддийн шашны бүтээлийг уг эхээр нь болон монголчлон хэвлэх гэсэн эрмэлзэлтэй холбоотой байсаны зэргэцээ тэдгээр бичиг бүрийн галиг үсгийн тогтолцоог улам нарийсгах зорилгыг давхар агуулж байсан тухай дээр өгүүлсэн бөлгөө. Тэхдээ баримт дурсгалаас үзэхэд хэсэг бусад гадаад үг, нэр томъёоны зүйл төдийгүй бүхэл бүтэн номыг галиглахдаа уг эх хэлээр нь хэрхэн бичдэг байдлыг үсэгчилэх хадахын сац хэрхэн дуудах байдлыг авиачилан галиглаж үзүүлдэг уламжлал зэрэгцэн оршоор байсан гэдгийг батлах нэг бус баримт жишээ бидний үед золгон ирсэн боловч тэр бүр судлагааны хүрээнд хангалттай өртсөнгүй⁹. Энэ талаар хойно арай дэлгэрүүлэн өгүүлнэ.

Тийнхүү галиглахдаа гадаадын ямар хэлийг илүүтэй анхаарсан бэ? гэдэг тухайд монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсгийн зүйлүүд харилцан адилгүйн дээр тухайн орчин ахуйн шаардалга хийгээд хэрэглэгчийн боловсролын улмаас зарим тохиолдолд төвөд зэрэг бусад улс үндэстний бичигийн бүхэл бүтэн тогтолцоог, бас зарим тохиолдолд, монгол бичигт үндэслэсэн манж, тод бичгийн хэрэгцээтэй гэсэн хэсэг бусад үсгийг дуудалгын галигийн журмаар хэрэглэх явдал ч байсан бөлгөө. Тэглээ гээд тэдгээр харь үсгийг тэгш хэрэгцээг хангадаг үндэсний бичгийн хэмжээнд хэрэглэж байсан гэж үзэх аргагүй ажээ.

⁷ Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Ленинград, 1929, стр. 79-85; N. Poppe, J. R. Krueger, *The Mongolian Monuments in ᠬᠦᠫᠭ᠎ᠠ script*, Wiesbaden, 1957; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1981.

⁸ Б. Бадараев, *Об основах транскрипции и транслитерации для тибетского языка*, Улан-Удэ, 1967.

⁹ Парва Т, *Төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиол*, SM, Tom. I, Fasc. 25, Ulan-Bator. 1959; Chagdarsureng Ts, *Sur quelques traduction mongoles de "Natha"*, - *Studia Mongolica*, Tom. II(10), Fasc. 11, Ulaanbaatar, 1975, pp. 143-183.

Гэвч монгол бичиг үсгийн түүхийг үзэхүл харь хэлний үг, нэр томъёоны зүйлийг уугуул дуудалгад нь аль болохойцаар ойртуулан галиглах гэсэн эрмэлзэлийг тухайн үеийнхээ хэлшинжлэлийн төвшинд хүргэж үсэгзүйн үүднээс нэгэн тогтолцоонд оруулан шийдэх гэсэн анхны үр дүнтэй оролдолго нь харчины Аюуш гүүштэний "Али галийн үсэг" болно. Гэвч дөрвөлжин, тод, соёмбо зэрэг монгол туургатны хэрэглэж ирсэн бичиг үсгийн галиглах зарчим Аюуш гүүшийнхээс ялгаатай байсан бөлгөө. Үүнд: дөрвөлжин бичигийг цаг хугацааны хувьд, соёмбо, хэвтээ дөрвөлжин зэрэг бичигийг үсэгзүйн хувьд хамааралгүй гэж үзэх бүрэн үндэс буй боловч монгол бичгээс эх авсан тод бичгийн тухайд "Али гали үсэг"-ийг төдий л баримтлаагүй нь сонирхол татдаг. Харин Вагиндрагийн бичигийн тухайд гэвэл цаг үеийн шаардалгаас үүдэж энэдхэг-европ овогийн орос хэл рүү түлхүү чиглэсэнтэй шууд холбоотой буй заа.

Иймд Аюуш гүүшийн галиг үсгийн тогтолцооны талаар дэлгэрүүлэн өгүүлэхийн өмнө бусад монгол бичиг үсгийн галиглах зарчимын талаар товч боловч авч үзэх нь зүйтэй гэж санана.

1269 онд зохион Юан улсын төрийн бичигээр хэрэглэсэн Дөрвөлжин бичиг нь монголоос гадна нангиад, самгард, төвөд, түрэг үг, нэр томъёоны зүйлийг тэмдэглэж ирсэн баримт бидний үед хүрэлцэн иржээ¹⁰. Тэгээд ч дөрвөлжин бичигийг А. М. Позднеев "монгол галиг үсэг" гэж, В. Лауфер (В. Laufer) "Монголоос гадна хятад хэлний цагаан толгой" гэж, Б. Я. Владимирцов "ХШ зууны олон улсын цагаан толгой" гэж онцлон нэрлэсэн хэрэг¹¹.

1648 онд Ойродын Зая бандида Намхайжамц - Огторгуйн далай тод бичигийг зохиохдоо гадаад үг, тухайлбал: төвөд, самгард болон тухайн үеийнхээ монголын аман аялгууг тэмдэглэх галигийн тогтолцоог буй болгохдоо монгол бичигт зориулж Аюуш гүүшийн боловсруулсан галиг үсгийн зарчимыг аль нэгэн хэмжээгээр анхааралгүй өнгөрөөгүй гэж үзэж болох боловч харин үсэгзүйн хувьд төвөд үсгийн хэлбэрийг түлхүү дагасан байдал илэрхий харагддаг¹². Тухайлбал:

tib.  (ka)	>	oïr. tc. 	;	mo. tc. 
tib.  (kva)	>	oïr. tc. 	;	mo. tc. 
tib.  (pa)	>	oïr. tc. 	;	mo. tc. 
tib.  (pha)	>	oïr. tc. 	;	mo. tc. 
tib.  (za)	>	oïr. tc. 	;	mo. tc. 

Өндөр гэгээн Занабазартаны зохиосон соёмбо болон хэвтээ дөрвөлжин бичигийн харь үг тэмдэглэх галигийн тогтолцоог тухайн бичиг бүрийн цагаан толгойн тайлбарт авч үзсэн тул дахин нурших явдалгүй боловч соёмбо бичигийн тухайд самгард үсгийн, хэвтээ дөрвөлжин бичигийн тухайд төвөд үсгийн хэв загварт шүтсэн болох нь бэлхэнээ мэдэгддэг.

¹⁰ L. Ligeti, *Trois notes sur l'écriture 'Phags-pa*, - AOH, Tom. VIII, Budapest, 1961, pp. 202-204; G. J. Ramstedt, *Mongolische briefe aus Idikut Schähri bei Turfan*, - SPAW, Berlin, 1909, ss. 838-848; L. Ligeti, *Le Po Kia-sing en écriture 'phags-pa*, - AOH, Tom. VI, Fasc. 1-3, Budapest, 1956, pp. 1 -52; N. Poppe, J. R. Krueger, *The Mongolian monuments in hPhags-pa script*, - Göttinger AF, Band. 8, Wiesbaden, 1957. L. Ligeti, *Monuments en écriture 'Phags-pa, Pieces de chancellerie en transcription chinoise*, IVLMMT, I, Budapest, 1968.

¹¹ А. Позднеев, *Лекции по истории Монгольской литературы*, II, С.- Петербургъ, 1897, стр. 30-43; В. Laufer, *Skizze der mongolischen Literatur*, - Keleti Szemle VIII, 1907, pp. 185-186, 194-195; Б. Я. Владимирцов, *Монгольский международный алфавит XIII века*, - Культура и письменность Востока, Москва, 1931, стр. 32-42.

¹² Х. Лувсанбалдан, *Тод үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975, 34-37-р тал.

Монголын судлалын хүрээнд Харчины Аюуш гүүшийн галиг үсэг гэдэг нэр томъёо өргөн хэрэглэгддэг бөгөөд түүнийг 1587 онд зохиосон хэмээмүй. Эл галиг үсгийн онцлог болон эрдэм шинжилгээний ач холбогдлын талаар академич Ринчен доктор нэлээд дэлгэрэнгүй дурджээ¹³. Харин Аюуш гүүшийн галиг үсгийн талаархи бие даасан судлагаа 1990 хэдэн он хүртэл гарч амжсангүй нь уг судлагдахууныг авч үзэхэд монголоос гадна самгард, төвөд, нангиад тэргүүтэн Азийн олон хэлний авианы зүй тогтолыг нарийвчлан мэдэх шаардалгатай холбоотой байсан буй заа. Харин 1997 онд Өвөр Монголын Их сургуулийн профессор Жалсаны шавь Цагаансар "Али гали үсэгийн судлал" хэмээх магистрын ажил бичиж уг сэдэвт холбогдох судлагааг нэлээн дэлгэрэнгүй гаргасан билээ¹⁴.

Долоон хуудас бүхий гурван үсэг хавсаргасан барламал, монголоор "Egesig üsüg kiged geyigülegä üsüg-üd orosiba", төвөдөөр "Da-byans gsal-bzugs", самгардаар "Ālikālibijahāram"¹⁵ гэдэг номын төгсгөлийн үгнээ Аюуш гүүштэний зохиосон галиг үсгийн тухай тодорхой мэдээ буйгаас гадна уг галиг үсэгт шүтсэн олон ном сударын зүйл Өвөр монгол, Халх, Буриад нутагт тус тус гарчээ¹⁶. Өвөрлөгч нутагт л гэхэд Манж Дайчин улсын үеэс "Jarliγ-iyar toγtaγaγsan üsüg-i nigedkeju ayaγus-i jokilduγuluγā", "Qaγan-u biāgsen manju kitad mongγol töbed kele qabsuruγsan ali γali" гэдэг хоёр ном тусгайлан бард гарчухуй¹⁷. Буриад газарын тухайд Цүүгэлийн Дашчоймпиллинг, Агын Дашлхүндүблингийн барханд дармалласан арав шахам судар буй. Эдгээрийн дотроос хамгийн дэлгэрэнгүй нь буюу самгард, төвөдийн дан, давхар, толгойт, зүүлтэт үсэг болон жишээ тэргүүтэн нийт 1200 шахам үе үсэгийг өвөр зуур нь болоод монголоор хэрхэн галиглах байдлыг үзүүлсэн нь эхинд дурдсан "Egesig üsüg kiged geyigülegä üsüg-üd orosiba" хэмээх судар болой.

Дээр цухас дурдсанчилан Аюуш гүүштэнээс өмнө олон ном сударын зүйлийг төвөд самгардаас монгол хэлнээ орчуулсан зүйл арвин бөгөөд үүнд харь нэр томъёоны зүйлийг монгол бичгээр галиглах ёсон байсаар ирсэн нь мэдээж боловч нарийвчилан үзэхүл дуутай болон дуугүй гийгүүлэгч, хамжин шүргэх дуутай хийгээд дуугүй хос гийгүүлэгч, самгардын охор болоод урт l, r өвөрмиц эгшигийг тэмдэглэх зэрэг нэлээд олон зүйл дээр нэгэдмэл болж хараахан чадаагүй байдал харагддаг бөлгөө. Энэ бүхнээс үүдэж зарим судлагч Аюуш гүүш Али гали үсгийг зохиосон гэхээсээ "эмхидхэн найруулсан гэвэл зохистой"¹⁸ хэмээн үзсэн нь буй. Гэтэл тиймэрхүү зөрөө бүр хожуу үед тухайлбал XIX зууны бичвэрт ч үргэлжилсээр ирсэн бөгөөд ийм ялгаа нь чухамдаа Аюуш гүүшийн галигийн тогтолцооноос болов уу, эс бөгөөс тухайн галиглагчийн самгард, төвөд хэлний боловсрол, баримтласан үзэл зэрэгтэй холбоотой юу? гэдэг асуулт аргагүй гарч ирнэ. Үүнээс үүдэж зарим судлагч гэдгээр зөрөөг Аюуш гүүшийн галигийн тогтолцоотой холбон үзэх хандалга байдагийг эргэж нягтлавал зохино.

Тэгээд ч академич Ринчен уг галиг үсгийн тогтолцоог европ дахинаа хэрэглэн буй самгард, төвөд бичгийг тэмдэглэх галигийн зүйлтэй харьцуулан үзээд:

¹³ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртхал, Улаанбаатар, 1964.

¹⁴ Čaγansara, *Ali γali üsüg-ün sudulul*, - Kele bičig-ün erdem sinjilegen-ü ögülel-ün tegübüri, 22-
duγar debter (Öbür mongγol-un yeke surγayuli, Mongγol kele bičig sudulqu γajar), Köke qota,
1999, 166-176.

¹⁵ Ālikālibijahāram being A Sanskrit-Tibetan-Mongolian Abecedarium, by Prof. Dr. Raghu Vira,
Lahore, 1941, 6.a.

¹⁶ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, Улаанбаатар, 1964, 99-108, 157-160.

¹⁷ Čaγansara, *Ali γali üsüg-ün sudulul*, - Kele bičig-ün erdem sinjilegen-ü ögülel-ün tegübüri, 22-
duγar debter (Öbür mongγol-un yeke surγayuli, Mongγol kele bičig sudulqu γajar), Köke qota,
1999, 167.

¹⁸ Čaγansara, *Ali γali üsüg-ün sudulul*, - Kele bičig-ün erdem sinjilegen-ü ögülel-ün tegübüri, 22-
duγar debter (Öbür mongγol-un yeke surγayuli, Mongγol kele bičig sudulqu γajar), Köke qota,
1999, 169.

"... Монгол үсэгт эл галиг үсэг нэмэн зохиосноор даруй шинжлэх ухааны нарийн тэмдэглэл хийх үсэг бүрдэж, Аюуш гүүшийн зохиосон галиг үсгээр энэдхэг төвөд үсгийг нарийн тэмдэглэх болсон нь хожуу хойно Европын эрдэмтэн энэдхэгч төвөдөчийн зохион боловсруулж латин галиг хийсэнтэй зарчим яг ив ижил. Энэдхэг төвөд үсгээр бичсэн зүйлийг Аюуш гүүшийн галигаар тэмдэглэх нь европын латин галигаар тэмдэглэхлүгээ ширхэгийн ч зөрөөгүйг үзэхэд сонин бөгөөд монголчуудын энэдхэгийн судлал, төвөдийн судлал тухайн үед өндөр байсныг гэрчилэн үзүүлж XVI зууны үеийн хэлшинжлэлтэн Аюуш гүүш европ нөхдөөсөө бараг хоёр зуугаад жилийн өмнө тэдний галиглах зарчмыг монгол үсэгтээ хэрэглэсэн байнам..."

хэмээн дүгнэжүхүй¹⁹.

Самгард, төвөд хэлний хэрэглэгдэхүүнийг монгол, тод, соёмбо, хэвтээ дөрвөлжин бичиг болоод латин галигаар хэрхэн тэмдэглэдэг ёсыг нэгэн дор харьцуулан гаргаж харилцан зохилдох байдлыг үсэгзүйн талаас нэгэн дор үзүүлэх нь монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсгийн галиглах тогтолцооны ерөнхий нийтлэг зарчмыг танилцуулахад дөхөм болно гэж үзлээ (1, 2-р хавсралтыг үзмүү). Гэвч монгол бичгээр галигласан самгард, төвөд бичвэрийн дотор тодорхой хэдэн үсгийн аймаг дээр зарим тохиолдолд бидний таацуулан жагсаасан хүснэгтээс гажсан зүйл гардагийг үгүйсгэх аргагүй бөгөөд энэ нь гол төлөв тухайн галиглагчийн баримтласан зарчимтай холбоотой хэрэг.

Самгард хэрэглэгдэхүүнийг монгол бичгээр галиглаж ирсэн уламжлал нэлээд өвөрмиц бөгөөд энэ талаар академич Т. Төмөртоого, доктор О. Сүхбаатар²⁰ нар судлаж тусгайлан өгүүлэл бичсэн тул дэлгэрүүлэх өгүүлэхээ үүгээр хязгаарлав. Харин нэгэн зүйлийг холбогдуулан нэмж тэмдэглэхэд самгард, төвөд хэрэглэгдэхүүнийг монгол бичгээр галиглаж ирсэн баримтыг үзэхэд, нэгд, тухайн бичсэн янзаар нь буюу угтвар, дагавар, толгой, зүүлт тэргүүтнийг байсанчилан тэмдэглэх, хоёрт, хэрхин дуудах байдлаар нь буюу зөвхөн дуудалгаар нь тэмдэглэдэг байсан байдал бэлхэнээ харагддаг (3-р хавсралтыг үзмүү). Үүнд: эхнийхи нь албан ёсны зүйл дээр, хоёрдахи нь амин хувийн тэмдэглэлд зонхилдог бөлгөө.

Бас нэгэн зүйл: Монголчууд зарим тохиолдолд монгол хэлний бичвэрийн зүйлийг төр-иргэний хүрээнд манж буюу тод бичгийн эгшиг болон d/t, g/k c/j зэрэг зарим үсэгийг монгол бичигтэй хослуулан тэмдэглэдэг; шашин-номын хүрээнд тухайн уншигч хэрэглэгчийн мэдэлгэд тохируулан төвөд үсэгийг бүхэлд нь галигийн үүргээр хэрэглэн тэмдэглэдэг уламжлал байсныг дурдах хэрэгтэй бөгөөд төвөд үсгээр үгчилэн тэмдэглэх ёсны талаар Ринчен нарын судлагчид ч хэдийнээ анхааран тэмдэглэсээр ирсэн ба 1959 онд эрдэмтэн Т. Пагва төвөд үсэгзүй болон авиазүйн учир холбогдлын үүднээс нь судлаж Олон улсын монгол хэл бичигийн эрдэмтний анхдугаар их хуралд нэгэн илтгэл тавьсан бөлгөө²¹.

Эхний тохиолдолд, монгол бичиг дэхи нэг дүрсийн хэд хэдэн дуудалгыг ялгах гэсэн оролдолгын үүднээс монгол бичвэрийн дотор манж буюу тод бичгийн дүрс ялгасан үсэг болон дусал, бинд зэрэг нэмэлт тэмдэгийн зүйлийг галигийн үүргээр харьцангуй хязгаарлагдмал хүрээнд хэрэглэж ирсэн гэж үзэх бүрэн үндэс буй. Гэхдээ нутаг нутагт, тухайлбал: буриад зүгийн бичвэрт γ -гийн цэгийг q -д сольж тавьсан, түрүү түрүү үеийн монгол бичигээрхи дурсгалд ерөөсөө цэг тавьдаггүй болон одоо бидний бичдэг зөвбичихзүйгээс зөрөөтэй зүйл харагддаг зэрэг нь энэ асуудалтай огтхон ч холбогдолгүй гэдгийг дурдахад илүүдэх нь юун (4-р хавсралтыг үзмү) !

¹⁹ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, Улаанбаатар, 1964, 99.

²⁰ Д. Төмөртоого, *XIII -XIV зууны монгол бичгийн дурсгал дахи самгарди үгийн бичлэгийн онцлог*, - Хэл зохиол, VII боть, 7-р дэвтэр, Улаанбаатар, 1969, 202-219; О. Сүхбаатар, *Монгол бичгийн хэлнээ санскрит үгийг тарнийн дуудлагаар тэмдэглэж ирсэн нь*, - SM, Tom. XIII (21), Fasc. 10 (1985), Ulaanbaatar, 1987, 72-76.

²¹ Т.Пагва, *Төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиол*, SM, Tom. I, Fasc. 25, Ulan-Bator. 1959.

Хоёрдахи тохиолдолын тухайд, Г. И. Рамстедт (G. J. Ramstedt), Б. Я. Владимирцов, Т. Пагва зэрэг нэрт монголчдын тэмдэглэсэнчилэн²², монгол газар Бүддийн шашины хүчтэй нөлөөгөөр төвөд хэл, төвөд бичиг үлэмжхэн нэвтэрэхийн хэрээр монгол хэл, монгол бичгийн хэрэглээ тодорхой хэмжээгээр саарч, ялангуяа монгол лам нарын дотор монгол бичиг мэдэх явдал хязгаарлагдмал болж ирсэнтэй шууд холбоотой бөлгөө. Өөрөөр хэлбэл, монгол хэлний хэрэглэгдэхүүнийг төвөд хэл бичиг мэддэг лам нарт зориулж төвөдөөр үсэгчилэн бичих уламжлал буй болсон гэж үзэж болно. Энэ уламжлалыг дээр өгүүлсэн эхний тохиолдолтой харьцуулан үзэхэд шашин ном, уран зохиол, улс төрийн хүрээгээр барахгүй гол төлөв лам нарын хувийн хэрэгцээнд илүү нийтлэг бөгөөд өргөн хүрээтэй хэрэглэгдэж ирсэн байдал бэлхэнээ харагддаг.

Ийнхүү төвөдөөр үгчилсэн ном зохиол гэхэд хэдэн арван дүймин (tib. btus-min), Ишдоржийн "Төвөд монгол дохионы бичиг"²³ зэрэг толь бичгийн зүйл, Гэлэгбалсангийн "Наадамын ерөөл" зэрэг уран зохиолын зүйл, 1936 оноос Гандан хүрээний "Лам нарын сэтгүүл" (5-р хавсралтыг үзмү) хэмээх сар тутам гаргаж байсан тогтмол хэвлэл зэргийг нэрлэж болохоос гадна лам нарын амин хувийн тэмдэглэл тэргүүтнийг дурдаж болно. Үүнээс дүймин хэмээх толь бичгийн тухай арай дэлгэрүүлэн ярису. Түүвэр нэрийн бичиг хэмээн монголчилож болох энэхүү дүймин²⁴ гэдэг нь шашин номын хүрээнд хэрэглэгдэж ирсэн хэдэн зүйл толь бичгийн нэг бөгөөд ямар нэгэн (төвөд) томоохон зохиолын доторхи бэрх хатуу үгийг түүвэрлэн орчуулж тайлбарласан байдаг. Тэгэхдээ ийм толийн толгой үгийг уг зохиолд гарах дэс дараагаар нь байрлуулж тайлбарласан орчуулдаг журамтай байсан нь тухайн зохиолыг уншин судлах хүмүүнд тэр үгийг хайж олох ажлыг дөхөмчлөх зорилготой холбоотой буюу. Ийм дүймингийн сонгодог жишээ бол олны дунд "Арвай хээрийн арван дүймэн" гэж алдаршсан төвөд монгол толь бөгөөд үүнд "Зонховын их мөрийн зэргэ", "Зонховын бага мөрийн зэргэ", "Бодовагийн увадус эрдэнэ цогцлосон", "Оюун судлахын анх судлахуй", "Их оюун судлахуй", "Винайн онц учрыг өгүүлсэн", "Винайн үндсэн товч бичиг", "Винайн тайлбар", "Мялын намтар, бум дуулал", "Эмийн дөрвөн үндэс" хэмээх олонаа тархасан алдартай бөгөөд томоохон арван зохиолын доторхи бэрх хатуу нэр (одоогийн ухаарлаар бол үг)-ийн тайлбар бүрэнээ багтжээ²⁵. Эрдэмтэн Т. Пагва дурдсан бүтээлдээ Ламын гэгээнд бартай байсан арван зохиолын дүймингийн тухай дурдсан²⁶ байх бөгөөд түүнд багтсан номын нэр усыг үзэхэд бидний саяын ярьсантай үндсэндээ тохирч байгаа боловч Ламын гэгээний хүрээнд барласан гэх номын гарчигт энэ хэр хараахан олдоогүй болохыг тэмдэглэсү. Монголчуудын дунд дүймин хэмээдэг ийм толийн зүйлд тайлбар орчуулгыг монгол хэлээр төвөд үсгээр бичсэнээрээ бидний энэ сэдэвт шууд холбогдох сонирхолтой судлагдахуун болж өгдөг (6-р хавсралтыг үзмү).

Судлагаанаас үзвэл ийнхүү төвөд үсгээр монгол хэлээр "үгчилэх"-эд тогтсон уламжлал нь эхин үедээ тодорхой зарчимгүй гэмээр байсан байх ба яваандаа нэгдсэн тогтолцоотой болсон гэж үзэх хангалттай баримт буй ажээ²⁷. Үүнээс гадна төвөд үсгээр үгчилсэн хэрэглэгдэхүүн нь Долгор-Ролгор, Дулмаа-Оролмаа, Даши-Рааши, Сүндэв-Сүнрэв, Жав-Гяв, Санжи-Санги гэх мэтээр төвөд үгийг тухайн нутагт ямар дэгээр хэрхэн дуудах байдлыг тодруулах бололцоог олгож өгдөгөөрөө эрдэм шинжилгээний хувьд давхар ач холбогдолтой болохыг онцлон дурдвал зохино. Бас төвөдийн дан болоод ямар ямар

²² Г. И. Рамстедт, *Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора*, С-Петербург, 1908, стр. 1-2; Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Ленинград, 1929, стр. 27-28; Т. Пагва, *Төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиол*, SM, Tom. I, Fasc. 25, Ulan-Bator. 1959, x. 4-5.

²³ Isidorji, *Töbed mongγol dokiyan-u biäḡ*, - CSM, Tomus IV, Ulaγanbayatur, 1959.

²⁴ Ц. Шагдарсүрэн, *Толь бичигийн судлал*, - Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс, Улаанбаатар, 1986, x. 193-198.

²⁵ Мөн тэнд.

²⁶ Т. Пагва, *Төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиол*, SM, Tom. I, Fasc. 25, Ulan-Bator. 1959, x. 6-7.

²⁷ Т. Пагва, *Төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиол*, SM, Tom. I, Fasc. 25, Ulan-Bator. 1959, x. 10-20.

давхар үсгээр монгол хэлний ямар авиаг яаж тэмдэглэдэг байдлыг тодруулан үзэх нь төвөд үсэггүй болон монгол хэлний авиазүйг хэрхин ойлгож ирсэн уламжлалыг судлахад багагүй сонирхолтой юм. Гэвч энэ бүхнийг нарийвчилан судласан зүйл одоо болтол гараагүй тул монгол хэлийг тэмдэглэх төвөд үсгийн тогтолцоог гаргах, мөн түүнчилэн монгол газар төвөдийн соёл боловсрол ямар ямар зам чийрээр хэрхин дэлгэрсэнийг тодруулах ач холбогдол бүхий Төвөд хэлний монгол аялгууны тухай, одоо яаравчилахгүй бол цаг алдах, нэгэн сонин сэдэв судлах эзнээ хүлээсээр байгааг номын мөр хөөх эрмэлзэл бүхий залуу судлагч нартаа дурдахын сац хэрэвзээ энэ сэдэвийг сонирхон судлах хүн байваас төвөдөөр үгчилсэн хэрэглэгдэхүүн нэгэн чухал судлагдахуун болж өгөх болно гэдгийг нэмэн сануулсу.

Энэ бөлөгт дурдсан зүйлийг бүхэлд нь авч үзвэл, монголчуудын хэрэглэж ирсэн олон зүйл бичиг үсгийн галиглах тогтолцоо нь нэгд, гадаад тийшээ, тухайлбал: шашин суртал улс төрийн харилцаа холбоо бүхий төвөд, энэдхэг, хятад, манж, орос зэрэг улс орнуудын хэл, бичгийг тэмдэглэх; хоёрт, дотоод тийшээ, тухайлбал: тэр цагийнхаа хэлшинжлэлийн хөгжил ололтын хэрээр монгол хэл болон монгол хэлний тухайлбал: халх, ойрод, буриад зэрэг нутаг нутгийн аялгууны өвөрмиц онцлогийг ёсочилон тэмдэглэх хоёр гол зарчимтай байсан ажээ.

Үүнээс, гадаад хэлний хэрэглэгдэхүүнийг галигласан баримт сэлтийг нэгэн цогц болгож үзвэл, монголчуудын өөрсдийнхи нь боловсруулан хэрэглэж ирсэн бичиг үсгүүдийн галигийн тогтолцоо

1. Самгард болон энэдхэг европ овогийн зарим хэл,
2. Төвөд хэл,
3. Хятад хэл,
4. Япон, солонгос зэрэг Зүүн хойд Азийн хэл,
5. Манж хамниган язгуурын хэл,
6. Орос зэрэг слав язгуурын хэл

хийгээд тэдгээр хэлний бичгийнхи нь дурсгалыг галиглах бүрэн боломжтой байсан бөгөөд хоцрол дурсгал нь их бага аль нэгэн хэмжээгээр бидний үед хүрэлцэн иржээ.

Ийнхүү бичиг үсгийнхээ галиглах тогтолцоог улам боловсронгуй болгох оролдолго эрт цагаас өдгөө хүртэл тасралтгүй үргэлжлэсээр ирсэн бөгөөд 1936 онд монгол бичигээр орос зэрэг гадаад нэрийг хэрхин зөв бичих тухай Ринчен багштаны бичсэн өгүүлэл үүний нэг батлагаа болно²⁸.

Эцэст нь тэмдэглэхэд монголчууд өөрсдийн боловсруулан хэрэглэж ирсэн бичиг үсгийн хажуугаар монгол бичгээс эх авсан манж болон өөр тогтолцоо бүхий төвөд үсгээр монгол хийгээд харь хэлний хэрэглэгдэхүүнийг галиглаж ирсэн туршилга буй боловч энэ нь тухайн бичиг үсэг мэдэгчийн хүрээгээр хязгаарлагдаж байсан гэдгийг дурдвал зохино (7, 8-дугаар хавсралтыг үзмүү).

²⁸ Rinchen, *Mong'ol üsüg-iyer oros-un jerge yadayadu-yin neres-i jöb biäkü tuqai*, - Sin-e toli, N. 3-4, Ulaanbaᠭᠰatur, 1936, 188-191.

Самгард, төвөдийн анги

А. Самгардын анги

А. 1. Эгшиг үсэг

1. Самгард бичиг	अ	आ	इ	ई	उ	ऊ	ऋ	ॠ
2. Төвөд бичиг	ཨ	ཨུ	ཨི	ཨී	ཨུ	ཨུ	ཨི	ཨི
3. Монгол бичиг	ᠠ	ᠠ	ᠢ	ᠢ	ᠤ	ᠤ	ᠤ	ᠤ
4. Тод бичиг	ᠠ	ᠠ	ᠢ	ᠢᠠ	ᠤ	ᠤᠠ	ᠤ	ᠤᠠ
5. Соёмбо бичиг	1	1a	2	2a	4	4a	42	42a
6. Хэвт. дөрвөлжин	1	1a	2	2a	4	4a	47	47a
7. Латин галиг	a	ā	i	ī	u	ū	r	r̄

1. Самгард бичиг	इ	ई	ए	ऐ	ओ	औ	अं	अः
2. Төвөд бичиг	ཨི	ཨི	ཨེ	ཨེ	ཨོ	ཨོ	ཨོ	ཨོ
3. Монгол бичиг	ᠢ	ᠢ	ᠡ	ᠡ	ᠢ	ᠢ	ᠢ	ᠢ
4. Тод бичиг	ᠢ	ᠢᠠ	ᠡ	ᠡ	ᠢ	ᠢ	ᠢ	ᠢ
5. Соёмбо бичиг	43	43a	3	3a	6	6a	44	45
6. Хэвт. дөрвөлжин	48	48a	3	3a	6	6a	-	-
7. Латин галиг	i	ī	e	ai	o	au	aṃ	aḥ

А. 2. Гийгүүлэгч үсэг

1. Самгард бичиг	क	ख	ग	घ	ङ	च	छ	ज
2. Төвөд бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ
3. Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ
4. Тод бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ
5. Соёмбо бичиг	10	11	46	47	12	13	14	48
6. Хэвт. дөрвөлжин	10	11	38	39	12	13	14	40
7. Латин галиг	ka	kha	ga	gha	ṅa	ca	cha	ja

1. Самгард бичиг	झ	ञ	ट	ठ	ड	ढ	ण	त
2. Төвөд бичиг	ᠵ	ᠠ	ᠲ	ᠳ	ᠣ	ᠤ	ᠨ	ᠤ
3. Монгол бичиг	ᠵ	ᠠ	ᠲ	ᠳ	ᠣ	ᠤ	ᠨ	ᠤ
4. Тод бичиг	ᠵ	ᠠ	ᠲ	ᠳ	ᠣ	ᠤ	ᠨ	ᠤ
5. Соёмбо бичиг	49	15	50	51	52	53	54	16
6. Хэвт. дөрвөлжин	41	15	30	31	32	33	34	16
7. Латин галиг	jha	ṇa	ṭa	ṭha	ḍa	ḍha	ṇa	ta

1. Самгард бичиг	थ	द	ध	न	प	फ	ब	भ
2. Төвөд бичиг	ᠲ	ᠨ	ᠳ	ᠨ	ᠲ	ᠳ	ᠲ	ᠳ
3. Монгол бичиг	ᠲ	ᠨ	ᠳ	ᠨ	ᠲ	ᠳ	ᠲ	ᠳ
4. Тод бичиг	ᠲ	ᠨ	ᠳ	ᠨ	ᠲ	ᠳ	ᠲ	ᠳ
5. Соёмбо бичиг	17	55	56	18	19	20	57	58
6. Хэвт. дөрвөлжин	17	43	44	18	19	20	45	46
7. Латин галиг	tha	da	dha	na	pa	pha	ba	bha

1. Самгард бичиг	ᠰ	ᠶ	ᠷ	ᠯ	ᠪ	ᠰ	ᠪ	ᠰ
2. Төвөд бичиг	ᠰ	ᠶ	ᠷ	ᠯ	ᠪ	ᠰ	ᠪ	ᠰ
3. Монгол бичиг	ᠰ	ᠶ	ᠷ	ᠯ	ᠪ	ᠰ	ᠪ	ᠰ
4. Тод бичиг	ᠰ	ᠶ	ᠷ	ᠯ	ᠪ	ᠰ	ᠪ	ᠰ
5. Соёмбо бичиг	21	22	23	25	24	26	59	27
6. Хэвт. дөрвөлжин	21	22	23	24	25	26	42?	27
7. Латин галиг	ma	ya	ra	la	va	ça/sa	sa	sa

А. 3. Нийлмэл гийгүүлэгч

1. Самгард бичиг	ᠬ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ
2. Төвөд бичиг	ᠬ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ
3. Монгол бичиг	ᠬ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ
4. Тод бичиг	ᠬ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ	ᠬᠠ
5. Соёмбо бичиг	28	29	60	61	62	63	64
6. Хэвт. дөрвөлжин	28	29	-	49	-	-	-
7. Латин галиг	ha	kṣa	kya	kra	kla	kva	kka

1. Самгард бичиг	:	ञ	ण	न्त	म्प	ल्क	श्क	स्क	र्क
2. Төвөд бичиг	:	ᠵᠠ	ᠵᠡ	ᠵᠢ	ᠵᠣ	ᠵᠤ	ᠵᠥ	ᠵᠦ	ᠵᠦ
3. Монгол бичиг	:	ᠵᠠ	ᠵᠡ	ᠵᠢ	ᠵᠣ	ᠵᠤ	ᠵᠥ	ᠵᠦ	ᠵᠦ
4. Тод бичиг	:	ᠵᠠ	ᠵᠡ	ᠵᠢ	ᠵᠣ	ᠵᠤ	ᠵᠥ	ᠵᠦ	ᠵᠦ
5. Соёмбо бичиг	:	66	67	68	69	70	71	72	73
6. Хэвт. дөрвөлжин	:	-	-	-	-	54	-	53	52
7. Латин галиг	:	ñca	ñta	nta	mpa	lka	çka	ska	rka

В. Төвөдийн анги

В. 1. Эгшиг үсэг

В. 2. Гийгүүлэгч үсэг

1. Төвөд бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
2. Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
3. Тод бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
4. Соёмбо бичиг	2	4	3	6
5. Хэвт. дөрвөлжин	2	4	3	6
6. Латин галиг	i	u	e	o

ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
10	11	46	12
10	11	38	12
ka	kha	ga	na

1. Төвөд бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
2. Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
3. Тод бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
4. Соёмбо бичиг	74	75	76	15	16	17	55	18
5. Хэвт. дөрвөлжин	-	-	-	15	16	17	43	18
6. Латин галиг	ca	cha	ja	na	ta	tha	da	na

1. Төвөд бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
2. Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
3. Тод бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
4. Соёмбо бичиг	19	20	57	21	13	14	48	24
5. Хэвт. дөрвөлжин	19	20	45	21	13	14	40	25
6. Латин галиг	pa	pha	ba	ma	ca	cha	ja	va

1. Төвөд бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠡ	ᠢ	ᠣ
2. Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠡ	ᠢ	ᠣ
3. Тод бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠡ	ᠢ	ᠣ
4. Соёмбо бичиг	77	78	79	22	23	25	26	27
5. Хэвт. дөрвөлжин	35	36	37	22	23	24	26	27
6. Латин галиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠡ	ᠢ	ᠣ

1. Төвөд бичиг	ᠠ	ᠡ
2. Монгол бичиг	ᠠ	ᠡ
3. Тод бичиг	ᠠ	ᠡ
4. Соёмбо бичиг	28	1
5. Хэвт. дөрвөлжин	28	1
6. Латин галиг	ha	a

В. 3. Нийлмэл гийгүүлэгч

1. Төвөд бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠡ	ᠢ	ᠣ
2. Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠡ	ᠢ	ᠣ
3. Тод бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠡ	ᠢ	ᠣ
4. Соёмбо бичиг	60	61	62	63	73	70	72	-
5. Хэвт. дөрвөлжин	-	49	-	-	-	-	-	-
6. Латин галиг	kyā	kra	kla	kva	rka	lka	ska	rkyā

1. Төвөд бичиг					
2. Монгол бичиг					
3. Тод бичиг					
4. Соёмбо бичиг	-	-	-	-	-
5. Хэвт. дөрвөлжин	-	-	-	-	-
6. Латин галиг	skya	skra	rcva	grva	phyva



Тэмдэглэх нь: Дээрхи жагсаалтад, ялангуяа нийлмэл гийгүүлэгчийн тухайд (-) тавьж орхисон газар нэлээн хэд буй. Энэ нь тухайн бичгээр уг хэрэглэгдэхүүнийг бичиж болохгүй гэсэн үг бус харин бидний түрүү түрүүчийн бөлөгт орсон жагсаалтад тэр хэвээрээ хамрагдаагүй гэсэн санаа болно.

Манж, хамниганы анги

No.	Манж үсэг			галиг (tc.)
	Эхин	дунд	адаг	
01	ᠠ	ᠡ	ᠢ	a
02	ᠣ	ᠤ	ᠤ	e
03	ᠤ	ᠤ	ᠤ	i
04	ᠤ	ᠤ	ᠤ	o
05	ᠤ	ᠤ	ᠤ	û(u)
06	-	ᠤ	ᠤ	û(ô)
07	ᠨ	ᠨ	ᠨ	n
08	-	ᠨ	ᠨ	ng
09	ᠨ	ᠨ	-	q
10	ᠨ	ᠨ	-	k
11	ᠨ	ᠨ	ᠨ	γ
12	ᠨ	ᠨ [ᠨ]	ᠨ	g
13	ᠨ	ᠨ	-	χ
14	ᠨ	ᠨ [ᠨ]	-	x
15	ᠨ	ᠨ [ᠨ]	ᠨ	b
16	ᠨ	ᠨ	ᠨ	s
17	ᠨ	ᠨ	-	š
18	ᠨ	ᠨ	-	t(a)
19	ᠨ	ᠨ	-	t(e)
20	ᠨ	ᠨ	ᠨ	d(a)
21	ᠨ	ᠨ	ᠨ	d(e)
22	ᠨ	ᠨ	ᠨ	l
23	ᠨ	ᠨ	ᠨ	m
24	ᠨ	ᠨ	-	c

No.	Манж үсэг			галиг
	Эхин	дунд	адаг	(tc.)
25	ᠠ	ᠡ	-	j
26	ᠢ	ᠣ	-	y
27	-	ᠤ	ᠥ	r
28	ᠠ ᠢ	ᠠ ᠢ	-	f
29	ᠠ	ᠢ	-	w/v
30	ᠨ	ᠨ [ᠨ]	-	p
31	ᠨ	ᠨ [ᠨ]	-	k
32	ᠨ	ᠨ [ᠨ]	-	g
33	ᠨ	ᠨ [ᠨ]	-	x
34	ᠨ	ᠨ	ᠨ	ʃ
35	ᠨ	ᠨ	-	c
36	ᠨ	-	-	č
37	ᠨ	-	-	ʃ
38	ᠨ	-	-	z

26
 2
 1
 2
 3
 4
 5
 6
 7
 8
 9
 10
 11
 12
 13
 14
 15
 16
 17
 18
 19
 20
 21
 22
 23
 24
 25
 26
 27
 28
 29
 30
 31
 32
 33
 34
 35
 36
 37
 38
 39
 40
 41
 42
 43
 44
 45
 46
 47
 48
 49
 50
 51
 52
 53
 54
 55
 56
 57
 58
 59
 60
 61
 62
 63
 64
 65
 66
 67
 68
 69
 70
 71
 72
 73
 74
 75
 76
 77
 78
 79
 80
 81
 82
 83
 84
 85
 86
 87
 88
 89
 90
 91
 92
 93
 94
 95
 96
 97
 98
 99
 100



Дөрвөлжин бичигээр хятад хэлээр бичсэн тамгын дардасууд



1801 онд гарсан хятад монгол ярианы зурагт дэвтэрийн нэг хуудас
(Энд хятад дуудалгыг манжаар хаджээ)

ТӨВ АЗИЙН АРД ТҮМНИЙ БИЧИГ СОЁЛЫН ТҮҮХНЭЭ МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧГИЙН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Монгол туургатны үсэг бичгийн түүхийг авч үзэхүл өвөг дээдсийнхээ үеэс эхлэн арав гаруй бичгийн тогтолцоог хэрэглэж ирсэн тухай дээр өгүүлсэн билээ.

Ер нь дэлхий дахинаа олон улс үндэстэн өдий төдий бичиг үсэг хэрэглэсээр байгаа боловч тэр олон бичгийн тогтолцоо нь цөм хүн төрлхитөний түүхийн өнө эрт үед буй болсон тоотойхон хэдэн бичгийн уламжлалд хамаардаг ажээ. Өөрөөр хэлбэл урдахи уламжлалаас ор тас салангид, өөр бичиг үсгийн нөлөө тусхал огт аваагүй, цоо шинээр зохион хэрэглэсэн бичиг гэж байхгүйг дэлхийн олон улс үндэстний бичиг үсгийн түүх бэлхэнээ харуулж өгдөг.

Монголчуудын түүхийнхээ туршид авч боловсруулан хэрэглэж ирсэн үсэг бичгийн түүх ч энэ нийтлэг уламжлалаас салангид байсангүй. Ийнхүү монголчууд соёлын хувьд нэгэн хүрээнд багтаж байсан бусад ард түмнээс үсэг бичгийг уламжлан авч оюун ухааныхаа хүчээр монгол хэлнийхээ зүй тогтолд таацуулан боловсруулж байсан нь зөвхөн нэгэн талын асуудал бөгөөд энэ талаар нэлээд судлагаа гарсан байна.

Нөгөө талаас нь авч үзвэл монголчууд үсэг бичиг авч хэлэндээ тохируулан боловсруулж хэрэглээд зогссонгүй, хөрш зэргэлдээ оршиж нутаг савлан аж төрдөг болон соёл боловсрол хийгээд улс төрийн хувьд хэлхээ холбоотой, Төв Азийн бусад ард түмний үсэг бичгийн хөгжилд гүнзгий нөлөөлж байсан нь тохиолдлын чанартай, ганц нэгийн төдий байгаагүй нь эрдэмтдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн боловч ерөнхийд нь нэгтгэн дүгнэж үзсэн бүтээл энэ хир гарч чадаагүй байна. Ийм нэгдсэн судлагаа гарах нь зөвхөн монгол үсэг бичгийн түүхэнд төдийгүй нийт монголын судлалд цаашилбал Төв Азийн олон ард түмний соёлын түүхэнд чухал ач холбогдолтой болох нь маргаангүй бөлгөө.

1. Зөрчид бичиг Хятан нарын бичигтэй холбогдох нь

Монголоор Зөрчид гэдэг ард түмний нэр эртний нангиад судар түүхнээ олон янзаар тэмдэглэгдэн үлджээ. Үүнд: Гурван улс (220-280)-ын үед *илоу* (𐰽𐰺𐰍), Умард Вэй улс (386-535)-ын үед *уцзи* (勿吉), Сүй (589-619) болон Тан улс (618-907)-ын үед *мохэ* (𐰽𐰺𐰍) гэж байснаа Хятаны Ляо улс (906-1125)-ын үеэс *Нюйчжэн* (女真) хэмээн нэрлүүлэх болсон ажээ. Энэхүү нюйжэн гэдэг үгийн үүслийн талаар эрдэмтэд тайлбарлахдаа одсогийн Дүнбэй нутгийн дорнод хэсэгт нутаглан байсан хамниган аймгийнханыг нэрлэдэг байсан *зөрчин* буюу *зөрчид* гэдэг нэрийн гажсан дуудалга хэмээн үздэг¹. Хятан нар *нюйжэн* гэдэг нэрийг *нюй-жи* гэх болсон нь эцэг эх, өвөг дээдэс болон эрхэм хүндтэй хүнийхээ нэрийг хэлэлгүй цээрлэдэг монгол заншилтай холбоотой хэмээн тайлбарладаг. Учир нь Син-зүн хэмээх өргөсөн нэртэй хааныхаа Зүн-жэн хэмээх нэрийн хоёрдугаар үе буюу *жэн* (眞) гэдэгийг хэлэхээсээ цээрлэж, эерүүлэх зорилгоор *жи* болгосонтой холбоотой гэнэ².

Түүхийн тавцанаа Алтан Улс (1115-1234)-аа байгуулсан Зөрчид нарын түүхийг үзэхүл Хятан нар тэдний нийгэм соёлын олон салбарт онцгой нөлөөтэй байсан ажээ. Энэ талаар энд тэнд тэмдэглэгдсэн нь цөөнгүй³. Тийм ч учраас 1002 онд зөрчидийн тэргүүн нь

¹ Е Лүн-ли, *История государства Киданей*, Москва, 1979, стр. 348.

² Е Лүн-ли, *История государства Киданей*, Москва, 1979, стр. 348.

³ *Altan ulus-un sudur*, Batuvčir-un orčiyulь-a, Neyite yisün debter, 1930 (Гар бичмэл)

аж амьдралын аливаа зүйлд сургахаар хүүгээ Ляо улсын хааны ордонд явуулж байсан ба 1021 онд зөрчидийн нөлөө бүхий 30 овогийн удирдагч мөн ийм хүсэлтэйгээ Ляо улсад илэрхийлсэн баримт байдаг⁴.

Бидний сонирхон буй сэдэвтэй шууд холбоотой баримт "Алтан улсын судар"-ын тэргүүн дэвтэрт байгааг эшлэвэл:

...Алтан улсад язгуураас бичиггүй. Улс улмаар түрэмхий (хүчирхэг Ц. Ш.) болох тулд ойрхи улс зохицож хойш урагшид цөм Дайляо улсын бичгийг хэрэглэх бөлгөө. Тайзү хаан, түүний Си -ин нэрт түшмэлд өөрийн улсын бичгийг үүсгэн бичигтүн! Хэв хэмжээ (дүрэм Ц. Ш.) байгуул! хэмээн тушаавай. Си - ин хятад бичгийг дууриан Дайляо улсын бичгийг дагаж түүний улсын үгэнд нийлүүлэн, Нюй-жи -гийн бичгийг эхлэн бичиж Тайзү хаанд хүргэж ирсэнийг хойно хаан их л баярлаж олонд тархааж Си - инд нэгэн морин нэгэн зэрэг хувцас шагнавай...⁵

гэсэн байдаг.

Бичиг зохиосон он цагийн хувьд судлагчид санал нэгдэж чадаагүй бөлгөө. Үүнд: Осибучи 1116 он⁶, Сү Пинг-чан 1121 он⁷ гэж үзсэнээс гадна "Их Алтан улсын түүх"-нээ 1122 он⁸ гэж үзжээ. Эшлэлд дурдсан Тайзү (太祖) хааны жинхэнэ нэр Агуда, бөгөөд 1113 онд зөрчидүүдийн удирдагч болж 1115 онд зөрчидийн Алтан улсыг байгуулж анхны хаан ширээнд суугаад 1123 онд нарс элсэн хүн.

Зөрчидөч эрдэмтэн М. В. Воробьев олон баримт сэлтийг харьцуулан судлаад зөрчидийн "их" бичгийг 1119 онд хятаны "их" бичигт үндэслэн зохиожээ хэмээн дүгнэсэн нь нарийн хянан тохиолдуулсан он цаг гэж үзэх бүрэн үндэстэй юм⁹.

Гэвч тэрхүү бичиг нь тийм ч сайн боловсорч чадаагүй ажээ. Тэгээд ч Алтан улсын гутгаар хаан (1135-1149) Хула¹⁰ хэмээх Си-зүнгийн үед зөрчидийн "бага" бичгийг зохион хэрэглэх болжээ¹¹. Үүнээс эхлэн 1119 онд эхлэн зохиосон бичиг нь "их" гэгдэх болж 1145 оноос хоюулаа зэрэг хэрэглэгдэж байснаа 1191 оноос "их" бичиг шахагдан улмаар хэрэглэгдэхээ больжээ¹². Сүүлд зохиосон эл "бага" бичгийг 1138 онд Си-зүн (熙宗) хаан зохиосон гэдэг мэдээ¹³ буй боловч тэр хааныг зохиосон гэхэд түүнийг үгүйсгэхээр олон баримт гарч ирдэг бөлгөө.

М. В. Воробьев, *Чжурчжэнь и государство Цзинь*, Москва, 1975; М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983.

⁴ М. В. Воробьев, *Чжурчжэнь и государство Цзинь*, Москва, 1975, стр.

⁵ *Altan ulus-un sudur*, Batuvčir-un orčiyul-y-a, Neyite yisün debter, 1930 (Гар бичмэл), тэргүүн дэвтэр; М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 151-152.

⁶ Осибучи Хадзимэ, *Воспоминание о поездке и стела с чжурчжэньскими письменами* - Сигаку кенкю, Хирошима, 1934, т. Y1, N. 2 (М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 296)

⁷ Hsu Ping-ch'ang, *Notes on the Epitaph on Wan Yen Hsi Yin of the Chin Dynasty*, - Shihhsue chikan (Historical Journal), Peiping, 1937, N 3 (М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 152).

⁸ *Да Цзинь го жи*, Госюе взньку, т. 41, Шанхай, 1937, цз. 2 (М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 152).

⁹ М. В. Воробьев, *Чжурчжэнь и государство Цзинь*, Москва, 1975, стр. 110, 411; М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 152.

¹⁰ М. В. Воробьев энэ нэрийг Хэла гэж тэмдэглэжээ (М. В. Воробьев, *Чжурчжэнь и государство Цзинь*, Москва, 1975, стр. 383)

¹¹ *Цзинь ши*, Сыбу бэйяо, т. 90-91, Шанхай, 1939, цз. 4 (М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 152).

¹² М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 152.

¹³ М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 152.

"Алтан улсын судар"-ын гутгаар дэвтрээс үзвэл 15 жил хаан сууринд сууж гучин нэгэн настайдаа хорлуулж үхсэн энэ хаан нэгэн удаа сүмд очиж залбирахдаа:

...Би багын цагт жарган амьдарч бичиг сурахыг мэдэхгүй (байв). Сар жилийг хоосоор өнгөрүүлсэндээ эдүгээ тэсхэл үгүй гомдумуй... Аливаа хүмүүн сайн болсугай хэмээвээс хичээхгүй болвоос болохгүй хэмээв. Түүнээс Сү-шинг, Лүн-июй, Таван улсын бичиг, Дайляо улсын бичиг, зүйл зүйлийн бичигийг шөнө өдөргүй үзэвэй...¹⁴

гэж байдаг боловч намтрын хэсэгт нь олон эрдэмтнийг хороож, олон сайдыг хөнөөсөн тухай, бичгийн утга учрыг өөрөө сайтар ухахгүй тул өшөөт хүнийхи нь хорт үгэнд итгэж бичгийнхээ ухаант түшмэлийг жанчиж үхэхгүй тул хутгаар ам руу нь бүлж алсан тухай, яв явсаар төрийн хэргийг огоорч архи өнгөнд шунасаар хорлуулж үхсэн тухай дурдсан байдаг. Ер бичиг зохиосон гэх үг санаа огт дайралддаггүй. Энэ бүхнээс үзэхэд Си-зүн хаан зөрчидийн "бага" бичгийг зохиосон гэх учир шалтгааны үндэс байхгүй гэж бодогдоно.

Зөрчидүүд хэдийгээр ийнхүү үндэсний бичигтэй болсон боловч Алтан улсын түүхийг бүхэлд нь авч үзэхэд соёл боловсролын хүрээнд хятан хэл, хятан бичгийн нөлөө урьдын адил хүчтэй байсаар байсан, хятан орчуулгаар дамжуулж нангиадын ном зохиолтой танилцаж¹⁵, зөрчид бичгийнхээ хажуугаар хятан хэл бичгийг хаан, бичиг цэргийн жанжинуудаасаа эхлэн цөм шамдан сурч байсан, бичгийн түшмэл болох хүнээс хятан хэл, хятан бичгийн зохих боловсрол шаарддаг байсан тухай едий төдий баримт нутлагаа тохиолддог билээ¹⁶.

"Алтан улсын судар"-т байгаа, бидний сонирхолыг татсан нэгэн хэсгийг эшлээ. Энд Алтан улсын цэргийн жанжин Мэүлиянхү хэмээгч баруун гарын их цэргээ авч Дайляо улсын цэрэгтэй тулалдаж явсан тухай хэсэгт:

... нэгэн хүмүүн Мэүлиянхү-г ташааран харваж оносны хойно Мэүлиянхү өнгө царай бага харин (өөрчлөгдөн Ц.Ш.) хувилсангүй, сумыг татан авч, хаан мэдвээс харвасан хүнийг ялалуузай хэмээж өвөдмүй хэмээн хуурмаглан гэрт эгж хоёр сар хэвтээд, Дайляо улсын их, бага бичгийг сурвай...¹⁷

гэж байгаа нь нэгд, өнөөдрийн бидний ухаарлын хирээр, тэр жанжин дайсныхаа хоёр зүйлийн бичгийг махран сурсан гэж буй мэдээ, хоёрт, хятан буюу Дайляо улсын "их", "бага" бичиг гэдэг үг зүй ёсоор бидний сонирхолыг татаж байна.

Үүнтэй холбож бодвол, зөрчидөч эрдэмтэн М.В. Воробьев 1138 онд зохиосон зөрчид бичгийг хятаны "бага" бичигт үндэслэсэн гэж үзээд "зөрчид бага бичиг"¹⁸ гэж нэрлэсэн нь улам ч батлагаатай болж байгаа юм.

Гэвч зөрчидийн "бага" бичиг нь тэмдэглэх чадвараараа хятан бичгийн хэмжээнд хүрээгүй нь хятан бичгийн нөлөө хуучин шигээ хэвээрээ байсаар байхын нэгэн үндэс болсон гэж хэлэх үндэс буй. Алтан улсын Үлү хэмээх Ши-зүн (世宗) хаан (1161-1189) 1180 онд хятан бичгийг их л алсын хараатай, төгс төгөлдөр зохиосон бичиг гэж үнэлээд:

¹⁴ *Altan ulus-un sudur*, Batuvčir-un orčiyulγ-a, Neyite yisün debter, 1930 (Гар бичмэл), гутгаар дэвтэр;

¹⁵ М. В. Воробьев, *Чжурчжэнь и государство Цзинь*, Москва, 1975, стр. 315; М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 155.

¹⁶ *Altan ulus-un sudur*, Batuvčir-un orčiyulγ-a, Neyite yisün debter, 1930 (Гар бичмэл), гутгаар дэвтэр, тэргүүн дэвтэр; М. В. Воробьев, *Чжурчжэнь и государство Цзинь*, Москва, 1975, стр. 315; М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 155.

¹⁷ *Altan ulus-un sudur*, Batuvčir-un orčiyulγ-a, Neyite yisün debter, 1930 (Гар бичмэл), тэргүүн дэвтэр;

¹⁸ М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 152.

...Зөрчидийн шинэ бичиг түүнээс давж чадсангүй...

гэж харамсан өгүүлсэн мэдээ "Алтан улсын судар"-т байдаг гэдгийг М.В. Воробьев бүтээлдээ тэмдэглэсэн нь үүний бодтой батлагаа буюу.¹⁹

Дээр дурдсан зүйлийг бүхэлд нь авч үзэхүл Зөрчидүүд угтаа өөрийн гэсэн үндэсний бичиггүй байсан бөгөөд үсэг бичгийн зайлашгүй шаардалга гарахад хөрш зэргэлдээ оршдог Хятан нарын бичгийг авч хэрэглэх болжээ. Яв явсаар хүчирхэгжиж 1115 онд Зөрчидийн Алтан улс гэдэгээ байгуулахад тэр цагт тусгаар улсын бэлгэ тэмдэгийн нэг - өөрийн гэсэн бичиг үсэгтэй болох амин чухал шаардалгаар хуучин уламжлалаа баримтлан хятаны "их" бичигт тулгуурлан зөрчидийн "их" бичгээ 1119 онд зохион хэрэглэх болжээ. Гэвч уг бичиг төдий л нарийн боловсроогүй тул сайжруулах зорилгоор зөрчид нар 19 жилийн дараа буюу 1138 онд мөн л хятаны "бага" бичигт сууриласан зөрчид "бага" бичгээ боловсруулан хэрэглэж эхлэжээ. Хэдийгээр ийнхүү удаа дараа өөрийн гэсэн бичигтэй болсон боловч төгс нарийн боловсорч хараахан чадаагүй тул зөрчид бичгийнхээ зэргэцээ хятан бичгийг давхар хэрэглэсээр ирсэн ажээ.

Зөрчидүүд хятаны Ляо улстай илэрхий дайсагналцаж мөхөөснийхээ дараа ийнхүү хятан үсэгт үндэслэсэн зөрчид бичгийг боловсруулан хэрэглэх болсон нь ямар учир холбогдолтой вэ? Өөр үсэгт үндэслэж үндэснийхээ бичгийг зохиож болоогүй юм уу? Бас зөрчид бичгийн хажуугаар хятан хэл бичгийг хэрэглэх, сурахыг төрийн зүгээс хөхиүлэн дэмжиж байсны учир шалтгаан юу вэ? гэдэг асуулт зүй ёсоор гарна.

Энэ нь юуны өмнө уламжлалаа дагаж баримтласан хэрэг гэж хэлэх үндэстэй юм. Учир юун хэмээвээс, хятаны бичиг үсэг нь Алтай язгуурын зөрчид хэлний онцлогт хамгийн тохиромжтой байсан төдийгүй тухайн цагтаа зөрчид хэлний талаас авч үзэхэд хамгийн боловсронгуй бичиг болж байсантай холбоотой буй заа. Үүнийг ч дээр дурдсан баримт хэрэглэгдэхүүн зохих хэмжээгээр нутлан өгч байна.

Түүхэн хувь заяаны эрхээр зөрчидүүд монгол туургатантай янз бүрийн учир шалтгаанаар холбогдож Монгол газар ул мөрөө үлдээсний баримт бас бус буй. Тухайлбал: 1986 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс Хэнтий, Дорнод аймагт илгээн ажиллуулсан бичгийн дурсгал сурвалжлах зорилго бүхий (энэ номыг бичигч, доктор Б. Сумъяабаатар нарын бүрэлдэхүүнтэй) шинжээний ангийнхан Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутаг, Хэрлэн мөрний өмнөд биед орших Сэрвэн хаалганы бичээсийг олж эрдэм шинжилгээний гүйлгээнд оруулсан билээ²⁰. Үүнээс өмнө уг бичээсийн талаар нийтлэгдсэн зүйл үгүй боловч доктор Х. Пэрлээ монголын нутаг дэвсгэрээс олдсон хятан бичгийн талаархи, хэвлүүлж амжаагүй тойм өгүүлэлдээ эл дурсгалын талаар дурдсан байх бөгөөд үүнийг хятан бичиг хэмээн үзсэн бололтой²¹.

Энэ бичээсийг гурван хэсэг хадат толгойн бусдаасаа том, хойд талын толгойн дунд биед, наран ургах зүг хандсан хөмөг хаднаа 150 орчим үсгийг есөн мөр болгон цохиж сийлжээ. Ерөнхийдөө бараг эвдэрч гэмтээгүй тул үсгийн тэмдэгтийг тодруулан үзэх боломжтой. Түүнээс хойхно, арваад метрийн зайд өөр нэгэн босоо хаднаа хятад бичээс буй бөгөөд цагийн эрхээр үлэмжхэн гэмтэж энд тэнд цөөн хэдэн тэмдэгт үлдсэн бөгөөд тухайн цагийн уламжлалаар зөрчид бичээсийн орчуулга гэж үзэх үндэс буй. Бичигт толгойн зүүн өмнөд бэлээр ойр ойрхон хэдэн дөрвөлжин булш оршино (*1-р хавсралт дахи гэрэл зургийг үзмүү*).

Зөрчидүүдтэй шууд холбогдох хадны бичээс сэлтийг өрөнхийд нь авч үзвэл одоогийн байдлаар Алтан улсын үед хамаарах нь хорь арай хүрдэггүй, түүнээс хожуу

¹⁹ Цзинь ши, Сыбу бэйяо, т. 90-91, Шанхай, 1939, цз. 51, стр. 326 (М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр).

²⁰ Ц. Шагдасрүрэн, *БНМАУ-ын нутгаас олдсон хятан, зөрчид бичгийн дурсгал* - Олон Улсын монголч эрдэмтний Ү их хурал, Ш салбар хуралдаан, Улаанбаатар, 1966 он.

²¹ Д. (Х) Пэрлээ, *Киданьские надписи на территории МНР*, гар бичмэл, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн хөмрөг.

үеийнхн гэхэд мөн л тэр орчим байгаа бөгөөд тэдгээр нь таван зуугаад жилийн дотор буй болсон гэж судлагчид тооцоолдог бөлгөө²².

Судлагаанаас үзэхүл дээр дурдсан дөч орчим дурсгалыг дотор нь хэд ангилан үздэг байна. Үүнд:

- а. Нангиад орчуулга бүхий хоёр хэлний дурсгал;
- б. Алтан улсын үед холбогдох дан хятад хэлээрхи дурсгал;
- в. Дан зөрчид хэлээрхи дурсгал

гэж үздэг бөгөөд дан зөрчид хэл, зөрчид бичгээрхи дурсгал харьцангуй ховор байдаг байна²³.

1894 онд Жөнөвт болсон Олон Улсын Дорнодахины судлалчдын Х Их хуралд проф. В. Грубе (W. Grube) Мин Улс (1368-1644)-ын үеийн Орчуулагчдын Товчооны хэрэглэгдэхүүн болох *Хуа-йи йи-юу* (Houa-yi yi-yu) толийн гарбичмэл эхийн тухай илтгэл тавьж уг дурсгал дахи нангиад-зөрчид толь болон нангиад-зөрчид хадмал хорин зүйлийн бичвэрийн судлагааг танилцуулсан нь зөрчид хэл, бичгийн судлагаанд анхны шинэ алхам болсон гэж үзэх бүрэн үндэстэй юм (2-р *хавсралтыг үзмүү*). В. Грубе хоёр жилийн дараа уг дурсгалуудын дэлгэрэнгүй судлагааг гаргажээ²⁴.

1953 онд академич Л. Лигети В. Грубегийн бүтээлд тулгуурлаж зөрчидийн "бага" бичгийг тайлж унших талаар нэгэн чухаг өгүүлэл бичиж түүндээ зөрчидийн "бага" үсгийг Мин (1368-1644) болон Чин улс (1644-1911)-ын үеийн хятад хэлний түүхэн авиазүй хийгээд ханз үсгийн хэлбэртэй давхар харьцуулан судлажээ. Академичийн энэ өгүүлэл нь хэмжээний хувьд төдий том бус боловч дараа дараагийн эрдэмтэд зөрчид бичгийг тайлж уншихад нэгэн гол үндэслэл болж өгсөн төдийгүй одоо ч гэсэн эрдэм шинжилгээний ач холбогдлоо алдаагүй байна.

Л. Лигети профессор энэ өгүүлэлдээ зөрчидийн бичгийн дурс үсгийн нэгэн хэсэг нь үл хувирдаг буюу үг-язгуур болдог, нөгөө хэсэг нь үеийн үүрэг гүйцэтгэдэг буюу нөхцөлийн чанартай дагаж ордог байна гэж хоёр ангилан үзжээ²⁵.

Зөрчид бичгийг тайлан уншсаны дүнд судлагааны бүтээлүүдийн зэргэцээ Япон, Хятад, АНУ-д хэд хэдэн толь бичгийн зүйл гарсан нь үндсэндээ дээр дурдсан Мин Улсын үеийн *Хуа-йи йи-юу* толь бичиг болон түүнд буй бичвэр дээр үндэслэсэн байдаг²⁶. Үүнтэй холбогдуулан *Йи-юу* маягийн толь бичиг нь тусхай бичвэрийн зүйлийг хамардагаараа бүтэцийн хувьд үндсэндээ адил байжээ гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал: Монгол хэлний *Хуа-йи йи-юу* толь-д ч нэгэн адил тусхай бичвэрүүд байдагийг бид мэдэх бөлгөө²⁷.

²² М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр. 159-160.

²³ М. В. Воробьев, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983, стр.159-160.

²⁴ W. Grube, *Note préliminaire sur la langue et l'écriture Jou-tchen* - T'oung Pao, T. V (1894) pp. 334 - 340. W. Grube, *Die Sprache und Schrift der Jučen*, Leipzig, 1896, p. 147.

²⁵ Louis Ligeti, *Note préliminaire sur le Déchiffrement des "petits caracteres" Joutchen*, - Acta Orientalia. Hung., Tom. III, Fasc. 3, Budapest, 1953, pp. 211 - 228.

²⁶ Gisaburo N. Kiyose, *A Study of the Jurchen language and Script Reconstruction and Decipherment*, Kyoto, 1974, p. 260;

Jin Qicong, *Nuzhenwen zidian* (Jurchen Dictionary), Peking, 1984, p. 300+67;

Dorj, *The First Research on the Pronounviation of Jurchen*, (in Chinese) - Өвөр монголын Их сургууль, Хөххот, 1983, 1-241;

Hesig, *The Resaerch on "Jurchen Guan Za Zi" and "Jurchen Guan Lai Wen"*, (in Chinese) - Өвөр монголын Их сургууль, Хөххот, 1983, 242-437;

Daniel A. Kane, *The Sino-Jurchen Vocabulary of the Bureau of Interpreters*, Indiana, Bloomington, 1989,

²⁷ Antoine Mostaert, *Le Matériel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*, I, édite par Igor de Rachewilts avec l'assistance de Antony Schonbaum, Bruxelles, 1977;

Дурдсан эрдэмтдийн тользүйн судлагаанд зөрчид бичгийг хэлбэрийн хувьд хятад болон хятаны "их", "бага" бичигтэй харьцуулсан судлагаа²⁸ хийгээд дээр дурдсан *Хуа-йи-йи-юу* маягийн толийн хэрэглэгдэхүүнээс гадна "*Зөрчид Гуан Жа Жу*" болон "*Зөрчид Гуан Лай Вэн*"²⁹ зэрэг өөр дурсгалын зүйлийн хамран үзсэн гэдгийг дурдалгүй орхих аргагүй.

2. Солонгос бичиг монголчуудын үсэг бичигтэй холбогдох нь

Солонгосын Жо-сөн улс (1392-1910)-ын дөтгөөр ван Сэжон (世宗 1397-1450) -гийн 25-р он буюу христусын тооллын 1444 онд зохиосон *Hunmin chông'ŭm* хэмээх солонгос авианы бичгийн талаар ярихын өмнө, үүнээс түрүү үед монголчууд хийгээд монгол хэл, бичгийн нөлөө тусгал Солонгост хир байсан талаар товч боловч авч үзэх нь зүйтэй гэж бодож байна.

Он цагийн дарааллаар авч үзвэл, өнөөдрийн бидний мэдэлгийн хирээр хятаны Ляо улс, Монгол хийгээд Юан гүрэнтэй улс төр, соёл, худалдаа арилжааны талаар Гуулин улс өргөн харилцаатай байж өдий төдий албан захидал бичилцэж, элчин төлөөлөгч солилцож байсан тухай, бийр бэх, бичгийн цаас, будаг шунх зэрэг бичиг соёлын хэрэглэгдэхүүн, түүнчлэн эмийн өвс ургамал зэрэг бусад эд таваарын зүйлийг Гуулин улсаас Монголд нийлүүлдэг байсан тухай урд өмнө нь монголын судлалд төдий л мэдэгдээгүй байсан олон баримт сэлтийг доктор Б. Сумъяабаатар монгол солонгос судлалын өргөн царатай асуудлаар удаа дараа бичсэн ном бүтээлдээ гаргаж эрдэм шинжилгээний гүйлгээнд оруулсан билээ³⁰. Тэдгээр мэдээний дотор бидний судлагдахуунд холбоотой хэд хэдэн чухал баримт байна. Үүнд: 995 онд хятан хэл сургахаар арван хүүхдийг Гуулин улсаас Хятаны хааны ордонд илгээж байсан тухай мэдээ *Гуулин улсын судар*-ын гутгаар дэвтэрт байдаг байна³¹. Бас мөн сударын 31-р дэвтэрт:

...Чүнрйөл вангийн 21-р он, хөхөгчин хонин жилийн хаврын тэргүүн сарын хар тахиа өдөр Юан улсаас монгол бичгийн багш Ли Мангодэй ирэв...

гэсэн мэдээ байдаг байна³². Энэхүү 21-р он гэдэг нь даруй 1295 он болой.

Үүнээс гадна Гуулин улсад 1393 оноос Сайөгвөн (Sajögwön) хэмээх орчуулагчдын тусхай газар байгуулж монгол хэлийг судлаж сургаж байсан бөгөөд монгол хэлний ангид нийслэл хотоос сурагч сонгон шилэх, сургаж шалгах тусхай журам байсан тухай, ХҮ зуун гэхэд лавтайяа монгол хэлний хориод сурах бичиг, толийн зүйл байсан тухай тодорхой баримт түүхэнд үлдэн хоцорчээ³³.

Ц. Шагдарсүрэн, *Толь бичгийн судлал*, - Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлал, Улаанбаатар, 1985, х. 203-206.

Antoine Mostaert, *Le Matériel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*, II, Commentaires par Antoina Mostaert at Igor de Rachewiltz, Bruxelles, 1995.

²⁸ Daniel A. Kane, *The Sino-Jurchen Vocabulary of the Bureau of Interpreters*, Indiana, Bloomington, 1989, pp. 11-22.

²⁹ Hesig, *The Resaerch on "Jurchen Guan Za Zi" and "Jurchen Guan Lai Wen"*, (in Chinese) - Өвөр монголын Их сургууль, Хөххот, 1983, 242-437;

³⁰ Б. Сумъяабаатар, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975; Б. Сумъяабаатар, *ХШ-Х1Ү зууны монгол солонгос харилцааны бичгүүд*, тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1978; Б. Сумъяабаатар, *Думдад зууны Солонгос Монгол харилцааны түүх*, Данкоок Их сургуулийн хэвлэл, Сөүл, 1992.

³¹ Б. Сумъяабаатар, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975, 11-р тал.

³² Б. Сумъяабаатар, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975, 30-р тал.

³³ Б. Сумъяабаатар, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975, 30-31-р тал.

Солонгосчуудын бичиг үсгийн уламжлал, түүхийг үзэхэд христусын тооллын бараг эхин үеэс нангиад үсгийг хэрэглэж ирсэн бөгөөд явцын дунд уг бичгийн тогтолцоог солонгос хэлний онцлогт ойртуулах оролдолгыг хэд хэдэн удаа хийсэн байдаг³⁴. Үүнд: Шиллагийн үеийн *Хянга* (Hyangga) хэмээх яруу найрагт солонгос зөв дуудалгыг тэмдэглэж байсан *Хянцал* (Hyang ch'al) хэмээх галигийн тогтолцоо; мөн харьцангуй хожуу үе болтол хэрэглэсээр байсан, солонгос хэлний хэлзүйн хэлбэрийн онцлогийг тэмдэглэх үүрэг бүхий *Иду* (Idu); түүнчилэн солонгос хэлний хэлзүйн харьцааны нөхцөлийг тэмдэглэж ирсэн *Кугюл* (Kugyol) гурвыг энд дурдаж болно ("*Хятан бичиг*" бөлгийн *4-р хавсралтыг үзмүү*). Энэ нь ханз үсгийн дуудалгыг хятад хэлээр бус солонгос хэлзүйн журмын дагуу уншуулах зорилготой байсан бөгөөд үүнд хэрэглэсэн нэмэлт тэмдэгтүүдийг шинээр боловсруулахдаа хятад үсгийг хялбарчилсан зарчим нь японы үеийн үсэгийн үүссэн зарчимтай үндсэндээ адил гэж хэлж болно.

Дээр дурдсан зүйл нь, Солонгосчууд хэдийгээр хятад бичгийг олон жил хэрэглэсээр байсан боловч уг бичиг солонгос хэлний онцлогийг тэр бүр гаргаж чадахгүй байсан гэдгийг харуулж байгаа юм. Энэ нь хятад бичиг хэвшинжийн хувьд тусхайлиг хэлэнд илүү тохирсон учир алтай овогийн залгамал солонгос, япон зэрэг хэлэнд төдий л зохистой бус байсантай холбоотой гэж үзэх үндэс буй.

Ийнхүү үсэг бичгийг солонгос хэлэндээ зохицуулах гэсэн эрмэлзлийн дүнд 1444 онд *Hunmin chōng'um* гэдэг үндэснийхээ бичгийн тогтолцоог буй болгох нийгэм улс төрийн боломж Жо-сөн улсын ухаант Сэжон вантаны үед сая бүрджээ. Б. Сумъяабаатарынхаар "*Иргэнийг сургах төв (буюу илэрхий) аялгуу*" хэмээн монголчлодог энэхүү бичгийн нэрийг судлагчид харилцан адилгүй орчуулдаг³⁵ боловч цөм нийт ард түмэнд зориулсан бичиг гэсэн нэгдмэл утга илэрхийлдэг нь нарийн учиртай бөгөөд түрүүн хэрэглэж ирсэн хятад үсэг нь боловсрол доогуур ер энгийн хүмүүст төдий л хүртээлтэй байгаагүйг харуулж буй хэрэг.

Солонгос бичгийг зохиох болсон учир шалтгаан хийгээд эгшиг гийгүүлэгч үсгийн хэлбэрийг юунд үндэслэж хэрхэн, яаж сонгосон тухай тодорхой тайлбарласан *Hunmin chōng'um* гэдэг ном эхлэхдээ:

...Манай улсын хэл аялгуу Хятадаас ялгаатай тул (хятад) бичгээр тэмдэглэхэд (тэрхүү ялгаа онцлог) зохих ёсоор гардаггүй. Тийм болохоор санасан бодсоноо бичин гаргаж үл чадах бүдүүлэг ард олон болой. (Иймд) ер нийт хүн сурч, өдөр тутам хэрэглэхэд амар дөхөмтэйг бодож хорин найман (үсгийн) тэмдэгтийг тулгар зохиов...³⁶ (*3-р хавсралтыг үзмүү*)

гэсэн байдаг.

Энэ бүхнээс үүдүүлэн бодохул, ханз бичиг нь солонгос хэл аялгууны өвөрмиц онцлогийг нарийн тусхаж чаддаггүй байсны дээр ер энгийн өтүл хүмүүн сурахад хүчирдэлтэй, өдөр тутам хэрэглэхэд төвөгтэй байсан гэдэг нь тодорхой харагдаж байна. Энэ талаар нэг бус эрдэмтэн санал нэгдсэн байдаг бөгөөд хойно тодруулан өгүүлэх болно.

³⁴ Ц. Шагдарсүрэн, *Монгол Солонгос бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд*, - Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), N. 4 (1996), Seoul, 1997, pp. 169-191; Ts. Shagdersuren, *A Study of Relations between the Korean and the Mongolian Script*, The Research Paper for Korea Foundation, Seoul, 1998.

³⁵ Профессор И Ги-мүн "*The Correct Sounds for the Instruction of the People*" гэж, И Жүн-Хо "*Right Sounds to Educate the People*" гэж, Л. Р. Концевич "Наставление народу о правильном произношении" тус тус орчуулсаныг дараахи бүтээлээс үзмүү. Lee Ki-Moon, *Linguistics*, ... p. 83; Jurng Ho Yi, Hounmin Jurng-um, *The Korean Alphabet "Right Sound to Educate the People"*, Explanation and Translation in Korean and English, Seoul, 1986; Л. Р. Концевич, *Хунмин чоным*, Москва, 1979.

³⁶ Jurng Ho Yi, Hounmin Jurng-um, *The Korean Alphabet "Right Sound to Educate the People"*, Explanation and Translation in Korean and English, Seoul, 1986, p. 30.

Солонгосчууд үндэсний бичигтэй болсоныг нэгөө талаас дундад зууны үед Ази дахины олон оронд (үндэсний бичиггүй байсан бөгөөс) бие даасан Төр улсаа байгуулмагц эх хэлнийхээ онцлогт тохирсон өөрийн гэсэн бичиг үсгээ боловсруулан хэрэглэдэг нийтлэг нэгэн хэв ёс үйлчлэж байсанаас салгаж үзэх аргагүй буй заа.

Солонгосын энэхүү шинээр зохиосон авианы (цагаан толгойт) бичгийн гарал үүслийг судласан олон эрдэмтэн бараг цөмөөрөө монголчуудын бичиг үсгийн нөлөө байгааг хүлээн зөвшөөрчээ. Гэхдээ монгол туургатны хэрэглэж байсан олон зүйл бичиг үсгийн дотроос чухам ямар бичигтэй нь холбоотой болохын тухайд нэгдмэл санал энэ хир үгүй байна. Дэлхийн олон улсын бичиг үсгийг судлагч Фридрих Иоханнес (Johannes Friedrich) монгол бичиг болоод солонгос бичигт аль алинд нь нийтлэг онцлог буйг хүлээн зөвшөөрчээ³⁷.

Солонгосын эрдэмтэн Ли Ик, Тэн Дон-Юу, Люхви, хятадын эрдэмтэн Лин Тай-Фү, японы эрдэмтэн К. Ширатори (K. Shiratori), Ш. Хаттори (Sh. Hattoti)³⁸, америкийн эрдэмтэн Гари Ледъярд (J.R. Ledyard), Дж. Р. Кинг (J.R.P. King) нар³⁹ солонгос авианы (g, d, r, b, s, m зэрэг) үсгийг монголын Дөрвөлжин бичигтэй шууд холбоотой гэж үзсэн бөлгөө.

Оросын эрдэмтэн Л. Р. Концевич солонгосын үндэсний бичигт хятад бус махбод байгааг дурдаад түүнийгээ Энэдхэгтэй холбоотой байж магадгүй⁴⁰ хэмээн тэмдэглэсэн нь монголын дөрвөлжин бичигтэй дам холбогдох боломжийг гарган өгч байна гэж үзэх үндэс буй.

1975 оны бүтээлдээ Б. Сумъяабаатар ХҮ зууны дундуур зохиосон солонгосын авианы бичгийг үсэгзүйн үүднээс задлан шинжилсэний дүнд тэдгээр үсгийн тэмдэгтүүдийн үүслийг ХҮ зуунаас түрүү үеийн монгол бичгийн үндсэн хэлбэр (үүнийг Ц. Шагдарсүрэн бүтээлүүддээ гол хэлбэр гэж нэрлэсэн байдаг)-тэй холбож үзсэн өвөрмиц саналаа дэвшүүлжээ⁴¹.

Энэ мэтээр солонгос үсэг, бичгийн гарлыг монгол болон монголын дөрвөлжин бичигтэй холбож үздэг хоёр зүйл саналын талаар өөрийн бодлоо нэмэрлэсү. Үүнд: Солонгос болон монголчуудын үсэг бичгийн учир холбогдлыг судласан эрдэмтэд их төлөв тухай тухайн үсгийн гадаад хэлбэрийн төсөөг дуудалгынхи нь үүднээс анхаарч харьцуулсан байдаг. Ийм харьцуулалт нь үсэгзүйн хэлбэрийн талын судлагааны хувьд нэгэн чухал арга байж болох нь маргаангүй ч тухайн бичиг үсгийг боловсруулахад баримтласан онолын үндэслэл, систем тогтолцоог зайлашгүй анхаарах шаардалгатай юм.

Иймээс энд судлагдахуун болж буй бичиг үсгийн дотоод тогтолцоог харьцуулсан зарим ажиглалтаа танилцуулах зорилго тавилаа.

Солонгосын хэлшинжлэлийн түүхэн хөгжлийг авч үзвэл, XIV зууны эцэс, XV зууны эхин гэхэд түрүү түрүү үеийнхээ уламжлалаас ялгаатай шинэ үе эхлэсэн гэж судлагчид

³⁷ Johannes Friedrich, *Geschichte der Schrift*, Heidelberg, 1966; Иоганнес Фридрих, *История письма*, Москва, 1979, стр. 185-187.

³⁸ Б. Сумъяабаатар, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975, 120-125-р тал.

³⁹ J.R. Ledyard, *The Korean Language reform of 1446*, The origin Background and Early History of Korean Alphabet, - Ph. Dr. Disseration, University of California, Berkeley, 1965.
J.R.P. King, *The Korean Elements in the Manchu Script Reform of 1632*, CAJ (Centrel Asiatic Journal), Vol. 31, N. 3-4, Wiesbaden, 1987, pp. 252-286.

⁴⁰ Л. Р. Концевич, *Хунмин чоным*, - Памятка письменности Востока, Том. LVIII, Москва, 1979, стр. 27-28.

⁴¹ Б. Сумъяабаатар, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975, 134-р тал.

үздэг⁴² бөгөөд чухам энэ үед солонгосын авианы цагаан толгойт бичгийн тогтолцооны үндэс болсон хэлшинжлэлийн шинэ онол бүрэлдэн буй болсон байна.

Мөн энэ үед Сайөгвон (Sajögwön)-д дөрвөн судлагдахуун нь болсон хятад, монгол, зөрчид (хожим нь түүний оронд манж), япон хэл бичгийг судлах ажил улам эрчимжсэн бөгөөд үүний дүнд хятан, монгол, дөрвөлжин зэрэг үеийн болоод цагаан толгойт бичгийн тогтолцоог судлаад зогссонгүй Бүддийн шашны нөлөөгөөр төвөд бичигтэй танилцаж байсан бөлгөө. Бас Сэжон вангийн үед японы худалдаачдаар дамжуулан Рюкко арлаас японы *кана* хэмээх үеийн бичгээр бичсэн номыг авчирсан цагаас уул бичгийн тогтолцоо мэдэх болсон тухай түүхнээ тэмдэглэгджээ⁴³.

Иймд олон янзын тогтолцоо бүхий бичиг үсгүүдээс чухам ямар зарчим нь солонгос хэлэнд зориулан зохиох шинэ бичигт илүү тохиромжтой болохыг анхааран судласан нь маргаангүй буй заа.

Солонгос бичгийн гарал үүсэлд холбогдох бүтээл болон холбогдох судлагааг авч үзвэл нэгд: гадаадын аль нэгэн үсэг бичгийг дууриасан (the imitation); хоёрт: өгүүлэх эрхтэний оролцоог бэлгэдсэн (the symbolization) гэдэг хоёр гол санал байдаг ажээ⁴⁴. Энэ асуудлыг цааш нь тодосгоход солонгос бичгийн эгшиг хийгээд гийгүүлэгч үсгийн бүтэц зохиомжийг задлан үзэх шаардалгатай бөгөөд үүнд бидний дээр эшлэл авсан "*Hunmin chöng'üm*" хийгээд "*Hunmin chöng'üm-ын тайлбар жишээ*" ("*Hunmin chöng'üm Haerye*")⁴⁵ гэдэг хоёр ном чухаг хэрэглэгдэхүүн болж өгнө. Эдгээр номд үсэг бүрийн мөн чанар, хэрхэн дуудах байдалыг таван махбод(The five Primitive Elements)-ын онолын үүднээс тайлбарласны зэргэцээ үсэг бүрийн хэлбэрийг юунд шүтэж хэрхэн дүрсэлсэн болохыг тодорхой дурдсан байдаг.

Солонгос бичгийн эгшиг үсгийн тухайд тэнгэр [☉], газар [—], хүмүүн [人] хэмээх Гурван хүчин (Three Powers: Heaven, Earth and Man)-ий бэлгэдлийг зурхайн ухаан (The Astrology)-ны тодорхой үндэслэлээр сэлгүүлэн бичих зарчмаар зохиосон нь (4-р *хавсралтыг* үзмүү) монгол бичигт эгшиг үсэг титэм буюу ацаг (ㄱ | ㅋ), гэдэс (ㆁ), шилбэ (ㄴ) гэдэг гурван махбодоос бүтдэг байдалтай зарчмын хувьд адил юм.

Монголын дөрвөлжин бичигийн эгшиг үсгийг холбон бичдэг журам нь мөн л монгол бичгийн дээрхи зарчимд үндэслэсэн хэрэг бөгөөд энэ тухай миний бие удаа дараа дурдан өгүүлсэн билээ⁴⁶.

Үүнд: эгшиг үсгийн "*Aleph*" буюу тухайлбал, монгол бичигт үгийн эхинд ордог бүх эгшиг үсгийн эхний *титэм* (ㄱ), дөрвөлжин бичигт түүнтэй дүйдэг "*ux a*" (ᠡᠭᠠ), солонгос бичигт мөн адил үүрэг бүхий "*i-üŋ*" (ㅁ) нь үгийн (үеийн) дунд, адагт орохдоо цөм орхигддог. Энэ нь зөвхөн үсэгзүйн асуудал биш бөгөөд Өвөг Алтай хэл (Proto-Altaic) -нээ эгшигээр эхлэсэн үг байсан уу? үгүй юу? гэдэг асуулттай аль нэгэн хэмжээгээр холбоотой

⁴² Lev Kontsevich, *Some Problems of the Periodization of Korean Linguistics History* (From Ancient Times until the 1950's), - Essays in honor of Ki-Moon lee, Seoul, 1996, pp. 967-986.

⁴³ Л. Р. Концевич, *Хунмин чоным*, - Памятка письменности Востока, Том. LVIII, Москва, 1979, стр. 24.

⁴⁴ Lee Ki-Moon, *Historical Studies on the Korean Writing System*, - Linguistics, Volum 18, The Korean Research Center, Seoul, 1963, (Abstract in English) pp. 2-3.

⁴⁵ Jurng Ho Yi, *Houhnmmin Jurng-um, The Korean Alphabet "Right Sound to Educate the People"*, Explanation and Translation in Korean and English, Seoul, 1986.

⁴⁶ Ц. Шагдарсүрэн, *Дөрвөлжин бичгийн үсэгзүйн нэгэн онцлог хослол*, - Хэл зохиол судлал, ҮШ боть, ҮП дэвтэр, Улаанбаатар, 1978, 57-64-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэгзүй*, Улаанбаатар, 1981, 38-44-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол солонгос бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд*, - Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), N. 4 (1996), Seoul, 1997, pp. 9-10; Ts. Shagdarsuren, *A Study of Relations between the Korean and the Mongolian Script*, The Research Paper to Korea Foundation, Seoul, 1998.

буй заа гэж үзэж байна. Монгол хэлний авиазүйн судлагааны бүтээлүүдэд үгийн эхний эгшиг болгон ямагт амьсгалын түрэлттэй байдаг бөгөөд үүнийг монгол бичигт "Aleph" буюу "титэм"-ээр, дөрвөлжин бичигт "их а"-аар тэмдэглэсэн гэж үзэх үндэстэй. Зарим судлагч энэхүү амьсгалын түрэлт нь эрт цагт гийгүүлэгчээр эхлэж байсны ул мөр гэж үздэг нь анхаарууштай зүйл мөнөөс мөн бөгөөд орчин цагийн монгол хэлнээ эгшигээр эхлэж байгаа өдий төдий үгийн гарлыг нэхэн үзвээс цөм гийгүүлэгчээр эхлэж байсны баримт захаас аван дайралддаг бөлгөө⁴⁷.

Дээр өгүүлсэнчлэн эхинд орсон эгшиг үсгийг хэрхэн тэмдэглэдэг байдлыг ө эгшигийн жишээн дээр толилуулбал доорхи мэт болно.

	Эхин	Дунд	Адаг	Дуудалга
Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ö ü
Дөрвөлжин бичиг	ᠠᠨ	ᠡᠨ		ö
Солонгос бичиг	ᠠ	ᠡ		ö

Солонгос бичгийн цагаан толгойд "i-ü᠑" буюу Aleph -ыг эгшиг бус, гийгүүлэгчийн бөлөгт багтаадаг нь бидний сонирхолыг татдаг юм. Учир нь: дөрвөлжин бичигт "их а"-г эгшиг хэмээн тооцдог боловч төвөд бичигт гийгүүлэгчийн бөлөгт оруулдаг. Харин самгардад төвөдийн "их а"-тай дүйх үсэг нь зөвхөн "а" эгшигийн үүрэг гүйцэтгэдэг. Иймд солонгос бичгийн "i-ü᠑" нь нэгд, гийгүүлэгчийн бөлөгт багтдагаараа, хоёрт, эгшигийн бие даасан хэлбэрийн суурь болдогоороо, гуравт, үеийн дунд болон адагт орхигддогоороо төвөд бичигтэй зарчим нэг ажээ. Үүнээс үүдүүлэн бодоход солонгосчууд үндэснийхээ бичгийг боловсруулахдаа төвөд бичгийг үсгийн зарчмыг мэддэг байсан гэж үзэх үндэслэл гарч ирэхээс гадна дээр бидний өгүүлсэнчлэн Өвөг Алтай хэлнээ эгшигээр эхлэсэн үг байгаагүй юм биш биз? гэдэг асуултад эерэг хэрэглэгдэхүүн болж өгдөг юм.

Монгол хэлшинжлэлийн бүтээлд монгол хэлний авианы үүсэх орон хийгээд түүнийг хэрхэн тэмдэглэсэн байдлыг Таван махбодын онолын үүднээс тайлбарласан байдаг боловч нарийвчлан хянаваас энэ онол нь хоёр зүйл ялгаатай гэдгийг Гунгаажалцан (1188-1231)-ы "Зүрхэний толта"-д тайлбар болгож бичсэн "Зүрхэний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч Огторгуйн Маани хэмээх оршив" гэдэг зохиолдоо Данзандагва хэдийнээ ХҮШ зуунд тэмдэглэжээ⁴⁸. Үүнд: нэг нь энэдхэгээс гаралтай Цагаан зурхай (The White or Indian Astrology), нөгөө нь хятадын буюу Хар зурхай (The Black or Chinese Astrology) хэмээх хоёр зүйл байдаг бөгөөд энэ хоёрын алинд нь үндэслэж байв гэдгээрээ ялгаатай байжээ. Үүнээс үзвэл христусын тооллын өмнөхи 5-р зуунаа Эртний Энэдхэгт үүссэн Банин (Pāṇini)-ы хэлзүйн онол бодрол Төв Азийн улс оронд шууд болон Төвөдөөр дамжиж багагүй нөлөөтэй болсон ажээ. Тэгээд ч тэр хоёр онолын үүднээс нэг авиаг тайлбарлахад хоорондоо тохирдоггүй тул ямар авиаг хэрхэн тайлбарласнаар нь хятадын уламжлалыг баримтлаж уу? энэдхэгийн уламжлалыг баримтлаж уу? гэдгийг ялгаж болно.

Ийм учраас солонгос хэлний авиа үүсэх орон хийгээд тухайн авиаг ямар үсгээр тэмдэглэснийг тайлбарлахад эртний Энэдхэгийн уламжлалын нөлөө огт байгаагүй гэж

⁴⁷ Ж. Лувсандорж, *Эртний монгол бичигт үгийн эхний Алеф үсгээр ямар авиа тэмдэглэсэн бэ?* - МУИС, Эрдэм шинжилгээний бичиг, N. 3 (87), Улаанбаатар, 35-44-р тал. Paul Pelliot, *Les mots a H initial, aujourd'hui amuie, dans le mongol des 13e et 14e siecles*, - Journal Asiatique, Avril-Juin, 1925, Paris, pp. 193-263.

⁴⁸ Т. Пагва, *"Зүрхэний тольтын (!) тайлбар"-ыг судласан тухай тэмдэглэл*, Улаанбаатар, 1957, 51-53-р тал.

үзэхийн аргагүй бөгөөд энэ нь ч цаашид нарийвчлан судлах эзнээ хүлээж буй сэдвийн нэг юм. Солонгос бичгийн авиалбарзүйн онол(The Phonology theory)-ын үндэслэлийг үүнтэй холбогдуулан ярьж болно. Үүнд: Сэжон вантаны үед эрдэм шинжилгээний байгуулга Chiphyon chon буй болж энд авиалбарзүйн онолыг тусхайлан судлах болсон байна⁴⁹. Энэ үед хэдийгээр хятадын гүн ухаан болон авиалбарзүйн онол нөлөөтэй байсаар байсан боловч Chiphyon chon-д боловсруулсан шинэ онол нь нангиадын уламжлалтай тохирдоггүй байсныг судлагчид нэг бус удаа дурджээ⁵⁰. Үүнд: Дүрс буюу үет бичгийн хувьд үеийн эхин, адаг хоёр (The Bi-partite) чухал болдог учир хятадын авиалбарзүйн онолоор үеийг эхин (The Initial), адаг (The Final) гэсэн хоёр байр (The Bi-partite)-т хуваан үздэг байхад солонгосын шинэ онолоор эхин (The Onset or Initial), дунд (The Peak or Medial), адаг (The Coda or Final) гэж гурван байр (The Tri-partite)-т хуваан үздэгээрээ эрс ялгардаг байна. Солонгосын авиалбарзүйн энэхүү шинэ үзэл нь цагаан толгойд бичигт тохирдог зарчим бөлгөө. Монгол бичигт ч ийм зарчим буй билээ.

Дээр дурдсан "Hunmin chōng'ŭm-ын тайлбар жишээ" ("Hunmin chōng'ŭm Haerye") номд "Эхинд тохиолдох авиаг тайлбарлах нь", "Дунд тохиолдох авиаг тайлбарлах нь", "Адагт тохиолдох авиаг тайлбарлах нь" гэж гурван байр (The Tri-partite)-ыг тус тусад нь бөлөг болгож тодорхойлсон байдаг⁵¹ тул шинэ онолд тулгуурлажээ гэж үзэх үндэстэй юм.

Энэ бүхнээс эргэцүүлэн бодоход, солонгос хэлний онцлогт тохируулан зохиосон авианы бичигт нангиадын авиалбарзүйн хоёр байрт онол төдий л тохиромжтой байж чадаагүй учир өөрсдийнхөө боловсруулсан гурван байрт шинэ онол тулгуурлаж Hunmin chōng'ŭm-ыг зохиожээ гэж үзэх бүрэн үндэслэл гарч байна.

Солонгос бичгийн гийгүүлэгч үсгийн хэлбэрийн хувьд өгүүлэх эрхтэний оролцоог хэрхэн тусгасан тухай "Hunmin chōng'ŭm-ын тайлбар жишээ" ("Hunmin chōng'ŭm Haerye")-д тодорхой дурдсан байдаг⁵². Үүнд:

k, g -гийн төрлийн гийгүүлэгчийг "хэлний үг"-ийн	(ㄱ) хэлбэрээр;
n -ийн төрлийн гийгүүлэгчийг "хэлний үзүүр"-ийн	(ㄴ) хэлбэрээр;
b, m -ийн төрлийн уруулын гийгүүлэгчийг "ам"-ны	(ㅁ) хэлбэрээр;
s -ийн төрлийн сийгэх гийгүүлэгчийг "шүүд"-ний	(ㅅ) хэлбэрээр;
хэлний гүн үгийн ng/ŋ гийгүүлэгчийг "хоолой"-н	(ㅇ) хэлбэрээр

тус тус дүрсэлсэн байна (5-р хавсралтыг үзмүү). Гийгүүлэгч үсгийн хэлбэрийн талаархи энэхүү ерөнхий зүйлээс гадна гийгүүлэгч тус бүрийг тодорхойлохдоо, жишээлбэл: уруулын гийгүүлэгчийн тухайд:

"...уруул дөрвөлжрөн нээгдэх ба бас нийлэн хамхигдана..."⁵³

гэх зэргээр бүр нарийвчлан тайлбарласан байдаг нь бидний сонирхолыг зүй ёсоор татаж байна.

Монгол бичигт үсэг бүр үгийн (үеийн бус!) эхин, дунд, адагт тохиолдох гурван хэлбэртэй. Гийгүүлэгч үсгийн дотроос тодорхой 11 нь "дэвсгэрлэж" ордог бөгөөд монгол

⁴⁹ Lee Ki-Moon, *Linguistics*, ...pp. 89-96; Lee Ki-Moon, *Historical Studies on the Korean Writting System*, - Linguistics, Volum 18, The Korean Research Center, Seoul, 1963, (Abstract in English), pp. 9-13.

⁵⁰ Lee Ki-Moon, *Historical Studies on the Korean Writting System*, - Linguistics, Volum 18, The Korean Research Center, Seoul, 1963, (Abstract in English), pp. 9-10.

⁵¹ Jurng Ho Yi, *Houhnmin Jurng-um, The Korean Alphabet "Right Sound to Educate the People"*, Explanation and Translation in Korean and English, Seoul, 1986, pp. 47-52.

⁵² Jurng Ho Yi, *Houhnmin Jurng-um, The Korean Alphabet "Right Sound to Educate the People"*, Explanation and Translation in Korean and English, Seoul, 1986, p. 43.

⁵³ Jurng Ho Yi, *Houhnmin Jurng-um, The Korean Alphabet "Right Sound to Educate the People"*, Explanation and Translation in Korean and English, Seoul, 1986, p. 36.

бичгийн дэвсгэр үсгийн дүрэм нь монгол хэлний авиазүйн гол хууль төдийгүй монгол бичгийн зөв бичихзүй (The Orthography)-н үндэс болдогийг бид сайн мэднэ. Харин сургалтын зорилгоор тэдгээр 11 дэвсгэр үсгийг өгүүлэх эрхтэний оролцох байдлаар нэрлэн заадаг уламжлал байдаг тухай бид удаа дараа дурдаж байснаас⁵⁴ гадна энэ номын *Монгол бичиг*-ийн хэсэгт арай дэлгэрэнгүй өгүүлсэн боловч энд зарим нэг жишээг татан харьцуулах нь улам ойлгомжтой болгоно гэж найдаж байна.

- d - тагнай дэлдэх (хэлний үзүүр дээш матийж тагнайд хүрэлцэн цохих);
- l - хэл тулах (хэлний үзүүр дээш хөмийж түүшинд хүрэх);
- m - ам хамжих (хоёр уруул нийлэх) ...
- s - шүдэн(ий) чөлөө (хийн урсгал шүдний завсраар сийгэн гарах)

гэх мэт болно.

Солонгос болон монгол бичгийн гийгүүлэгч үсгийн талаар дээрхи харьцуулсан баримт нь өгүүлэх эрхтэний оролцоог тусган тайлбарласан зарчимын хувьд үндсэндээ адил ажээ. Үүнээс гадна монгол бичгийн дэвсгэр үсгийг тайлбарласан нэрээр улбаалан солонгос бичгийн *d* /*t*, /*l* /*r* зэрэг гийгүүлэгч үсгийн нийлмэл хэлбэрийн бүтэцийг тодруулан тайлбарлах боломж улам бүр нэмэгддэг⁵⁵ бөгөөд хэрэвээ лавшруулан үзэе гэвэл зүүлтэд заасан бүтээлээс тодруулана уу.

Энэ мэтийн нийтлэг болон төстэй зүйл солонгос бичиг болон монгол, хятан, дөрвөлжин бичгийн үсэгзүйн хүрээнд ганц нэгээр тогтохгүй, тогтолцоотой байгаа тул санамсаргүй тохиолдлын хэрэг гэж үзэхийн аргагүй. Үүнээс гадна солонгос бичгийн хувьд хуучин уламжлалаас ялгаатай онолын шинэ үндэслэлийг бодолцохгүй байхын аргагүй.

Тэгвэл яагаад энэ талаар ном бичгийн дотор дурдсангүй вэ? гэдэг асуулт аяндаа гарна. Гэхдээ 1444 онд солонгос бичгийг боловсруулахад хуучин хүчтэй байсан хятадын гүн ухааны уламжлал хийгээд авиалбарзүйн онол огт нөлөөлөөгүй гэж бүрмөсөн үгүйсгэж болохгүй. Учир нь, нэгд, олон жилийн туршид дадал болсон үзэл наад зах нь олон нийтийн сэтгэлгээнд амь бөхтэй зууралдсаар байдагтай холбоотой. Жишээлбэл: солонгос бичигт нэгэн хэсэгтээ хоёр зүйлийн хөг (The Tone)-ийг тэмдэглэж байсан нь даруй хятад хэл, бичгийн нөлөө гэхээс өөрөөр тайлбарлах аргагүй. Хоёрт, хуучин хэрэглэсээр ирсэн хятад үсгийг солонгос шинэ бичгээр солино гэхэд Мин улс (1368-1644)-ын зүгээс яавч дэмжихгүй нь мэдээж билээ. Иймд хятадын гүн ухаан, авиалбарзүйн онолоос өөр онолыг баримтласан гэж ил тод хэлэх боломж байгаагүй байж ч болно. Нөгөө талаас Мин улс Монголтой ид зөрчилдөж байсан болохоор монгол, хятан, дөрвөлжин бичгийн нөлөө тусгалын талаар дурдаад байх улс төрийн хувьд шаардалгагүй байсан нь мэдээж юм.

Солонгосч эрдэмтэн Л. Р. Концевич энэ асуудлын талаар бас анхааран үзсэн байдаг. Тэрээр *Hunmin chông'üm* -д албан ёсоор ил тод өгүүлсэн зүйлүүд, тухайлбал: Сүн улс (960-1279)-ын үеийн Байгалийн гүн ухаан болон Шүлэгийн онол нь түүний цаадхи бодот юм буюу Цагаан толгойн бүтэц, Энэдхэгийн Бүддийн үзэл санаатай таардаггүй бөгөөд үүний чухам нарийн учир нь Мингийн төрийн бодолгоос шалтгаалан, төөрөлдүүлэх

⁵⁴ Ц. Шагдарсүрэн, *Традиционные монгольские фонетические термины*, - Исследования звуковых систем языков Сибири, Новосибирск, 1984, стр. 193-194; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, 1981, 63-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол солонгос бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд*, - *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), N. 4 (1996), Seoul, 1997, pp. 12-14; Ts. Shagdarsuren, *A Study of Relations between the Korean and the Mongolian Script*, The Research Paper to Korea Foundation, Seoul, 1998, pp. 11-13.

⁵⁵ Ц.Шагдарсүрэн, *Монгол солонгос бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд*, - *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), N. 4 (1996), Seoul, 1997, pp. 13-14; Ts. Shagdarsuren, *A Study of Relations between the Korean and the Mongolian Script*, The Research Paper to Korea Foundation, Seoul, 1998, p.13; Б. Сумъяабаатар, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975, 130-р тал.

зорилгоор ийнхүү санаатайгаар өөрөөр тайлбарлаж байсан гэж онцлон тэмдэглээд тэрхүү зөрчилдсөн зүйлүүдийг тусхай хүснэгтэнд харьцуулан жагсааж үзүүлсэн байдаг⁵⁶.

Бусад хэд хэдэн эрдэмтэн ч дээрхи асуудлыг Солонгос болон Мин Улсын харьцаа хийгээд тухайн үеийн улс төрийн байдалтай холбон тайлбарласан бий⁵⁷.

Мин Улс хийгээд Чин улс (1644-1911)-ын зүгээс солонгос бичгийг үл таашаасан байдал харьцангуй хожуу үе хүртэл үргэлжилсээр байсан бололтой. Тэгээд ч Манж нарын шахалтаар Сөүлд босгосон манж, монгол, хятад бичээс бүхий Sam Jon-Do⁵⁸ -гийн хөшөөнд солонгос бичвэр байхгүй байгаа нь үүнтэй холбоотой буй заа гэж санана.

Солонгос бичгээр үсэг холбон бичихийн тухайд гэвэл үгийг үе үеэр нь бичих боловч монголын дөрвөлжин бичиг шиг нэгэн шугамаар бус, өөрөөр хэлбэл цувуулан (The Linear form) бичдэггүй, харин хятаны "бага" бичгийн маягаар багцлан (The Assembled or Group form) бичдэг байна. Үүнийг бүдүүвч байдлаар харьцуулан үзүүлбэл:

Хятаны "бага" бичиг	Монгол дөрвөлжин бичиг	Солонгос бичиг
1. 支	1. ㅅ	1. 아
1 2, 又及	2 ㅅ 3. ㅅ	2 3, 버
1 2 天天 3, 月	1 ㅅ 2 ㅅ 3. ㅅ	4 5. 지 1 우 2, 우
1 2 天 3 4, 天		3 주 4. 주
		1 2 사 3 4 전 5. 전

⁵⁶ Л. Р. Концевич, *Хунмин чоным*, Москва, 1979, стр. 27-28;
⁵⁷ Lee Ki-Moon, *Historical Studies on the Korean Writting System*, - Linguistics, Volum 18, The Korean Research Center, Seoul, 1963, (Abstract in English), pp. 4-17. Б. Сумъяабаатар, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975, 134-р тал.
⁵⁸ Энэ дурсгалын тухай анх 1889 онд W. B. Carles -ийн *A Corean Monument to Manchu Clemency* гэдэг өгүүлэл гарснаас хойш А. Позднеев, W.W. Rockhill, B. Laufer, M. Forbes A. Fraser, Hauer, Oshibuchi Hajime, W. Fuch, L. Hambis, L. Ligeti, Kim Bang-Han, Seong Baeg-In, H. Walravens, S. M. Grupper, Ch'oe Hak-Kun нарын судлагаа гарчээ. Дээрхи судлагаануудыг нэгтгэн үзээд уг дурсгалын монгол бичвэрийн талаар Francis Woodman Cleaves авгай дараахи өгүүллийг нийтлүүлжээ.
Francis Woodman Cleaves, *The Mongolian Text of the Tri-lingual Inscription of 1640 (Part I)*, - Mongolian Studies, Journal of the Mongolia Society, Vol. XVIII, 1995, Bloomington, pp. 5-47;
Francis Woodman Cleaves, *The Mongolian Text of the Tri-lingual Inscription of 1640 (Part II, Notes to the Translation)*, - Mongolian Studies, Journal of the Mongolia Society, Vol. XIX, 1996, Bloomington, pp. 3-49.

Солонгос бичгээр хөндлөн бичихээс гадна дээрээс доош нь бичих ёсон буй бөгөөд үүнийг зарим судлагч "...яха аргагүй хятад бичгийн маяг загвар..."⁵⁹ гэж үзсэн байдаг боловч монгол бичиг болон дөрвөлжин бичгээр тэгж бичдэг гэдгийг бас мартаах аргагүй билээ.

Дээр өгүүлсэн зүйлүүдийг дараахи хэдэн зүйлд хурааж, товчлон дүгнэж болно.

Нэг: Солонгос бичгийг боловсруулахад баримтласан онолын үндэслэл нь хуучин ноёрхож байсан уламжлалт онолоос мөн чанарын хувьд ялгаатай байсан гэж үзэх бүрэн үндэстэй.

Хоёр: *Hunmin chǎng'ŭm* хэмээх бичгийг анх зохиохдоо гадаадын аль нэгэн бичгийг дангаар нь үндэс болгож "дууриагаагүй", харин тухайн үед Ази дахинаа хэрэглэгдэж байсан бусад улс орны, ялангуяа гарал ойр Алтай овогийн хэлний үсэг бичгийн тогтолцоог судлаж танилцаад солонгос хэлний онцлогт илүү тохиромжтой гэж үзсэн хэд хэдэн зарчмыг сонгон авч хэрэглэсэн байна. Тэдгээр зарчмыг дурдвал:

Хоёр. 1. Үсгийн бүтэц, хэлбэр болон үүргийн хувьд:

Эгшиг үсэг дээр:

- *Hunmin chǎng'ŭm*-д эгшиг үсгийн махбодыг холбох ёс нь монгол бичигт эгшиг үсэг бүтээх зарчимтай их адил, өөрөөр хэлбэл тодорхой 3 махбодыг сэлгүүлэн холбож бүтээдэг байна.

- *Hunmin chǎng'ŭm*-д эгшиг үсэг нь эхин, дунд-адагт тохиолдох хоёр хэлбэртэй байдаг нь дөрвөлжин бичгийн зарчмыг санагдуулна.

- *Hunmin chǎng'ŭm*-д үеийн эхинд тохиолдох бие даасан эгшигийн суурь болж өгдөг "i-ŭng" нь үүрэг хийгээд гийгүүлэгчийн бөлөгт багтдагаараа төвөд бичгийн "их а"-тай адил гэж болно.

Гийгүүлэгч үсэг дээр:

- *Hunmin chǎng'ŭm*-д гийгүүлэгч нь гурван байршилаар дүрсээ өөрчлөдөггүй бөгөөд энэ байдал нь дөрвөлжин бичгийн зарчимтай адил ажээ.

- *Hunmin chǎng'ŭm*-д өгүүлэх эрхтэний оролцоогоор гийгүүлэгч үсгийн дүрс хэлбэрийг зохиосон байдал нь монгол бичигт дэвсгэр гийгүүлэгчийг нэрлэдэг зарчимтай үндсэндээ тохирч байна.

Хоёр. 2. Үсэг холбон бичихийн хувьд:

- Солонгос бичгээр үсэг холбож үг болгохдоо үе үеэр нь багцлаж бичдэг ёс нь хятан "бага" бичгийн багцлаж бичдэг (The Assembled or Group form) хэлбэртэй адил байдаг.

Гурав. Эцэст нь бүр товчлон дүгнэхэд *Hunmin chǎng'ŭm*-ыг анх зохиохдоо бусад улс үндэстний бичиг үсгийн зарчмыг ч сонгон авч "дууриан" (The Imitation) хэрэглэх, өгүүлэх эрхтэний оролцоог ч харгалзаж "бэлгэдэн" (The Symbolization) дүрслэх хоёр зарчмыг хоюуланг нь хэрэглэсэн байна гэж үзэх баримт сэлт ажиглагдана.

⁵⁹ Johannes Friedrich, *Geschichte der Schrift*, Heidelberg, 1966; Иоганнес Фридрих, *История письма*, Москва, 1979, стр. 187.

3. Манж бичиг монгол бичигтэй шүүд холбогдох нь

XIII зуунаас өмнө манж нарыг нангиад бичиг хэрэглэж байсан бөгөөд Монголчууд дэлхийн тавцанаа хүчирхэгжин гарч ирсэн цагаас монгол бичгийг албан ёсоор хэрэглэх болсон гэж эрдэмтэд тэмдэглэжээ⁶⁰.

Үүнээс гадна XVII зууны эхин хүртэл манж нар монгол хэл, монгол бичгийг гадаад харилцаандаа албан ёсоор хэрэглэж байсан гэдэг баримт бидний анхаарлыг гойд татдаг бөлгөө⁶¹.

Хамниган (The Tungus) угсааны Манж нар XVI зуунаас хүчирхэгжиж Төв Азийн өргөн уудам нутагт нөлөөтэй болохын хирээр нэгэн талаас, улс төр, суртал соёлын хувьд өөрийн гэсэн бичиг үсэгтэй болох шаардалга гарч, нөгөө талаас албан хэргээ дан манж хэлээр явуулах хэрэгцээ буй болсон нь мэдээж билээ. Тэгээд ч Манжийн Нурхац баатар хэмээгддэг хаан нь 1599 онд Эрдэнэ багш, Гагай заргач гэдэг хоёр бичгийн хүмүүнд монгол бичгийг түшиж манж бичиг боловсруулахыг даалгасан баримт Манж Чин улсын түүх сударт тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Бас мөнөөхи хоёр бичгийн сайд нь хуучин уламжлалын дагуу монгол хэл, бичгээр гадаад хэргийг явуулбал ямар хэмээсэнд Тай-зү сэцэн бэйл буюу Нурхац эс зөвшөөрсөн гэдэг. Тэр жилдээ Гагай заргач эзэн төрийн өмнө нүүр алдаж үхэх ял олсон гэх зэрэг олон сонин мэдээ "*Manju-i yargiyan kooli*" гэдэг "*Манжийн үнэн магад хууль*"-д тодорхой гардаг бөгөөд энэ талаар олон эрдэмтэд дурдсан нь буй⁶². Үүнээс гадна Эрдэнэ багш, Гагай заргач хоёрыг монгол угсааны хүн байсан гэж нэг бус эрдэмтэн үздэг бөлгөө.⁶³

Ийнхүү манж бичгийг буй болгоход Эрдэнэ багш гагцаар зүтгэж Манж хэлэнд тохируулсан манж бичгийг монгол бичгээс ялгах дусал, бинд нэмж зарим үсгийн дүрсийг өвөрчлөсөн бөгөөд дараа нь Дахай хэмээгч бичгийн сайд нарийсган боловсруулж 1632 онд дуусгасан гэж үздэг⁶⁴. Тийм ч учраас Эрдэнэ багш монгол бичгийг манж хэлэнд таацуулан боловсруулах ажлыг хийсэн байхад Дахай нь Эрдэнэ багшийн эхлэж боловсруулсан манж бичгийн тогтолцоог гүнзгийрүүлсэн бөлгөө.

Манж бичгийн хөгжлийн түүхийг ерөнхийд нь хоёр ангилаж үздэг. Эхний шатны хэрэглэгдэхүүн гэвэл тухайн үед шүүд холбогдох монгол бичгээр үлдсэн манж хэлээрхи баримт сэлт хамаарах бөгөөд хамгийн сонгодог жишээнд Цян-лүний үед зохиосон "*Tongki fuqa aqδ xergen-i bitxe*" буюу *Дусал биндгүй үсгийн бичиг* хэмээх харьцуулсан толь маягийн бүтээл, харьцангуй сүүлд олдсон Манжийн Төрийн "*Эртний хууль цаазын баримт*" (буюу Lao-dan)-ыг багтаасан томоохон гарбичмэл эмхэтгэл хоёрыг оруулдаг. Харин "шинэ" манж бичгийн дурсгал харьцангуй элбэг тул тусхайлан яриад байх зүйлгүй гэж үзнэ.

"*Tongki fuqa aqδ xergen-i bitxe*" буюу *Дусал биндгүй үсгийн бичиг* хэмээх дурсгалыг авч үзэхүл дусал биндгүй бичиг, дусал биндтэй бичиг хоёрын гол ялгааг харьцуулан гаргасан манж-манж толь бичгийн байдалтай бөгөөд дусал биндгүй бичгийн уламжлалыг хойч үеийнхэн мартуужин хэмээж Тайбоо, Ортайн хэмээгч хоёр хүн зохиосон ажээ. Энэ бүтээл 1741 онд бард гарсан бөгөөд өдгөө Улаанбаатар, Бээжин, Мүгдэн, Парис хотноо нэжгээд хувь үлдсэн байна. 1959 онд академич Б. Ринчен гар биеэрээ үндэслэсэн "*Монголын дурсхалт бичгийн чуулган*" (*Corpus Scriptorum Mongolorum*) хэмээх цуврал

⁶⁰ Johannes Friedrich, *Geschichte der Schrift*, Heidelberg, 1966; Иоганнес Фридрих, *История письма*, Москва, 1979, стр. 169; В. А. Истрин, *Возникновение и развитие письма*, Москва, 1965, стр. 323.

⁶¹ Johannes Friedrich, *Geschichte der Schrift*, Heidelberg, 1966; Иоганнес Фридрих, *История письма*, Москва, 1979, стр. 169; Hans Jensen, *Die Schrift*, Berlin, 1969, s. 409.

⁶² Louis Ligeti, *A propos de l'écriture mandchoue*, - Acta Orientalia Hung., Tom. II, Budapest, 1952, pp. 233-301; Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, 1964, 168-172-р тал; Л. Мишиг, *Манжийн дусал биндгүй үсгийн бичгийн тухай*, - Эрдэм шинжилгээний бичиг, Улаанбаатар, 1964, 21-36-р тал.

⁶³ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, 1964, 168-р тал.

⁶⁴ Louis Ligeti, *A propos de l'écriture mandchoue*, - Acta Orientalia Hung., Tom. II, Budapest, 1952, pp. 233-301;

бичгийнхээ Ү ботид Улаанбаатар хотод хадгалагдаж байсан ганц хувь эхийг гэрэл зураг татаж эрдэм шинжилгээний гүйлгээнд оруулсан билээ⁶⁵

Монгол бичгийг манж хэлэнд зохируулан өөрчлөхөөс өмнөхи *Tongki fuqa aqδ xergen* -ээр бичсэн дурсгалын байдалыг үзвэл монгол бичгийн уламжлалт бичилгээс нэлээд хэдэн зүйлийн ялгаа харагддаг. Үүнд: үгийн эцсийн а, ө эгшигийг ямагт хамт залган бичдэг, дунд орсон d гийгүүлэгчийг гогцооруулдаг, хойш татсан сүүл болон эцэст орсон хөндий гэдсийг яльгүй махирладаг, дүрс ижил боловч дуудалга ялгаатай гийгүүлэгчийн хэлбэрийг ялгах гэж эрмэлзсэн байдал харагддаг. Энэ бүхэн нь манж хэлнээ эгшиг зохицох ёсон байдаггүй хийгээд авиазүйн хувьд манж хэл монгол хэлнээс ялгарах онцлогтой холбоотой болох нь төвөггүй мэдэгдэнэ (*6.7-р хавсралтыг үзмүү*). Иймд манж хэлэнд тохируулан засахаас өмнө манж нарын хэрэглэж ирсэн (дусал, биндгүй) монгол бичиг нь бичилгэ хийгээд зарим үсгийн хэлбэрийн хувьд монголчуудын монгол бичгээс нэлээд ялгаатай байсан гэж хэлэх бүрэн үндэстэй.

Tongki fuqa aqδ xergen-i bitxe гэдэг бүтээл нь дөрвөн дэвтэрээс бүрдэл болдог бөгөөд тэргүүн дэвтэрт манж хэлний (V, V + V; C + V, C + V + V) задгай үет үгийг, дараахи гурван дэвтэрт манж хэлний -y(i), -г, -n, -ng, -γ | -g, -s, -d, -b, -v, -l, -m гэсэн арван нэгэн дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн битүү үет үгийг толгой болгон жагсааж тэдгээр үгийг дусал биндгүй бичиг болон дусал биндтэй үсгээр хэрхэн бичдэг байдлыг харьцуулан үзүүлсэн байдаг. *Tongki fuqa aqδ xergen-i bitxe* хэмээх дурсгалыг ийнхүү дэвсгэр үсгээр толгойлон зохиосон нь хятадын толилох уламжлалыг эрхгүй санагдуулдаг бөлгөө.

Манж бичгийн цагаан толгойг авч үзэхэд уугуул манж хэлний авиаг тэмдэглэх үсгээс гадна харь үгийг тэмдэглэх "Tulergi xergen" буюу "гадаад үсэг" хэмээх галигийн бөлөгтэй бөгөөд тэдгээр нь гол төлөв хятад хэлний авиаг тэмдэглэхэд илүүтэй анхаарсан ажээ. Үүнээс үүдүүлэн академич Ринчен профессор: Манж үсгийг зохион боловсруулсан хүмүүс 1599 онд Харчины Аюуш гүүшийн зохиосон галиг үсгийг мэдээгүй буюу "тогтоон сурч, хэрэглэн дасаагүй байдал"-тай тул "шашны сургуультай хүн гэж арай үзэж боломгүй" гэж ажиг тэмдэглэсэн байдаг⁶⁶.

Ийнхүү манж бичгийн "Tulergi xergen"-ий хувьд самгард, төвөд хэлний авиазүйг төдий л хайхраагүй, харин хятад хэлний авиазүйг түлхүү анхаарсан байдалыг үзэхэд уг бичгийг зохиоход шашин номын зорилгоос илүү улс төрийн зорилгыг эн тэргүүнд тавьсантай холбоотой гэж үзэх үндэслэл гарч байна.

Манж бичиг буй болсон нь монголчуудын хувьд төрийн ном бичгийн хүрээнд хятад, манж зэрэг гадаад нэр томъёоны дуудалгыг ялган тэмдэглэхэд их бага аль нэгэн хэмжээгээр хэсэг бусаг хэрэглэгдэж ирсэн боловч тэр нь албан ёсны бус байсан гэж үзэх үндэс буй.

Манж бичгийн талаар өрнө дахинаа нэлээд судлагаа гарсан бөгөөд нэгэн хэсэгтээ манж бичгийг үеийн бичиг хэмээж байсан явдал ч буй. Бас манж бичгийг латин, орос үсгээр галиглан тэмдэглэх хэд хэдэн хувилбар буй болсон бөгөөд 1952 онд Мажарын академич Л. Лигети профессор "*Манж бичгийн тухай*" гэдэг томоохон өгүүлэл бичсэн нь манж бичиг үсгийн судлалд шинэ үеийг нээж олон нийтээр даган мөрдөх нэгдсэн латин галигийн тогтолцоог буй болгож өгсөн билээ⁶⁷.

1987 онд Дж. Р. П. Кинг (J. R. P. King) нэгэн өгүүлэлдээ 1632 оны манж бичгийн шинэчлэлд солонгос үсгийн махбод буй тухай тэмдэглээд "...Манж бичгийг засан

⁶⁵ *Tongki fuqa aqδ xergen-i bitxe* - Corpus Scriptorum Mongolorum, Tom. V, Fasc. 1, Redigit Prof. Dr. Rintcen, Ulaanbaatar, MCMLIX (1959); Cornélie Melles, *Tongki fuqa aqδ xergen-i bitxe* - AOH, Tomus XXX, Fasc. 2, Budapest, 19, pp. 209-244.

⁶⁶ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, 1964, 169-170-р тал.

⁶⁷ Louis Ligeti, *A propos de l'écriture mandchoue*, - Acta Orientalia Hung., Tom. II, Budapest, 1952, pp. 233-301; Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Удиртгал, 1964, 170-171-р тал.

боловсруулахад нөлөөлсөн солонгос үсгийн нөлөө тусхалыг тухай таамаглал нь цаашдын нарийвчласан судлагааны дунд улам тодорхой болно гэж найдна..." гэжээ⁶⁸. Бидний хувьд ч одоогийн байдлаар уг таамаглал төдий л итгэлтэй бус тул "цаашдийн нарийвчласан судлагааны дунд улам тодорхой болно..." гэсэн түүний үгтэй санал нэг байна.

4. Тангуд бичиг хятан бичигтэй холбогдох нь

Хэлний гарал үүслийн хувьд Алтай овог хэлтэнд багтдаггүй, Хятад-төвөд хэлний бөлөгт хамаардаг Тангуд нар өөрийн хэмээсэн тангуд бичгээ XI зуунд зохиохдоо хятан бичгийн нөлөө тусхалыг авсан гэж эрдэмтдийн тэмдэглэснийг дурдалгүй орхих бөгөөс шууд холбогдох судлагааны үр дүнг анхаараагүй хэрэг болох буй заа⁶⁹.

Өөрсдийгөө "хүн" гэсэн утга бүхий 'mi буюу 'mi-'nia хэмээн нэрлэдэг Тангуд нар 1032 онд төр улсаа засчээ. Энэ тулгар улсыг Европ дахины ном зохиолд Си-ся (Hsi-Hsia ~ Si-hia) буюу монголчлох бөгөөс Баруун Ся улс гэж тэмдэглэсээр ирсэн бөгөөд 1226 онд Чингис хаан эл улсыг мөхөөсөн түүхтэй бөлгөө. Тангуд иргэний аж төрлийн талаар "Монголын нууц товчоон"-ны 265-р зүйлд:

"...nödüksен balaqasutan
nunji nuntaqтан..."

гэж тэмдэглэсэн нь буй⁷⁰.

Тэр цагтаа Тангуд нар ном хэвлэх талаараа нэлээд хөгжсөн тухай түүхэнд олонтаа тэмдэглэгдсэн боловч түүнийг батлах бодтай дурсгалыг П.К. Козлов Хар хотод хийсэн малталгынхаа үеэр анхлан олж нийтийн хүртээл болгосон бөлгөө⁷¹.

Бас Марко Поло номдоо:

"...тэр газар орныг Тангуд хэмээн дуудах бөгөөд ард иргэн нь онгон шүтэх боловч Христусын несториан, саррацин нар бас тэнд буй. Тэрхүү онгон шүтээнтэн нар өөрийн гэсэн тусхай хэлтэй..."⁷²

гэж тэмдэглэсэн нь буй.

"Монголын нууц товчоон"-д Тангудуудыг Qasin⁷³ - Хашин иргэн гэж нэрлэсэн байдаг. Юан гүрний үед хятадууд тэднийг Шар мөрөн буюу Хатун голын өрнөд этгээдэд аж төрдөг учир Хэ-си буюу "мөрний өрнөд этгээдийнхин" гэж нэрлэдэг байсантай холбоотой ажээ. Одоо болтол монголчууд малийсан суумал өвгөний барималыг Хашин хаан гэдэг нь мөн л үүнтэй холбоотой гэлцнэм.

Хатун голын орчимынхины хэрэглэж байсан И-юй маягийн тольд тэднийг хятадаар tanut⁷⁴ гэж нэрлэсэн байдаг нь мөн л эртний улбаатай ажгуу. 734 онд Орхоны эрэгт

⁶⁸ J. R. P. King, *The Korean Elements in the Manchu Script Reform of 1632*, - CAJ, Vol. 31, N. 3-4, Wiesbaden, 1987, pp. 252-286.

⁶⁹ А. П. Терентьев-Катанский, *Книжное дело в государстве Тангутов*, Москва, 1981, стр. 55-59.

⁷⁰ L. Ligeti, *Histoire secrete des Mongols*, Budapest, 1971, p. 238.

⁷¹ А. П. Терентьев-Катанский, *Книжное дело в государстве Тангутов*, Москва, 1981, стр. 137-141.

⁷² И. П. Минаев, *Путешествие Марко Поло*, Санкт-Петербург, 1902, стр. 80-81.

⁷³ Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972, Lines: 4537, 5833, 10020, 10021, 10036.

⁷⁴ Н. А. Невский, *Тангутская филология*, книга 1, Москва, 1960, стр. 19.

босгосон Хөшөө цайдамын түрэг, хятад бичээст уг үг *taŋut* гэсэн хэлбэрээр тохиолддог⁷⁵. Монголчуудын Тангуд гэж нэрлэдэг нь үүнтэй холбоотой нь мэдээж бөгөөд тангудач эрдэмтэн Н. А. Невский тангуд гэдэг нэрийн -уд гэдэг төгсгөлийг монгол хэлний "бөлөг олон"-ыг заадаг дагавар хэмээн үзжээ⁷⁶. Үүнтэй холбогдуулан хэлэхэд Асуд, Башигуд, Оросуд, Сойуд, Тэлэнгуд, Уйгуд, Хаасуд, Эрхүд зэрэг харь овог аймгийн нэр, Баатуд, Баюуд, Бодонгуд, Галзуд, Бэсүд, Мангуд, Огниуд, Олхунуд, Таргуд зэрэг монгол овог аймгийн нэрийн бүтэцэд -уд/-уд гэдэг тусхай дагавар залгаж бүтээдэг ёс тогтолцоотой байдагийг энд давтан дурдсуу⁷⁷.

Шинэ тулгар төр улсаа байгуулмагц үндэсний бичиг үсгээ зохиож хэрэглэдэг тогтсон ёс Төв Ази дахины түүхэнд түгээмэл байдагийн жишигээр 1032 онд Си-ся улсаа байгуулсан Тангудууд дөрвөн жилийнхээ нүүр дээр өөрийн гэсэн тангуд бичгээ зохиож 1036 онд Юан Хао (*Li Yuan hao*) хааны зарлигаар албан ёсоор хэрэглэх болжээ (*8-р хавсралтыг үзмүү*).

Энэ бичгийг хэрхэн, хэн зохиосон тухайд нангиадын түүхэнд хэдэн янзаар дурдсан байдаг боловч ерөнхийд нь гурван зүйлээр тайлбарлаж болно.

Нэгд: "*Ляо ши*"-гийн мэдээгээр 1004-1031 онд Тангудын төрийг барьж байсан Тоба Дэ-мин гэгч тангуд бичгийг зохиосон хэмээжүүй.

Хоёрт: "*Сүн ши*"-гийн мэдээгээр эзэн хаан Юан Хао өөрөө бичиг зохиогоод Ели Жэн-Юн гэгчид зарлиг болж дүрэм зохиолгосон, үсгийн хэлбэр тэгш дөрвөлжин, бичихүйе нэн төвөгтэй, бүх түшмэл албандаа хэрэглэхийн тул уул бичгийг заалгасан тухай дурдсан нь буй. Өөр нэгэн газар, саяхи мэдээг дурдаад Юан Хао сургууль нээж Тангуд түшмэдийн хөвгүүн, дүү нарыг сургаж байсан, уг бичиг нь хятадынхитай адилдуу, 1039 онд Юан Хао "хаан" цолыг олоод Сүн улсын хаанд захидал илгээж:

"...толгой эргүүлсэн хээ угалз (шиг хятад бичиг Ц. Ш.)-аас салж тангуд бага (! Ц.Ш.) бичгээ зохиолоо би..."

гэж мэдэгдсэн тухай мэдээ дайралддаг. Түүх судрын дотор ч Юан Хао хааны нэрийн өмнөхи олон тодотголын дотор "үсэг бичиг зохиосон" гэдэг үг байдагийг дурдахад илүүдэх нь юун.

Гуравт: Ели Юй-Ци хэмээх түшмэл нэгэн бэхлэлт балгадад гагцаар сууж байхдаа тангуд бичгийг зохиогоод 1036 онд Юан Хао хаанд өргөн барьсан гэдэг мэдээ бий.

Дээрхи гурван зүйл мэдээ тэмдэглэлийн аль нь зөв болохыг өдгөө хүртэл ац хагалаж нэгэн тийш болгож амжаагүй⁷⁸. Зарим нь он цагийн хувьд түүхийн бусад баримттай зөрчилддөг тал ч бий. Харин зарим судлагч Ели Жэн-Юн, Ели Юй-Ци хоёрыг нэг хүн гэж үздэг боловч тангудач эрдэмтэн К. К. Флуг, Н. А. Невский, Е. И. Кычанов нар үүнийг зөвшөөрдөггүй. Н. А. Невский, Е. И. Кычанов нар тангуд бичгийг Юан Хао хааны заавар удирдалгаар Ели Жэн-Юн зохиосон байж болох үндэслэл бага бус гэж үздэг бөлгөө.

Тангуд бичгийг хэн хэрхэн зохиосон талаар одоо болтол санал нэгдмэл бус боловч хятан бичгийн нөлөө гэж үзэж болохуйц адил дүрс, зурам тогтолцоотой байдаг тухай

⁷⁵ *Древнетюркский словарь*, Ленинград, 1969, стр. 533. 6.

⁷⁶ Н. А. Невский, *Тангутская филология*, книга 1, Москва, 1960, стр. 74.

⁷⁷ Ц. Шагдарсүрэн, *Монголжсон харь харь овогийн тухай тэмдэглэл*, - *Studia Mongolica*, Tom. VIII, Fasc. 19, Ulaanbaatar, 1971, 255-267-р тал; Ц. Шагдарсүрэн, *Некоторые заметки о монголизированных родах по костям инородного происхождения*, - *Эрдэм шинжилгээний бичиг* (МУИС, Монголын судлалын хүрээлэн), Улаанбаатар, 1996, 186-194.

⁷⁸ А. П. Терентьев-Катанский, *Книжное дело в государстве Тангутов*, Москва, 1981, стр. 55-59.

судлагчид ажиглан тэмдэглэж иймэрхүү адил төсөөтэй зүйл нь тохиолдлын хэрэг биш гэж үздэг⁷⁹.

Тангуд бичигийн тогтолцоон дахи хятан бичгийн нөлөөний асуудлыг бидний зүгээс энэ хир хангалттай судлаагүй учир эрдэмтдийн тодорхойлсончлон, тангуд бичиг дэхи тэдгээр адил төстэй дүрс, зурам нь энэ номын "Хятан бичиг" хэмээх бөлгийн 1-р хавсралт дахи үсгийн жагсаалтын 26, 143, 144, 156, 179, 250, 334-рт буй тэмдэгтүүдэд лавтай давтагддаг гэдгийг цухас дурдая.

Энэ мэтийн нөлөө тусхалын асуудал бодтай гэдэг нь баттай нутлагдах аваас дээрхи арваад үсгийн тэмдэгтээр хязгаарлагдахгүй, илүү өргөн хүрээг хамрах нь мэдээж бөлгөө. Тийм ч учраас тангуд "бага" бичгийн судлал нь хятан, тангудын соёлын харилцааны түүхэнд шууд холбогдохын хажуугаар хятан бичгийг тайлж уншихад зайлашгүй анхаарваас зохилтой нэг судлагдахуун болж өгөх нь маргаангүй юм.



Монголчууд ийнхүү лавтайяа X-XI зуунаас Төв Азийн бусад ард түмний бичиг үсгийн хөгжилд бодтай нөлөөлсөөр ирсэн нь ганц нэгэн тохиолдлын хэрэг биш бөгөөд цаанаа соёл, улс төр, хэлшинжлэлийн тодорхой үндэслэлтэй ажээ. Өөрөөр хэлбэл зөрчид, солонос, манж нар хэлний хувьд цөм Алтай овогийн залгамал хэлтэн мөн бөгөөд түүхэн хөгжлийнхөө тодорхой үед бүгд хятадын дүрс бичгийг хэрэглэж байсан боловч бие даасан төр улсаа байгуулмагц өөр өөрийнхөө үндэсний бичгийг боловсруулдаг нэгэн уламжлал тэр цагт Төв Ази дахинаа тогтсон байсан бөгөөд тийнхүү боловсруулахдаа дээр бидний өгүүлсэнчлэн монгол туургатны бичиг үсгээс их бага аль нэгэн хэмжээгээр санаа сэдэлгэ авсан нь нэгд, монгол туургатны хэрэглэж байсан бичиг нь дүрс бичигтэй харьцуулахад залгамал хэлний онцлогт илүү тохирсон авианы бичиг байсан хийгээд бүтэц тогтолцооны хувьд үлгэр жишээ авахуйц боловсронгуй байсантай; хоёрт, тухайн үед нийгэм-соёл болон шашин суртлын хувьд бие биедээ илүү ойр дөхөм байсантай холбоотой гэж үзэх үндэс буй.

Тэдгээр улс үндэстэн нийтдээ хятад бичиг хэрэглэж байсан тухайд японы монголч эрдэмтэн Масао Онуки профессор:

"...Зүүн Азийн олонхи үндэстэн дээр үеэс эхлэн хятад бичиг соёлын хүчтэй нөлөөн дор байсаар ирсэн ба гагцхүү монгол үндэстэн л уг нөлөөг үл зөвшөөрснөөрөө бусдаас ялгарах өөрийн хувь шинжээ илэрхийлсээр иржээ..."⁸⁰

гэж дурдсан байдаг. Ийнхүү хятад үсгийг Ази дахины олон улс үндэстэн нэгэн хэсэгтээ нийтлэг хэрэглэж байсан нь хятад бичигийн олон хэлэнд тохирох онцгой шинжтэй шууд холбоотой хэмээн тайлбарласан бүтээл ч буй⁸¹.

Хэдий тийм боловч хятад бичгийг хэрэглэж байсан япон, солонгос зэрэг улс үндэстэн хятад бичгийг эх хэлнийхээ онцлогт тохируулан засах оролдолгыг нэг бус удаа

⁷⁹ Е. И. Кычанов, *К изучению структуры тангутской письменности*, - Краткие сообщения Института народов Азии СССР, 63, Москва, 1964, стр. 56; Е. И. Кычанов, *Очерк истории тангутского государства*, Москва, 1968, стр. 263.

⁸⁰ Масао Онуки, *Монголын үндэстэн бүрэлдэн тогтсон түүхэн явцын онцлог*, - Олон улсын монголч эрдэмтний IV их хурал, 1-р боть, Улаанбаатар, 1985, 136-р тал; - "Mongol Kenkyu", N. 6, 1983, Osaka, p. 18.

⁸¹ Чингэлтэй, *Хятад үсгийн олон хэлэнд тохиролцох шинж*, - Хэл бичгийн Эрдэм шинжилгээний өгүүллийн түүвэр, XX дэвтэр, Өвөр монголын Их сургуулийн Хэл бичиг судлах газар, XX дэвтэр, 1997, 1- 10-р тал (хятад хэлээр).

хийж байсан тухай судлагчид тэмдэглэжээ⁸². Бид ч энэ тухай солонгос бичгийн хэсэгт хөндөн ярьсан бөгөөд хятад бичгийг тухай тухайн хэлнийхээ онцлогт тохируулан засах гэсэн оролдолго бүтээгүй нь цаанаа хэлшинжлэлийн учир холбогдолтой бөлгөө. Ийнхүү тэдгээр улс үндэстэн нийгэм-улс төр, хэлшинжлэлийн шаардалгаар үндэснийхээ бичгийг шинээр зохиох болсон байна.

Тангуд нарын тухайд бол хэдийгээр Алтай овогийн хэлтэн бус боловч Төв Азийн бусад улс үндэстний адилаар, тухайн цаг төрийн аясыг дагасан хэрэг гэж үзэж болно. Түүнээс гадна, тангуд (бага) бичиг нь өөрөө *үг-үеийн дүрс бичиг* мөний учир тийм тогтолцоо бүхий хятан "бага" бичгийн нөлөөг авсан гэхэд хэлшинжлэлийн үүднээс огт боломжгүй гэж үзэх үндэс бас байхгүй.

⁸² Louis Ligeti, *Le Tabghach, un dialecte de la langue Sien-pi*, - Mongolian Studies, edited by Louis Ligeti, Budapest, 1970, pp. 265-308; Hans Jensen, *Die Schrift*, Berlin, 1969, s.203.



Хэнтий аймагийн Баянхутаг сумын Сэrvэн хаалганы зөрчид бичээс

Texte Jou-tchen.

处五北来又为岳史休奈来
 育肥寸罕罕又夫余右
 交友夫社光元北更吾夫年孟姜
 也美伟右乎王更乞非美休干
 社梁半月寸半日育无寺居保
 又升支史礼斥社光肥寸罕罕
 又克史休又升及友夫育无
 令史 虎 亮 杀 元 屏

Texte Chinois.

海西法因河衛都指揮同知滿
 答男羅羅合謹
 奏奴婢祖在邊方出力有年正德
 十五年十月初十日得了職事
 命奴婢男羅羅合襲職奏得
 聖皇帝知道

Хятад орчуулга бүхий зөрчид бичээс

(Үүнийг W. Grube, Note préliminaire sur la langue et l'écriture Jou-tchen [T'oung Pao, Vol. 5, 1894] гэдэг өгүүллээс авав)

訓民正音

國之語音異乎中國與文字
 不相流通故愚民有所欲言
 而終不得伸其情者多矣予
 爲此憫然新制二十八字欲
 使人易習便於日用耳
 一。牙音。如君字初發聲

"Hunmin chǎng'ūm" номын эхний хуудас
 (Уг бичигийг зохиох болсон шалтгааныг энд дурджээ)

丨。如業字中聲

一。如欲字中聲

卞。如穰字中聲

二。如成字中聲

卩。如擎字中聲

終聲復用初聲。○連書屑音

之下。則為屑輕音。初聲合用

"Hunmin chǎng'üm"-ын нэг хуудас
(Эгшиг үсэгийн бүтэц)

理而已。理既不二。則何得不與天
地鬼神同其用也。正音二十八字。
各象其形而制之。初聲凡十七字。
牙音ㄣ。象舌根閉喉之形。舌音ㄥ。
象舌附上腭之形。唇音□。象口形。
齒音人。象齒形。喉音○。象喉形。𠂔。
比。𠂔。聲出稍厲。故加畫。ㄚ。而。ㄗ。而。
而。ㄘ。而。ㄙ。而。

[illegible]

Tongki fuqa aqδ xergen-i bitxe
НОМЫН НЭГЭН ХУУДАСНЫ БАЙДАЛ

[illegible]



Тангуд бичгийн дурсгалаас

ТӨГСГӨЛ

Бидний өнөөдөрийн мэдэлгийн хэрээр, түүхэн үеийн туршид Монгол туургатны боловсруулан хэрэглэж ирсэн одон зүйл бичиг үсэгийн тогтолцоог нэгэн цогц болгон авч үзэхүл лавтайяа 2000 жилийн түүхтэй ажээ. Зарим нэгэн онцгой гажилтыг эс тооцвол, 2000 жилийн энэхүү түүх нь үсэг бичигийн тогтолцоог боловсронгуй болгох гэсэн, ганц нэг удаагийн бус, оролдолго эрмэлзэлийн түүх гэж лавтай хэлж болох бөгөөд энэ нь улс төр, соёл иргэншлийн тусгаар тогтнолоо эрхэмлэсээр ирсэн монгол түмний утга соёлын түүхийн салаашгүй үндсэн нэгэн хэсэг мөнөөс мөн бөлгөө.

Энэ номын үндсэн арван гурван бөлөгт дурдсан зүйлийг нэгтгэн авч үзвэл доорхи хэдэн дүгнэлтийг гаргаж болно.

- Түүхэн хөгжлийнхөө туршид монголчуудын боловсруулан хэрэглэж ирсэн арав гаруй бичиг үсгийг дотор нь:

1. Улс төр, шашин сурталын дотоод шалтгаанаар, өөрсдийн санаачилгаар боловсруулан хэрэглэсэн бичиг үсэг;
2. Улс төр, үзэл сурталын гадаад шалтгаанаар, бусдын шахалтаар авч хэрэглэх болсон бичиг үсэг

гэж хоёр хувааж болно.

- Монголчууд түүхийн туршдаа улс төр, шашин сурталын хүрээнд хэдийгээр арав гаруй бичиг үсэг хэрэглэсэн боловч тэдгээр нь үүсэлийн хувьд яв явсаар хүмүүн төрөлхитөний буй болгосон өнийн уламжлалт гурваас дөрвөн бичиг, тухайлбал:

Арамей гаралтай *согд бичиг*,
Брахми гаралтай *нагар-төвөдийн бичиг*,
Финик гаралтай *кирилл, латин бичиг* болон
Хятадын дүрс үсэгт

тус тус холбогдоно. Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд, 920 онд зохиогдсон хятан "их" бичигийг нангиад дүрс үсэгт үндэслэсэн гэж үзэх магадлалтай боловч уг бичиг Алтай овогийн монгол хэлнээ төдий л зохистой бусын учир таван жилийн дараа буюу 925 онд зохиосон хятан "бага" бичиг хэмээх авианы шинэ бичигт байраа тавьж өгсөн билээ. Энэ бүхнийг бодолцвол, монгол туургатны хэрэглэж ирсэн бичиг үсэг нь цөм авианы бичиг байсан гэж үзэж болно.

- Хятан "бага" бичигийг үл тооцон, бидний судлагдахуун болсон бичиг үсэгүүдээс тамга маягийн "рүн" бичиг, дөрвөлжин, соёмбо, хэвтээ дөрвөлжин бичигийг нэгэн цогцод нь авч үзэхүл тэдгээр бичигээр аливаа үгийг үе үеэр нь бичдэг боловч (зарим хүний үзэгчилэн үеийн бичиг огт биш!) цөм цагаан толгойт, авианы бичиг бөлгөө.

- Монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсгийн бүх тогтолцоо нь зөвхөн монгол хэлний хүрээгээр хязгаарлагдаж байсангүй, бүр анханаасаа улс төр, шашин суртал, аж төрөл, эдийн засагийн өргөн салбарт холбогдол, шаардалга бүхий төвөд, самгард, хятад, манж, орос, түрэг зэрэг гадаадын олон хэлний ном зохиол, үг хэлэлгэ, нэр томъёо тэргүүтнийг тэмдэглэж бүрэн чадахуйц галигийн нарийн тогтолцоотой байсан нь бусад улс түмний соёл боловсролыг адил тэгш хүндэтгэж ирсэний нэг нутлагаа хэмээн хэлж болно.

- Монголчуудын бичиг үсэгүүд нь монгол туургатны дотоодод харилцан нөлөөлөлцсөн төдийгүй, гадаад тийшээ, ялангуяа Төв Азийн Алтай хэлтэнд багтдаг Эртний түрэг, Зөрчид, Манж, Солонгос нарын үндэсний бичиг үсэг буй болоход багагүй нөлөө үзүүлжээ. Үүнээс гадна Алтай овог хэлтэнд үл багтах Тангуд нарын бичигт Хятан үсэг нөлөөлсөн тухай гаднахи хэлбэрийн талаас нь нэг бус судлагч бичиж байгааг дотоод тогтолцооны үүднээс нь батлах баримт энэ хир олдоогүй байгаа ч шууд үгүйсгэхэд бас бэрхтэй.

- Түүхэн хөгжлийн туршид монголчуудын боловсруулан хэрэглэж ирсэн олон зүйл үсэг бичиг нь нэг талаас төрийн тусгаар тогтнолыг эрхмилэх үзэлтэй, нөгөө талаас шашин суртал, утга соёлын шаардалгаар галиглах тогтолцоог боловсронгуй болгох зорилготой холбоотой байсан боловч монголчуудын түүхэнд цөмөөрөө дэвшилт үүрэгийг төгс төгөлдөр гүйцэтгэж ирсэн гэж үзэхэд учир дутагдалтай санагдана. Зарим тохиолдолд, тухайлбал: үсэгзүйн талаас нийт монголчуудын бичигийн тогтолцоог улам нарийсган боловсруулах гэсэн оролдолгын эцсийн үр дүн нь тэр бүр санаснаар болж өгөлгүй, тодорхой нэг аялгуутан буюу тэдний оршин суух нутаг дэвсгэрээр хязгаарлагдаж, нийт монгол туургатны хүртээл болж чадалгүй, харин зааглах үүргийг санамсаргүй гүйцэтгэх болсон тал ч буй. Үүнээс гадна зарим бичиг үсэг нь томоохон ном бүтээлийг бичихэд хүчирдэлтэй буюу түргэн бичих шаардалга хангаагүй зэргээсээ болж нийтийг хамран дэлгэрч чадалгүй зуурам орхигдсон байдал ч ажиглагддаг бөлгөө.

- Монгол түмний хэрэглэж ирсэн олон зүйл бичиг үсгийн тогтолцоо нь түүхийн туршид нийгэм-соёлын шалгаруулалтаар шүүгдэж монгол хэл, аялгууны шаардалгад хамгийн зохистой нийцсэн нь ялгарч нийт монголчуудын хүртээл болсоор ирсэн бөлгөө. Үүнд: олон зүйл бичиг үсгийн дотроос, орон зайн хувьд хамгийн өргөн дэлгэр - нийт монголчуудын дунд, цаг хугацааны хувьд хамгийн урт удаан - анх буй болсон цагаасаа өнөөдрийг хүртэл, хамгийн тогтвортой хэрэглэгдэж ирсэн¹ нь монгол бичиг болой. Үүний гол учир гэвэл: уг бичиг нь үсэгзүйн хувьд монгол хэл, түүний нутаг нутагийн аялгууны онцлогт бүрэн зохицож нийт монгол туургатныг хэл болон бичигийнхи нь хувьд нэгтгэж өгөхийн сацуу монгол хэлний аливаа аялгууны онцлогийг эрх тэгш хадгалан хөгжүүлэх бололцоог жигд хангаж чадсанд оршимуй.

- Аливаа улс үндэстний бичиг үсгийн үүсэл гарал болон авч хэрэглэсэн учир холбогдол нь эрт үедээ шашин шүтэлгэ, харьцангуй хожуу үед үзэл сурталтай нягт холбоотой байдаг нь дэлхий даяар нийтлэг үзэгдэл болой. 1941 оноос өмнөхи үеийн турш дахи монголчуудын үсэг бичигийн түүхийг авч үзвэл шашин номын хэрэг болон бичиг үсгийн уламжлалаа шууд хил нийлж нутаг савласан их хөршүүдээсээ биш, ямагт өөрсдийн шилж сонгосон, нутаг алсласан бусад ард түмнээс монгол хэл, монгол аж төрөлдөө тохируулж, монголжуулан боловсруулж авдаг байсан явдал бэлхэнээ харагддаг. Үүнд: шашин сурталын тухайд профессор Л. Хүрэлбаатар удаа дараагийнхаа бүтээлүүдэд тусгайлан авч үзсэн зүйл буй; бичиг үсгийн талаар М. Онуки зэрэг гадаадын зарим судлагч нарын ажиглан тэмдэглэсэн зүйл ч буй². Чухамхүү ингэх нь нутаг савласан их үндэстний хүн амтай харьцуулахад ямагт цөөн байсан монголчуудын хувьд улс төр, хэл бичиг, соёл боловсрол, шашин сурталын хувьд бие даан тусгаар орших хамгийн эрхэм нэгэн батлагаа нь болж өгсөөр ирсэн ажээ.

- Монголчуудын хэрэглэж ирсэн олон зүйл үсэг бичигээрхи дурсгалын зүйлийг улариулан үзвэл тэдгээр бичиг үсгийн нэгэн хэсэг нь гол төлөв улс төрийн хүрээнд, бас нэгэн хэсэг нь их төлөв шашин суртал, утга соёлын хүрээнд хэрэглэгдэж ирсэн байх ба энэ


¹ Юан гүрний үед дөрвөлжин бичигийн нөлөөгөөр монгол бичигийн хэрэглээ хязгаарлагдсан гэж зарим хүн үздэг боловч тэр үед ямар ч атугай орчуулгын олон бүтээл монгол бичгээр гарсан төдийгүй, Юан гүрний дотоодод ч албан гэрээний зүйлийг монгол бичгээр бичдэг байсан биет баримт олдсоор байгааг дараахи номоос үзмүү: *Chinese History - From Primitive Society Down Through the Qing Dynasty*, Great Wall Books, Beijing, 1988 [Хавсралт дахи гэрэл зураг]. Энэ номын "Монгол бичиг" бөлөгийн 4-р хавсралтыг үзмүү.

² М. Онуки, *Монгол үндэстэн бүрэлдэн тогтсон түүхэн явцын онцлог*, - *Mongol-Kenkyū* (Journal of Mongolian Studies), No. 6, 1983, Osaka, (pp. 1-33) 18-р тал.


ялгаа нь номын хэлбэрт тусгалаа олж, улс төр, иргэний агуулгатай ном нь голдуу дэвтэрлэж товхисон, шашин сурталын ном нь ихэнхидээ сударчилсан байдалтай байдаг бөлгөө. Үүнийг хүснэгтлэн үзүүлбэл доорхи мэт болно.

	<u>Улс төр, иргэний</u> <u>хүрээ</u>	<u>Шашин сурталын</u> <u>хүрээ</u>
<u>Ном бичиг зохиолын хэл</u>	Монгол хэл	Төвөд хэл Монгол хэл Самгард хэл
<u>Үсэг бичиг</u>	(Тамга үсэг) Монгол бичиг Хятан бичиг Дөрвөлжин бичиг Тод бичиг Оросжин кирилл бичиг	Төвөд бичиг Монгол бичиг Тод бичиг Соёмбо бичиг Хэвтээ дөрвөлжин бичиг
<u>Номын хэлбэр маяг</u>	Дэвтэрлэж товхисон ном	Сударчилсан ном


1. Монгол бичиг түүнээс уламжласан бичиг үсгийн гарал үүсэл, нөлөөний тойм зураг



2. Дөрвөлжин, соёмбо, хэвтээ дөрвөлжин бичигийн гарал, нөлөөний тойм зураг



3. Хятан бичиг, түүний үүсэл болон нөлөөний тойм зураг



Тэмдэглэх нь: үргэлж зураасаар гарлыг, тасархай зураасаар нөлөөлснийг ялган үзүүлэв.

ЕРӨНХИЙ НОМЗҮЙ

- Айдаров Г.** *Язык орхонских памятников древнетюркской письменности VIII века*, Алма-Ата, 1971.
- Алтангэрэл Ч.** *Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн бүтээл, I - II боть*, Улаанбаатар, 1967/1968.
- Алтангэрэл Ч.** *Цэрэнсодном Д.* *Турфаны цуглуулгын ТМ-38*, SM, Tom. V, Fasc. 18, Улаанбаатар, 1966, 113-122.
- Алтангэрэл Ч.** *Цэрэнсодном Д.* *Турфаны цуглуулгын ТМ-8, Т-11, Т-662*, SM, Tom. VI, Fasc. 18, Улаанбаатар, 1967, 38-43.
- Археология и этнография Монголия*, Новосибирск, 1978.
- Бадараев Б.-Д.** *Об основах транскрипции и транслитерации для тибетского языка*, Улан-Удэ, 1967.
- Банзаров Д.** *Собрание сочинений*, Москва, 1955.
- Барайшир Ш.** *Үсэг бичигээ улам сайн болгохын төлөө*, Улаанбаатар, 1959.
- Бартольд В.В.** *История Туркестана*, Ташкент, 1922.
- Бартольд В.В.** *История изучения Востока в Европе и России*, 2-е издание, Ленинград, 1925.
- Бартольд В. В.** *Сочинения*, Том. V, Москва, 1968.
- Басаков Н. А.** *Алтайская семья языков и её изучение*, Москва, 1981.
- Бира Ш.** *Монгольская тибетоязычная историческая литература XVII - XIX веков*, Улан-Батор, 1960.
- Бира Ш.** *БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудал*, Улаанбаатар, 1977.
- Бира, Ш.** *Монгольская историография, XIII-XVII вв.* Москва, 1978.
- Биткеев П. Ц.** *Проблема долготности в фонологической системе ойратского языка*, ВЯ, 1985, No. 5, Москва, стр. 111-120.
- Биткеев П. Ц.** *Языки и письменные системы Монгольских народов*, Москва-Элиста, 1995.
- Бичурин (Иакинф) Н. Я.** *Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена*, Том. I-III, Москва-Ленинград, 1950/1953.
- Бобровников А.** *Грамматика монгольско-калмыцкого языка*, Казань, 1849.
- Бобровников А.** *Памятники монгольского квадратного письма*, ТВОИРАО, Том. XVI, Санкт-Петербург, 1870, стр. 1-90.
- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх, I-III боть*, Улаанбаатар, 1960/1969.
- Бямбаа Р.** *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1997.
- Владимирцов Б. Я.** *Монголо-Ойратский героический эпос*, Петербург-Москва, 1923.
- Владимирцов Б. Я.** *MONGOLICA - Об отношении монгольского языка к Индо-европейским языкам Средней Азии*, ЗКВ, Том. I, Ленинград, 1925, стр. 305-341.
- Владимирцов Б. Я.** *Bodhicaryavatara Cantideva - Монгольский перевод Chos-kyi 'Od-zer'a*, ВВ, Том. XXVII, Ленинград, 1929.
- Владимирцов Б. Я.** *Общественный строй монголов*, Ленинград, 1934.
- Владимирцов Б. Я.** *Надписи на скалах Халхаского Цогту Тайджи*, ИАН СССР, Том. XX, Ленинград, 1926/1927, стр. 1253-1280 / 215-240.
- Владимирцов Б. Я.** *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, введение и фонетика, Ленинград, 1929.
- Владимирцов Б. Я.** *Монгольский международный алфавит XIII века*, - Культура и письменность Востока, Москва, 1931, стр. 32-42.

Замдарицов Б. Я, *Монгольские литературные языки*, ЗИВ, Том. I, Ленинград, 1931, стр. 7-10.

Воробьев М. В, *Чжурчжэнь и госудадарство Цзинь*, Москва, 1975.

Воробьев М. В, *Культура чжурчжэней и государство Цзинь*, Москва, 1983.

Воробьев П. И, *Новые данные о происхождении и развитии маньчжурской письменности*, - Записки ИВАН, том. У, Москва, 1935, стр. 115-134.

Гамкрелидзе Т. В, *Происхождение и типологии алфавитной системы письма*, ВЯ, Москва. 1988, No. 5-6.

Гафуров Б. Г, *История Таджикского народа в кратком изложении*, Том. 1, Москва, 1952.

Гельб И. Е. *Опыт изучения письма (Основы грамматиологии)*, Москва, 1982.

Геродот, *История в девяти книгах*, издательство: Наука, Москва, 1972.

Гиляревский Р. С, Гривнин В. С, *Определитель языков по письменностям*, Москва, 1964.

Голстунский К. О, *Монголо-ойратские законы 1640 года*, дополнительные указы Галдан-хун тайджия и законы составленные для Волжских Калмыков при калмыцком хане Дондук-Даши, Санктпетербургъ, 1880.

Гумилев Л. Н, *Хунны*, Москва, 1960.

Гумилев Л. Н, *Древние тюрки*, Москва, 1967.

Гумилев Л. Н, *Поиски вымышленного царства*, Москва, 1970.

Гумилев Л. Н, *Хунны в Китае*, Москва, 1974.

Гумилев Л. Н, *Ритмы Евразии*, Москва, 1993.

Дамдинсүрэн А, *Археологийн шинжилгээгээр олдсон Хүннугийн бичигийн дурсгал*, - Монголын эртний түүх соёлын зарим асуудалд, Улаанбаатар, 1972, 99-115.

Дамдинсүрэн А, *Монгол мөнгө*, Улаанбаатар, 1975.

Дамдинсүрэн А, *Монголын дөрвөлжин бичиг*, Улаанбаатар, 1986.

Дамдинсүрэн Ц, *Монголын шинэ үсгийн дүрэм*, Улаанбаатар, 1942.

Дамдинсүрэн Ц, *Монголын шинэ үсгийн товч дүрэм*, Улаанбаатар, 1946.

Дамдинсүрэн Ц, *Монголын уран зохиолын тойм*, Улаанбаатар, 1957.

Дирингер Д, *Алфавит*, Москва, 1963.

Дорж Д, Новгородова Э. А, *Петроглифы Монголии*, Улан-Батор, 1975.

Дорж Д, Цэвээндорж Д, *Монголын палеолит*, Улаанбаатар, 1978.

Доржсүрэн Ц, *Умард хунну*, Улаанбаатар, 1961.

Доржсүрэн Ц, *Говь-алтайн Цагаан голын хадны зураг*, - Эртний судлал - угсаатны зүйн бүтээл, СА, Том. II, Улаанбаатар, 1963, 16-26.

Древнетюркский словарь, Ленинград, 1969.

Е Лун-ли, *История государства Киданей*, Москва, 1979.

Жамъян Г, *Тод үсгийн зөв бичих дүрэмд урт эгшигийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудалд*, SM, Том. VII, Fasc. 20, Ulan-Bator, 1970, 257-270.

Жамъян Г, *Обозначение долгих гласных в ойратском ясном письме*, НАА, Москва, 1970, No. 5, стр. 150-152.

Жамъян Г, *Ясное письмо в сравнительном освещении*, - Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук, рукопись, Улан-Батор, 1988.

Зиграф И. Т, *Среднекитайский язык*, Становление и тенденции развития, Москва, 1979.

Зиграф И.Т, *Монгольско-Китайская интерференция (Язык монгольской канцелярий в Китае)*, Москва, 1984.

Иакинф (Бичурин Н. Я.), *Статистическое описание китайской империи*, С-Петербургъ, 1842.

Истрин В, *Возникновение и развитие письма*, Москва, 1965.

Их тэнгэрийн харшид болсон яриа, - Цог, 1990, No. 5, Улаанбаатар, 123-148.

Кара Д, *Книги монгольских кочевников*, Москва, 1972.

Кара Д, *Хятан нарын хоёр бичигийн тогтолцооны тухай*, Олон улсын монголч эрдэмтний III их хурал, II боть, Улаанбаатар, 1977, 86-89.

Кацпржак Е. И, *История письменности и книги*, Москва, 1955.

Кляшторный С. Г, Лившиц В. А, *Согдийская надпись из Бугута*, СНВ, Том. X, Москва, 1971, 121-146.

Кляшторный С. Г, Лившиц В. А, *Открытие и изучение древнетюркских и согдийских эпиграфических памятников Центральной Азии*, - Археология и этнография Монголии, Новосибирск, 1978, стр. 37-60.

- Книги Марко Поло, Москва, 1956.
- Козлов П. К, *Монголия и Амдо и мертвый город Хара-Хото*, Москва, 1948.
- Кондратов А. М. Шеворошкин В. В, *Когда молчат письма*, Москва, 1970.
- Концевич Л. Р, *Хунмин чоным*, - Памятники письменности Востока, Том. LVIII, Москва, 1979.
- Котвич В, *Из находки П. К. Козлова в г. Харахото, образцы ассигнации Юаньской династии в Китае*, - ИИРГО, Том. XLV, С.-Петербург, 1904, стр. 474-477.
- Леонтьев А. А, *Некоторые вопросы лингвистической теории письма*, - Вопросы общего языкознания, Москва, 1964.
- Лившиц В. А, *О происхождении древнетюркской рунической письменности*, - СТ, 1978, No. 4. Москва, 84 - 98.
- Лигети Л, Г. Д. Санжеев: *Сравнительная грамматика монгольских языков*, - ВЯ, 1955, No. 5,
- Лоукотка Ч, *Развитие письма*, Москва, 1950.
- Лубо-Лесниченко Е. И, *Ассигнации Монгольской времени, по материалам Хара-хото*, НАА, 1963, No. 3, Москва, стр. 140-147.
- Лувсанбалдан Х, *Тод үсэг, түүний дурсгалууд*, Улаанбаатар, 1975.
- Лувсанбалдан Х, *Хуучин монгол бичгийн татлан бичдэг журам*, SM, Том. IV (12), Fasc. 11, 1976, 295-298.
- Лувсанвандан Ш, *Дөрвөлжин, тод үсгийн зөв бичих дүрэмд монгол хэлний урт эгшигийг тэмдэглэсэн нь*, ХЗС, XI боть, 2-р дэвтэр, Улаанбаатар, 1970, 103-114.
- Лувсанвандан Ш, *Монголын дөрвөлжин үсгийн их А, шанаган А-гийн тухай асуудалд*, SM, Том. VI (14), Fasc. 6, Улаанбаатар, 1980, 31-32.
- Лувсандорж Ж, *Эртний монгол бичигт үгийн эхний Алеф үсгээр ямар авиа тэмдэглэсэн бэ?* -Эрдэм шинжилгээний бичиг (МУИС), No. 3 (87), Улаанбаатар, 1984, 35 - 44.
- Лувсандэндэв А, *Из письменных традиций кочевых кочевников Центральной Азии*, - Роль кочевых народов в Цивилизации Центральной Азии, Улан-Батор, 1974, 185-191.
- Лувсандэндэв А, *Хэлбичгийн ухааны зарим асуудал*, I - II дэвтэр, Улаанбаатар, 1982.
- Маявкин А. Г, *Материалы по истории Уйгуров в IX-XI вв.*, ИКВА, Том. П, Новосибирск, 1975.
- Малов С, *Памятники древнетюркской письменности (Монголии и Киргизии)*, Москва-Ленинград, 1951.
- Материалы по дешифровке киданьского письма*, Книги I, II, Москва, 1970.
- Махмутов А, *Как возник древнетюркский алфавит*, Исследование по тюркологии, Алма-Ата, 1969, стр. 141 - 147.
- МАХН-аас бүх нийтийг үндэсний бичиг үсэгт сургасан нь (Эх бичгийн эмхэтгэл: 1921-1964), Улаанбаатар, 1967.
- Михайлов Г. И, *Из наследия академика Б. Я. Владимирцова*, - MONGOLICA памяти академика Бориса Яковлевича Владимирцова (1884-1931), Москва, 1987, стр. 10-22.
- Мишиг Л, *Манжийн дусал бинтгүй үсгийн бичгийн тухай*, - ЭШБ (МУИС), Улаанбаатар, 1964, 21 - 36.
- Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр сурвалж бичиг*, - МН, Том. VI, Fasc. 1-2, Улаанбаатар, 1967.
- Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлшинжлэлийн атлас* (тайлбар сэлт нь монгол, орос, франц хэлээр), 1, 2-р боть, Ерөнхийлөн эрхилсэн: акад. Й. Ринчен, Улаанбаатар, 1980, Оршил, тайлбар: 73 х, газрын зураг 244.
- Монголын соёлын түүх*, I-III боть, Улаанбаатар, 2000,
- Нацагдорж Д, *Монгол хэлний ба латинчлалын дүрэм* (Грамматика), - УТТА, Ф. 23, Д. 2, ХН. 50.
- Наваан Д, *Сумъяабаатар Б, Өвөг монгол хэл бичигийн чухаг дурсгал*, Улаанбаатар, 1987.
- Надмид Ж, *Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм*, Улаанбаатар, 1967.
- Невский Н. А, *Тангутская филология*, Том. I-II, Москва, 1984.
- Новгородова Э. А, *Мир петроглифов Монголии*, Москва, 1984.
- Новгородова Э. А, *Древняя Монголия*, Москва, 1989.
- Норовсамбуу Г, *Монголын архив-албан хэрэг, түүний бичгийн хэв*, Улаанбаатар, 1975.

- Окладников А. П.**, *Центрально-Азиатский очаг первобытного искусства*, Новосибирск, 1972.
- Окладников А. П.**, *Петроглифы Монголии*, Новосибирск, 1981.
- Окладников А. П.**, *Петроглифы Чулутын гола*, Новосибирск, 1981.
- Окладников А. П.**, *Древнейшие петроглифы Аршан-Хада (Монголия Хэнтэй)*, - Пластика и рисунки древних культур, Новосибирск, 1983.
- Олон улсын монгол хэлбичгийн эрдэмтний анхдугаар их хурал**, I-IY боть, 1961-1962.
- Олон улсын монголч эрдэмтний II их хурал**, I-II боть, Улаанбаатар, 1973.
- Олон улсын монголч эрдэмтний III их хурал**, I-III боть, Улаанбаатар, 1978-1979.
- Олон улсын монголч эрдэмтний IV их хурал**, I-IY боть, Улаанбаатар, 1984-1986.
- Олон улсын монголч эрдэмтний V их хурал**, I-III боть, Улаанбаатар, 1991-1992.
- Онуки М.**, *Монгол үндэстэн бүрэлдэн тогтсон түүхэн явцын онцлог*, - Mongol-Kenkyū (Journal of Mongolian Studies), No. 6, 1983, Osaka, pp. 1-33.
- Опыт совершенствования алфавитов и орфографий языков народов СССР*, Москва, 1982.
- Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс*, Улаанбаатар, 1986.
- Өлзийдолгор Д.** *Монгол улсын төрийн тамга*, Улаанбаатар, 1999.
- Павлов Д. А.**, *Зая пандита - создатель старокалмыцкой письменности*, Элиста, 1970.
- Пагва Т.**, *Төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиол*, SM, Tom. I, Fasc. 25, Ulan-Bator. 1959.
- Позднеев А.**, *Пять китайских печатей*, ЗВОИРАО, Том. X, С.- Петербургъ, 1895, стр. 280-290.
- Позднеев А.**, *Лекции по истории Монгольской литературы*, I-II, С.- Петербургъ, 1896/1897.
- Попов А.**, *Грамматика калмыцкого языка*, Казань, 1851.
- Поппе Н.** *Монгольский словарь Мукаддимат Ал-Адаб*, книги I-III, Москва-Ленинград, 1938.
- Поппе Н.**, *Квадратная письменность*, Москва-Ленинград, 1941.
- Пробст М. А.**, *О машинной обработке киданьских текстов*, Москва, 1970, 27-34.
- Пэрлээ Х.**, *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*, Улаанбаатар, 1959.
- Пэрлээ Х.**, *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*, Улаанбаатар, 1976.
- Радлов В. В.**, *Атлас древностей Монголии*, С.-Петербургъ, 1902.
- Ринчен**, *Из нашего культурного наследия*, Улан-Батор, 1958.
- Ринчен**, *Монгол бичигийн хэлний зүй*, I-IY боть, Улаанбаатар, 1964-1967.
- Ринчен**, *Тод монгол бичиг, түүний соёлын ач холбогдол*, SM, Tom. VIII, Fasc. 22, Ulan-Bator, 1971, 291-297.
- Ринчен И.**, *К истории древних культурных связей монголов со другими народами по данным монгольского фольклора*, - Роль кочевых народов в цивилизации Центральной Азии, Улан-Батор, 1974, стр. 259-263.
- Розенберг Ф. А.**, *О Согдийцах*, ЗКВ, Том. I, Ленинград, 1925, стр. 81-95.
- Роль кочевых народов в цивилизации Центральной Азии*, Улан-Батор, 1974.
- Руденко С. И.**, *Культура Хуннов и Ноинулинские курганы*, Москва-Ленинград, 1962.
- Рудов Л. Н.**, *Проблемы киданьской письменности*, СЭ, 1963, No. 1, Москва, стр. 89-98.
- Санжеев Г. Д.**, *Лингвистическое введение в изучение истории письменности монгольских народов*, Улан-Удэ, 1977.
- Санжмятав Т.**, *Монголын хадны зураг*, Улаанбаатар, 1997.
- Смирнова О. И.**, *Очерки из истории Согда*, Москва, 1970.
- Смирнова О. И.**, *Сводный каталог согдийских монет (бронза)*, Москва, 1981.
- Смирнова О. И.**, *Двугорбый верблюд на согдийских монетах*, СНВ, вып. XXV, Москва, 1987.
- Согдийские документы с горы Муг*, вып. II, Москва, 1962.
- Согдийский сборник*, Ленинград, 1934.
- Софронов М. В.**, *Китайский язык и китайское общество*, Москва, 1979.
- Сталин И. В.**, *Хэлний шинжлэлд марксизмын холбогдох нь*, Улаанбаатар, 1950.
- Стариков В. С.**, **Наделяев В. М.**, *Предварительное сообщение о дешифровке киданьского письма*, Москва, 1964.
- Сумъяабаатар Б.**, *Монгол солонгос бичиг үсгийн холбооны тухай*, - Олон улсын монголч эрдэмтний II их хурал, II боть, Улаанбаатар, 1973, 127-133.
- Сумъяабаатар Б.**, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*, Улаанбаатар, 1975.

Сумъяабаатар Б, XIII-XIV зууны монгол солонгос харилцааны бичгүүд, тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1987.

Сумъяабаатар Б, Дундад зууны Солонгос Монгол харилцааны түүх, Сөүл, 1992.

Сүхбаатар Г, Сяньби, Улаанбаатар, 1971.

Сүхбаатар Г, Монголчуудын эртний өвөг, Улаанбаатар, 1980.

Сүхбаатар Г, Монгол Нирүн улс, Улаанбаатар, 1992.

Сүхбаатар О, Монгол бичигийн хэлнээ санскрит үгийг тарнийн дуудлагаар тэмдэглэж ирсэн нь, - SM, Tom. XIII (21), Fasc. 10 (1985), Ulaanbaatar, 1987, 72-76.

Таскин В. С, Опыт дешифровки киданьской письменности, НАА, Москва, 1963, No. 3.

Таскин В. С, Материалы по истории древних кочевых народов группы Дунху, Москва, 1984.

Таскин В. С, Материалы по истории кочевых народов в Китае I - III вв. Москва, 1989.

Терентьев-Катанский А. П, Книжное дело в государстве Тангутов, Москва, 1981.

Толстов С. П, Древняя культура Узбекистана, Ташкент, 1943.

Толстов С. П, Древний Хорезм, Москва, 1946.

Төмөртоого Д, Монголын дөрвөлжин бичгийн "мөнх" гэдэг үгийн бичлэгийн тухай, - SM, Tom. VI, Fasc. 2, Ulan-Bator, 1966, 11-16.

Төмөртоого Д, XIII -XIV зууны монгол бичигийн дурсгал дахи самгарди үгийн бичлэгийн онцлог, - Хэл зохиол, VII боть, 7-р дэвтэр, Улаанбаатар, 1969, 202-219.

Төмөртоого Д, Монгол хэлний үеийн бүтэц, хувьсал, - SM., Tom. XIII(21), Fasc. 12, Ulan-Bator, 1985, 83-91.

Төмөртоого Д, Монгол хэлний түүхэн хэлзүй, Авиа зүй, Улаанбаатар, 1992.

Фридрих И, Дешифровка забытых письменностей и языков, Москва, 1961.

Фридрих И, История письма, Москва, 1979.

Хон Ги-мүн, Солонгос монгол хэлний харьцаа, - Олон улсын монгол хэлбичгийн эрдэмтний анхдугаар их хурал, SM, Tom. II, Fasc. 20, Ulan-Bator, 1961, 313-325.

Цэвэл Я, Монгол хэвлэлийн ажил ба Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс хэвлэсэн утга зохиол, ШУ, Улаанбаатар, 1946, No. 12-13, 93-98.

Цэвэл Я, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966.

Цэвээндорж Д, Монголын эртний урлагийн түүх, Улаанбаатар, 1999.

Цэрэнсодном Д, XIV зууны үеийн яруу найрагч Чойжи Одсэр, Улаанбаатар, 1969.

Цэрэнсодном Д, Монгол Данжуурын төгсгөлийн шүлэг, ХЗС, VIII боть, 4-р дэвтэр, Улаанбаатар, 1970, 73-163.

Цэрэнсодном Д, Пагва ламын шажин номын үйл ажиллагаа, - Монгол хэл шинжлэл (УБИС), No. 1, Улаанбаатар, 1996, 3-10.

Шавкунов Э. В, К вопросу о расшифровке малой кидань-чжурчженьской письменности, - Эпиграфика Востока, Том. XV, Москва, 1963, 149-153.

Шагдарсүрэн Ц, Об одном букваре монгольского письма, -Rocznik Orientalistyczny, Tom. XXXVII, z. 2, Warszawa, 1975, pp. 101-112.

Шагдарсүрэн Ц, Монгол бичгийн галигийн тухай асуудалд, - Хэл зохиол судлал, XV боть, YП дэвтэр, Улаанбаатар, 1976, 44-53 х.

Шагдарсүрэн Ц, Монголчуудын бичиг үсгийн эвхмэл хэлбэр, - Studia Mongolica, Tom. IV(12), Fasc. 15, Ulaanbaatar, 1976, pp. 339 - 360.

Шагдарсүрэн Ц, Нэн эртний бичиг үсгийг тайлан унших нь, - Шинжлэх ухаан амьдрал, 1977, N. 6, Улаанбаатар, 66 - 69 х.

Шагдарсүрэн Ц, К вопросу о происхождении монгольского письма, - Олон улсын монголч эрдэмтний III их хурал, III боть, Улаанбаатар, 1978, 286 - 290 х.

Шагдарсүрэн Ц, Дөрвөлжин бичгийн үсэгзүйн нэгэн онцлог хослол, - Хэл зохиол судлал, ХШ боть, YП дэвтэр, Улаанбаатар, 1978, 57 - 64 х.

Шагдарсүрэн Ц, Шинээр олдсон араб бичээс бүхий хөшөө, - ШУА-ийн мэдээ, 1978, N. 2, Улаанбаатар, 65- 67 х.

Шагдарсүрэн Ц, Монгол үсэг зүй, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1981.

Шагдарсүрэн Ц, Монгол үсэг бичгийн шинэчлэлтийн түүхийн асуудалд, - Studia Mongolica, Tom. XII (20), Fasc.6, Ulaanbaatar, 1984, 119 - 124 х.

Шагдарсүрэн Ц, Традиционные монгольские фонетические термины, - Исследования звуковых систем языков Сибири, Новосибирск, 1984, стр. 193 - 194.

Шагдарсүрэн Ц, Об одном новонайденном памятнике горизонтально-квадратного письма, - Монгольский лингвистический сборник, Москва, 1985, стр. 150 - 154.

- Шагдарсүрэн Ц.** *Толь бичигийн судлал*, - Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс, Улаанбаатар, 1985, 169 - 240.
- Шагдарсүрэн Ц.** *Тодо үзүг*, - Кэлэ ба орчуулга, 1986, N. 2, Өрүмчи, 29 - 37 х (Монгол үсэг зүй номын бөлөгийг тод үсгээр дахин хэвлэжээ).
- Шагдарсүрэн Ц.** *Монголчуудын үсэг бичиг, үг хэлэлгийн түүх гарлаас*, (нэмж зассан 2-р хэвлэл), Улаанбаатар, 1986, 168 х (Ха. Лувсанбалданы хамт).
- Шагдарсүрэн Ц.** *Монгол, тод бичгийн дэвсгэр үсгийн нэр томъёоны тухай*, - Хэл зохиол судлал, ХҮ1 боть, IX дэвтэр, Улаанбаатар, 1986, 86 - 91 х.
- Шагдарсүрэн Ц.** *К вопросу истории реформ монгольских письменностей*, - Хэл зохиол судлал, ХХ1 боть, Х1Х дэвтэр, Улаанбаатар, 1987, стр. 91 - 93.
- Шагдарсүрэн Ц.** *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 1991.
- Шагдарсүрэн Ц.** *О памятниках киданьской и чжурчжэньской письменности в МНР*, - Олон улсын монголч эрдэмтний Ү их хурал, Ш боть, 1992.
- Шагдарсүрэн Ц.** *Өвөг монголчуудын үсэг бичгийн түүхийн асуудалд*, - Олон улсын монголч эрдэмтний Ү1 их хурал, Илтгэлүүдийн товчлол, Улаанбаатар, 1992, 62-64 х.
- Шагдарсүрэн Ц.** *Монгол дөрвөлжин бичгийн үсэгзүйн онцлог, ач холбогдол*, - Монгол хэлшинжлэл, (Улсын багшийн их сургууль), N. 1, Улаанбаатар, 1996, 11-17 х.
- Шагдарсүрэн Ц.** *Монгол солонгос бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд*, - Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), No. 4 (1996), Seoul, 1997, 169-192 х.
- Шагдарсүрэн Ц.** *"Монголын нууц товчоон"-ы уг эхийн талаар эргэцүүлэх нь*, - Эрдэм шинжилгээний бичиг (МУИС, Монголын судлалын сургууль), No.XIV (151), Улаанбаатар, 1999, 10-19.
- Шагдарсүрэн Ц.** *Монгол бичигийн үсэгзүй-зөв бичихзүйн асуудалд*, - Proceeding of the 4th Seoul International Altaistic Conference "Altaic Studies and Philology", Seoul National University, Oct. 23-25. 2000, Seoul, pp. 171-177.
- Щепкин В. Н.** *Русская палеография*, Москва, 1967.

-
- Aalto Pentti,** *Altaistica I*, The Mannerheim Fragment of Mongolian Quadratic Script, - SO, Tom. XVII, Helsinki, 1952.
- Aalto Pentti,** *A second Fragment of the Subhasitaratnanidhi in Mongolian Quadratic Script*, - JSFOu, Tom. LVII, Helsinki, 1954/5.
- Aalto Pentti,** *Qutuγ-tu Pancaraksā kemekū tabun sakiyan neretü yeke kölgen sudur*, - AF, Band 10, Wiesbaden, 1961.
- Aalto Pentti,** *L'esquisse de la Grammaire mongole qu'on trouve chez Melchisedéché Thévenot*, - CAJ, Tom. 8, 1963, pp. 151-162.
- Ayvang,** *Soyangbu-yin udq-a-yi tobā üjegülügen biāgeā cōrji-yin jokiya orosibai*, (rap бичмэл) *Alikalibijaharam being A Sanskrit-Tibetan-Mongolian Abecedarium* {tib. da byans-gsal-bzugs; mo. egesig üsüg kiged geyigülügči üsüg-ud orosiba}, Lahore, 1941.
- Altan ulus-un sudur**, I - IX debter, Batuvčir-un orciyuly-a, Ulaγanbayatur (rap бичмэл).
- Altangerel, Chagdarsüreng,** *Note sur un diplôme bilingue*, - RO, Tom. XXV, z. 2, Warszawa, 1973, pp. 33-42.
- Altheim B. F.** *Hunnische Runen*, Halle, 1848.
- Altheim B. F.** *Geschichte Hunnen*, Berlin, 1969.
- Arjai aγui-yin uyiyurjin mongγol biāgesü-yin sudulul**, Liyooning, 1997.
- Batuvčir,** *Mongγol üsüg-un mörden daγuriyaqu üliger*, MKBSBÖ, Tom. IV, Ulaγanbayatur, 1934.
- Bawden Ch. R.** *Some Protraits of the first Jabtsandamba Qutugtu*, - ZS, Tom. IV, Wiesbaden, 1970, pp. 183-198.
- Biography of Caya Pandita in oirat characters*, - CSM, Tom. V, Fasc. 3, Ulan-Bator, 1967.
- Bira, Sh.** *Mongolian historical literature of the XVII-XIX centuries written in Tibetan*, Bloomington, Indiana, 1970.
- Bira, Sh.** *Problems of History culture and Historiography of the MPR*, Ulan-Bator, 1977.
- Bla-ma nar-un sed-k'ul / lama-nar-un sedkül*, No. 1, Ulaγanbayatur, 1936.
- Bloch E,** *Les inscriptions turques de l'Orkhon*, - Revue Archéologique, troisième série, XXXII, Mai-Juin, 1898, Paris.

- Bonaparte R**, *Documents de l'époque mongole des Xlle et XIIIe siècles*, Paris, 1895.
- Boodberg Peter A**, *The langue of the T'o-pa Wei*, HJAS, Vol. 1, July, 1936, No. 2, pp. 167-185.
- Boosiyang**, *Mongγol üsüg biāg-ün uqayan*, Kökeqota, 1984.
- Breasted J. H**, *The Conquest of Civilization*, New-York, 1926.
- Bulay Bu**, *Mongγol üsüg biāg-ün tobā teūke*, Kökeqota, 1983.
- Burād xūr*, turūsin depter, "Naran" gedeg mongol burād nom bisig gargaxo oron, S.-Peterburg, 1907.
- Byams-ba**, *Asarayā neretü-yin teūke*, MH, Tom. II, Fasc. 4, Ulayanbayatur, 1960.
- Chagdarsureng Ts**, *Les chansons amadoyant la femelle qui refuse d'accepter son petit nouveau-né*. -Rocznik Orientalistyczny, Tom. XXXIII, z. 1, Warszawa, 1969, pp. 97-103.
- Chagdarsureng Ts**, *A propos de deux sortes de papier-monnaie mongol*, - МУИС-ийн Эрдэм шинжилгээний сонсгол, N. 30, Улаанбаатар, 1972, 37-47 х.
- Chagdarsureng Ts**, *Note sur un diplôme bilingue*, - Rocznik Orientalistyczny, Tom. XXXV, z. 2, Warszawa, 1973, pp. 33-42 (en collaboration de Tch.Altanguerel).
- Chagdarsureng Ts**, *Sur quelques traduction mongoles de "Natha"*, - Studia Mongolica, Tom. II(10), Fasc. 11, Ulaanbaatar, 1975, pp. 143-183.
- Chandra Das S**, *The sacred and Ornamental Characters of Tibet*, - JASB (1888), Tom. LVII, Part I.
- Clauson G**, *The Origin of the Turkish "Runic" Alphabet*, - Acta Or. Havniae, Tom. XXXII, Munksgaard Copenhagen, 1970, pp. 51-76.
- Cleaves F. W**, *The Mongolian Text of the Tri-lingual Inscription of 1640 (part I)*, - MS, Vol. XVIII, 1995, Bloomington, pp. 5-47.
- Cleaves F. W**, *The Mongolian Text of the Tri-lingual Inscription of 1640 (part II)*, - MS, Vol. XIX, 1996, Bloomington, pp. 3-49.
